

ПОЛИТОЛОГИ XIX

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19 (558)

XIX

ISSN 2227-6904

Key title: Политологи

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Эрхлэгч:

профессор Ж.Төртогтох

Нарийн бичгийн дарга:

дэд профессор Ц.Батболд

Гишүүд:

профессор Ц.Ганболд

профессор С.Базарпүрэв

дэд профессор Я.Төгөлдөр

доктор Г.Цэнд-Аюуш

доктор Д.Ундрах

доктор Д. Бумдарь

доктор Д.Мягмарсүрэн

Техник редактор:

магистр Т.Есүхэй

Хаяг:

Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө, МУИС-ийн хичээлийн II байр,
226 тоот, Шинжлэх Ухааны сургууль, Улс төр судлалын тэнхим

Утас: 976 - 75754400 (2317)

POLITOLOGY XIX

SCIENTIFIC JOURNAL

№ 19 (558)

XIX

ISSN 2227-6904

Key title: Politology

EDITORIAL BOARD

Editor in chief: Turtogtokh Janar, National University of Mongolia
Secretary: Batbold Tserendash, National University of Mongolia
Board members: Ganbold Tseren, National University of Mongolia
Bazarpurev Sambuu, National University of Mongolia
Tuguldur Yanjiv, Mongolian University of Science and Technology
Tsend-Ayush Galsanpiljee, National University of Mongolia
Undrakh Davaadorj, National University of Mongolia
Bumdari Dagva-Ochir, National University of Mongolia
Myagmarsuren Dashzevge, National Academy of Governance

Technical Editor: Yesukhei Tumurbaatar

Address: Department of Political Science, School of Arts and Sciences, National University of Mongolia, Zaluuchuud avenue, Ulaanbaatar, Mongolia

Phone: 976 – 75754400 (2317)

ПОЛИТОЛОГИ XIX

Эрдэм шинжилгээний бичиг
№ 19 (558)

АГУУЛГА

5 Өмнөх үг

УЛС ТӨРИЙН ОНОЛ, СЭТГЭЛГЭЭ, ҮЗЭЛ САНАА

- 6 Диктатурын мөн чанарын асуудалд
С.Базарпүрэв, О.Мөнхжаргал
- 18 Нутгийн өөрөө удирдах ёсны онол, үзэл баримтлал
Ц.Ганболд, Ц.Бямбачулуун
- 26 Үндэсний үзэл, үндэсний адислал, үндэсний өөрийн ухамсрын хоорондын харилцан хамаарал
М.Мөнхзул
- 39 Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудалд
Л.Идэр
- 50 Монголын өнөөгийн улс төрийн соёлын ойлголт, төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлохуй
О.Хатанболд, Д.Энхболд
- 81 Засаглалын хэлбэр Монголчуудын уламжлалт засаг төрийн тогтолцоо, соёл иргэншил, легитимчлэлтэй уялдах тухай
Д.Сүхболд
- 90 Олон нийтийн улс төрийн шүүмжлэлт байдал болон буруутгалд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг тодорхойлох нь
Д.Уртнасан

СОНГУУЛИЙН УЛС ТӨР, ПАРЛАМЕНТ, НАМ СУДЛАЛ

- 102 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020)
Э.Гэрэлт-Од
- 128 2020 оны УИХ-ын сонгуулийн үйл явц, үр дүн
Д.Түмэнжаргал, Г.Эрдэнэбаяр
- 149 The Development and Transformation of the Mongolia's Party System, 1992-2020
Pavel Maškarinec
- 170 A Brief Overview of the Korean National Assembly
Turtogtokh Janar

- 178 Санал худалдан авалт, түүний онцлог: улс төрийн асуудал
Б.Эрдэнэдалай, О.Батзаяа
- 192 Монгол дахь эмэгтэйчүүдийн квотын хэрэгжүүлэлтэд хийсэн шинжилгээ
Д.Ундрах, Б.Болорчимэг

БОДЛОГО СУДЛАЛ

- 210 Монгол Улс ба БНСУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц:
харьцуулсан үндсэн хуулийн зохицуулалт
Т.Заяа
- 226 Хүний эрхэд суурилсан хандлага арга зүйг хөгжлийн бодлого төлөвлөлтөд
хэрэглэх нь
Т.Есүхэй
- 236 Ковид-19-г дотооддоо алдсан үеийн бодлого нийгмийн сэтгэл зүйд
нөлөөлсөн байдал
Д.Бумдарь, Б.Хишигням, М.Тэгшбуян
- 260 Зохиогчдын тухай товч

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж байна. Дэлхий дахины улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр улс төрийн мөн чанар, агуулга улам бүр гүнзгийрч түүний үүрэг роль өсөн нэмэгдсээр байгаа билээ. Ийм учраас улс төрийн мөн чанарыг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлэлт дүгнэлтийг өгөх улс төрийн мэдлэгийг бий болгодог улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг их юм. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны аргахэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна.

Улс төрийн мэдлэгийн даяарших үйл явц нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэсээр байх болно.

Монголд шинээр үүсэн төлөвшиж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм. Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн онол, сэтгэлгээ, үзэл санаа, сонгуулийн улс төр, парламент, нам судлал, бодлого судлал зэрэг улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүйн болон практик асуудлуудыг хөндсөн сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн өгүүллүүд нийтлэгдэж байна.

Энэхүү дугаарт нийтлэгдсэн өгүүллэг тус бүр нь тухайн зохиогчийн үзэл санаа, байр суурь, судалгааны өгөгдөхүүнд тулгуурлаж байгаа бөгөөд МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим, Политологи сэтгүүлийн редакцийн байр суурь биш болохыг анхаарч хүлээн авна уу.

Уншигч та сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ Улс төр судлалын тэнхимийн хаягаар ирүүлбэл бид гүнээ талархах болно.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ДИКТАТУРЫН МӨН ЧАНАРЫН АСУУДАЛД

С.Базарпүрэв

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор

О.Мөнхжаргал

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн багш

Урд зүгээс гаралтай “халуун” ханиад дэлхий даяар үтэр түргэн тархаж, түгшүүр айдас төрүүлэх болов. Хүмүүний түүхэнд тахал гарч үй олон хүний аминд хүрсэн тохиолдол байдаг. Орчин цагийн энгийн ханиад хамуунаас хорвоог орхих явдал олон хүнийг хамарсан үзэгдэл болж тахлын хэмжээнд хүрсэн. Тиймээс өнөөдөр ч гэсэн яг энэ “19” цар тахлаас хүмүүс үхээд байгаа ч юм уу, бүү мэд. Ахуйн шинжтэй шалтгаанаар осолдсон хүний тоо ямар ч тахлаас дутахааргүй байна.

... Цар тахал нэг хэсэгт нь айдас төрүүлж улмаар тэд хором алдалгүй арга хэмжээ авч, нөгөө нэг нь үл анзаарч, цаг алдаж, багагүй хохирол амсаж амжив. Уг тахал хэдэн жилийн өмнө бүтээгдсэн, их гүрэн болох АНУ, БНХАУ хамтын бүтээл гэж үзэх судлаачид байгаа нь тухайн мэдээ ортой байх тал бий. Нэгэнт тарсан тул хэр зэрэг хяналтад байна гэдэг л асуудал болоод байх шиг. Мөн хэр хувирдаг “увидастай”, ямар зориулалтаар бүтээгдсэн гэдгийг мэдэхийн аргагүй. Түүнийг дарж авах вакцин бүтээх нь яадаг бол. Хэзээ “цурманд” нь оруулж авах бол гэсэн асуудал хариулт нэхсээр. Хэрэв хүн уг вирусыг бүтээсэн бол түүнийг бас зогсоох арга байх болов уу, гэм нь түүнийгээ нууцалж, ашиг хараад байна уу гэсэн хардлага төрөх юм. Бид дархлаанд нэмэртэй, цайр ихтэй хонины мах тогтмол иддэг тул вируст дайруулах магадлал багатай ч засаглагч ямар дэг журам гарган, диктатур тогтоож иргэд ээ “аврах” вэ гэдэгт илүү найдахаас өөр сонголт алга...

Хууль ёсны дэг журамт цайз хэрэм нурж, гинжит хүлээс тайлагдсан тэр газар, тэр цагт анархи үүсэн хүн зэрлэг, аймшигтай амьтан болох үнэн дүр төрх, мөн чанар ил гардаг хэмээн XIX зууны иррационал философич Артур Шопенгауэр

онож хэлсэн байдаг. Хүмүүний хэрцгий занг даран номхруулах шаардлагаас үүдэн дэглэмийн систем бүтээх хэрэгцээ гардаг гэдгийг тэрээр ингэж онцлон тэмдэглэсэн.

Автократ, хаант, бүгд найрамдах, ардчилсан, диктатурт зэрэг удирдлагын хэлбэр дэлхийн улс оронд тогтсон. Диктатурт тулгуурласан удирдлага эрт үеэс л улс төрийн амьдралд хэрэгжиж байсан, өнөөдөр ч диктатурт дэг журам давамгайлсан засаглал дэлхийн зарим нэгэн улс оронд ноёрхсоор байна.

Зургаан жилийн өмнө Freedom House-ийн гаргасан мэдээгээр хагас ба бүтэн 106 диктатурт журам дэлхийд тогтнож байна гэжээ. Дэлхийн бүх улс орны 54 хувьд нь диктатурт ёс ноёрхож байна гэсэн үг юм. Дэлхийн хүн амын гуравны хоёр буюу хоёр миллиард хүн диктатурын нөхцөлд байгаа нь тухайн систем хэр түгээмэл гэдгийг харуулж байх шиг.

Диктатур гэдгийг хүчирхийлэл, дарангуйлал хэмээн ойлгох тал байдаг ч албадах нь аль ч дэглэмийн системд байдаг л зүйл. Нийгэм, эдийн засаг, улс төрийн онцлог, үндэстний соёл зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан дэглэмийн хэм хэмжээг чангатгах эсхүл сулруулах болдог. Улс төрийн засгийн эрх мэдэл баригч субъектийн зүгээс баримталж байгаа журмаас шалтгаалан диктатурыг хоёр янзаар авч үзэж болно. Нийгмийн хөгжил дэвшилд нэмэртэй диктатур эсхүл нийгмийн чадвар, чанарыг бууруулдаг диктатур. Хөгжилд нэмэр болж буй эсхүл саад болох гэдгээр дэглэмийг ялгах нь арга зүйн хувьд ач холбогдолтой болов уу.

Нийгэмд тогтоох дэглэм нь юуны өмнө тухайн орны эрх ашигт нийцсэн улс төрийн бодлого боловсруулахаас, хоёрдугаарт, түүнд таарсан улс төрийн шийдвэр гаргахаас, гуравдугаарт, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг сонгохоос шалтгаална.

Диктатур, диктатор нь Таркин хааныг халсаны дараа Ромд тогтсон гүйцэтгэх засаглалын нэг өвөрмөц институт юм. Жирийн үед тэнцвэр оруулах гэсэн бодлоор улс орныг хоёр консул удирдаж байсан. Онцгой тохиолдолд диктаторыг өргөмжлөн, хэнтэй ч үл зөвлөлдөн, тулгамдаж буй асуудлыг шийдэх дархан эрхийг түүнд өгдөг байсан. Түүний зарлиг шийдвэр хууль мэт хүчин төгөлдөр үйлчилдэг байж. Диктаторын бүрэн эрх хагас жилээр хязгаарлагдан, хийсэн үйлдлийн төлөө хариуцлага хүлээдэггүй байв.

Эртнээс диктатур гэдэгт зайлшгүй шаардлагатай, аюулгүй болгох гэсэн логикийг агуулж ирсэн. Тухайн ойлголтын утга өөрчлөгдсөн ч диктатурыг үндэслэх гол санаа эртний Ромын үеэс огт өөрчлөгдөөгүй өдий хүрсэн. Диктатур анхнаасаа л Ромд онцгой нөхцөл байдалд тодорхой хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилготой бүтээгдсэн систем юм. Диктатурыг Ромын эзэнт гүрэнд

гарч болзошгүй дотоод зөрчлийг урьдчилан сэргийлж, зогсоох учиртай ашиглаж байсан хэмээн ромын консул байсан, грек гаралтай түүхч Кассий Дион тэмдэглэсэн байдаг.

Эртний грекийн түүхч, төрийн зүтгэлтэн, сэтгэгч Полибий Пунийн хоёрдугаар дайн, Ганибалтай хийсэн дайны үед диктатур тогтож байсан талаар дурьдсан. Тэр цагт хүн ам төдийгүй сенат сандралд орж, жил бүр магистратаар сонгогддог удирдлагын системийг орхин, үүсэж бий болсон нөхцөл байдлаас гарах радикал арга замыг сонгох аргагүй байдалд орж, бодитой тулгарсан нөхцөл байдал, ирж буй аюулаас ангижруулах чадвартай, бүрэн эрхээр хангагдсан цорын ганц генералыг тохоон томилох шийдвэр гаргах ёстой болсон гэж Полибий тайлбар өгсөн.

Нийгэмд нүүрлэсэн аюулыг тодорхой хугацаанд шийдвэрлэх ёстой гэсэн логик байгааг анзаарах хэрэгтэй болов уу. Уг диктатурын ноёлох цаг хугацаа сунжрах тусам улам хүчирхийлэн дарангуйлах хандлага үүсэн, олигарх-тиран дарангуйлагч төрөх магадлалтай гэсэн үг. Бусад төрийн байгуулалтаас олигарх, тираны амьдрал богино... тиран удаан “насалж” байгаагүй гэж Аристотель дүгнэсэн байдаг нь цаг хугацааны хувьд нийгмийг удаан дарангуйлан харгис бодлого баримтлах зохисгүй гэдгийг улс төр судлаачид сануулсны нэг жишээ юм. Нийгэмтэй дайсагнасан удирдагч өөрийгөө аюулд унагаж, харгислах тусам түүний дэглэм сулардаг гэж италийн түүхч Макиавелли үзэн тодорхой байгууламжинд таарсан засаглал байдгийг сануулсан.

“Эрүүл” ардчиллагчид диктатурын элемент зайлшгүй ... ардчилал диктатур хоёр нь нэг нэгийгээ үгүйсгэж болохгүй, харилцан зохицож байх нь зүйтэй гэж америкийн түүхч Росситер Клинтон үзжээ. Аливаа засаглагч зорилго биелүүлж, гүйцэлдүүлэхийн тулд тодорхой нөхцөлд зайлшгүй диктатор болох ёстой болдог ч тиран-дарангуйлагч болох замыг хаах нэг арга нь олон селектораттай байх явдал юм.

Бүгд найрамдах институционал системд диктатурыг байршуулах хэрэгтэй гэсэн сонирхолтой санааг Макиавелли дэвшүүлсэн. Ромын эзэнт гүрний амжилт, сүр хүчийг бүтээн арвижуулахад оролцсон институтын нэг нь диктатур байсан ба хүнд байдлаас гарах, нийгмийн боломжийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байгууламж байсан гэж тэрээр үзсэн. Диктатур хэт абсолют засаглалыг тогтоодоггүй харин ч эсрэгээрээ түүний зааг хилийг тогтоон, ямар нөхцөлд засгийн хүчийг нягтлан төвлөрүүлэн нэгтгэх эсхүл задлан сааруулах вэ гэдгийг мэддэг эрхэм чанар агуулдаг хэмээн Макиавелли үнэлсэн. Мөн бүгд

найрамдах засгийн үнэт зүйлсэд гаднаас заналхийлэх аюул, дотоодод хууль бусаар засгийн эрх булаагчдаас аврах чадвар диктатурт байдаг гэж тэрээр онцлон тэмдэглэсэн.

Айдас диктатурын эх болдог ч түүнд бүрэн автан захирагдаж үл болно эс тэгвээс засаглал хэт төвлөрөх аюултай ба бүгд найрамдах диктатур нь айдсыг ашиглан тиран болох санаа агуулсан индивидыг зогсоох учиртай гэж Макиавелли анхааруулсан. Айдас – засгийн эрхийг хууль бусаар гартаа оруулах таатай нөхцөл, болзол гэж тэрээр үзэж байв. Айдсыг давж гарах арга нь абсолют засаглал тогтооход оршино гэж Гоббс үзэж байсан бол Макиавелли абсолют засаглал айдас дээр “тоглолт” хийж, айдсыг улам хөөрөгдөн нэмж ашиг хонжоо хайдаг гэдгийг мартаж болохгүй гэжээ. Тиймээс ч тэрээр бүгд найрамдахчууд айдас хүйдсийн үр дагаврыг мэддэг, түүнээс ангижруулах чадвартай тодорхой институт бүтээхийг чухалчилж үзсэн. Жорж Вашингтоны их сургуулийн улс төрийн психологийн программын захирал Жеролд Пост диктатор практикаар батлагдсан, нэг бус удаа шалгагдсан хэрэгсэл болох айдас ба мэдээллийг хянах замаар хүмүүсийг удирдах чадвартай хэмээн үзсэн нь ямарч цаг үед диктаторын ашигладаг арга нэг байсныг харуулж байна.

Бүгд найрамдах системийг сэргээн, анхдагч дүр төрхөнд нь оруулах ажлыг гүйцэтгэх гол функцтэй гэж диктатурын үүргийг XVII зууны Нидерландын рационал-философич Спиноза тодорхойлсон. Ийм санааг Платон ч дэвшүүлж байсан. Эхэлж бүрэлдсэн байгуулал руу эргэн ирэх чадвартай байна гэдэг нь бүгд найрамдах тогтолцоог хадгалах сэргээж шинэчлэх боломж нээгдэнэ гэж үзээд диктатурыг таван жилд нэг удаа тогтмол тогтоож байх зүйтэй гэсэн хувилбар ярих болсон ч онцгой байдалд тогтдог диктатур биш болж хувирах талтай гээд Спиноза диктатураас татгалзсан байдаг. Өөр шалтгаан байдаг. Диктатур хүний адгийн аашийг өдөөж байдаг төдийгүй хязгаар, хэмжээ үгүй эрх мэдэлд шунах хүмүүнд ашиглагдаж магадгүй хэмээн үзсэн. Онцгой байдал үүсэхэд диктатур тогтоох шалтгаан болдог ч ёс суртахуун, ёс журам, ёс жудаг тогтоох нэн хүнд “ажлыг” зөвхөн диктатур хэрэгжүүлнэ гэж Спиноза дүгнэсэн.

Спиноза диктатурыг хаант засаглал гэж үзээд бүгд найрамдах системийг нугаслах институт ба абсолют шинжтэй учир бүгдийг дарангуйлах болно гэжээ. Зөв зохист хүмүүсийн “зүрхийг” авч, зөвхөн хөлжих гэсэн бодолтой “эвдэрсэн” хүмүүстэй тэгшитгэх гэсэн тун зохисгүй эдийн айдсыг диктатур төрүүлдэг гэжээ. Саруул бодрол, эрүүл бясалгах чадалгүй, хийморь лундаа гүйхгүй цагт хүмүүст айх, найдах гэсэн үндсэн хоёр сэтгэл үлддэг. Ийм сэтгэл нь эмзэг, хар дарж

сүсэглэхэд өртөмтгий тул дарангуйлагч-тиран түүн дээр дөрөөлөн мэндэлдэг хэмээн Спиноза үзсэн. Тиймээс айдас хүйдсийг төлжүүлэн, санаатай тулган суулгаж, үржүүлэх сонирхол тиранд байдаг ба хаант засаглалын оршин тогтнох нууц нь юм. Диктатур ч гэсэн айдсаар удирддаг гэдгийг тэрээр үгүйсгээгүй байна. Айдас хүмүүсийг боол ч болгож мөн эрх чөлөөний төлөө тэмцэгч болгодог гэжээ.

Засаглагч “цэвэр” ардчилагч эсхүл дарангуйлагч байх боломжгүйг хүмүүний түүх гэрчилж байдаг. Аливаа засаглагч төрийг мэдэн түүнийг “зарах” эрхтэй болоод нийгэмд ач тустай “зүйл” хийх гэж хичээнгүйлэн чармайдаг. Тодорхой хугацааны дараа нийгмийн хүндрэлтэй асуудалтай тулгарч шийдэх чадваргүй ч юм уу эсхүл хүсээгүй ч юм уу бодит байдалтай эвлэрч дүжирдэг. Хожим нийгмийн хөдөлгөөнд саад тогтор болж, халагдах цаг нь ирдэг.

... Актор улс төрийн системийг засаглан нийгмийг удирдах арга хэрэгсэл улс гүрэн бүрт янз янз л байдаг. Олон хүчин зүйлээс хамаарч нийгмийн оршин тогтнох нөхцлийг хангах технологи тодорхойлогддог. Байгаль, газар зүйн байдал нэн тэргүүнд анхаарч үзэх хүчин зүйлд тооцогддог. Мөн нийгэм, эдийн засгийн төлөвшил засаглагчийн үйл ажиллагаанд тун чухал нөлөөтэй. Эдгээр товч дурьдсан факторыг хооронд нь уялдаатай авч үзэн, төрийн хэрэгжүүлэх бодлого, шийдвэр тодирох учиртай ажээ.

Засаглагч ямагт нийгмийг арга ухаан зарж, эвээр удирдах санаа байдаг ч тухайн бодлого хэрэгжих магадлал тун хомс байдаг. Түүний ажилд саад бологч дотоодод ч, хилийн чанадад ч байх тул засаглагч диктатур тогтоож, чанд дэг журам нийгэмд тулган хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Дарангуйлагч, диктатор (диктатур тогтоогч) гэсэн хоёр ойлголт хоорондоо нягт холбоотой, ойролцоо агуулгатай ч ялгаатай юм. Тиран засаглал нь төрийн хүчийг захиран зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах нэг онцлог хэлбэр. Тодорхой онцгой нөхцөлд дарангуйлагч бус диктатор төрөн гарах зүй тогтоолтой. Засаглалын амтанд ороод, мөнх засаглах сонирхлыг төрүүлдэг ч эрх мэдлээ хадгалж үлдэх нь тун хэцүү үйл ажиллагаанд тооцогддог.

Италийн эрдэмтэн Парето удирдагчдыг хүчирхийлэгч авторитар мөн овжин, далдуур үйлдэлтэй гэж ангилласан. Макиавелли төгс удирдагч нэгэн зэрэг үнэг шиг аргатай, арслан шиг хүчирхэг байх хэрэгтэй гэж үзсэн.

Цөөн тооны удирдагчдаас бусад ихэнх засаглагч дарангуйлан боолчлох чин эрмэлзэлтэй байж, захирагдаж буй харьяат иргэддээ хэрцгий харгис хандахад албатууд ч хариу барьж хэдэрлэн ярдаглах болдог гэж XIX зууны германы материалист философич Август Эйнзидель дурьдсан.

Диктатор дэглэмийг ангилах гэсэн оролдлого судлаачдын дунд түгээмэл байдаг. Засаглагчид нийгэм, иргэд, улс төрийн сөрөг хүчийг дарангуйлан, дэглэх түмэн төрлийн арга хэрэгслийг ашиглаж байсан. Өнөөдөр ч мөн адил олон янзын заль бүтээн, ухаан зарж байгаа ч цэргийн, гэр бүлийн буюу хааны, иргэний гэсэн гурван төрөл диктатур түгээмэл оршин тогтнож байна.

Диктатур нь аливаа засаглалд ямар нэгэн хэмжээгээр зайлшгүй байдаг. Улс төрийн системийг хэн эзэмшиж, захиран зарцуулах хэрэгтэй байна гэдгээс дарангуйлагч болж хувирах нь шалтгаална. Мөн өөрөөс нь хамаарахгүй засаглагчийг дарангуйлан захирагч болгодог бодит ба субъект хүчин зүйл байдаг.

Фашизм, нацизм, тоталитар социализм, клерикал диктатур, нэг хүний ба авторитар деспот, олигарх ба нэг намын дарангуйлал зэрэг дэглэмд диктатурын дарангуйлан захирах шинж төрх агуулагдаж тэр нь тодорхой нөхцөлд түлхүү илэрч байдаг. Диктатурыг өнгөн шинжээр нь ялгаж болох ч гүнзгий шинжилгээ хийж, дүгнэлт гаргах боломжгүй ба шаардлага ч байхгүй бололтой.

Нийгэмд өгч буй ач тус, иргэдийн хэрэгцээг хангаж байгаа гэдгээр нь дэглэмийг үнэлэх түүгээр ангилах нь зохистой болов уу гэдгийг дахин сануулах нь зүйтэй.

Бүх улс гүрэнд таарсан жор гэж үгүй. Улс төрийн системийн ерөнхий загвар байх ч улс орон бүр өөрийн гэсэн онцлогоос хамааран өвөрмөц дэглэм тогтоодог. Тухайн газар нутагт зохицох нийгэм, эдийн засгийн дэглэм ямар байх вэ гэдэг асуудалтай тулгардаг. Зарим нэг газар нутаг дээр ашгаа өгч байсан систем өөр оронд ажиллахгүй байх жишээтэй. Тиймээс эрсдэлгүй нөхцөл бүрдүүлэхийн тулд гадаад, дотоод хүчин зүйлсийг нягтлан дэг тогтоох системийг бүтээх нь чухал юм. Диктатур тогтоох нь нөхцөл байдлаас шалтгаалан зайлшгүй зүйл ч байнга орших нь нийгэм ба засаглагчид ашиггүй.

Тайвань, Хойд Солонгост 1940-д оноос 1980 оны хооронд нэг намын диктатурт дэглэм ноёрхож байсан. Тайваньд авторитар, Хойд Солонгос улсад тоталитар систем тогтсон. Японы эзэнт гүрний мэдэлд байж, нэг ижил нөхцөлтэй гараагаа эхэлж, хатуу улс төрийн диктатурт дэглэм тогтож байсан ч үйл ажиллагааны ялангуяа нийгэм эдийн засгийн үр дүн харьцуулшгүй өөр гарсан. Тайвань Швейцарь лугаа адил хөгжингүй орон болж хувирсан. Кимийн тогтоосон дэглэм Хойд Солонгосыг Африкийн ядуу орнуудтай нэгэн ижил болгосон. Тайваньд тогтсон Гоминданы дэглэм, Өмнөд Солонгост ноёрхож байсан Пак Чон Хи, Чон Ду Хваны цэргийн дэглэм тун хатуу бодлого баримталж байсан ч улс орно

хөгжүүлэх, үндэсний баялгийг арвижуулах ажиллагаа нь чанартай, үр дүнтэй болсон.

Тодорхой цаг хугацаанд, тодорхой орон зайд шаардлагатай нөхцөлд иргэдийн бүсийг чангалах хэрцгий гэмээр эдийн засгийн арга хэмжээг авсан нь өгөөжтэй байж эерэг үр дүн гардаг тал бий ч нугалаа гаргалгүй цагаа олж, шинэ шатанд гарч аажмаар өөрчлөгдөн зөөлөрч, чанд дэгийг сулруулах либералчлагдах учиртай. Удаан хугацаанд эзэрхэг, хатуу эдийн засаг, улс төрийн бодлого баримтлан, хэрэгжүүлэх нь нийгмийн хөгжилд хортой үр дагавар авчирдаг гэдгийг түүх гэрчилсэн байдаг.

Сэтгэл зүй, соёл, угсаа зүй зэргээр ялгаатай ч диктаторыг нэгтгэдэг нийтлэг зүйл байна. Диктатор, тойрон хүрээлэгч, ойр орчмын хүмүүст үл итгэх тохиолдол түгээмэл байдаг. Өөртөө бодит аюулгүй, ээлтэй орчинг бүрдүүлэх, тодорхой субьектээс дэмжлэг авах сонирхол, хэрэгцээ байдаг. Ард түмэнд хандаж түүнд зориулж сайн сайхан үйлсийг хийж иргэдийн хайр хүндэтгэлийг хүртэж, “энхрий хайрт удирдагч” болон хувирсан түүх олон оронд бий. Каддафи Ливийн ард түмэнд урьд өмнө нь ч байгаагүй, хэт дээ ч байхгүй “баян бүрдийг” бүтээж, үлгэр жишээ үзүүлсэн нь Африкийн төдийгүй дэлхийн бусад орон түүний жишээг даган хуулбарлах хандлага үүссэн.

Иргэдийг хуулийн хүрээнд, тунгий нь тааруулан дэг журамтай хэм хэмжээнд оруулах нь нийт нийгмийн эрх ашигт, хүмүүний үйлсэд хэрэгтэй төдийгүй засаглагч, бие хүнд ч ач тустай гэж үзэж болно. Хүмүүс уг чанартаа тодорхой хэмжээний эрх чөлөөг эдлэх чадвартай байдаг тул түүнд нэмж эрх олговол түүнийг өөрөө үгүй хийх, дарангуйллын шинэ хэлбэрийг зохион байгуулахад санаа тавьдаг гэсэн дүгнэлтийг XIX зууны английн социологич Герберт Спенсер хийсэн.

Улс төрийн засаглагч нийгмийг албадах төрийн аппарат, хэрэгслийг өөрийн үйл ажиллагаанд ашиглаж байдаг учир иргэдэд нөлөөлдөг хүчтэй субьектэд тооцогддог. Нийгмийн зүгээс зохих ёсны хяналт тавих боломж хомс байдагтай уялдаатай засаглагч өөрөө мэдэж гартаа төрийн нөөц хүчийг төвлөрүүлж, диктатур тогтоох нөхцөл үүсдэг.

Нөхцөл байдлаас шаардлага гарвал Скандинавын зөөлөн ардчилал ч диктатураар солигдож болно, төрд нэг л зорилго байдаг түүнд хүрэхийн тулд ардчилсан ч бай, диктатурт ч бай аль хэрэгтэй гэж үзсэн аргыг ашиглах ёстой хэмээн орчин цагийн франц сэтгэгч Жиль Дове тэмдэглэсэн. Нэрлэсэн хоёр аргын эхнийх нь харгислал бага ч төр хувирч диктатур тогтоох боломжтой. Эрх баригч

ангийн ашиг сонирхолд нийцсэнээр Веймарын бүгд найрамдах улс найр тавин Гитлерт бууж өгсөн байдаг нь диктатургүй ардчилал байдаггүйг харуулж байна гэж Дове онцлон сануулсан.

Диктатур удирдлагын бүрэн эрхийг улс төрийн ижил байр суурьтай, “элэг” нэгтэй бүлэг хүмүүст төвлөрүүлэн атгуулж, улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх нэг хэлбэр. Засаглалын хэлбэрээс үл хамааран захирамжаар удирдах онцлог байна. Бүгд найрамдах засаглал тогтсон ч түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь диктатур байх тохиолдол түгээмэл юм.

Диктатор өөрийн үзэл суртал, улс төрийн үзэл санаа, шийдвэрийг үл зөвшөөрсөн улс төрийн хүчний эсрэг залхаан цээрлүүлэх арга хэмжээг авдаг. Дэглэмийн эрх барих зарчимд харшилтай иргэдийн эрх, эрх чөлөөнд халдаж дарангуйлдаг.

Орчин цагт диктатур гэдгийг хууль эрхийн хүрээнээс хальсан хатуу чанд удирдлагын төрөл маяг хэмээн ойлгох талтай байдаг. Нэн шинэ түүхэнд хууль бусаар засгийн эрх аван олон жил иргэдийг дарангуйлсан диктатор олон бий. Испанид Франко, Унгарт Хорти, Иракт Хусейн, Португалид Салазар, Чилид Пиночет, Ливид Каддафи, Комбоджид Пол Пот, Индонезод Сухарто зэрэг хэрцгий удирдагч төрийн эргэлт, бослого, хувьсгал хийж мөн цэргийн хунтыг ашиглаж засгийн эрхэнд гарсан байдаг. Хуулийн хүрээнд бүх нийтийн сонгуулийн үр дүнд засгийн эрхэнд гарсан түүх ч байна. Филиппиний дарангуйлагч Маркос сонгуульд ялалт байгуулж, төрийн эрх мэдлийг хорь гаруй жил барьсан.

Бага буурай орны засгийн эрх мэдэл авахад хилийн чанадаас санхүү, цэргийн дэмжлэг, “гүн туслалцаа” үзүүлэн тоглоомын дэглэм тогтоох практик тархсан. Засаглагч гадны сонирхлыг ил, далд илэрхийлж, санхүүгийн дэмжлэг авсан улс орон цөөнгүй байдаг. Түүний үйл ажиллагаа “хөрөнгө оруулагчийн” эрх ашигт нийцэхгүй тохиолдолд олон аргаар дарамтлан хавчих, эдийн засгийн хориг тавих арга хэмжээг авч, удирдагчийг нь хороох, солих ч ажиллагаа хийгддэг. Хусейн, Каддафи зэрэг эзэн захирагчийн үгэнд орохгүй шийтгүүлсэн диктатор хүн төрөлхтний түүхэнд олон байна. Тодорхой орны дотоод хямрал гаарч, засгийн эрх мэдлийг хуваан хувиарлах явцад диктатур үүсдэг тохиолдол байдаг ч гадаадын томоохон хөрөнгийн сонирхол байвал, дэглэм тогтооход эсхүл диктатурыг татан унагахад түүний оролцоо илт болдог.

Орчин үед “ардчилал” зөвхөн хөрөнгөтөн, албан тушаалтны эрх ашигт үйлчилдэг хэрэгсэл гэдгийг хэзээ ч мартаж үл болно. Тухайн багаж нь тодорхой шалтгаанаар саатаж, олон түмний хөдөлгөөнийг дарах эсхүл орон нутгийн

санаачлагыг намжааж чадахгүй тохиолдолд өмчтэй засаглагч түүнийг тэр доор нь диктатураар сольдог. Хөрөнгөтний нийгэмд ардчилал, диктатур хоёр нь амин холбоотой ба нэг цул биетийн хоёр хэсэг болон оршин тогтнож байдаг. Диктатур дэлхийн бүх ард түмэн, улс оронд зохих албагүй. Диктатур болгон муугаар төгсдөггүй, хүн бүр ардчилсан төр улсад амьдрах хүсэлтэй байдаггүй. “Үл бүтэх, зохисгүй ардчилал, хүмүүнлэг диктатураас доор” гэж Гарвардын их сургуулийн психологийн профессор Стивен Пинкер тэмдэглэсэн.

Диктатор, тиран-дарангуйлагч хэмээх ойлголтууд хоорондоо холбоотой ч диктатур гэх нэр томьёо хожим гарч ирсэн. Дарангуйлагч-тираны талаар Аристотелийн үеэс дурдсан ч диктатуртай холбож байсангүй.

Эртний Ромд диктатур тогтоох нөхцөл байдалтай холбоо бүхий хэд хэдэн онцлог байсан. Юуны өмнө Ромын эзэнт гүрний төрийн институт болох магистрат эсхүл сенат зэрэг нь диктатур тогтоох нөхцөл бүрэлдсэн эсэхийг тодруулан шийдвэр гаргадаг байсан. Эл асуудлыг хэлэлцэх эрх бүхий этгээд, диктаторт нэрээ дэвшүүлдэггүй журамтай байсан нь нэн зохистой дэг тогтож байсныг харуулж байна.

Бий болж, үүссэн хямралыг шийдвэрлэхэд олон субъект оролцох шаардлагагүй, ажил үйлсэд саадтай гэж үзэж диктаторын сэнтийд нэг л хүн залардаг байж. Диктатор хэмжээлшгүй их дархан эрхтэй ч төрийн бусад институтийг татан буулгах эрх мэдэл байгаагүй. Ард түмэн, олонх диктаторыг сонгоход оролцдоггүй байв. Өмнөх улс төрийн дэглэмийг сэргээн засварлах гэсэн эцсийн зорилго агуулан засаглалын динамик хөгжилд диктатор их үүрэг ач холбогдолтой байсныг илтгэн. Тэрч бүү хэл диктатурыг эрх чөлөөг хамгаалах хэрэгсэл гэж XX зууны германы социологич Карл Шмитт тодорхойлсон байна.

Диктатурт дэглэм цаг тутамд тогтож байгаагүй. МЭӨ 437, 434, 426 онуудад Эртний Ромд диктатур тогтон үүсэж, Мамерк Эмилий Мамерцин анхны диктатор болсон. Манай эриний 501 оноос 200 оны хооронд Эртний Ромд даланзургаан диктатор өөрийн диктатурыг тогтоон, улс төрийн бодлого хэрэгжүүлсэн гэж түүхчид тэмдэглэсэн. Эдгээрийн дийлэнх нь бусад улс гүрэнтэй дайтах мөн дотоод самуун хөдөлгөөнийг дарах ажиллагаа хийсэн. Тэр үед өшөө авах үйлдэл хийх эрхгүй байсан тул диктатор харгис хэрцгийд үл тооцогдож байсан.

Ромын цэргийн жанжин, диктатор Луций Корнелий Сулл диктатур гэх ойлголтод өөр уур амьсгал оруулсан. Тэрбээр манай эриний 82 онд огцрохоос татгалзан Ромыг эзлэн цэргийн хүчинд тулгуурласан диктатур тогтоон, өөрт

эсэргүүцсэн этгээдийг нэн хэрцгийгээр даран харгислал үйлдсэн. Засаг захиргаа, хууль тогтоох, шүүх эрх мэдэл, цэргийн хүчийг нэг гарт төвлөрүүлэн, өмнөх диктатурын утга учир алдагдсан. Ийнхүү диктатурын мөн чанарыг завхруулах эхлэл тавигдсан.

Манай эриний 44 оны дундуур Юлий Цезарь “насан туршийн диктатор” гэсэн хэргэм хүртсэн явдал, диктатур тодорхой цаг хугацаатай оршино гэсэн Эртний Ромын үед үйлчилж байсан шалгуур журмыг үгүй болгосон бололтой.

Гэсэн хэдий ч Ромын диктатурыг шүтэн бишрэгчид улс төр судлаачдын дунд ямагт байсан. Хожим хойно Ромын эзэнт гүрний сүр жавхланг бүтээлцэхэд диктатур агуу их гавьяа байгуулсан гэж Никколо Маккиавелли үнэлснийг дээр дурдсан билээ. Хамтарч хууль хэлэлцэж батлах нь уян хатан зүйл бишээс гадна хямралыг шийдвэрлэхэд тийм ч зохимжтой бус хэмээн үзээд нэг хүний засаглалыг илт давуу чанартай гэж онцолсон нь диктатурт их элэгтэй байсныг харуулж байна.

Үүнтэй агаар нэг санааг Ж.Ж.Руссо дэвшүүлсэн. Хуулийг даган мөрдлөө гэж үзий, гэтэл тэр нь нүүрлэж буй аюул заналхийллийг сэргийлэхэд саад учруулсан тохиолдолд дээд удирдагчийг томилж, хуулийн “амыг” барьж, засаг баригчийг тодорхой хугацаанд үйлдэл хийлгэхгүй болгож, улс орноо аврах учиртай гэжээ.

XIX зуунд диктатурын мөн чанарын тодорхойлох шинж дотор байдаг нэг хүний ноёрхол гэсэн үзүүлэлт хамтын ажиллагаа гэх санаагаар “баяжигдан”, эртний Ромын сонгодог загварыг эвдсэн болно.

Хувьсгал хэмээх ойлголттой холбогдон улам өргөжин ангийн диктатур болон хувирч, 1917 оноос Орос оронд хэрэгжиж эхэлсэн. Ленин “пролетарийн диктатурын” талаар эерэг тайлбар өгч “сайн” үйлсийг бүтээх санаа агуулж, зөвхөн Орос оронд төдийгүй орон бүрийн ажилчин ангийг нэгтгэн бүх дэлхий дээр пролетарийн диктатурт дэглэм тогтоох үзлийг сурталчилсан ч тэр нь үл гүйцэлдэх сургаал болох тул бүтэлгүйтсэн түүхтэй.

XX зуунд зөвлөлт засаг, фашизм, нацизмыг шүүмжлэгч либералууд үзэн ядсан хамаг л зүйлээ диктатуртай холбон түүнд тохон тайлбарласан байдаг.

Тэд ба тэд мэт нь сонгууль хийж, өрсөлдөхгүй өөр аргаар тухайлбал, төрийн ба ордны эргэлт, хувьсгал хийсний үр дүнд улс төрийн эрх мэдэлд удирдагч нь гарч тогтоогдсон дэглэмийг диктатур гэж үзсэн. Хүчний байгууллага эсхүл гаднын тодорхой сонирхолд хөтлүүлсэн, тэдгээрийн дэмжлэгтэйгээр төрийг эзэмдэх тохиолдол бишгүй байна гэсэн байр суурьтай байдаг.

Дээрх ойлголт үйлдлийн талаас тодорхойлсон ба мөн чанарын юм багатай. Гүйцэтгэх засаглал, парламент сонгогдох учиртай, сонгуульд зөвхөн нэг нам оролцохгүй байж, засаг солигддог ёстой гэсэн ерөнхий шалгуурт нийцэхгүй л бол диктатур тогтож байна гэж үзэх байр суурь юм. “Гүйцэтгэх засаглал солигдохгүй байгаа тохиолдолд диктатур байна гэж үзэж болно” хэмээн Эссексийн их сургуулийн эрдэмтэн Наташа Эроу дүгнэсэн байдаг.

Улс орнуудын диктаторууд улс орноо хөгжүүлэх, удирдах үйл ажиллагааг зохион байгуулах талаар өөртөө болон улс орондоо тохирсон ур ухаан зарж, санаачилга гаргаж ирсэн. Цэргийн хунт, улс төрийн товчоо, гэр бүлийн зөвлөл, улс төрийн нам зэрэг институтийг бүтээн түүнд тулгуурлан шийдвэр гаргаж байсан. Үүний зэрэгцээ инновацид тулгуурлах хандлагатай диктаторууд парламент эсхүл улс төрийн нам мэт ардчилсан байгууллагыг ашиглах сонирхолтой байдаг ба үүний үр хөврөл эерэг гарч нийгэм эдийн засаг, улс төрийн дэвшил, хөгжилд хүрсэн үлгэр жишээ орон байна.

Орчин цагийн ихэнх диктаторууд улс төрийн намуудыг үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрч өөрийн шүүлтүүрээр оруулан, тэнцээгүй улс төрийн намыг хориглодог явдал байна. Улс төрийн орон зайд нэг намыг ашиглан диктатор бүрэн эрхээ тогтоох тохиолдол түгээмэл байдаг. Диктатор улс төрийн системд “эрээн бараан” гэгдэх байгууллагыг нэн дараатай, түвэг их уддаг гэж үзэн тоог нь цөөлөх, байхгүй бол бүүр ч сайн гэх бодол агуулдаг.

Диктатур Эртний Ромд онцгой нөхцөлд тодорхой зорилгыг цаг хугацаатай гүйцэтгэх үүрэгтэй үүсэж байсан нэг бие хүн-диктаторын өвөрмөц институт ба сонгодог хувилбарын зарчмыг харгалзан баримталж өнөө үед, одоо цагт ч шаардлага гарсан тохиолдолд тогтоож болох зүй ёсны дэг юм. Цаг хугацааны хувьд хязгаарлах албагүй ч тодорхой тулгарсан асуудлыг шийдвэрлээд өөрт өгсөн бүрэн эрхийг буцаан хүлээлгэж өгөхөд диктатурын утга учир орших билээ.

Хэдийгээр хаана диктатур үүсэж, хэр удаан оршин тогтнохыг хэлж мэдэхгүй ч диктатур биднээс салшгүй юм. Бас диктатор унахад диктатур устдаг гэвэл эндүүрэл. Аль ч улс оронд диктатур үүсэх эрсдэл бага ч гэсэн байдаг гэж Денверийн их сургуулийн олон улс судлалын тэнхмийн судлаач эрдэмтэн Эрик Ченовет үзсэн байдаг.

Эрх чөлөө, ардчилалыг хүсэх нь хүний байгалийн мөн чанар гэдгийг батлах удирдамж байдаггүй гэж Эроу үзсэн. Амьдралын төвшин өндөр, хүн хүссэнээрээ амьдрах боломжтой байгаа нөхцөл байвал диктатурын үед ч аз жаргалтай байж

болдог. Диктатур нь индивидийн эрх чөлөөг дэг журмаар давамгайлах удирдлагын нэг хэлбэр. Эзроугийн үзэж байгаагаар “зарим нэгэн соёл эрх чөлөөнөөс илүү аюулгүй, тогтвортой байдлыг үнэлдэг” гэжээ.

Абстракт

Диктатура представляется формой осуществления власти, при которой правитель либо управляющая группировка, независимо от властной формы, независимо от формы отношения к власти, реализует собственное управление прямым, директивным путём.

Ном зүй

Шмитт К. Диктатура. От истоков современной идеи суверенитета до пролетарской классовой борьбы. СПб.: «Наука», 2005.

Макиавелли Н. Рассуждения о первой декаде Тита Ливия. Книга I. Глава XXXIV .

Руссо Ж.-Ж. Об Общественном договоре, Принципы политического права.

Шмитт К. Диктатура: от истоков современной идеи суверенитета до пролетарской классовой борьбы /Пер.с нем. Ю.Ю.Коринца; под ред. Д.В.Скляднева.СПб.: [Наука](#), 2006.

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ц.Ганболд

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор

Ц.Бямбачулуун

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй

Нутгийн өөрөө удирдах ёсны талаарх ойлголт, үүсэл, хөгжил, үзэл санаа, эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлалын талаар дурьдсан.

Түлхүүр үг: Муниципалитет, өөрөө удирдах ёсны тухай институци, онол, үзэл баримтлал, төрийн байгуулалт.

Нутгийн өөрөө удирдах ёсны талаарх үзэл баримтлалын үүсэл, хөгжил.

Өөрөө удирдах ёсны онолын үзэл баримтлал нь хүн төрөлхтний хувьд он удаан жилийн түүхтэй юм. Нутгийн өөрөө удирдах ёсны үзэл санаа нь XVIII зууны сүүлч XIX зууны эхээр баруун Европын улс орнууд болон Америкт анх үүсчээ. Францын хувьсгалын (1789) үед төртэй харилцах нэгжийн бие даасан байдлыг илэрхийлэх, нөгөө талаар нутгийн өөрийгөө удирдахтай холбон “Өөрөө захирах” хэмээх ойлголтыг хэрэглэх болжээ. Пруссийн сайд Хенрих Фридрих Карл вон Штейн (1757-1831) хагаран бутрах аюул нүүрлэж байсан тухайн үед Пруссийн иргэдийн нийгмийн эрмэлзлийг дэмжиж, герман үндэстнийг нэгтгэхэд олон жижиг ванлигуудын бие даасан эрхийг хүлээн зөвшөөрөх зорилгоор уг үзэл баримтлалыг боловсруулжээ. Энэ үзлээ 1808 оны “Пруссийн хотын журам”-д тусгасан бөгөөд, хожим нь Пруссийн ерөнхий сайд Отто фон Бисмарк энэ үзлийн дор германыг тайван замаар нэгтгэжээ¹.

Хожим Америкийн засаг төрийн тогтолцооны суурь болсон “Тусгаар тогтнолын тунхаг”-ийн (1776) зохиогчдын нэг, Холбооны Үндсэн хууль боловсруулсан төлөөлөгчдийн нэг болох Томас Джефферсон нутгийн удирдлагыг хүнд байгалиас заяасан үндсэн эрх хэмээн үзэж, улс орон даяар хөгжүүлэхийг уриалж байсан байдаг².

Нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндсийг боловсруулахад Д.Морган, А.Токвиль, Л.Штейн, Р.Гнейст нарын зэрэг эрдэмтэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж

¹ Баттогтох Б. Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. УБ., 2018. тал 350

² ШУТИС Төрийн удирдлага. Хамтын бүтээл. УБ., 2019. тал 146

үздэг³. А.Токвель өөрийн бүтээлдээ “Засаглалын анхдагч үндэс нь төр улс, тэр ч байтугай ард түмэн биш, харин өөрсдийн хувийн хэргийг өөрсдөө зохицуулж, сайн дурын үндсэн дээр нэгдсэн бие хүмүүс мөн” хэмээн тэмдэглэж байв⁴.

Германы төрийн зүтгэлтэн Пруссин сайд Барон Фон Штейн (1757-1831) нь 1808 оны 11 сарын 19-нд “Хотын дүрэм” баталсан нь хотын өөрөө удирдах эрхийг хүлээн зөвшөөрсөн анхны эхлэл болж түүхэнд үлджээ⁵. Түүний энэ реформын гол агуулга нь хотын өөрөө удирдах ёсыг шинээр төлөвшүүлэн тогтоох тухай үзэл санаа байсан бөгөөд “Өөрөө удирдах ёсыг иргэд орон нутгийн түвшинд төрийн удирдлагын хэрэгт оролцох хэлбэр” гэж үзжээ. Штейн нэгэн илтгэлдээ: “Орон нутгийн хэмжээнд шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх бодлогыг төрийн байгууллагаас тусдаа нутгийн бие даасан иргэдийн удирдлага, түүний субъект хариуцах ёстой. Энэ нь төрийн үүрэг, ачааллыг зохицуулахад томоохон түлхэц болно⁶” хэмээн дурьдсан байдаг. Штейний энэхүү үзэл санаа тухайн үедээ бүрэн төгс хэрэгжиж чадаагүй ч, хожим энэ ойлголт либерализмын нөлөөгөөр иргэдийн хувийн эрх, эрх чөлөөний агуулгаар хүрээгээ тэлж өргөн хүрээнд хэрэглэгдэх болжээ.

Ф.Л.Кнемайер үзэхдээ “...Нутгийн өөрөө удирдах ёс гэдгийг тодорхойлохын тулд юуны өмнө төрийн харьяаллын нутаг дэвсгэрийн нэгж дэх нутгийн бие даасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн боломж статус гэдгийг нь хүлээн зөвшөөрөх ёстой” гэсэн⁷ бол Америкийн эрдэмтэн В.Рожер “...Нутгийн өөрийн удирдлага гэдэг нь ...гадны ямар нэгэн нөлөө хяналтаас чөлөөтэй байж хэрэгжүүлдэг, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн бие даасан тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлэгч субъект...” гэж тэмдэглэжээ⁸.

Нутгийн удирдлагын тухай Европын Дүрмийн 3-р зүйлд: Нутгийн өөрөө удирдах ёс (Local self-governance) нь орон нутгийн эрх барих байгууллагаас төрийн хэргийн үлэмж хэсгийг хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд, өөрийн хариуцлага дор, орон нутгийн хүн амын ашиг сонирхолд нийцүүлэн зохицуулах болон удирдах эрх, чадварыг илэрхийлнэ (“Нутгийн өөрөө удирдах ёсны үзэл баримтлал” Европын зөвлөл, Страсбург, 1985)⁹ хэмээ тодорхойлсон байдаг.

Нутгийн удирдлага гэдэг нь төвийн удирдлагаас ангид орон нутгийн төвшний удирдлагыг хэлэх бөгөөд энэ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зорилго, өөрөө удирдах ёсыг захиргааны удирдлагын арга барилтай зөв хослох чиг үүргийг хэрэгжүүлэхэд олон түмэн оролцох боломжтой, гадны ямар нэгэн нөлөө, хяналтаас чөлөөтэй байж тэдгээрийн тодорхой засаглах бүрэн эрхийн тухай асуудал юм¹⁰. Тухайлбал, “Нутгийн удирдлага” гэдэг ойлголт: 1. Нутгийн өөрөө

³ Шарбанди Б. Удирдахуй ба нутгийн удирдлагын зарим асуудалд. УБ., 2010. тал 49

⁴ МУЗГ “Монгол улсад нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь” МНУХолбоо. УБ., 2003. тал 19

⁵ Төмөр С. Монгол улсын үндсэн хуулийн эрх зүй: Нутгийн өөрөө удирдах ёс онол, туршлага, хэтийн төлөв. УБ., 2004. тал 27

⁶ Heinrich Scholler, Hans Stimpfl. Kommunale selbstverwaltung Munchen. 1995.S.17-18.ff

⁷ Кнемайер Ф.Л. Организация местного самоуправления в Баварий Государство и право М. 1995 №4 стр.

⁸ Roger H. Wels Amerikan Local Government. Mc. Graw.-Hill 1939 p. 4-5

⁹ Даваадулам Ц. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. УБ., 2010. тал 59

¹⁰ Roger H.Wells: American Local Government. New York. 1939. Pp 1-4

удирдах ёсны, 2. Нутгийн захиргааны /гүйцэтгэх/ байгууллагын удирдлага гэсэн хэсгээс бүрдэнэ¹¹.

Орон нутгийн удирдлага ба Муниципалитет.

Орон нутгийн захиргаа хэмээх нэр томьёо нь (Местные власти, local government)¹², (local government буюу орон нутгийн засаг захиргаа)¹³ гэх зэргээр дэлхийн улс орнуудад янз бүрээр нэрлэгдэж иржээ. Орчин үеийн ардчилсан засаглалтай улс орнуудад Нутгийн өөрөө удирдах ёсны агуулгыг шингээсэн “Орон нутгийн удирдлага” гэсэн нэр томьёог өргөн хэрэглэдэг. Харин муниципалитет¹⁴ бол зөвхөн хотын иргэдийн өөрөө удирдах ёсыг илэрхийлэх нэр томьёо бөгөөд хотын удирдлага (Urban government)¹⁵ нь хөдөө орон нутгаас илүү нарийн төвөгтэй олон зохицуулалттай байдгаас улбаалан энэ нэр томьёог Европт хэрэглэсээр ирсэн байна. Л.А.Велихов “Хотын аж ахуйн үндсүүд” (1978 он) бүтээлдээ “Minis гэдэг нь латиний “тяжесть, тягота, бремя, cargo, geririo-беру, принимаю” гэсэн утгатай үг юм. Ингэхлээр “Муниципалитет” гэдэг бол нийгмийн болон аж ахуйн зорилтыг төрөөс зөвшөөрсөн хүрээнд өөрийн хөрөнгө, эдийн засгийн зохих хүчин зүйлс, төр засгийн дэмжлэгт тулгуурлан хэрэгжүүлэх удирдлага юм” хэмээн тодорхойлсон.

Дэлхий нийтийн ерөнхий жишгээс харахад “муниципалитетийн удирдлага”-ыг нутгийн өөрөө удирдах ёс, төрийн удирдлагын нэгдлийг өргөн утгаар, харин зөвхөн нутгийн өөрөө удирдах ёс, эсвэл зөвхөн нутаг дэвсгэрийн тодорхой нэг нэгж, жишээлбэл, “Хотын удирдлага” гэсэн явцуу хоёр утгаараа хэрэглэдэг байна. Гэхдээ зарим улсад жишээ нь, АНУ-д муниципалитетийн удирдлагад зөвхөн хотын удирдлагыг хамааруулж ойлгодог бөгөөд, муниципалитетийн удирдлага нь үйл ажиллааныхаа үндсэн арга, хэлбэрийг Үндсэн хуульд нийцүүлэн өөрөө журамлан тохируулж тогтоодог. Энэхүү хэлбэрийг сүүлийн үед “Муниципалитетийн эрх зүй” буюу “Нутгийн өөрөө удирдах ёсны эрх зүй” гэж томъёолох болжээ¹⁶.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага (Local selfgoverninig bodies, местные самоуправляющиеся органы)¹⁷ нь төрийн байгуулалтын хувьд холбооны (federal, федеральное)¹⁸ болон нэгдмэл (unitary state, унитарное государство)¹⁹ байгууламжтай улс орнуудад адил түвшинд хэрэглэгдэх боловч, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын дээд эрх мэдлийн түвшинд л ялгаа нь ажиглагддаг. *Холбооны төрийн байгууламжтай улсууд* нь үндэстний ба газар нутгийн холбооны

¹¹ Төмөр С. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. Нутгийн өөрөө удирдах ёс: онол, туршлага, хэтийн төлөв. УБ., 2004. Дөтгөөр дэвтэр. тал 8

¹² Довчин Ё. Улс төрийн үг хэллэг нэр томьёоны толь. УБ., 2005. тал 132

¹³ Баттогтох Б. Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. УБ., 2018. тал 346

¹⁴Муниципалитет **англиар municipality**, латинаар municipium гэж нэрлэдэг байна. Энэ нь зөвхөн хотуудын удирдлагыг хэлнэ. 1789 оны 12 дугаар сарын 14-нд Муниципалитетийн статусын тухай хуулийг баталсан. Энэхүү хуулиар нутаг дэвсгэрийн бүх нэгжийг communes гэж нэрлэн нэг адил статустай, адил нутаг дэвсгэртэй байхаар тооцож зохицуулсан байдаг.

Бямбачулуун Ц., Пүрэвсүрэн Ц. “Нийгмийн шинжлэх ухааны ойлголт, нэр томьёоны тайлбар толь”. УБ., 2008. тал 216

¹⁵ Салватор Шиава-Кампо ба Пачампет Сундарам Иргэддээ үйлчилж, төрт ёсны үнэт зүйлсээ хадгалах: Өрсөлдөөнт Ертөнцөд Төрийн Захиргааг Сайжруулах нь. УБ., 2011. I дэвтэр. Орч. Ц.Даваадулам, Ган.Батбаяр. тал 153

¹⁶ Төмөр С. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. Нутгийн өөрөө удирдах ёс: онол, туршлага, хэтийн төлөв. УБ., 2004. Дөтгөөр дэвтэр. тал 17-18

¹⁷ Довчин Ё. Улс төрийн үг хэллэг нэр томьёоны толь. УБ., 2005. тал 132, 324

¹⁸ Дурьдсан бүтээл. тал 84

¹⁹ Дурьдсан бүтээл. тал 247

улс гэсэн хоёр хэлбэрт хуваагддаг. Тухайлбал, ОХУ, Нигер, Энэтхэг зэрэг улсууд үндэстний холбооны улсад хамаарагддаг бол; АНУ, Герман, Швейцар зэрэг улсууд газар нутгийн холбооны улсад хамаарагдана²⁰. Эдгээр улсуудад холбооны төв засаглалыг хүлээн зөвшөөрч захирагддаг ч бие даасан үндэстний болон газар нутгийн бүсчлэлээр хязгаарлагдсан муж улсын засгийн газар оршдог.

Нэгдмэл төрийн байгууламжтай улсуудад орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ажилладаг боловч улс төрийн бие даасан засаглал бүхий засгийн газар байдаггүй бөгөөд зөвхөн төв засгийн газартаа захирагдан ажилладаг. Нэгдмэл төрийн байгууламжтай улсуудыг энгийн нэгдмэл, нийлмэл нэгдмэл гэж хоёр ангилдаг. Энгийн нэгдмэл улсад ихэнх иргэд нь нэг үндэстнээс бүрдсэн, газар нутгийн хувьд салшгүй нэгдмэл түүхэн уламжлалтай улсууд ордог. Тухайлбал, Монгол, Япон, Итали гэх мэт. Харин нийлмэл нэгдмэл улсуудын жишээ нь олон үндэстнээс бүрдсэн Хятад, газар нутгийн хувьд нийлмэл Франц, Их Британи зэрэг болно²¹.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны үндсэн ойлголтууд.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны бас нэгэн гол ухагдахуун нь оросоор община, англиар community бөгөөд ард иргэдийн коммунити нь төрөөс хараат бус иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгад тулгуурласан иргэний байгуулал юм. Коммунити хэмээх үг нь хэрэглэгдэж буй байдлаасаа хамааран дараах утга санааг өөртөө агуулж байдаг. Үүнд:

- Газар зүйн байршлаараа нэгдсэн хүмүүс: Хот айлууд, нутаг усныхан, хотынхон
- Хамтын эзэмшил: Сууц өмчлөгчид, нэг хорооллынхон
- Нийтлэг эрх ашиг, нэгэн зорилгын төлөө ажиллаж буй бүлэг: Төрийн бус байгууллагууд, нэг шашин шүтлэг
- Нутаг дэвсгэр, засаг захиргаагаар нэгдсэн оршин суугчид: Баг, хороо, сум, дүүрэг, хот, тосгон²².

Нутгийн өөрөө удирдах ёсны талаарх монгол эрдэмтдийн үзэл баримтлал.

Б.Чимид: “...Хураангуйлж авч үзвэл өөрөө удирдах ёс гэдэг нь тухайн нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага хамт олны дотоод амьдралын асуудал, хэргийг тэндхийн иргэд, хамт олон шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан бие даан шийдвэрлэж, эрхлэн хөтлөх, хариуцах ёс, баталгаа бүхий чадавхи мөн...”²³ бөгөөд “Нутгийн өөрөө удирдах ёс бол орон нутгийн хүн амын хамтын нийгэмлэг нь ардчилсан төр-нийгмийн байгууллын нэг үндсэн бүрдүүлбэр байж, иргэдээс засгийн эрхийг барилцаж, нийгмийн хэргийг удирдахад оролцох улс төрийн суурь эрхээ хэрэгжүүлдэг гол боломж юм²⁴” гэжээ. Тэрээр Хууль зүйн утгаараа өөрөө удирдах ёс нь:

- Өөрсдийн асуудлаа өөрсдөө хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх
- Тэрхүү шийдвэр нь тэдний орших нутаг дэвсгэрт заавал биелэгдэх

²⁰ Баттогтох Б. Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. УБ., 2018. тал 347

²¹ Дурьдсан бүтээл. тал 347

²² <https://en.oxforddictionaries.com/definition/community> эх сурвалжаас, Баттогтох Б. Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. УБ., 2018. тал 347

²³ Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал. Тохимол П. УБ., 2000. тал 20

²⁴ Чимид Б. Монгол Улсын Үндсэн хуулийн мэдлэг, УБ., 2008. тал 365

хүчинтэй байх

- Тийнхүү шийдвэрлэх хэрэгжүүлэхдээ гаднын (төрийн) нөлөө дарамтад автахааргүй бөгөөд хэрэгжих баталгаатай байх зэрэг гол шинжтэй байдаг²⁵” гэж дурьдсан байна.

С.Төмөр “... хүн амаас орон нутгийн шинжтэй асуудлыг бие даан, гэхдээ хариуцлагаа өөрөө хүлээж шийдэх, орон нутгийн өмчийг өөрөө захиран зарцуулах явдал мөн.” бөгөөд “...Үндсэн хуульт байгууллагын үндэс суурь, шууд ардчиллын үндсэн институт төдийгүй түүхэн болон нутгийн уламжлалт заншлыг харгалзан нутгийн амьдралын асуудлаа бие даан шийдвэрлэх нөхцлийг хангадаг нутгийн нэгж дэх хамт олны (иргэд, хүн амын) зохион байгуулалтын хэлбэрүүдийн тогтолцоо болдгоороо онцлогтой юм” гэж тэмдэглэжээ²⁶.

Д.Ганзориг “Нутгийн өөрөө удирдах ёс бол ...тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн ашиг сонирхлын илэрхийлэл, тэдний бие даасан субъект хэрэгжүүлдэг, тэдгээрээс явуулж буй үйл ажиллагаа нь төрийн бус, харин түүний тодорхой хэсэг (энэхүү хэсгийг төр нь нутгийн өөрөө удирдах байгууллагад хуулиар шилжүүлнэ) төрийн ба нутгийн ашиг сонирхлууд нь бие даасан байдлаар зэрэгцэн оршиж, мөн хоорондоо уялдаатай байж болно”²⁷ хэмээн үзсэн. М.Сандаг-Очир Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагыг зарим шинжүүдээр ялган тодорхойлж орон нутгийн бүх асуудлыг бие даан шийдвэрлэх, төрийн удирдлагаас тусдаа байх зэргийг авч үзжээ.

2001 оны 11 сарын 9-ний өдөр Монголын нутгийн удирдлагын II их хурлаар Нутгийн өөрөө удирдах ёсны Монгол улсын тунхаг бичгийг сайшаан баталсан ба энэ нь орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын Олон улсын холбооны 31 дүгээр бага хурлаас Торонто хотноо 1993 онд баталсан “Нутгийн өөрөө удирдах ёсны олон улсын тунхаг”-ийн үзэл санааг дэмжсэн байдаг. Уг баримт бичгийн 3-р зүйлд “Нутаг дэвсгэрийн аливаа нэгжид оршин суугчид өөрсдийн амьдрал аж ахуйд хамаарах бүхий л асуудлыг ардчилсан шууд, нууц, тэгш, тогтмол хугацааны, бүх нийтийг хамарсан сонгуулиар сонгон байгуулсан төлөөллийн байгууллаараа дамжуулан өөрсдийн итгэл үнэмшил, нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн хөрөнгө мөнгөнийхөө хэмжээнд, хууль тогтоох дээд байгууллагаас батлан гаргасан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн зохицуулах эрх мэдлийг нутгийн өөрөө удирдах ёс хэмээнэ” гэж тодорхойлжээ²⁸.

Дээрх тодорхойлолтуудаас үзэхэд нутгийн өөрөө удирдах ёс нь дараах үндсэн шинжүүдтэй байна. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах ёс бол жам ёсны эрх зүйн үнэт зүйлс төдийгүй ардчилсан Үндсэн хуульт ёсны чухал илэрхийлэл мөн.
- Нутгийн иргэдийн эрхийг хамгаалсан нутаг дэвсгэрийн бие даасан зохион байгуулалтын дээд хэлбэр мөн.

²⁵ Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал. Тохимол II. УБ., 2000. тал 20

²⁶ Төмөр С. Монгол улсын үндсэн хуулийн эрх зүй: Нутгийн өөрөө удирдах ёс онол, туршлага, хэтийн төлөв. УБ., 2004. тал 16

²⁷ Д.Ганзориг. Нутгийн өөрөө удирдах ёсны онол, практикийн зарим асуудалд. “Эрх зүй” сэтгүүл. УБ., 2001. № 6-7. тал 86

²⁸ Тунгалаг О. Иргэдийн төлөөлөгчдийн хурал-түүнтэй холбоотой зарим асуудлууд. УБ., 2012. тал 11

- Орон нутгийн байгууллагын өөрт нь хамаарах асуудлуудыг тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид, иргэдийн сайн сайхны төлөө зохицуулан хэрэгжүүлэх эрх, чадварыг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад хадгалах.
- Нутгийн өөрөө удирдах байгууллага бол нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлогч, шийдвэр гаргач, хяналт хэрэгжүүлэгч байгууллага мөн.
- Энэхүү эрхийг чөлөөтэй, нууц, тэгш, шууд, бүх нийтийн сонгуулиар сонгогдсон гишүүдээс бүрдсэн, өөрсдийн өмнө хариуцлага хүлээх гүйцэтгэх байгууллагатай Зөвлөл буюу Хуралд эдлүүлэх.
- Нутаг дэвсгэрийн байгууллага мөн бөгөөд энэ нь төрийн бус боловч эрх зүйн статусын зарим хосолсон шинжийг өөртөө агуулсан байхыг үгүйсгэх аргагүй юм.
- Эрх зүйн төдийгүй, улс төр, эдийн засаг, соёл, уламжлал, зан заншил зэргийг цогц байдлаар өөртөө агуулсан хэв шинжийг илэрхийлдэг.

Дүгнэлт

Эцэст дүгнэхэд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын тогтолцооны үүсэл хөгжил нь суурин болон нүүдлийн соёл иргэншил оршин тогтсонтой холбоотой байна. Тухайн үедээ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хөгжилд том хувь нэмэр оруулсан гол үйл явдал нь Францад гарсан хувьсгал байжээ. Энэ үед Европын орнуудад ч гэсэн засаглалын шинэ хэлбэр бий болгох зайлшгүй шаардлагыг дэвшүүлэн тавьж байжээ. XIX зуунд нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндсийг А.Токвиль, Ф.Штейн, Р.Гнейст нарын зэрэг эрдэмтэд өөрсдийн бүтээлд тодорхой тусгаж байжээ.

Ардчилсан нийгмийн нэг онцлог нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаа өөрсдөө сонгож, төрийн болон орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан үйл ажиллагаанд оролцдог юм²⁹. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн хамт олны нийгмийн асуудал болон тэдний эрх ашгийг хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэж чаддаг, өөрөө хариуцлагаа үүрэх чадвартай, өөрийн гэсэн өмчтэй, иргэдийн төлөөллийн нөгөө талаас төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага юм.

НӨУЁ-ны тухай Европын Хартийн 3 дугаар зүйл буюу “НӨУЁ-ны ойлголт” гэсэн хэсэгт: “НӨУЁ гэдэг нь нутаг дэвсгэрийн бие даасан хамтлагаас өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн орон нутагт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлагыг хэрэгжүүлэх эрх, бодит чадвар юм” гэжээ.

Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь тухайн орон нутгийн уугуул иргэд, оршин суугчид өөрсдийн нутаг дэвсгэрийн хэмжээний асуудлыг өөрсдөө бие даан хэлэлцэж, шийдвэрлэх, татварын бодлогоор дамжуулж өөрсдийн төсвөө бүрдүүлэх, иргэдийн сонгуулийн байгууллагаар дамжуулж нутгийн удирдлагыг дангаараа буюу төрөөс шилжүүлсэн зарим чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх

²⁹ Бямбачулуун Ц. “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг дээшлүүлэх нь” сэдэвт Баруун бүсийн онол, практикийн бага хурал. НӨУЁ-ны байгууллагын сонгууль. /Эмхэтгэл/. УБ., 2006. тал 301

чадавхи бүхий Үндсэн хуульт ёсны байгууллага, ардчилсан ёсны илэрхийлэл мөн” гэж тодорхойлж болох юм.

Нутгийн өөрөө удирдах ёсыг зөв ойлгож, түүний мөн чанарыг нээн илрүүлснээр тухайн институцийн хөгжлийн онцлог, хандлагыг бодитойгоор авч үзэх, тодорхойлох боломж бүрдэнэ.

Abstract

The concept, origin, development, ideas of local self-government, and the views of scholars and researchers are mentioned.

Ашигласан ном, материал

Батболд Ц. “Нутгийн удирдлагын шинэтгэлийн асуудалд: төвлөрлийг сааруулах нь” Төрийн албан хаагчийн ширээний ном-хамтын бүтээл. УБ., 2017 он

Батболд Ц. “Нутгийн удирдлага дахь сонгууль, томилогоо, эрх мэдлийн хуваарилалт, үүрэг, хариуцлагын тогтолцоо” /Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо: Монгол улсын орон нутгийн бодлогын зөвлөмж. УБ., 2017 он

Батболд Су. “Орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх асуудал”. УБ., 2010 он
Бямбачулуун Ц. “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг дээшлүүлэх нь” сэдэвт Баруун бүсийн онол, практикийн бага хурал. НӨУЁ-ны байгууллагын сонгууль. /Илтгэлийн эмхэтгэл/. УБ., 2006 он

Ганзориг Д. “Нутгийн өөрөө удирдах ёсны онол, практикийн зарим асуудалд” Эрх зүй сэтгүүл. УБ., 2000 он

Чимид, Б. Монгол Улсын Үндсэн хуулийн мэдлэг, УБ., 2008 он

Төмөр, С. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, УБ., 2004 он

Шарбанди Б. Удирдахуй ба нутгийн удирдлагын зарим асуудалд. УБ., 2010 он

Сандаг-Очир М. Нутгийн удирдлага. УБ., 2003 он

Салватор Шиаво-Кампо ба Пачампет Сундарам Иргэддээ үйлчилж, төрт ёсны үнэт зүйлсээ хадгалах: Өрсөлдөөнт Ертөнцөд Төрийн Захиргааг Сайжруулах нь. I дэвтэр. Орч. Ц.Даваадулам, Ган.Батбаяр . УБ., 2011 он

Ширэндэв Д. Монгол улсын нутгийн өөрөө удирдах ёс, түүний эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал. УБ., 2013 он

МУИС Нийтийн удирдлага. УБ., 2018 он

МУШУТИС Төрийн удирдлага. УБ., 2019 он

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж. УБ., 2019 он

Төрийн байгуулал судлал. Монгол дахь Конрад-Аденауэр сан. УБ., 2018 он

Гадаад хэлээр:

Article 38 and 39 “Belgium 1831 (rev.2012)”. Constitute. Retrieved 30 March 2015

А. Токвиль “Демократия в Америке”. Прогресс. М. 1992

В.П.Безобразов Земские учреждения и самоуправления. М. 1874

Государственное и административное устройство Германий- Сб. Международных терминов из области права и управления. Немецко-Русский. Серия Р., Мюнхен-Бонн, 1993

- Локк Ж. Избранные Философские Произведения М. 1960
- Коркунов Н.М. Русское государственное право. Спб., 1909
- Лазеревский Н.И. Самоуправление мелькой земское единицы. Спб.,1903
- Фадеев В.И. Муниципальное право России. М.,Юрист, 1994, с.21
- Европейская Хартия о местном самоуправлений. Международные акты о правах человека. Сборник документов. М. 2000
1. Heinrich Scholler, Hans Stimpfl. Kommumale selbstverwaltung Munchen. 1995
 2. Hill D.M. Democratic Theory and Local Government L. 1974

**ҮНДЭСНИЙ ҮЗЭЛ, ҮНДЭСНИЙ АДИЛСАЛ, ҮНДЭСНИЙ ӨӨРИЙН
УХАМСРЫН ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ**

М.Мөнхзул

ХААИС, Эдийн Засаг Бизнесийн Сургууль

ХААХЭЗТэнхимийн дэд профессор

*Түлхүүр үг: Үндэсний өөрийн ухамсар, үндэсний адилсал, үндэсний мэдрэмж,
угсаатны өөрийн ухамсар*

Судалгааны тойм

Сэтгэл зүй бол ухамсрын анхдагч системчлэгдээгүй хэлбэр юм. Үндэстний сэтгэл зүй нь зан авир, үйл хөдлөлийг тодорхойлж, үндэсний өөрийн ухамсар нь түүнээс нөөцөө олж авдаг. Э.А.Поздняков үндэсний өөрийн ухамсрыг асуудлыг үндэсний төлөв байдалтай харьцуулан авч үзэж, онол сэтгэлгээний хувьд илүү рациональ шинжтэй хэмээн үзэж, улмаар үндэсний өөрийн ухамсрыг үндэсний сэтгэл зүйн “дээд түвшин” нь¹ гэсэн байдаг. Үндэстний өөрийгөө ухамсарлахын хандагч хүчин зүйл нь үндэсний мэдрэмж юм. Өөрөөр хэлбэл үндэсний мэдрэмж иргэн бүрт сууснаар үндэсний өөрийн ухамсар төлөвшинө. Үндэсний сэтгэл зүй, үндэсний мэдрэмж, үндэсний өөрийн ухамсар зэрэг нь системчлэгдээд ирэхээрээ үндэсний үзэл болдог. Үндэсний өөрийн ухамсар нь үндэсний үзлийн нэг бүрэлдэхүүн болох боловч үзэл санааны зарим нэг онцлог нь үндэсний өөрийн ухамсраар илэрнэ. Үндэсний үзэл-Nationalism хэмээх нэр томъёог XVIII зууны үеэс албан ёсоор улс төрийн хэллэгт хэрэглэгдэх болсон гэж үздэг². Үндэсний үзэл гэдэг нь үндэстэн хүн төрөлхтний түүхэнд өөрийн эзлэх байр суурийг зохих түвшинд нь авч үзэх үзэл бөгөөд ийм үзэл аливаа улс үндэстэн бүрт байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн үндэстэн төрөө байгуулж хамгаалан бэхжүүлэх улс төрийн хөтөлбөр гэж ойлгож болох нь. Үндэсний үзэл нь олон хүчин зүйлийн

¹ Поздняков .Э.А. Нация, национализм, национальные интересы. М.,1994. Стр 45

² Болд-эрдэнэ,Д. Үндэсний үзлийн мөн чанар: төөрөгдөл, уг чанар, хүч боломж. Философи эрхийн судлал №29. УБ.,2014. 179 дэх тал

нөлөөгөөр бүрэлдэж бий болох бөгөөд язн бүрийн түүхэн шалтгаан, зүй тогтлоос хамаардаг. Үүнд:

- Газар зүй, байгаль, уур амьсгалын нөхцөл,
- Ахуйн онцлог, материаллаг болон оюун санааны үйл ажиллагааны шинж чанар,
- Нийгэм-улс төрийн түүхийн онцлог зэрэг болно.

Үндэстэн бүхэнд түүний нийгмийн, газар зүйн, угсаатны, хэлний болон бусад онцлогийг тусгасан оюун санааны зүйлүүд байдаг. “Үндэсний өөрийн ухамсар бол үндэсний үзэл болох бөгөөд энэ нь үндэсний адилсал, уламжлал, зан төрх, заншлыг төлөвшүүлдэг”³. Тэгэхлээр үндэсний үзлийн төлөвшил, хөгжилд үндэсний өөрийн ухамсар гол үүрэгтэй гэсэн үг билээ. А.В.Мазуренко “үндэсний үзэл, үндэсний өөрийн ухамсар хоёр нягт холбоотой ойлголт юм. Үндэсний нийгэм-түүхийн нийтлэгийн үр дүнд үндэсний мэдрэмж, сэтгэл зүй, зан заншил, уламжлал гэх мэтийн оюун санааны төрхөөр илэрдэг үндэсний өөрийнх нь тухай төсөөлөл бий болдог бөгөөд үндэсний өөрийн ухамсар нь төсөөллийн үр дүн байдаг”⁴ гэсэн байна. Үндэсний үзлийн онцлог нь үндэсний өөрийн ухамсрыг нэгтгэн дүгнэж үндэсний төрийн анхдагчийн тухай, үндэсний оршихуй, цаашдын чиг хандлагын тухай төсөөллийг илэрхийлдэгт байдаг юм. “Үндэсний өөрийн ухамсрын өөрчлөлт нь үндэстний өөрийн түүхэн ирээдүйн тухай төсөөллийг өөрчлөхөд хүргэнэ”⁵.

Үндэсний эрх ашгаа дээдлэх энэхүү үндэсний үзлээс үндэсний адилсалаа тодорхойлох эх сурвалж бий болно. Үндэсний адилсалыг хөндлөнгөөс нь тогтоохдоо хэл, соёл, гадна төрх зэрэг байдал дээр үндэслэдэг хэдий ч хамгийн чухал нь дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн тусгаар тогтносон үндэстэн байх явдал юм. Учир нь үндэсний адилсал нь хувь хүн аль нэг үндэстэнд харьяалагдах гол хүчин зүйл бөгөөд өөрийгөө адилтгах явдал юм. Үндэсний өөрийн ухамсрын улс төрийн шинж нь хүмүүсийн хувийн чанар, тухайн үндэстэн-ястны, үндэстэн-угсаатны, улс төрийн хамаарлаа ухамсарлах үндэсний адилсалд суурилдаг байна. Үндэсний адилсал, угсаатны адилсал, угсаатны гарал үүсэл зэрэг нь XX зууны дунд үеэс шинжлэх ухаанд нэвтэрсэн цоо шинэ ойлголтууд юм.

Үндэсний үзэл ба үндэсний өөрийн ухамсар нь үндэсний адилсалтай хэрхэн харилцан хамааралтай байхыг судлах нь тэдгээр нийгмийн үзэгдлүүдийн байр суурийг

³ Попов.В.Д. Психология и экономика. М.,1989. Стр 25

⁴ Мазуренко.А.В. Формирование правовой культуры в России. М.,2001. Стр 78

⁵ Рубинштейн.С.Л. Основы общей психологии. М.,1946. Стр 677

тодорхойлох, зарчмыг нь тодорхойлох боломж олгодог. Үндэсний адилсал нь үндэсний өөрийн ухамсрыг одоо байгаа нийгмийн олон категориос ялгаж, байр сууриа олох боломжийг олгодог бөгөөд энэ нь нийгэм, улс төр, эдийн засаг, соёл тэр ч бүү хэл шашны харилцааны илэрхийлэл болдог.

Энэ утгаараа үндэсний эрх ашиг нь үндэсний өөрийн ухамсрын түвшинг тусгасан байдаг бөгөөд энэ нь эдийн засаг, улс төрийн ашиг сонирхлыг ихэвчлэн тусгадаг. Мөн үүнээс гадна үндэстэн өөрийгөө танин мэдэх соёлын түвшинг ч бас тусгадаг. Үндэсний эрх ашиг бол үндэсний өөрийн ухамсрын инструменталь илэрхийлэл юм. Хэрэв үндэсний өөрийн ухамсар нь үндэсний төр улсын төлөв байдлын тусгал бол үндэсний эрх ашиг нь үндэсний өөрийн ухамсрыг нийгэмшилт болгох хэрэгсэл юм. Хэрэв үндэстэн өөрийгөө ухамсарлах нь бүтцийн тусгал юм бол үндэсний эрх ашиг нь түүний чиг үүргийн тусгал юм.

Үндэсний өөрийн ухамсрын бас нэгэн чухал зүйл нь үндэсний үзэл болдог бөгөөд үндэстний эв нэгдлийг бэхжүүлэгч хүчин зүйл нь болдог. Үндэсний үзэл нь үндэсний өөрийн ухамсрын тогтвортой, нэгдмэл байдлыг илэрхийлдэг бол үндэсний эрх ашиг нь үндэсний өөрийн ухамсрын динамик өөрчлөлтийг илэрхийлдэг⁶.

Үндэсний үзэл ба үндэсний эрх ашиг бол үндэсний өөрийн ухамсрын үйл ажиллагааны багаж хэрэгсэл нь болдог. Үндэсний өөрийн ухамсар нь үндэсний үзлийн үйл ажиллагаа, үндэсний эрх ашгийн өөрчлөлтийн үр дүн гэж хэлж болно. Үндэсний үзэл, үндэсний эрх ашгийг бий болгогч субъектүүд бол үндэсний өөрийн ухамсрыг өдөөгч улс төр, оюуны элитүүд билээ.

Үндэсний эрх ашгийг хувь хүний эрх ашгаас ялгаж салгах нь инструменталь эсвэл субъектив хандлага юм. Нийгмийн ашиг сонирхлын гол байр суурийг үндэсний эрх ашиг голлож байдаг нь инструментализмын орон зайтай холбоотой. Энэ бол үндэстэн өөрийгөө танин мэдэх арга хэрэгсэл бөгөөд конструктивизм нь үндэсний үзлийг илэрхийлдэг. Үндэстэн өөрийгөө ухамсарлах нь үндэсний үзэл, үндэсний эх оронч үзлийн нийлмэл бөгөөд энэ нь нийгмийн төлөв байдлын ерөнхий үзүүлэлт байдаг гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Угсаатны болон иргэний үндсэрхэг үзэл нь нийгмийн тусгал юм. Үндэсний өөрийн ухамсрын ухамсарлагдаагүй хэлбэр нь үндсэрхэг үзэл, иргэний үндэсний үзэл

⁶ Gellner.E. Nations and nationalism. Oxford.,1993 p 98

нь эх оронч ухамсрыг илэрхийлдэг бөгөөд эдгээрийн нийлмэл нь үндэсний өөрийн ухамсар юм.

Үндэсний үзэл нийгмийн хөгжилд биеллээ олж байгаа нь үндэсний өөрийн ухамсар нэмэгдсэний үр дүн боловч үндэсний үзлийн тархалт нь үндэсний өөрийн ухамсрын зөвхөн параметрийн хэсгийг л илэрхийлдэг. Тиймээс үндэсний өөрийн ухамсар нь үндэсний үзлийг үнэмлэхүй шинжтэй болгодог хэдий ч түүний мөн чанарыг бүрэн дүүрэн таних боломжгүй. Энэ байдлаас үзэхэд үндсэрхэг үзэл нь хүмүүсийн примордиаль түвшинд үзэл суртлын үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг. Зарчмын хувьд үндсэрхэг үзэл нь примордиализмтай холбоотой бол үндэсний үзэл нь инструментализмтай холбоотой, үүний туйлын илрэл нь либераль үзэл юм.

Улс төрийн шинжлэх ухаанд үндэсний төр улсын оршин тогтнох, хөгжихтэй холбоотой нэлээд олон онол байдаг. Эдгээр онолуудад төр улсын хөгжил нь түүнийг тодорхойлдог хүчин зүйлүүд дээр тулгуурладаг тухай илүүтэй түлхүү байдаг. Судлаачдын дунд үндэсний адилсалын талаар арай өөр байр суурьтай байдаг нь: Кристиан Вельцель⁷, С.Хантингтон⁸, Ортега и Гассет⁹, Френсис Фукаяма, А.Смит¹⁰, Русанна Габер¹¹, Дуглас В.Блум¹², К.Гаджиев¹³ нар юм.

Үндэсний адилсал нь улс төрийн онцлог, эзэнт гүрэн, улс төрийн соёл, иргэншил, эх оронч үзэл зэргийг хэсэгчлэн хамарсан олон хэмжээст түүхэн ойлголт юм. Үүнийг ойлгохын тулд үндэстэн өөрийгөө танин мэдэх хэрэгтэй. Үндэсний адилсал нь нийгмийн бүрэн бүтэн байдал, төрийн оршихуйн асуудалтай шууд холбоотой. Хүмүүсийг нийтлэг соёл, түүх, газар нутаг, хуувь тогтоомжууд нэгтгэдэг. Эдгээр нь хүмүүсийн бэлгэдлийг бэхжүүлдэг. Аливаа улс үндэстний хүмүүс бүгд бие биенийгээ танихгүй, магадгүй бүх газар нутгаараа явж үзээгүй ч гэсэн бэлгэдлээрээ төр улсынхаа дүр төрхийг төсөөлдөг.

⁷ Инглхарт Р., Вельцель К. Модернизация, культурные изменения и демократия: последовательность человеческого развития. М. : Новое издательство, 2011.

⁸ Хантингтон С. Кто мы? Вызовы американской национальной идентичности. МОСКВА, 2008.

⁹ Ортега-и-Гассет, Х. Восстание масс. Дегуманизация искусства. Бесхребетная Испания МОСКВА, 2008.

¹⁰ Smith, Anthony D. National Identity. Penguin Books, 1991.

¹¹ Gaber, Rusanna. National Identity and Democratic Consolidation in Central and Eastern Europe // International Journal of Sociology. 2006. Vol. 36. № 3

¹² Blum, Douglas W. National Identity and Globalization Youth, State, and Society in Post-Soviet Eurasia. Cambridge University Press, 2007

¹³ Гаджиев К.С. Национальная идентичность: концептуальный аспект // Вопросы философии. 2011. № 10.

Үндэсний ашиг сонирхол, үндэсний адилсал нь хүмүүсийн дүр төрх, ёс зүйн хэм хэмжээтэй нь холбоотой байдаг. Учир нь нийтлэг газар дээр амьдарч буй хүмүүсийн шашин, үнэт зүйл, хэл нь бие биетэйгээ адилсах шалтгаан нь болдог. Цаашлаад энэ нь үндэсний төрийн уялдаа холбоог бий болгодог байна. Ийм үйл явц нь хүмүүсийн соёлын олон янз байдал, газар нутаг, засаг захиргааны сул байдлаас шалтгаалан өөр өөрөөр явагддаг. Энэ шинж чанараас улбаалаад үндэстнээс давсан эзэнт гүрэн байгуулагдах буюу үндэстнийг нэгтгэх үйл явц эхэлдэг байна. Олон янзын угсаатны соёлоос үндэсний адилсал бий болж эзэнт гүрний бэлгэдэл бий болдог. Тиймээс Наполеон Бонапартын дайны үеэр Францын эзэнт гүрэн бий болсон байна. Мөн Английн үндэсний төр бий болсноор Их Британи даяар үндэстэн дамнасан далайн шинж чанартай үндэстэн бий болсон.

Ер нь дайн байлдааны нөлөөн дор үндэстэн, эзэнт гүрнүүд бүрэлдэн бий болсон байдаг. Тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөөх тулалдаан нь “төрөлх газар нутаг”-тай нь холбоотой. Энэ нь дайнд ялахаас илүүтэйгүүр юу юунаас илүү эх оронч үзлийг бий болгосон байна. Үндэсний адилсал бол хүмүүсийг нэгэн үнэт зүйлд нэгтгэж нийгмийн бүрэн бүтэн байдал, төрийн тогтвортой байдлыг баталгаажуулдаг. Олон түмний хувьд үндэсний баатар, агуу удирдагчаараа дамжуулан “Бид хэн бэ?”, “Бид хаанаас эхлэлтэй вэ?” хэмээх асуултууд гарч ирж энэ нь үндэсний түүхийг бүтээдэг байна¹⁴. Үндэсний гарал үүслээ хайж, эх түүхээ бүтээх нь улс үндэсний адилсал бүрэлдэхийн томоохон нөхцөл юм. Үндэсний адилсал нь нийгэм, улс төрийн бодлогыг тодорхойлж, үндэстэн өөрийгөө танин мэдэх зорилгыг бий болгож байх ёстой. Үндэсний адилсалын шинж чанарын бүрдэл нь дараах агуулгыг илэрхийлдэг.

1. Нийгэм-үндэсний (хэл, соёл, эдийн засаг, өдөр тутмын үйл ажиллагаа)
2. Улс төрийн-үндэсний (төрийн эрх мэдэл, төрийн байгууллагууд, хил, арми, төрийн тэргүүн, төрийн харяалал, сүр сүлд)

Дээрх хоёр бүрэлдэхүүн нь үндэсний адилсалыг тодорхойлдог байна.

Үндэсний адилсал бол зөвхөн архив, уламжлал, нутагшилт төдийгүй олон түмнийг орчин үеийн ертөнцөд нэгтгэх арга хэрэгсэл юм. Тийм учраас үндэсний адилсалыг шинжилж, үнэлэх, цаашлаад даяаршлын үйл явц дахь үндэсний адилсалыг судлах шаардлагатай байгаа. Даяаршлын нөхцөлд үндэсний адилсал үүсэх нь нэг талаас

¹⁴ Хантингтон С. Кто мы? Вызовы американской национальной идентичности. М.: АСИ, 2004. С. 558.

тусгаар тогтнол, бусад үндэстэн-угсаатнуудаас хол байх, үндэсний нэгдмэл “Би”-гээ хайх, нөгөө талаас даяаршсан нийгэмд өөрийн байр сууриа илэрхийлэх өрсөлдөөнд оролцох замаар тодорхойлогддог.

Орчин үед үндэсний адилсал нь үндэстэн болж байна. Хэдий тийм боловч үндэсний адилсалыг тодорхойлдог хэлбэрүүд нь холбоотой байсаар байна. Тиймээс даяаршлын нөхцөлд үндэсний адилсал нь субьектив хүчин зүйлсийн ялгарал, хуваагдал, нэгдлийн системтэй үйл явц болдог. Үндэсний адилсалын үйл явц дахь нарийн төвөгтэй байдал нь соёлын олон талт байдал, бэлгэдэл нийгэм, улс төрийг бодит байдалд нийцүүлэхэд оршино. Тиймээс өнөөгийн даяаршсан ертөнцөд үндэсний адилсалыг судлах нь нийгэм-танин мэдэхүйн болоод онол арга зүйн ач холбогдолтой. Учир нь үүнийг социологийн бие даасан томоохон судалгаа, хэлэлцүүлэгтэй адил томъёолж болно.

Үндэсний адилсал нь олон талт шинж чанартай бөгөөд үүнийг хэзээ ч нэг бүрдэл хэсэгт оруулж үзэж болдоггүй. Үндэсний адилсалыг бий болгож бүрдүүлэх үйл явц нь мөн чанарын хувьд субьектив тул цаг хугацааны явцад байнга өөрчлөгдөн хувьсаж байдаг. Орчин үеийн шинжлэх ухаан болон олон нийтийн цахим ертөнцөд “үндэсний асуудлууд” дахин сөхөгдөж байна. Энэ нь дэлхийн интеграцилах үйл явцтай холбоотой. Дэлхийн соёл, эдийн засгийн нөлөөн дор үндэстнүүд бүрмөсөн алга болох, эсвэл өөр шинэ шинж чанаруудыг олж авч байгаа өнөөгийн нөхцөлд үндэсний төр улсыг ойлгох зөрчилтэй үзлүүд ч мөн бий болж байна.

Примордаль хандлагын үүднээс үндэсний адилсалыг хүмүүсийн субьектив үзэл бодлоос үл хамааран тодорхой объектив шинж чанарууд дээр тулгуурлан танин мэдэх боломжтой. Үндэсний адилсалын хамгийн эхний анхан шат нь хувь хүмүүстэй харилцах ухамсартай харилцаатай уялдаатай бөгөөд үүний үр дүнд үндэсний өөрийгөө ухамсарлах мэдрэмж, туршлага бий болно. Үндэсний харъяаллыг дараах хэмжээсээр тодорхойлно. Нэгдүгээрт, үндэсний төрийн бүрэн бүтэн байдлыг илэрхийлсэн объектив бэлгэдэл. Хоёрдугаарт, хувь хүний субьектив хандлага, үнэт зүйлсийн чиг хандлагад тулгуурлан ухамсартайгаар танин мэдэх. Хувь хүн бүр өөрийгөө үндэстний соёлын нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрөхдөө нэгдүгээрт бодитой, хоёрдугаарт, субьектив байдлаар ханддаг. Судлаачид үндэсний адилсалын хоёр төрлийг ялгаж өөр өөрөөр нэрлэдэг. Үүнд: иргэний ба угсаатны, улс төрийн ба соёлын, либераль ба интеграцийн, органик ба ид шидийн, нутаг дэвсгэрийн ба угсаатны гэх мэт. Энэхүү хос тус бүрийн эхнийх нь сайн, хоёр дахийг нь муу гэж тооцдог байна.

Судалгааны явцад угсаатны бүлэгт хамаарах гол хүчин зүйлийг нэрлэхдээ: энэ нь хүний тухайн үндэстэнд харьяалагдах хүсэл эрмэлзэл буюу өөрийгөө бүлгийн гишүүн гэдгээ тодорхойлох явдал юм. Үндэсний адилсалыг гаднаас нь тодорхойлохдоо ихэвчлэн хэл, гадаад төрх зэрэг шинж тэмдгүүд дээр үндэслэдэг. Харин гарал үүсэл бол хоёрдогч нөхцөл юм. Бүлэг нь гишүүдийнхээ харилцан үйл ажиллагаа, хоорондын харилцааг зохицуулагч зарим төрлийн нийгмийн байгууллага байх ёстой. Тиймээс үндэсний адилсал нь үзэл баримтлал, үзэл бодол, нийгэм угсаатны организм болох олон нийтийн харилцааг багтаадаг. Ерөнхийдөө үндэсний адилсалын тухай үзэл баримтлалыг системтэйгээр хөгжүүлэх нь үндэстэн түүний үүсэл, цаашдын хөгжлийн тухай нийгмийн санаа бодлыг өргөжүүлэх юм. Энэ талаар логик дүгнэлт хийх нь илүү тохиромжтой.

Э.Гидденс үндэстэн, үндэсний үзэл, үндэсний төр улсын тухай асуудлыг нэлээд хөндөж тавьдаг. Түүний үзлээр “үндэсний үзэл, үндсэрхэг хүсэл эрмэлзэл, дайчин зан үйлүүд нь гол төлөв мөргөлдөөний шалтгаан болдог тул үндэсний мэдрэмж ба адилсал нь бүтээлч байж чаддаггүй. Үнэн хэрэгтээ үндэстэн нь нийгмийн хувьсах хамгийн чухал үүргийг гүйцэтгэдэг”¹⁵.

Угсаатны өөрийн ухамсар нь үндэсний адилсалд тулгуурлаж үндэсний өөрийн ухамсрыг үүсгэж бүрдүүлэх үйл явц болсноор үндэстэн оршин тогтнох, хөгжих чухал нөхцөл болдог байна. Үндэсний адилсал гэдэг нь тухайн үндэстэнд харьяалагдах хүний онцлох шинжийг илэрхийлэхээс гадна хувь хүний нийгэмд эзлэх байр суурь, харилцан холбоо, үнэлэмжийн үйл ажиллагааг ч илэрхийлдэг. “Угсаатны өөрийн ухамсар”, “угсаатны адилсал” хэмээх ойлголтуудыг ижил хэмээн үзэх хандлага байдаг ч үнэндээ тийм биш юм. Угсаатны адилсал нь танин мэдэхүй-сэдэл судлалын гол цөм юм¹⁶, харин угсаатны өөрийн ухамсар нь илүү өргөн ойлголт бөгөөд мөн ухамсаргүй давхаргыг ч илэрхийлдэг. Үндэстний соёл, оюун санааны элементүүд болсон хэл, шашин шүтлэг, түүхэн ой санамж, уугуул гарал үүслийн тухай үзэл, домог, ёс суртахуун, ардын урлаг зэрэг нь бусдаас ялгарах шинж чанарууд болдог ба түүхэн нөхцөл байдал, угсаатны онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байдаг.

Үндэсний адилсал нь хэн болохоо танихаас гадна түүний үнэлгээ, гишүүнчлэлийн ач холбогдлыг илэрхийлдэг бол харин “айдас, нэр төр, бардамнал, дургүйцэл нь угсаатнуудын хоорондын шалгуур юм”¹⁷. “Эдгээр мэдрэмжүүд нь тухайн

¹⁵ Гидденс.Э. Ускользающий мир: как глобализация меняет нашу жизнь. М.,2004. Стр 39

¹⁶ Солдатова.Г.У. Психология межэтнической напряженности. М.,1998. Стр 44

¹⁷ Солдатова.Г.У. Психология межэтнической напряженности. М.,1998. Стр 75

угсаатны сэтгэл хөдлөл, ёс суртахуунтай нь гүнзгий холбоотой бөгөөд хувь хүн төлөвших явад үүсэн бий болдог байна”¹⁸. Үндэсний адилсал нь үндэсний өөрийн ухамсарт чухал үүрэгт гүйцэтгэдэг. Тухайлбал, “хүн төрөлхтний түүхийн эртний үед үүссэн өөрсдийнхөө гарал үүслийг ямар нэгэн амьтантай зүйрлэдэг сэтгэл зүйгээс эхлэн өөрийгөө ухамсарлах ухамсар бий болсон байна”¹⁹.

Үндэсний адилсал нь зан үйлийн онцлогийг илэрхийлсэн нийгмийн шинж юм. Тэр нь дотроо өөрийн үндэстний онцлогийг илэрхийлсэн ухамсрын талаарх мэдлэг, өөрийн үндэстнийг үнэлэх гишүүнчлэлийн ач холбогдол гэсэн танин мэдэхүйн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Үндэсний адилсал хүний амьдралын туршид ихэвчлэн өөрчлөгддөггүй, хөдөлгөөнгүй хэвээр хадгалагддаг ба ямар ч насны хүн өөрийгөө ухамсарлахад түлхэц болж өгдөг. Зарим угсаатны сэтгэл судлаачид “үндэсний адилсалыг үндэстний хамгийн чухал шинж тэмдэг хэмээн онцолдог байна”²⁰.

Угсаатны адилсалын эерэг хандлага нь угсаатны мэдрэмжид тулгуурласан сэтгэл ханамж, хүсэл бахархал, амжилт бүтээлээр илэрдэг. Харин сөрөг хандлага нь өөрийн угсаатны онцлогийг буруушаах, мэдрэмжийг үгүйсгэх, доромжлох, бусад угсаатан, ард түмнийг илүүд үзэх шинжээр илэрдэг. Үндэсний адилсалын гол шинж нь үндэстэн өөрийгөө үнэлэх үнэлэмжээс өөрийгөө ухамсарлах ухамсар билээ. Мөн эцэст нь “хувь хүний өөрийнх нь чадвар, угсаатны үүргийг үнэлэх байдал, бусад ард түмнүүдийн дунд үндэстнийхээ ач холбогдлыг үнэлэх үнэлэмж маш чухал”²¹.

Орчин үед “адилсал”-д дүн шинжилгээ хийж, шинжлэх ухааны судалгаанд өргөн ашиглаж байна. Энэ нь ч санамсаргүй зүйл биш. “Даяаршлын эрин үе дэх улс төр, эдийн засаг, соёлын өөрчлөлтөөс шалтгаалж хүний амьдрал, үйл ажиллагааг олон талаас нь судалдаг судлаачид тэднийг дагасан олон үзэл баримтлалтай холбоотой”²². Судлаачдын гаргасан ажлын агуулгатай танилцаж түүнд дүн шинжилгээ хийхэд “үндэсний адилсал”, “үндэсний өөрийн ухамсар”-ийн тухай ойлголтуудыг янз бүрээр илэрхийлсэн байдаг. Тухайлбал, В.Ю.Хотинец үзлээр “угсаатны адилсалыг угсаатны өөрийн ухамсрын өндөр түвшний үзүүлэлт гэж үзэх хэрэгтэй”²³ болж байна. Тэгвэл эсрэгээрээ “угсаатны өөрийн ухамсрын гол шинж үзүүлэлт нь угсаатны адилсал бөгөөд тэр нь илүү

¹⁸ Мөн тэнд. Стр 49

¹⁹ Поршнев Б. Ф. Социальная психология и история. М., 1979. Стр. 83.

²⁰ Бромлей Ю. В. Очерки теории этноса. М., 1983, Стр. 45-48.

²¹ Крысько В. Г. Этнопсихология и межнациональные отношения. Курс лекций. – М., 2002, Стр.109

²² Бауман.З. Идентичность в глобализирующемся мире // Бауман, З. Индивидуализи/ рованное общество : пер. с англ. М.,2002. Логос. Стр.390

²³ Хотинец.В.Ю. Этническое самосознание. СПб. : Алетейя.,2000. Стр.240

өргөн ойлголт”²⁴ гэж үзэх хандлага бий. Т.Г.Стефаненко угсаатны адилсал нь тухайн хүний нийгмийн танин мэдэхүйн салшгүй нэгэн хэсэг болохынхоо хувьд тухайн угсаатны төлөөлөгчийн хувьд сэтгэл хөдлөл, өөрийгөө ухамсарлах үйл явцын үр дүн гэж үздэг. В.Н.Павленко үүнтэй төстэй байр суурийг баримталж угсаатны адилсал нь тодорхой нийгэмд гишүүнчлэлтэй байх явдал бөгөөд зөвхөн сэтгэл хөдлөлийн ухамсар төдий биш юм. “Ер нь энэ бол нэлээн төвөгтэй үзэгдэл бөгөөд үүнд танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлөөс гадна зан үйл ч орно”²⁵. Хувь хүн өдөр тутмын амьдралдаа соёл, дадал зуршлаас гадна тухайн угсаатны гишүүн болохоо байнга батлан харуулж байдаг.

Үндэсний өөрийн ухамсар бол хүн үндэстэнд харъяалагдан тэр адилсалын дагуу нийгэмших үйл явц юм. Үндэсний өөрийн ухамсрыг бий болгох сэтгэл зүйн чухал хөдөлгөгч хүч бол тухайн хүний өөрийгөө танин мэдэх эх үүсвэр болсон үндэсний адилсал юм. Үүний зэрэгцээ үндэсний адилсалд давамгайлах шинж чанараас гадна нөхцөл байдлаас хамаарч хоёрдогч шинж чанарууд хосолж болдог. Хэрвээ үндэсний адилсалыг конструктив онолын үүднээс авч үзвэл энэ нь “үндэсний төр улс, түүний элитүүдийн зүгээс зохиомлоор өдөөж буй үндэсний үзэл”²⁶ юм. Үүний үр дүнд үндэсний адилсалыг бий болгох үйл явц нь бодитой, хэсэгчилсэн, домогжсон, өнгөрсөн, одоо, ирээдүйд суурилсан хүмүүсийн оюун санааны мэдрэхүй, сэтгэл хөдлөлийг нэгтгэсэн үзэл баримтлал болдог. Үндэсний адилсалыг бий болгох нь зөвхөн ухамсартай холбоотой биш юм. Хүний үндэстэнд харъяалагдахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн төсөөлөлд тулгуурладаг бөгөөд тэр нь улс төрийн нийтлэгээр илэрнэ. Үүний зэрэгцээ “улс орнуудын хүрээнд угсаатны бүлгүүдийн, хүмүүсийн эх оронч үзэлд суурилан үндэстэн болгон нэгтгэх замаар үндэсний адилсал бий болно”²⁷.

Примордиаль хандлагаар үндэсний адилсалыг угсаатны бүлгийн хүн, угсаатны төрөлхийн өмч мэт үздэг. Энэхүү хандлагыг баримтлагчдын тайлбараар өвөг дээдэс, гал голомт, цус зэрэг “удам угсаа” гэсэн анхдагч мэдрэмжийг чухалчилдаг. Угсаатныг нэг гарал үүсэлтэй биологийн нийтлэг гэж үзэж бусдаас ялгаатай гэсэн үндэслэлээр гол хандлагаа баримталдаг. “Хэрвээ угсаатны нийтлэг шинжийг удмын сан, нийтлэг газар нутгаар хэмжвэл энэ тодорхойлолт зөв”²⁸.

²⁴ Стефаненко.Т.Г. Этнопсихология : учебник для вузов. М,2004. Аспект Пресс. Стр.368

²⁵ Павленко.В.Н, Таглин.С.А. Общая и прикладная этнопсихология. М.,2005. Товарище/ ство науч. изд. КМК. Стр.483

²⁶ Копцева.Н.П, Кисова.А.В. Конструирование этнокультурной и общенациональ/ ной идентичности как философская проблема // Философия и культура. №1 (8). М.,2015.Стр. 12–19.

²⁷ Левашов.В.К. Патриотизм в контексте современных социально/политических реал/ лий // Социологические исследования. №8. 2006. Стр.67–69.

²⁸ Севастьянов.А.Н. Этнос и нация. М.,2008. Книжный мир. Стр.192

Примордиализмын олон зарчимд судлаачид сэтгэл дундуур байдаг учраас угсаатан үндэстнийг судлах өөр олон арга замыг хайж эхэлсэн. Эдгээр оролдлогуудын нэг нь инструментализм юм. Энэ онолын дагуу үндэсний ашиг сонирхлыг хэрэгжүүлэхийн тулд угсаатны бүлгийг арга хэрэгслээ болгон ашиглах явдал юм. Сүүлийн үеийн судлаачид энэхүү хандлагад шүүмжлэлтэй бөгөөд үнэлж хандаж байгаа. Учир нь энэ онолын хамгийн чухал шинж чанар нь утилитаризм ба прагматизмыг онцолж байгаад юм.

Бергер, Лакманн зэрэг судлаачид адилсалыг угсаатных нь шинж чанарыг харгалзан үзэлгүйгээр “нийгэмших явцад бүрэлдэн бий болдог хүн ба нийгэм хоорондын диалектик юм”²⁹ гэж үздэг. Өөрөөр хэлбэл, конструктивистууд соёл, уламжлал нь алс холоос бий болоогүй, түүнийг өнгөрсөн одоо үеийн элитүүд бүтээсэн гэдгийг батлахыг хүсдэг. Энэ утгаараа угсаатан бол байгуулагдаж бий болсон нийгмийн бодит байдлын мөн чанар юм. Тиймээс конструктивизм нь угсаатны шинж чанарыг угсаатны бүлэг хоорондын бэлгэдэл, нөхөн үржих замаар оршин тогтнодог нийгмийн байгуулалын тусгай хэлбэр гэж үздэг.

Угсаатан, үндэстний талаарх дэвшүүлж буй конструктивист хандлага нь угсаатан гэдэг бол байгалийн жамаар үржүүлдэггүй, харин түүнийг байнга хадгалж, бүтээн босгож байдаг хүний бүтээл юм гэж үзэх ёстой болж байна. Үүний зэрэгцээ конструктивистууд үндэсний адилсалыг бий болгох гурван үндсэн хэлбэрийг ялгаж үздэг. Тиймээс энэ хандлагаар үндэсний адилсал бол төр нийгмийн элитүүдийн зориудын үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтэц юм. Үүний зэрэгцээ үндэсний адилсалыг бий болгоход эх оронч үзлийг ихэвчлэн ашигладаг.

Үндэсний адилсалыг үндсэндээ нийтлэг соёлын үнэт зүйлс, түүхэн ой санамжинд тулгуурласан үндэсний эв санааныг нэгдлийг хөгжүүлэгч гэж ойлгож болно. Үүнээс гадна “үндэсний өнгөрсөн үеийн түүхийн гол гол үйл явдлуудын тайлбарт нийгмийн дийлэнх хэсэг нь зөвшөөрсөн үндэсний зөвшилцөл чухал юм”³⁰.

Үндэсний өөрийн ухамсар, үндэсний адилсал, эх оронч үзэл нь адил төлөв байдал, үйл явц, үр дүн юм. Улс орондоо хүн бүрийн хийж буй үнэ цэнийн сонголт гэдэг утгаар үйл явц гэж хэлж болно. Төр нь “үндэстэн”, “эх орон” гэдэг тусгалаар өөрийгөө тодорхойлдог. Үүний үр дүнд үнэт зүйлс, уламжлал, үзэл суртал, хандлага,

²⁹ Бергер.П., Лукман.Т. Социальное конструирование реальности. Трактат по социо/ логии знания / пер. Е. Руткевич. М.1995. Стр.323

³⁰ Тишков.В.А. Российский народ : кн. для учителя. М.2010. Стр.191

зан үйлийн хандлага нийгэмд бий болно. Нэгдүгээрт, хүн өөрийгөө ухамсарлахад оруулах хувь нэмэр, хоёрдугаарт, нийгэмд бүтээлчээр ажиллах ур чадвар, гуравдугаарт, ёс суртахууны хэм хэмжээ, үнэ цэнэгүйгээр хүн төрөлхтөн орших боломжгүй юм.

Дүгнэлт: Дээр дурдсан агуулгуудад дүн шинжилгээ хийхэд дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Нийгмийн идэвхтэй хувь хүн төлөвшихтэй холбоотой бүх шинж чанарууд болох: танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, зан үйлийг хооронд нь уялдуулах замаар иргэний байр суурийг тодорхойлдог байна. Үндэстэн дэх нийтлэг санаа бодлыг дэмжиж, хувийн ашиг сонирхлоос илүү эх орон, улсынхаа эрх ашгийг илүүд үздэг, түүхийн соёлын ололт амжилтыг хайрлан хамгаалдаг, үндэстэнд өөрийгөө харьяалуулах хүсэлтэй, үндэстнээ танин мэдэхийн ач холбогдлыг ойлгох нь үндэсний өөрийн ухамсар нь үндэстнийг нэгтгэдэг. Үүний зэрэгцээ үндэсний соёл, сүлд хийморь, бэлгэдэл нь цаашид үндэстэн оршин тогтнох найдварыг төрүүлж байдаг. Хамтын шинжтэй адилсал нь ухамсартай ухамсаргүй шинж чанараар тодорхойлогддог тул эх оронч үзлийг бүрэлдүүлэх явцад бэлгэдэл нь нэг талаас үндэсний эв нэгдлийг дэмжиж нөгөө талаас “бид” ба “тэд” гэсэн ялгах хандлагыг үүсгэдэг. Эх оронч үзлээр төлөвшүүлэх хүмүүжилд урьд өмнө гарч байсан ийм алдаануудыг засах хэрэгтэй. Тухайлбал, залуу үеийнхний оюун санаанд үндэсний адилсалын дүр төрхийг бүтээхдээ “бусад” гэсэн дайсны дүрийг бүтээх замыг сонгож болохгүй. Тэгэхээр үндэсний адилсалыг эерэгээр бүтээх хэрэгтэй. Энэ нь тухайн үндэстний нэгж, эс гэдгээрээ бахархах үзэл юм. Энэхүү байр суурь маш чухал. Үндэсний өв уламжлал, түүхэн гавъяа, соёлын хосгүй үнэт зүйлс, байгалийн баялаг зэрэгт хандах сөрөг нөлөөллийг сулруулж соёл иргэншлийнхээ өвөрмөц байдлыг хадгалах нь хамгийн зөв байр суурь юм. Олон судлаачид түүх, соёлыг хамтын ухамсрыг бий болгоход хамгаас чухал үүрэгтэйг онцолсоор ирсэн.

Краткий обзор

Понятия национальное самосознание и национальная идентификация очень часто понимаются как синонимы, однако, по нашему мнению, эти понятия необходимо разграничить. Национальное самосознание это осознание народом себя как этнической общности. Национальное самосознание возникнув, становится важным условием существования и развития нации, оно во многом основывается на национальной идентификации, которая рассматривается как механизм формирования этнического самосознания. Национальная идентичность чаще всего остается неизменной на протяжении всей жизни человека, но все-таки этот феномен – статичное адинамичное

образование, поэтому внешние социальные обстоятельства могут толкать человека любого возраста на переосмысление роли национальной принадлежности в его жизни.

Ашигласан ном зохиолууд

Болд-эрдэнэ.Д. Үндэсний үзлийн мөн чанар: төөрөгдөл, уг чанар, хүч боломж.

Философи эрхийн судлал №29. УБ.,2014.

Бауман.З. Идентичность в глобализирующемся мире // Бауман, З. Индивидуализи/ рованное общество : пер. с англ. М.,2002. Логос.

Бергер.П, Лукман.Т. Социальное конструирование реальности. Трактат по социо/ логии знания / пер. Е. Руткевич. М.1995.

Бромлей Ю. В. Очерки теории этноса. М., 1983,

Гаджиев К.С. Национальная идентичность: концептуальный аспект // Вопросы философии. 2011. № 10.

Гидденс.Э. Ускользающий мир: как глобализация меняет нашу жизнь. М.,2004.

Инглхарт Р., Вельцель К. Модернизация, культурные изменения и демократия: последовательность человеческого развития. М. : Новое издательство, 2011.

Копцева.Н.П, Кистова.А.В. Конструирование этнокультурной и общенациональ/ ной идентичности как философская проблема // Философия и культура. №1 (8). М.,2015.

Крысько В. Г. Этнопсихология и межнациональные отношения. Курс лекций. – М., 2002,

Левашов.В.К. Патриотизм в контексте современных социально/политических реал/ лий // Социологические исследования. №8. 2006.

Мазуренко.А.В. Формирование правовой культуры в России. М.,2001.

Ортега-и-Гассет, Х. Восстание масс. Дегуманизация искусства. Бесхребетная Испания М, 2008.

Павленко.В.Н, Таглин.С.А. Общая и прикладная этнопсихология. М.,2005. Товарище/ ство науч. изд.

Поздняков .Э.А. Нация, национализм, национальные интересы. М.,1994.

Попов.В.Д. Психология и экономика. М.,1989.

Поршнев Б. Ф. Социальная психология и история. М., 1979.

Севастьянов.А.Н. Этнос и нация. М.,2008. Книжный мир.

Солдатова.Г.У. Психология межэтнической напряженности. М.,1998.

Стефаненко.Т.Г. Этнопсихология : учебник для вузов. М,2004. Аспект Пресс.

Стр.368

- Тишков.В.А. Российский народ : кн. для учителя. М.2010. Стр.
- Рубинштейн.С.Л. Основы общей психологии. М.,1946.
- Хантингтон С. Кто мы? Вызовы американской национальной идентичности. М, 2008.
- Хотинец.В.Ю. Этническое самосознание. СПб. : Алетейя.,2000.
- Blum, Douglas W. National Identity and Globalization Youth, State, and Society in Post-Soviet Eurasia. Cambridge University Press, 2007
- Gaber, Rusanna. National Identity and Democratic Consolidation in Central and Eastern Europe // International Journal of Sociology. 2006. Vol. 36. № 3
- Gellner.E. Nations and nationalism. Oxford.,1993 p 98
- Smith, Anthony D. National Identity. Penguin Books, 1991.

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛД

Л.Идэр
Доктор

Хураангуй

Монголын төрт ёсны түүхэн уламжлалыг хадгалсан түүх архивын баримт бичигт орсон зүйл, бусад мэдээллээс эхлээд эрдэмтэн, мэргэд түүхч нарын тэмдэглэл, “Арван буянт номын цагаан түүх” зэрэг олон арван материал нь Монголын төрт ёсны түүхэн уламжлал, улс төрийн сэтгэлгээний түүхийг судлахад чухал ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Улс төрийн сэтгэлгээний түүх, Төрт ёс, Сурвалж, Домгийн сэтгэлгээ, Уламжлал

Монгол төрийн үзэл баримтлалын тулгуур үндэс нь байгаль, нийгмийн язгуур шинж, зүй ёсыг тулгуурлан, түүнийг таньж хэрэглэхэд оршино. Энэ нь байгаль дэлхийнхээ уг чанарыг түшиглэж, аливааг ёсоор нь байлгахыг эрхэмлэдэг Монгол сэтгэхүйн нэг илрэл юм. Монгол орны хувьд улс төрийн сэтгэлгээний хөгжилд домог, шашны сэтгэлгээ үнэхээр чухал үүрэг гүйцэтгэсэн. Эхэн үедээ Монголчуудын улс төрийн сэтгэлгээний анхны хэлбэр нь домгийн сэтгэлгээгээр дамжин илэрч байсан.

Домгийн сэтгэлгээг шүтлэг бишрэл, дэврүүн санаа, ёс зүй, хүмүүнлэг сэтгэл, хүмүүнчилсэн дүрслэл бүхий философи, улс төр, ёс зүйн олон талын агууламжтай, мэдрэхүй, сэтгэхүйн нэгдмэл үзэгдэл гэж үзэж болох юм.

Монголчуудын улс төрийн сэтгэлгээ үүсэл, бүрдэлтийнхээ эхэн үед домгийн сэтгэлгээ түүгээр илэрхийлэгдсэн дүр дүрслэл, шүтлэгийн хэлбэрээр илэрч байсан юм. Юмс үзэгдлийн мөн чанарыг ерөнхий ойлголт категориор илэрхийлэх танин мэдэхүйн түвшинд Монголчууд хараахан хүрээгүй байсан цаг үед мэдрэхүй болон амьдрахуйн туршлагынхаа хэмжээнд хүний үйл ажиллагааны загвараар ертөнцийг төсөөлж, овог, аймгийн зохион байгуулалтын бүтэц, харилцааны хэлбэрийг бодит

байдлын бүхий л хүрээнд хамаатуулан сэтгэж байсныг Монголчуудын домгийн сэтгэлгээ хэмээн ерөнхийлөн нэрлэж болох юм. Домог зүйн судлагдахуун болохуйц бичгийн дурсгалт зүйлс Монгол хэлнээ бараг үгүй боловч хожуу үеийн түүх, уран зохиолын бүтээлд Монголчуудын гарал үүсэл, ертөнцийг үзэх үзэл, төр, төр ёсны үзэл сэтгэлгээтэй холбогдол бүхий домгийн зарим өгүүлэмжийг тэмдэглэн үлдээсэн нь цөөнгүй бий. Тухалбал, “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Цагаан түүх”, “Шар тууж”, “Эрдэнийн товч” зэрэг Монголын түүх, соёлын эх сурвалжид домгийн сэтгэлгээтэй холбогдох баримт, мэдээ мэр сэр үлдсэн байдаг. Амаар уламжлагдан ирсэн домгийн өгүүлэмж, эртний домгийн сэтгэлгээтэй холбогдол бүхий эх сурвалж, материалыг эмхтгэн тэмдэглэж хэвлүүлсэн бүтээл нэлээд байдаг. Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын дээж зуун билэг оршивой”, Б.Ринчин “Монгол ардын аман зохиол” хэмээх цуврал эмхтгэл, Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном “Монгол ардын аман зохиол дээж бичиг”, Х.Сампилдэндэв “Монгол домог” зэрэг эмхтгэл бүтээлүүдэд Монголчуудын амаар уламжилж ирсэн домгийг олны хүртээл болгоход үнэтэй хэрэглэгдэхүүн болоод зогсохгүй эрдэм судлалын ажлын чухал иш материал болж байдгаараа ач холбогдолтой юм. Харин домгийн сэтгэлгээг улс төрийн үзэл, сэтгэлгээний талаас нь тусгайлан судалсан бүтээл одоогоор байхгүй байна.

Монголчуудын домгийн сэтгэлгээ нь хэдийгээр тэдний ердийн ухамсар, амьдралын өдөр тутмын ажиглалт, туршлагын үр дүнд голчлон боловсрогдсон байдаг ч түүнд хүрээлэн байгаа газар дэлхий, хүний үүсэл гарал, хүн байгалийн харилцаа, хаад язгууртны гарал угсаа, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалсан, тэнгэр шүтлэг, төрийн улс төрийн үзлийн зарим үнэт зүйлс, эе, эвийн үзэл номлолтой холбоотой гүн ухаан, улс төрийн онолын агууламж бүхий чухал санаа, өгүүлэмж гүнзгий шингэсэн байдаг юм. Тэр дундаа Монголын төрт ёсны үзлийн тулгуур санаа болсон хаан дээдэс, төр, улсаа шүтэх үзэл, мөнх тэнгэрийн гүн ухаан, эв нэгдлийн талаарх улс төрийн гүн ухааны чухал язгуур үндэслэлүүдийг домгийн сэтгэлгээнээс харж болно.

Монголын төр ёсны түүхэн их шастир болох “Монголын нууц товчоонд” тэмдэглэгдэн үлдсэн Алун-Гуагийн домгийг дээрхтэй холбогдуулан онцлон үзэхэд л хангалттай юм. Энэ домогт Монголын алтан ургийн хаад ихэс дээд тэнгэрээс заяасан, тэнгэр язгуурт болохыг тод томруун дүрсэлснээрээ Монголчуудын бүхнийг нөхцөлдүүлэгч дээд тэнгэрийн санаа зоригыг газар дэлхийд гүйцэлдүүлэгч гэх хаад, язгууртнуудын үйл хэргийг магтан алдаршуулж түүгээрээ дамжуулан

төрийг шүтэх сэтгэлгээг олон түмэнд шингээн, төлөвшүүлэх гүнзгий санааг тусган илэрхийлж байдаг юм. Энэ утгаараа энэ домог нь улс төрийн үзэл, сэтгэлгээний бодитой тусгал болж байдаг гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Монголчууд домгийн сэтгэлгээний тансаг баян өв сантай байсан бөгөөд энэ нь хэдийгээр тэдний ердийн ухамсар, сэтгэл зүйн төгс боловсрогдоогүй санаа, төсөөллийн илэрхийлэл байсан боловч цаад агуулгандаа төрт ёсны улс төрийн үзэл, сэтгэлгээний онол, номлолын элементийг ямар нэг хэмжээгээр багтаан агуулсан Монголчуудын улс төрийн сэтгэлгээний анхны хэлбэр гэж үзэж болохоор байна. Домгийн сэтгэлгээнээс гадна Монголчуудын улс төрийн сэтгэлгээний тодорхой нэгэн илэрхийлэл нь шашны гүн ухаан, ёс зүйн хэлбэр байсан юм. Тэдний улс төрийн үзэл, сэтгэлгээ нь шашинтай нягт холбоотой хөгжиж иржээ. Монголчуудын язгуурын шашин бол бөө мөргөлийн шашин юм. Бөө мөргөлийн шашин-философийн гол үзэл нь тэнгэр шүтлэг мөн билээ. Тэнгэр шүтлэгийн шашин-философийн үзэл нь Монголчуудын улс төрийн үзэл, сэтгэлгээний оюун санаа, танин мэдэхүйн үндэс суурь нь болж байсан.

Монгол бөө мөргөлийн шашны ертөнцийг үзэхүйн онол, номлолын үндэс нь “ерэн ёсон тэнгэр”-ийн үзэл юм. 99-тэнгэрээ дотор нь баруун зүгийн цагаан буюу өөдрөг сайн талын 55 тэнгэр, зүүн зүгийн хар буюу сөрөг талын 44 тэнгэр хэмээн ангилдаг. Монгол бөө мөргөлийн 99 тэнгэрийг судлаачид “нийгэмшүүлэн хүнийсгэсэн” ертөнцийн загвар юм гэж үзсэн байдаг. Энэ үзэл ёсоор бол хэвтээ тэнхэлгээр найман зүгийн орон, босоо тэнхлэгээр доод, дунд, дээд гэсэн гурван зүгийн орон бүгд арван зүгийн арван нэгэн оронд ангилж орон бүрийн найман зүг болон төвийг эзлэн суугч есөн тэнгэр байдаг мэтээр загварчлан төсөөлдөг. Орон зайн зүгийн энэ хуваарийг бэлэгдэл, эрхэмлэлийн зүйлстэй нь харгалзуулан шүтэлцүүлбэл эртний Монголчуудын ертөнцийг үзэхүйн өвөрмөц тогтолцооны загварыг олж харж болно.

XIII зууны эхээр Их монгол улс байгуулагдаж, бөө мөргөлийн шашин нь тэр үеийн хаад, ноёдын улс төр, үзэл суртлын хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чадахгүй болжээ. Үүнтэй холбоотойгоор энэ шашин нь цаг үеийн өөрчлөлтийг дагаж, өөрийн номлол, зан үйл, ёс жаягандаа ямар нэг хэмжээгээр өөрчлөлт хийх болсон юм. Энэ өөрчлөлтийн үр дүнд “мөнх тэнгэр”-ийн үзэл уг шашны гол шүтээн болж, түүнийг бурханчлан товойлгох болсон юм. “Мөнх тэнгэр”-ийн шашин, философийн үзэл ёсоор мөнх тэнгэр нь Монгол хүмүүсийн төрж үхэх, жаргаж зовох, дээшилж буурах, ялж ялагдахын бүх хувь тавиланг шийдэх бөгөөд Мөнх тэнгэртэй ид

шидтэй бөө удган нар л харьцаж чадна хэмээн итгүүлэх болсон байна. Түүнчлэн наран саран, од гариг, уулын эзэн, усны савдаг, өвөг дээдсийн сүнс зэргийг чухал үзэлд тооцох болсон байна. Энэ бүхэн нь XIII зууны Монголчуудын төрт ёсны улс төрийн үзэл, сэтгэлгээний хөгжилд тодорхой нөлөө үзүүлсэн гэж хэлж болно. Түүнчлэн бөө мөргөлийн дараагийн шашин болох шарын шашны үзэл, номлол нь ч бөө мөргөлийн шашны нэгэн адил Монгол төрт ёсны улс төрийн үзэл санааны хөгжилд тодорхой байдлаар нөлөөлсөн нь эргэлзээгүй юм. Үүнтэй холбогдуулан XIII-XIV зууны үеэс Монголчуудын төр барих ёсны онол, үзэл шашны үндэс болсон шашин төрийг хослон барих “хос ёс” буюу “хоёр ёс”-ны зарчмын тухай онцлон тэмдэглэхэд л хангалттай юм. Гэхдээ энэ үеийн улс төрийн сэтгэлгээг зөвхөн шашинд тулгуурлаж, өөрийн бие даасан шинж үгүй байсан гэж үзэх аргагүй юм. Тэдгээр нь цаг үе, танин мэдэхүйн эрхээр холбоо хамааралтай байж, бие биенээ харилцан нөхөн сэлбэж байсан ч тус тусын өвөрмөц агуулга, бие даасан байр суурь, статусаа хадгалж байсныг дурдах хэрэгтэй юм.

Монголчуудын улс төрийн сэтгэлгээ нь шинж байдлын хувьд шашин, шүтлэг бишрэл, билэгдэл, домогчлолын агуулгатай байдаг. Учир нь Монголчууд улс төрийн үзэгдэл, үйл явцыг бүхнээс дээр байх мөнх тэнгэртэй, тэнгэрийн заяа төөрөг, түүний бүхнийг нийгүүлсгэгч, ариун, хүчирхэг байдалтай холбон үздэг. Түүнчлэн шашны энэрэн нийгүүлсгэгч хүмүүнлэг ёс суртахуун, шударга хүлцэнгүй байх ёс журам нь Монголчуудын улс төрийн сэтгэлгээний онол, үзэл санааны үнэт зүйлсийн бүрдэлт төлөвшилтөнд ямар нэг байдлаар нөлөө үзүүлсэн юм.

Мөнх тэнгэрийг шүтэх үзэл. Монголчуудын ертөнцийг үзэх үзлийн, ялангуяа төрд хандах сэтгэлгээний уг сурвалж нь юуны өмнө мөнх тэнгэрийг шүтэх үзэл байсныг Монголын түүхэн эх сурвалжуудад нотолж байна. Тухайлбал:

“Монголын нууц товчоо” түүхэн эх сурвалжид: “Тэнгэр газар эелдэж, Тэмүүжинг улсын эзэн болготугай” гэж зарлигдав гэсэн бол Монголын их эзэн Чингис хаан хэлэхдээ:

“Эрэмгий сайнаар

Эзэн эс боллоо, би.

Эрхт тэнгэр

Эцгийн хайраар

Эзэн боллоо, би.

Эцэг тэнгэрийн ачаар

Эсрэг дайснаа дарлаа, би” гэжээ. Монголчууд яагаад мөнх тэнгэрийг шүтэх болов? Доктор Г.Лувсанцэрэнгийн: “Байгальтай зохицон аж төрөх ёсны нэг илрэл нь Тэнгэр, газрын нэгдлийг голчоор баримтлах үзэл, дадал болно. Газар дэлхий, агаар тэнгэр хоёр үзэгдэл үйлчлэлийн нягт уялдаатай, байгалийн нэгдмэл цогц болох нь ойлгомжтой. Түүгээр зогсохгүй байгалийн бүрдэл хэсэг болсон хүн, түүний үйл ажиллагааг ч уг нэгдэлтэй холбон үздэг байв” гэж хэлсэнчлэн газарзүйн орчин, амьдрах аж төрөх арга, ёс заншил, соёл иргэншил нөлөөлөхөөс гадна Монголчуудын ертөнцийг үзэх үзэл сэтгэлгээ нь юмсын мөн чанарт чиглэсэн трансценденталь шинжтэй байсан байна. Доктор С.Дулам: “Мөнх тэнгэр бол оюун санааны дээд түвшний үзэгдэл”, Доктор Г.Лувсанцэрэн: “Мөнх тэнгэрийн тухай ойлголт нь бүхний язгуур болж, бүхэнд түгээмэл байдаг, энэ утгаараа бүхнийг “амилуулан”, шимэлж өгдөг түгээмэл чанарыг илэрхийлнэ.

Ийнхүү мөнх тэнгэрийн тухай үзэл бол бөө мөргөлийн олон тэнгэрт ёсноос /политеизмээс/ дээш гарсан онол болох юм” гэж мөнх тэнгэрийн шүтэх үзлийг рационал утгаар тайлбарлаж байна.

Л.Лоренц: “Мөнх тэнгэр бол ердийн утгаараа бурхан тэнгэрч биш, эзэн сахиус ч биш, Мөнх тэнгэр юмсын гадна, хамгийн дээр оршиж байдаг” гэсэн бол доктор Ч.Жүгдэр: “Тэнгэр хэмээх ойлголтод байгалийн харагдах ба үл харагдах бүх хүчийг хамруулан үзэж байсан” гэжээ. Өөрөөр хэлбэл тэнгэр бол оюун санааны болон материаллаг ертөнцийн нэгдлийг тодорхойлох дээд хүчний нэгдэл болно. Иймд мөнх тэнгэр бол объектив, субъектив шинжтэй.

Доктор Г.Лувсанцэрэн: “Мөнх тэнгэрийн үзэл бол Чингис хааны төрийн үзлийн онолын үндэс мөн гэж хэлэх бүрэн үндэстэй

...Мөнх тэнгэрийг шүтэх нь их үйл хэргийн төлөө эрч хүчээ хураан зангидаж, дайчлан илэрхийлэх хүчин зүйл болж байжээ. Төр, түүний эзэн өөрийн туйлын хүслэн болох тэнгэрлэг чанартаа дүйцэж, түүнийг хадгалан байх гэсэн чармайлт нь төрөө төр шиг байлган барьсан жинхэнэ хаан шиг хаан байхад хөтлөн дуудаж дайчлан зоригжуулж байжээ. Энэ нь угтаа төр хийгээд хаан өөрийнхөө тэнгэрлэг чанарыг олж, түүндээ хүрч, түүнийг илэрхийлж хэрэглэх арга мөн юм. Үнэндээ ч нэгэн тэнгэрт түгээмэл чанарыг шүтэн барих үзэл л нэгдсэн том гүрний төрийн онолын үндэс болсон, үзэл суртал болохоос өөр аргагүй” гэж мөнх тэнгэрийг шүтэх үзэл нь Монголын төрт ёсны үндэс болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

Дорно дахины төрт ёсны сэтгэлгээ, түүний нэг хэсэг болох Монголчуудын төрт ёсны сэтгэлгээ нь өрнийн төрт ёсны сэтгэлгээ, соёлын нэгэн адил үнэт зүйлсийг агуулж байна. Монголчууд эртнээс нийгмийн ёс, суртахууны хэм хэмжээний үзэл санаа үүсч хөгжжээ. Төрийн талаар Монголчуудын сэтгэлгээний уг сурвалж болох ардын зүйр цэцэн үгэнд:

“Амраглах гэгч анхны ёс

Мэндлэх гэгч мөнхийн ёс

Зуд нэгэн жилийнх

Журам мянган жилийнх¹

Төр ёсыг дагаж явбал хүндлэл ихтэй болох

Төв журмыг дагаж явбал

Түмэн зүйлийг мэдэж болох²” гэснийг шинжлэн үзвэл хүний ёс, нийгмийн хэм хэмжээ нь хүмүүсийн харилцааны мөнхийн орших ёс бөгөөд энэхүү ёсыг дагаж явбал оюуны болон нийгмийн эрх чөлөөтэй байх үзэл санааг илэрхийлсэн байна.

Өөрөөр хэлбэл, хүмүүсийн зан үйлийн ёс журам нь байгалийн хуулийн нэгэн адил зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээ болохыг Монголчууд эртнээс ойлгож, хэрэгжүүлж байсан. Энэ үндсэнд Чингис хааны тархай бутархай олон ханлиг улсыг нэгтгэн нэгэн улс болгохдоо: “Мөнх тэнгэр мөхөс миний биеийг зарлигдан түмэн иргэдийг захируулахаар соёрхов. Тал нутагт одоо болтол ямар ч эмх журамгүй учраас ийм зэрэгт хүрсэн ажээ. Үр хүүхэд нь эцэг эхийн үгийг авахгүй, дүү нар нь ахаа дагахгүй, эр нь эхнэртээ итгэхгүй, эхнэр нь эрийнхээ үгийг даахгүй, дагагсад нь ахлагчаа хүндлэхгүй, ноёд нь ард албатынхаа дотор үүрэг гүйцэтгэхгүй, баячууд нь ядуучуудаа тэтгэхгүй, газар сайгүй сэтгэл тайван суухыг бодохгүй, бидний омог аймаг, төрөл угсаатны дэг журам бүр алдагдаж, сүр сүлдгүй болоход хүрч буй. Эдүгээ хүрсэн газар болгонд дураараа авирласан хүмүүн олон. Худалч хулгайч, урвагчид, дээрэмчид хүртэл бий болжээ. Иймээс миний бие ард олныхоо хүсэл захиасыг даган энэхүү мөчид хатуу төв чанга жам ёсоор тэд нарыг засаж нэгтгэн энх амгалан зол жаргалыг энэ нутагтаа хүртээн тогтоохыг чармайх ёстой³” гэж хүн өөрийн дур зоргоороо байж, хэний ч эсрэг юу хүссэнээ хийх нь ёс журамгүй явдал бөгөөд энэ нь ард түмний хүсэл зоригийн гадуур зүйл учраас нийгмийн засах ёсыг тогтоон, ард түмнийг нэгтгэн тэдэнд сайн сайхныг хүртээх ёстой гэсэн нь төрийн үзэл санааг маш тод илэрхийлж, дээд зарагч Тататунгад зарлигдахдаа: Би нэгэн

¹ Монголын философийн түүх. (1997). Дэвтэр №1. 153 дахь тал. Улаанбаатар

² Дээрх бүтээлийн 155 дахь тал

³ Далай Ч. (1990). Эзэн Чингис хааны гэрээслэл ба эдүгээ миний бодол. Чингисийн туг. №1. 492 дахь тал. Улаанбаатар, Сайшаал. (1987). Чингис хааны товчоон. Дэвтэр №1, 2. Хөх хот

“ёс” хэмээх хууль дүрмийг бүтээе гэж бодож байх юм. Энэхүү ёс дүрмээр миний үйлсийг залгамжлагчид бүхэн баларшгүй их судар болгох хэрэгтэй. Таван зуун он, мянган он, түмэн оны хойно миний үндэс суурийг залгамжлахад Чингис хааны хууль дүрмийг баримталж өчүүхэн ч өөрчлөхгүй бол “Мөнх тэнгэр” тэднийг тэтгэх болно. Бид нар урт наслаж хүн төрөлхтний зол жаргалыг эдэлж чадах магад. Хэрвээ энэхүү хууль дүрмийг чанд сахихгүй бол хаант улс минь бутран саринхад хүрнэ⁴,

“Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай. Нийт улсын өмчийг хувааж заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж тэмдэглэгтүн.

Надтай зөвлөж, Шихихутагийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг урагийн урагт хүртэл үүрд хэн бүү өөрчилтүгэй”⁵ гэж “Их засаг” хуулийг тогтоосон юм. Үүнээс хойш одоог хүртэл Монголчууд өөрсдийн дагаж мөрдөх хэм хэмжээнүүдийг /Монгол-Ойрадын хууль, Халх журам г.м хууль тогтоомж/ тогтоон гаргаж, үеийн үед даган мөрдөж ирсэн.

Дээрх ардын зүйр үгний “төрт ёс буюу төрөөс тогтоосон хэм хэмжээ хуулийг дагаж мөрдсөнөөр хүндлэл ихтэй болох” гэж үзэж байснаас үзвэл, ёс журмыг дагаж мөрдсөнөөр засаглал тогтвортой шударга механизмын үндэс бий болохыг тодорхойлсон байна.

Тийм ч учраас төрт ёс буюу төрийн хууль дээдлэх ёс зарчмыг төлөвшүүлж иржээ.

“Цааз хэмээгч эзнээс үүсэн түшмэлээр зарламой

Цаазыг дагах эзнээс эхлэн олон цэрэг дор хүрмой

Цаазыг чангатгах дор эрхбиш урьд эзэн нь сахимой

Цааз барьсан жононгийн дохиог хэн айлгүй зөрчмой⁶” гэсэн төрийн хууль засаглал бүгдэд ижил үйлчилж, бүх нийтээр дээдлэн, чанд сахин биелүүлэх үзэл санаа Их засаг хуулиас эхлэн өнөөгийн Монгол улсын үндсэн хуульд⁷ тусгалаа олжээ.

Нөгөө талаар Монголчууд өөрсдийн оршихуй, хүчирхэг эрхийн хамгаалалттай байх үндсийг тэнгэрлэг ёс-эв эеийг сахих явдал хэмээн үзэж:

“Хаалгат гэрт суусан

Хатан хүн жаргахдаа

⁴ Перецен. (1983). Чингис хааны байлдааны бодлого ба арга. 114 дэх тал. Хөх хот

⁵ Монголын нууц товчоо. (1990). 179 дахь тал. Улаанбаатар

⁶ Инжиннаши В. (2006). Хөх судар, 1179-1180 дахь тал. Улаанбаатар

⁷ Монгол улсын үндсэн хууль. (1992). 2, 14-р зүйл. Улаанбаатар

Эр юүгээ сайнд жарга юу

Хамаг бүгд жаргахдаа

Эв эеийнхээ сайнд жаргамуй за”...⁸

“Хоёр хүн эвтэй болбоос

Төмөр хүрээ мэт бэх

Хорин эвгүй болбоос

Эвдэрхий хүрээ мэт хэврэг

Өнөр хүн эвгүй болбоос

Өнчин хүний элэг болох

Олон хүн эвгүй болбоос

Оорцог хүний идэш болох”⁹ гэж үзэж байсан нь Монголын нууц товчооноос Оюунтүлхүүр хүртэлх бүх л сурвалж бичгүүдэд тусгагдсан байдаг.

“Эв эе”-ийг сахих сургаал. Монголчуудын төрт ёсны сэтгэлгээний үндэс нь мөнх тэнгэрийг шүтэх үзлээс гадна Алунгоо “Эв эе”-ийг эрхэмлэх сургаал мөн. “Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг” гэсэн ардын зүйр цэцэн үгнээс улбаатай Алунгоо хатны “эв эе”-ийг сахих сургаал нь Монголчуудын оюуны соёлын илрэл юм. “Эв эе”-ийг сахих сургаал нь Монголчуудын оршихуй мөнх, хүчирхэг байхыг үндсийг илэрийлжээ. “Эв эе”-ийг сахих сургаал Монголчуудын тэнгэрлэг зарчим болохыг хувьд овог ургийн бичиг нэгдлээс аймаг улсын үзэл баримтлал болж хөгжсөн байна.

Иймд Доктор Н.Лүндэндорж: “Эв нэгдлийн үзэл санаа-Монголчуудын төрт ёсны үзэл сэтгэлгээний язгуур эх сурвалж мөн¹⁰” гэжээ.

“Эв эе”-ийг эрхэмлэх сургаал:

1. “Эв эе” гэдэг нь нийгмийн хөгжлийг тодорхойлох нэгдлийн буюу арга билгийн шүтэн барилдлагын илрэл.
2. “Эв эе” гэдэг нь Монголчуудын хамтран аж төрөх, оршихуйн үндэс
3. “Эв эе”- нийгэмшлийн дээд хэлбэр

Монголчуудын төрт ёсны сэтгэлгээ нь нийгэмшиж ирсэн цаг үеэс хөгжсөн, Монголчуудын оюун санааны хөгжлийн бүтээгдэхүүн, соёлын нэг хэсэг юм.

⁸ Алтан товч. (1990). (Лувсанданзан). 104-106 дахь тал. Улаанбаатар

⁹ Оюун түлхүүр нэрт шастир. (2006). (МУИС). 24 дэх тал. Улаанбаатар

¹⁰ Лүндэндорж Н. (2002). Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. 264 дэх тал. Улаанбаатар

Мөн нөгөө талаас орчин үеийн эко төрийн асуудлыг аль эрт үед тавьж, ертөнцийн жам ёсны асуудлыг тавьж байснаараа онцлог юм.

Дорно дахин, тухайлбал, Монгол төрт ёс уламжлалыг сэргээн судалж, түүнийг орчин үеийн үзэл онолын ололтоор баяжуулан хэрэглэх замаар үндэсний нийгэм-улс төрийн сэтгэлгээний цогц сургаалыг боловсруулах хандлага үр хөврөлийн байдалтай байна. Дорно дахины төрт ёсны сэтгэлгээ нь газарзүйн орчин, түүнээс үүдсэн амьдрах аж төрөх аргад тулгуурлан хөгжиж, улмаар өрнөөс ялгагдах дорнын өвөрмөц төрт ёсны үзэл сэтгэлгээ, соёл иргэншлийг бий болгосон юм. Дорно дахины улс орнууд нь дорнын соёлд үндэслэн төрөө, зан заншлаа дээдлэн, төрөө шүтэж ирсэн төрт ёсны үзэл сэтгэлгээний түгээмэл шинжийг агуулдаг.

Дорно дахины төрийн сэтгэлгээнд нөлөөлсөн хүчин зүйлс:

- Газарзүйн орчин,
- амьдрах аж төрөх арга,
- дорно дахины соёл иргэншил,
- нийгэм улс төрийн тогтолцоо.

Газарзүйн орчин, амьдрах аж төрөх аргаас улбаалан цусан төрлийн холбоонд үндэслэгдсэн эцгийн эрхт ёс, уламжлалт ёс заншил дорнын улс орнуудад харьцангуй удаан хугацаагаар хадгалагдан үлдсэн нийгмийн нөхцөл байдал нь төрийг дээдлэх, төрийн үүргийг хувь хүний үүргээс дээгүүрт авч үзэх улмаар төрийг дээдлэх үзлийн нийгмийн үндсийг бүрдүүлжээ.

Дорно дахинд төрийг дээдлэх ёс нь ахас дээдсийг хүндлэн, хүү нь эцэгтээ, залуучууд нь ахмадаа, харьяат ард нь төрдөө захирагдах нийгмийг удирдах удирдуулах жам ёсны зайлшгүйг ухаарсан ёс заншил өвөрмөц сэтгэлгээнд үндэслэгдсэн юм.

Дорно дахины төрт ёсны сэтгэлгээний онцлог:

- “Хүн тэнгэрийн дор төрж, төрийн дор захирагдана” гэсэн захирах, захирагдах ёсонд үндэслэгдсэн.
- Шударга ёсыг нийгмийн хариуцлага хэмээн ухамсарласан үүргийг дээдэлсэн төрт ёсны сэтгэлгээ хөгжих үндсийг бүрдүүлсэн.
- Нийгмийн удирдах, удирдуулах жам ёсны зайлшгүйг ухаарсан ёс заншил, өвөрмөц сэтгэлгээнд үндэслэгдсэн г.м

Монголчууд хамтран аж төрөхдөө хоорондоо зохицон эв эеийг хичээн, төр ёсыг эрхэмлэх нь тэдний оршихуй, амьдрах чадвартай хүчтэй байхын үндэс хэмээн үзэн хүний зан үйлийн ёс журмыг илэрхийлэн, эв эеийг сахих явдлыг өрх гэрээс төрийн түвшинд гаргаж тавьсан явдал бол төрт ёсны үзэл санааны чухал үнэт зүйл болно. Иймд “эв эе”-ийг сахь гэсэн тэнгэрлэг зарчим нь Монголын төрт ёсны тулгуур зарчим болж иржээ. Энэхүү “эв эе”-ийг сахь гэсэн сургаалыг орчин үеийн улс төрийн сэтгэлгээний үүднээс дахин үнэлж, хүний зан үйлийн зайлшгүй дагаж мөрдөх үндсэн хэм хэмжээ /категорический императив, basic norm/ гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. Өөрөөр хэлбэл төрт ёсны гол үзэл санаа бол ард түмний хүсэл зориг, үнэт зүйлсийг харгалзан үзэх нь туйлын чухал төдийгүй аж ахуй, амьдрал, зан үйлээр нь суулгаж өгсөнд оршино. Хүний зан үйлийн зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээний үндсийг Германы сонгодог философич И.Кант гаргаж тавьсан бөгөөд түүний үзэл санаанд тулгуурлан Кельзен, Харт гэх мэт судлаачид хөгжүүлсэн байна.

Хүний зан үйлийн зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээ нь нийгэм, түүх, төрөөс дээгүүр орших бөгөөд хүний амьд байх гэсэн амьдралын зорилгыг өөртөө багтаасан “Өөрт хүсэхгүй зүйлийг бусдад бүү хий” /Т.Гобсс/, “Хүн өөрийн зан үйлийг авч явахдаа бусдад хууль болохуйцаар авч яв, хүн хүндээ хүний ёсоор ханд” /И.Кант/ гэсэн хүний оршихуйн зарчмаар илэрдэг нөхцөлгүй хууль билээ. Энэхүү үзэл санаа дорно дахинд ч байсан /Хятадын Күнз: “Өөртөө тохиохыг хүсэхгүй байгаагаа бусдад бүү хүс”, Японы хан хүү Сётоку Тайси: “юмсын хамгийн зохистой зөв ёс журам нь зөвшилцөл”/ бөгөөд Монголчуудын “эв эеийг сахь” гэсэн сургаал нь дээрхи санаануудтай агуулгаараа ижил байгаа болно.

Өөрөөр хэлбэл, харилцан бие биений амьдрах хүсэл эрмэлзлэл, эрхийг хүлээн зөвшөөрч, эв эеийг сахих буюу зохицох гэсэн санааг бүрэн агуулж байна.

Монголчууд хүний зан үйлийн зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээг гаргаж тавьсан явдал нь тэдний улс төрийн сэтгэлгээний түвшинг тодорхой хэмжээгээр тодорхойлж байна.

Учир нь хүн төрөлхтөний улс төрийн сэтгэлгээний хөгжлийн бүхий л үе шатанд ард түмний хүсэл зориг, хүмүүс хоорондын зохицлыг хангах гол арга хэрэгсэл механизмыг бүрдүүлж ирсэн байдаг.

Abstract

The series of books, "White history of 10 virtuous" by renowned scientists and historians, is the historical and cultural heritage of Mongolia preserved in that information these materials help study the historical traditions of Mongolia.

Ном зүй

Алтан товч. (Лувсанданзан). УБ., 1990 он

Далай Ч. Эзэн Чингис хааны гэрээслэл ба эдүгээ миний бодол. Чингисийн туг.№1.
УБ.,1990 он

Инжиннаши В. Хөх судар, УБ., 2006 он

Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002 он

Монголын нууц товчоо. УБ., 1990 он

Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992 он

Монголын философийн түүх. Дэвтэр №1. УБ., 1997 он

Оюун түлхүүр нэрт шастир. (МУИС). УБ., 2006 он

Сайшаал. Чингис хааны товчоон. Дэвтэр №1, 2. Хөх хот., 1987 он

Перецен. Чингис хааны байлдааны бодлого ба арга. Хөх хот., 1983 он

Цэрэнсодном Д. Монголын нууц товчооны эрдэм шинжилгээний орчуулга,
тайлбар. Ред Д.Төмөртоогоо.УБ., 2000 он

**МОНГОЛЫН ӨНӨӨГИЙН УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ОЙЛГОЛТ,
ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХУЙ****О.Хатанболд**ШУА-ийн Философийн хүрээлэнгийн
Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч**Д.Энхболд**

Докторант

Хураангуй

Бид энэхүү өгүүлэлдээ монголын нийгмийн улс төрийн соёлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг тодруулж, улмаар улс төрийн соёлын талаарх орчин үеийн онолд тулгуурлан дүгнэлт гаргах, таамаглалаа шалгах, онолын шинжтэй шинэ санааг дэвшүүлэхийг зорилоо. Тодруулбал, өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг мэргэжлийн чиглэлээр ажилладаг экспертүүдээр тодорхойлуулах зорилготой ба Монгол дахь ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, үнэлэмж, үнэ цэнийг өсгөх, улс төрийн ухаалаг сонголт хийхэд нь туслах, оролцооны субъектив хүчин зүйлийг түлхүү судлан тогтоох нь нэн чухал. Угтаа 1990-ээд оноос хойшхи иргэдийн улс төрийн соёлын төлөвшилийг шинжээчдээр үнэлүүлэн улмаар энэ хүрээн дэх сорилт бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулах, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулахыг чухалчилав. Энэ хүрээнд ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр-эрх зүйн салбарт хэрэгжсэн «Монголын нийгмийн хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» суурь судалгааны хүрээнд хийгдсэн «Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага» (УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА, 2020) сэдвийн хүрээнд шинжээчдийн судалгааны үр дүнг дэлгэрэнгүй танилцуулж буйгаараа өгүүллийн гол зорилго оршино. Чингэхдээ бид дараах тодорхой асуудлуудыг (i) монголчуудын улс төрийн соёлын талаарх ойлголт, төсөөлөл, хандлагын түвшин; (ii) улс төрийн

соёлын ба түүний субъектуудын төлөвшил, түүний өөрчлөлт; (iii) улс төрийн соёлын шинж чанар, хэв маягийн талаарх өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ зэргийг хөндөх болно.

Ориил

Аливаа нийгэм нь хууль ёсных байж гэмээ нь хэм хэмжээний журмаас халихгүйгээр хуулийг дээдлэж, хууль ёсны үнэлэмжийг дэмжсэн ардчилсан улс төрийн дарамтнаас өөрийгөө зориуд хамгаалах байдлаар зохион байгуулагдсан байдаг. Энэ утгаараа орчин үеийн ардчилал хөгжсөн бүх орон сонгууль явуулдаг, гэхдээ сонгууль болгон ардчилсан байдаггүй. Ардчилсан төрийн үйлдлийн хууль ёсны байдал нь эцсийн дүндээ ардчилсан зөв дэг дээр бус, хуулийн дэг журмаас дээгүүр байдаг ёс суртахууны хүрээнээс үүссэн энэ тэргүүний эрх, хэм хэмжээн дээр суурилна. Зөвхөн төр л хууль ёсыг сахиулах хүчийг нэгтгэж, зүй зохистой байршуулж (Фукуяама, 2014) чадна. Эдгээр хүч нь улс оронд хууль дээдлэх ёсыг сахиулахад ч зайлшгүй хэрэгтэй. Бид ардчилал, өөрийгөө удирдах ёс, хүний эрхийг дээдлэх ёсыг сахиулан бататгах, мөн түүнчлэн өөр ард түмнийг захирах аливаа оролдлого бол эзэрхийлэх санаархал бус ердөө шилжилтийг хэрэгжүүлэх санааг нотлохын зэрэгцээ төрийг төвхнүүлэх урлаг үндэсний хүч чадлын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг байхыг онцолж буй.

Чухамдаа улс төрд өөрийгөө бэлтгээгүй, хүнийхээ хувьд төлөвшөөгүй, итгэл үнэмшил үнэт зүйлс нь тогтоогүй, хувийн хариуцлагаа ухамсарлаагүй, ёс зүйгүй, хариуцлагагүй, эрх зүйт төрийн хэм хэмжээний наад захын мэдлэг ойлголтгүй, мэдлэг боловсрол тааруу улс төрчид хошуучлагч болох боломжгүй гэдгийг бидэнд өнөөгийн хувьсан өөрчлөгдөж буй цаг үе анхааруулж байна. Нэг үгээр, улс төрийн соёл бол зөвхөн улс төрчдийн асуудал биш бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр нийгмийн сэтгэл зүйг алдагдуулсан, өсвөр үеийнхэнд сөргөөр нөлөөлөх олон янзын мэдээ мэдээлэл, санал сэтгэгдлүүдийг түгээж буй нь угтаа нийгмийг хагаралдуулах, хэт туйлширсан хандлагыг бий болгоход нөлөөлж буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Тиймээс улс төрийн соёлын төлөвшлийн үйл явц нь бүхий л цаг үед үргэлжлэн хэрэгжиж байдаг үзэгдэл. Энэ утгаараа улс төрийн соёл нь нийгмийн оюун санаанд бүрэлдсэн итгэл үнэмшил, ёс заншил, уламжлалт сэтгэлгээтэй холбоотой байдаг учраас түүний өөрчлөлт удаан явагддаг. Мөн иргэдийн ухамсарт ардчиллын үзэл санааны үнэт зүйлсийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, анархизм руу чиглэсэн үйлдлүүдийг хууль эрх зүйн зохистой бодлогоор хазаарлан барих, улмаар


нийгмийн сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх ач холбогдлыг тодруулах нь нэн чухал. Угтаа, улс төрийн соёл нь хэдийгээр орон бүрт, үндэстэн бүрт өөр өөрийн онцлогтой байдаг боловч бодит, нийтлэг үзэгдлийг илэрхийлдэг шинжлэх ухааны ойлголт болохын хувьд нийтлэг гэж болмоор хэмжигдэхүүнтэй. Тэдгээрийг ашиглах нь судалгааг тодорхой, чиглэлтэй болгох бөгөөд аль ч нийгмийн гишүүдийн улс төрийн соёлын ерөнхий дүр зураг, тэдгээрийн ойлголт, төсөөлөл, улс төрийн субъектуудын улс төрийн соёлын төлөвшил, улс төрийн шинж чанар, хэв маягийг тодруулах нь чухал. Үүнийг дараах гурван хэсэгт тухайлан авч үзсэнээ толилуулж байна.

(i) Монголчуудын улс төрийн соёлын талаарх ойлголт ба төсөөлөл

Олон түмний улс төрийн мэдлэг, улс төрийн соёлын чанар чансаа, хэр хэмжээ манай нийгмийн улс төрийн амьдрал ээдрээтэй, зөрчил бэрхшээлтэй болж байгаа өнөөгийн нөхцөлд эерэг сөрөг талын алинаар ч тодорхой илрэх тохиолдол бий. Энэ нь олон нийтийн багагүй хэсгийн хувьд, улс төрийн мэдлэг дутуу, дулимаг байгаа тохиолдолд улс төрийн үйл явдалд мэдлэгт үндэслэгдсэн ухаан бодлоор биш, харин сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжээр хандах явдал цөөнгүй гарч байгаа нь судалгааны дүнгээр батлагдсан юм.

Нэг үгээр хэлбэл, хүн амын тодорхой хэсэг нь онол, улс төрийн мэдлэг, түүнд тулгуурласан үзэл санаа болоод улс төрийн итгэл үнэмшил төдийлэн хангалтгүй байгаагийн улмаас нийгэм-улс төрийн үйл ажиллагаа, байр суурийн хувьд хүлцэнгүй, идэвхгүй байх, эсвэл өөрийн үзэл бодолгүйгээр бусдыг аялдан дагалдах явдал нилээд ажиглагдах боллоо. Нөгөөтээгүүр, жирийн иргэд биш харьцангуй боловсролтой, улс төрийн итгэл үнэмшил, оролцоо сайтай үзэл бодлоо илэрхийлэхүйц хэмжээний улс төрийн соёл, мэдлэг өндөртэй хүмүүсээс тэдний улс төрийн идэвх, улс төрийн амьдралд ямар байр суурьтай оролцоог тодруулахад судалгаанд хамрагдсан шинжээчдийн 69.2 хувь нь улс төрийн амьдралд өөрсдийгөө идэвхтэй оролцдог гэж хариулсан бол 30.8 хувь буюу 3 хүн тутмын нэг нь идэвх хангалтгүй гэж үнэлсэн байна. Энэ бол судалгаанд хамрагдсан шинжээчдийн улс төрийн идэвх хангалттай хэмжээнд буй хэмээн үнэлж болох авч тэдний ихэнх нь зөвхөн ажиглагчийн байр сууринаас хандах, тэднийг идэвхтэй оролцогч гэж дүгнэх боломжгүй байгаа ажиглагдаж байна (Зураг 1).

Зураг 1. Улс төрийн амьдралд ханддаг байр суурь (нас, байр сууриар)



Эх сурвалж: «Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлох»

Экспертийн судалгаа. Улс төр, эрх зүйн салбар, Философийн хүрээлэн, ШУА.
Уб., 2019

Үүнийг дээрх зургаас харвал, эрхэлж буй ажил мэргэжилтэй нь харьцуулж үзэхэд төрийн захиргааны байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, их дээд сургуульд ажиллагсад зонхилон ажиглагчийн байр сууринаас хандахыг илүүд үздэг болжээ. Тухайлбал, судалгаанд хамрагдсан 40 хүртэлх насны оролцогчдын 80 хувь, 50 хүртэлх насны оролцогчдын 77 хувь нь, 50-аас дээш насны оролцогчдын 58 хувь нь тус тус улс төрд идэвхтэй оролцдог гэж үзсэн нь нас ахих тусам улс төрийн идэвх буурч байгааг илтгэнэ (УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА, 2019). Тэдний эл хариултаас улс төрийн амьдралыг сонирхон ажигладаг байдлаа идэвхтэй оролцдог гэж үзэх явдал илүү байгаа гэж дүгнэж болох юм.

Бидний хийсэн дараагийн шинжилгээ бол улс төрийн соёл, хандлагын түвшинд хийсэн шинжилгээ юм. Эл шинжилгээгээр онолын мэдлэг, мэдээлэл сайтай оролцогчдын хувьд тэдний үзэл хандлага, цаашлаад хууль, шударга ёс, ёс зүйг дээдэлсэн институт болон иргэдийн итгэл үнэмшил, ухамсарт суурилсан үзэл хандлагын нэгдэл гэсэн хоёр байр суурьт хувь тэнцүү хуваагдсан нь ажиглагдсан юм. Тодруулбал, иргэд олон нийтийн итгэл үнэмшил хийгээд түүнээс үүдсэн дадал хандлага, ойлголт, иргэдийн эрх ашиг дээдлэгдсэн, үнэт зүйлдээ тулгуурласан хандлагыг улс төрийн соёл хэмээн үзсэн нь 42.1 хувийг эзэлсэн байна. Харин хуулиа дээдэлдэг улс төрийн нам, улс төрчид сонгуульд шударга нэр төртэй өрсөлддөг зарчимд тулгуурласан улс төрийн оролцоо эрх тэгш байдал нь орчин үеийн улс төрийн соёлыг илэрхийлэх үнэт зүйлс, үнэлэмжийг илүүд чухалчилсан нь 44.7 хувийг эзэлж байна. Энэ нь улс төрийн соёлын үзэл хандлагыг улс төрийн оролцооны учир шалтгааны онолтой харьцуулбал, хэм хэмжээний хандлага

давамгайлж, үзэл суртлын хандлага, ойлголт удаалж байгаагийн зэрэгцээ оролцооны энэ хоёр төрөл холимог байдалтай болохыг харуулж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Улс төрийн соёлын үзэл хандлага, төрөл, хувиар

Үзэл хандлагын төрөл	I. Нийгмийн нийт гишүүдийн засаглал, засаг төрийн үндсэн зорилго, чиг үүрэг, үйл ажиллагаа, улс төрийн тогтолцоо, хөгжил төлөвшлийн үйл явц, нийгэмд болон шийдвэр гаргах түвшинд нөлөө үзүүлдэг хүчин зүйл	10.5
	II. Хүн төрөлхтний өв соёл, түүх уламжлал, сэтгэлгээний салшгүй нэг хэсэг, иргэдийн ухамсар сэтгэлгээтэй холбоотой мэдрэмж, иргэд олон нийтийн итгэл үнэмшил, итгэл үнэмшлээс үүдсэн дадал хандлага, ойлголт, иргэдийн эрх ашиг дээдлэгдсэн, үнэт зүйлдээ тулгуурласан хандлага байхыг улс төрийн соёл гэнэ. Бие хүний төлөвшил, үнэт зүйлс болоод мэдрэмжийн нэгдэл.	42.1
	III. Улс төрийн институт, бодлого боловруулагчдын харилцаанд үндсэн хуулийн үнэт зүйлс, зарчим дээдлэгдсэн хууль, улс төрчид шударга, дүрэм журмаа хуулиараа зохицуулдаг байх. Хуулиа дээдэлдэг улс төрийн нам, улс төрчид сонгуульд шударга нэр төртэй өрсөлддөг байх. Улс төрийн оролцоо орчин үеийн улс төрийн соёлыг илэрхийлдэг, улс төрчид нийгэм, эдийн засгийн үнэт зүйлсийг хүндэтгэх. Ёс зүй, ёс суртахуунтай байх, ёс зүйн хэм хэмжээг үйл ажиллагаандаа чандлан баримталдаг байх. Улс төрийн нам боловсон хүчний төлөвшил, үнэт зүйлс, үнэлэмжийг чухалчилсан.	44.7
	IV. Эдийн засаггүйгээр жирийн бор амьдралын үнэнг хүлээн зөвшөөрөхийг улс төрийн соёл гэнэ.	2.6


Эх сурвалж: «Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлох»

Экспертийн судалгаа. Улс төр, эрх зүйн салбар, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 2019

Улс төрийн соёлын дээрх үзэл хандлагыг улс төрийн оролцооны учир шалтгаантай харьцуулан дараах гурван хэсэгт буюу (i) үзэл суртлын; (ii) хэм хэмжээний; (iii) үүргийн түвшинд ангилан үзэхэд доорх сонирхолтой дүр зураг

ажиглагдсан юм. Тодруулбал, **үзэл суртал** бол хувь хүн нийгмийн албан ёсны үзэл суртлыг хуваалцаж, дэмжиж улс төрийн амьдралд оролцохыг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл, хувь хүний улс төрийн үнэт зүйлсийг төрийн улс төрийн үнэт зүйлстэй ижилсүүлдэг нэг хэлбэрийн сэдэл юм. Нэг үгээр төрийн улс төрийн үнэт зүйлс нь хувь хүний бүтцэд ордог. Ингэснээр хувийн ба улс төрийн зорилго чиглэл зөрөлдөх нь төр, улс төрийн системийн эсрэг, эрс сөрөг, бүр цаашлаад дайсагнасан хандлагыг бий болгож болно. Харин **хэм хэмжээний** учир шалтгаан нь хүний улс төрийн үйл байдлыг тухайн хүний хувийн үнэт зүйлс, зорилготой хамаагүйгээр улс төрийн системийн тулгалтаар бий болгодог гэж үздэг. Чингэхээр хувь хүний үйл байдал нь улс төрийн нийгэмшилтийн явцад бий болсон засаглалын хүчийг хүлээн зөвшөөрөх үндсэн дээр бий болдог гэж үзвэл улс төрийн системийг хүлээн зөвшөөрөх нь зөв бөгөөд үнэт чиг баримжаа мөн хэмээн тайлбарлахад хүргэнэ. Тэгвэл, **үүргийн** учир шалтгаан нь улс төрийн үйл байдлыг оршин буй улс төрийн системд байгаа хувь хүний нийгмийн үүргээр тодорхойлогдоно. Угтаа тухайн зонхилгч үүргийн учир шалтгаантай хүний улс төрийн үйл байдал нь түүний нийгмийн байр суурь, өөрийгөө үнэлэх үнэлэмжтэй салшгүй холбоотой (УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА, 2019).


Зураг 2. Улс төрийн соёлыг ойлгох хандлага ба түүний давамгайлах байдал (хувиар)



талаарх нийгэм, бүлгүүдийн ойлголт, үнэт зүйлд тулгуурласан хариу хандлага **2.6%**

Улс төрийн соёлын тухай ойлголтыг тодорхой тогтсон тодорхойлолтоор хязгаарлахгүйгээр ерөнхийд нь *нэгд*, танин мэдэхүйн төвшинд, *хоёрт*, сэтгэл хөдлөлийн төвшинд, *гуравт* үйл ажиллагааны хүрээнд илрэх учиртай гэж үзэж буй үзүүлэлтүүдээр үзэхүл танин мэдэхүйн түвшинг судалгаанд оролцсон экспертүүд илүүд үзэх хандлага үүгээр илэрнэ. Үүнийг тодруулбал, сэтгэл хөдлөлийн түвшний болон оролцооны хандлага харьцангуй бага байгааг харуулна.

Зураг 3. Улс төрийн соёлын бүтцийн талаарх бүрдэл хэсгүүд



Эх сурвалж: «Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлох»

Экспертийн судалгаа. Улс төр, эрх зүйн салбар, Философийн хүрээлэн, ШУА.
Уб., 2019

Судалгаагаар улс төрийн соёлын бүтцийн хамгийн чухал бүрдэл хэсгүүдэд **47.4** хувь нь чиг баримжаа, үзэл бодол, үнэт зүйлс, мэдлэг, санаа бодол, байр суурь, дадал туршлагад суурилсан **улс төрийн ухамсар** хэмээн үнэлсэн. Харин шинжээчдийн **31.6** хувь нь эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээ, уламжлал, хэл, бэлэг тэмдэгт суурилсан **улс төрийн хэм хэмжээг** дараагийн чухалд үнэлсэн байна. Түүнчлэн экспертүүдийн хувьд улс төрийн соёлтой хүн гэж ямар хүнийг нэрлэх талаар тодруулахад дараах шинж чанаруудыг өөртөө төлөвшүүлсэн байх ёстой хэмээн онцолжээ.

*Хүснэгт 2. Улс төрийн соёлтой хүний шинж чанарын талаарх шинжээчдийн
төсөөлөл (хувиар)*

Улс төрийн соёлын илэрхийлэмж	Хувийн ашиг сонирхлоос илүү үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэдэг байх	21.8	61.5
	Хууль, ёс зүйн хэм хэмжээг үйл ажиллагаандаа чандлан баримталдаг	18.2	51.3
	Улс төр, нийгмийн үйл явцыг бодитой үнэлж, дүгнэх чадвартай	14.5	41.0
	Эх орон, ард түмнийхээ сайн сайхны төлөө гэсэн итгэл үнэмшилтэй	12.7	35.9
	Хариуцлагатай, хэлсэн үгэндээ эзэн байдаг	9.1	25.6
	Шударга, үнэнч байх	8.2	23.1
	Улс төр, эрх зүйн өндөр мэдлэг, боловсролтой	6.4	17.9
	Алдаа, дутагдлаа ухамсарлаж, хариуцлага хүлээн, залруулах чадвартай байх	4.5	12.8
	Бусдын санаа бодлыг хүндэтгэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг	1.8	5.1
	Нийтэч, бусдыг ялгаварлан гадуурхдаггүй байх	0.9	2.6
	Сахилга баттай бусдын эрх ашгийг дээдэлдэг	0.9	2.6
	Чин сэтгэлээсээ ханддаг	0.9	2.6
НИЙТ		100	282.1

Хүснэгтэд хамгийн өндөр хувь авсан үзүүлэлтээр эрэмбэлэхэд, аливаа улс орны үйл явцад дүн шинжилгээ хийж чаддаг, хуулийн болон ёс зүйн хэм хэмжээг баримталдаг, үндэсний эрх ашгийг эрхэмлэн дээдэлдэг байх нь улс төрийн соёлтойг илэрхийлэх чухал гурван үзүүлэлт болохыг онцолсоныг хүснэгт (Хүснэгт 2)-ээс дэлгэрүүлэн харж болно. Дээрх шинж чанарыг өөртөө төлөвшүүлсэн улс төрчид өнөөгийн монголын нийгэмд байгаа эсэхийг судалгаанд хамрагдсан шинжээчдээр үнэлүүлэхэд тэдний таван хүн тутмын нэг нь «байхгүй» гэж хариулсан. Үүнээс 10.4 хувь нь УИХ-ын гишүүн асан, Р.Амаржаргалыг улс төрийн соёлтой гэж үзсэн нь доор дурдагдсан улс төрчдөөс харьцангуй илүү хувийг эзэлж байна.

Улс төрчдийг яагаад улс төрийн соёлтой гэж үзсэн шалтгааныг тодруулахад, шинжээчдийн 13.6 хувь нь эдгээр хүмүүс судалгаа шинжилгээнд тулгуурладаг, улс төр, хуулийн өндөр мэдлэгтэй, хуулийг дээдэлдэг мэргэшсэн, хүлээн зөвшөөрөгдсөн, бодитой үр дүн гаргадаг, харизм сайтай, боловрол мэдлэгтэй, манлайлах чадвартай гэж үзсэн байна. Харин 22.7 хувь нь зөв сэтгэлгээтэй, ёс суртахуунтай, харилцааны соёлтой, нийгмийн хариуцлагатай, олон нийтийг сонсдог, ард түмний төлөө шийдвэр гаргах чадвартай, хариуцлагаа ухамсарлаж, хариуцлага хүлээх чадвартай, амлалтаа биелүүлэхийг хичээдэг, үзэл бодлоосоо няцадаггүй учир ийнхүү улс төрийн соёлтой хэмээн үнэлж буйгаа илэрхийлсэн байна. Тэгвэл, улс төрийн соёл төлөвшөөгүй улс төрчдийн жагсаалтыг шинжээчдээр үнэлүүлэхэд дараах байдал ажиглагдсан юм (Зураг 4).

Доорх зургаас харвал, улс төрийн соёл төлөвшөөгүй улс төрчдийн жагсаалтыг С.Эрдэнэ (УИХ-ын гишүүн 2012-2020 оны 6 сар хүртэл) тэргүүлсэн нь харагдаж байна. Шинжээчдээс улс төрчдийг ийнхүү «улс төрийн соёлгүй» гэж үнэлэх болсон шалтгааныг тодруулахад тэдний 22.7 хувь нь эрх мэдлийн хуваарилалтын тэгш бус байдал, улс төрийн нам-бизнесийн олигархи бүлэглэл, хувийн эрх ашгийнхаа төлөө ажилладаг, өөрийн эрх ашгийн төлөө хууль баталдаг, хувийн асуудлаа нэн тэргүүнд тавьж, аливаа зүйлд хувийн өс хонзон санах, үнэнээс хол тасарсан, шударга бусаар хөрөнгөжсөн хэмээн үзсэн тул ийнхүү үнэлжээ. Харин шинжээчдийн 25 хувь нь улс төрчийн хувьд өөрийгөө улс төрд бэлтгэж чадаагүйгээр үл барам, хувь хүнийхээ хувьд төлөвшөөгүй, итгэл үнэмшил, үнэт зүйлс нь тогтоогүй гэж үзжээ.

Зураг 4. Улс төрийн соёлтой болон соёлгүй гэж үзсэн улс төрчид (хувиар)



Тайлбар: Зурагт 3 хувиас дээш хувь авсан улс төрийн соёлтой болон соёлгүй улс төрчдийг харуулсан болно.

Түүнчлэн хувийн хариуцлагаа ухамсарлаагүй, ёс зүйгүй, хариуцлагагүй, эрх зүйт төрийн хэм хэмжээний наад захын мэдлэг ойлголтгүй, мэдлэг боловсрол тааруу, боловсрол мэдлэг нимгэн улс төрчдийг ийнхүү улс төрийн соёл төлөвшөөгүй гэж үзэхэд хүрсэн байна. Шинжээчдийн 4.5 хувь нь нээлттэй ил тод байдал төлөвшөөгүй, 2.3 хувь нь ЖДҮ-ийн хэрэг, авлига хээл хахууль авсан, 2.3 хувь нь 1992 оны үндсэн хуулийн оршил хэсгийн «хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм» байгуулахын төлөө ард түмнийхээ эрх ашгийг хамгаалахын төлөө хэрхэн зүтгэсэн зэргийг үндсэн шалгуур болгосон талаар шинжээчид онцолсон байна.

Улс төрийн соёл, түүний хандлага, түвшин дэх өнөөгийн улс төрийн идэвх харьцангуй боломжийн түвшинд байгаа боловч үүнийг өнөөгийн оролцоотой нь харьцуулбал зөвхөн ажиглагчийн байр сууринаас хандаж байгаа нь тэднийг идэвхтэй оролцогч хэмээн шууд дүгнэх боломжгүй. Нөгөө талаар, насны бүлэг дээшлэх тусам улс төрийн идэвх буурах хандлага ажиглагдахын зэрэгцээ шинжээчдийн улс төрийн соёлын ойлголт, үзэл хандлага нь хууль, шударга ёс, ёс зүйг дээдэлсэн институт болон иргэдийн итгэл үнэмшил, ухамсарт суурилсан үзэл хандлагын нэгдэл гэсэн хоёр байр суурьт хувь тэнцүү хуваагдсан байна. Энэ нь онолын хувьд аль нэг хандлага давамгайлан орших боломжгүй гэдгийг практикт нотлон харуулсан. Тухайлбал, монголын өнөөгийн улс төрийн соёлд танин мэдэхүйн түвшин илүү, харин сэтгэл хөдлөлийн түвшний болон оролцооны

хандлага харьцангуй бага байгаа нь эл шинжилгээгээр тодорхой ажиглагдсан. Үүнийг ч судалгаанд оролцсон экспертүүд тухайлан үнэлсэнийг дээр дэлгэрэнгүй тэмдэглэсэн. Харин улс төрийн соёлтойг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн тухайд улс орны өмнө тулгарч буй аливаа асуудал, үйл явцад дүн шинжилгээ хийж чаддаг, хууль эрхийн болон ёс зүйн хэм хэмжээг баримталдаг, үндэсний эрх ашгийг эрхэмлэн дээдлэх зэрэг гурван үзүүлэлтийг чухал хэмээн үзсэн байна. Энэ бол улс төрийн соёлын төлөвшил манай улс төрчдөд хангалттай төлөвшөөгүйн дээр улс төрийн соёлтой гэж үзэх, улмаар улс төрчид монголын улс төрчдөөс 10 хүртэл хувийг авч чадаагүй нь судалгааны үр дүн тодорхой харуулсан.

ii. Улс төрийн соёлын ба түүний субъектуудын төлөвшлийн өнөөгийн байдал, өөрчлөлтийн тухайд

«Төлөвшил» хэмээх ойлголт нь улс төрийн соёлын хувьд өргөн дэлгэр хэрэглэгддэг суурь нэр томьёо юм. Өөрөөр хэлбэл, «улс төрийн соёлын төлөвшил» хэмээх ойлголтыг харьцуулсан улс төр судлалын шинжлэх ухаанд улс төрийн соёлын хувьсал, өөрчлөлтийн үйл явцын хүрсэн түвшин, түүний хүрээнд илрэх тэдгээрийн үйлчлэн орших динамик шинжийн илэрхийлэл гэдэг утгаар тайлбарладаг (Баасансүрэн Д, Хатанболд О. Энхболд Д, ба бусад, 2020). Улс төрийн соёлын төлөвшлийн үйл явц нь бүхий л цаг үед үргэлжлэн хэрэгжиж байдаг үзэгдэл гэж болно. Бид энэ хэсэгтээ улс төрийн соёлын төлөвшлийн өнөөгийн байдал хийгээд түүний субъектуудын төлөвшил, өөрчлөлтийг тодруулахыг зорив.

Улс төрийн соёлын гол элементүүдэд *итгэлцэл, оролцоо, мэдлэг, хандлагын* үзүүлэлт маш чухал. Энэ нь зөвхөн улс төрийн соёлын хэмжүүр төдийгүй ерөнхий соёлд ч өндөр ач холбогдолтой зүйл. Эдгээрийн төлөвшил сайн эсвэл муу байх нь улс орны хийгээд эдийн засгийн өсөлтөд шууд хамааралтайг олон судлаачид онцлон тэмдэглэсэн (Баасансүрэн Д, Хатанболд О. Энхболд Д, ба бусад, 2020) байдаг. Бид эл судалгаагаар нийгэм дэх олон институтуудын томоохон төлөөлөл болох төр, түүний институтэд олон нийтийн итгэл, хандлага ямар түвшинд байгааг болон иргэдийн улс төрийн оролцоо, тухайн улс төрийн систем, үйл явцын талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг тодорхойлохыг зорив. Чингэхэд, төр түүний институтэд итгэх иргэдийн итгэл, төрийг хүндэтгэх байдал «*маш хангалтгүй*» хэмээн үнэлэгдсэн нь иргэдийн улс төрийн боловсрол ч хангалттай төлөвшөөгүй байгааг шинжээчдийн судалгааны дүн харуулав.

Хүснэгт 3. Иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийн өнөөгийн нөхцөл байдлыг
үнэлсэн үнэлгээ (хувиар болон дундаж үнэлгээгээр)

Улс төрийн соёлын зарим элемент	Иргэдийн төр засгийг хүндэтгэх байдал	74. 4	17. 9	7.7	1.33
	Төр, түүний институтэд итгэх иргэдийн итгэл	71. 8	28. 2	0.0	1.28
	Иргэдийн төр засаг, түүний шийдвэрийг хүлээн зөвшөөрөх байдал	76. 9	23. 1	0.0	1.23
	Төр засагт хандах иргэдийн хандлага	59. 0	38. 5	2.6	1.43
	Иргэдийн төр засаг, түүний шийдвэрийг хүлээн зөвшөөрөх байдал	33. 3	59. 0	7.7	1.74
	Иргэдийн улс төрийн оролцоо	20. 5	61. 5	17. 9	1.97
	Улс төрийн систем, үйл явцын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл	47. 4	47. 4	5.3	1.57
	Иргэдийн улс төрийн боловсрол	65. 8	28. 9	5.3	1.39

Дээрх үзүүлэлтэд дундаж үнэлгээг тооцох үүднээс эл нөхцөл байдлыг өмнөх 5 жилтэй харьцуулахад, иргэдийн төр засгийг хүндэтгэх, төр түүний институтэд *итгэх иргэдийн итгэл, төр засгийн талаарх иргэдийн үнэлэмж, төрд хандах иргэдийн хандлага* гэсэн үзүүлэлтүүд өмнөхөөс дордсон үзүүлэлт өндөр хувьтай байгааг гэрчилнэ. Бидний энэ хэсэгт онцлохыг хүссэн зүйл бол иргэдийн оролцоо өмнөх 5 жилтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнд шинжилгээ хийж үзсэн. Чингэхэд, сүүлийн таван жилд эл байдал *бага зэрэг* сайжирсан гэж 3 шинжээч тутмын нэг нь хариулсан бол, бусад улс төрийн элементүүдээс ганц *зэрэг*

үнэлгээтэй гарсан үзүүлэлт байлаа. Тодруулбал, иргэдийн төр засгийг хүндэтгэх байдал (48.7%), төр, түүний институтэд итгэх иргэдийн итгэл (53.8%), төр засгийн талаарх иргэдийн үнэлэмж (50%), төр засагт хандах иргэдийн хандлага (42.1%)-ын төлөвшил сүүлийн 5 жилд хамгийн их дордсоныг доорх хүснэгт (Хүснэгт 4)-ээс харагдаж байна.

Хүснэгт 4. Улс төрийн соёлын төлөвшлийн өнөөгийн байдлыг

өмнөх 5 жилтэй харьцуулсан үнэлгээ (хувиар)

Улс төрийн соёлын зарим элемент	Иргэдийн төр засгийг хүндэтгэх байдал	48.7	23.1	20.5	7.7	0.0
	Төр, түүний институтэд итгэх иргэдийн итгэл	53.8	20.5	12.8	12.8	0.0
	Иргэдийн төр засаг, түүний шийдвэрийг хүлээн зөвшөөрөх байдал	15.4	35.9	25.6	23.1	0.0
	Иргэдийн улс төрийн оролцоо	7.7	25.6	28.2	35.9	2.6
	Улс төрийн систем, үйл явцын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл	17.9	15.4	43.6	23.1	0.0
	Төр засгийн талаарх иргэдийн үнэлэмж	50.0	31.6	13.2	5.3	0.0
	Төр засагт хандах иргэдийн хандлага	42.1	34.2	7.9	13.2	2.6
	Иргэдийн улс төрийн боловсрол	21.1	23.7	36.8	15.8	2.6

Энэхүү өөрчлөлтийн үндсэн шалтгааныг шинжээчид улс төрчдийн буруутай үйл ажиллагаатай шууд холбон тайлбарласан нь үнэний ортой. Тодруулбал, улс төрчид биелэх боломжгүй зүйлийг амладаг, амалснаа биелүүлдэггүй, хоосон «*нопордог*», ёс зүйгүй зан үйл, иргэдийг хэт бэлэнчлэх сэтгэлгээ рүү түлхсэн үйл ажиллагааг явуулдаг нь ийнхүү улс төрийн соёлын төлөвшилд сөргөөр нөлөөлсөн хэмээн үнэлсэн байна.

Зураг 5. Сүүлийн таван жилд гарсан улс төрийн соёлыг өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс (хувиар)

	• Явуулж буй үйл ажиллагаа хэлбэр хийсвэр төдий иргэдийг бэлэнчлэх сэтгэлгээ рүү хандуулж байна	29.8%
	• Улс төрчид амлалтандаа хүрэхгүй байгаа тул иргэдийн итгэл үнэмшил буурсан	26.3%
	• УИХ, ЗГ-ын гишүүний ёс зүйгүй, хариуцлагагүй байдал ихсэх болсон нь төрийн болон намын институтэд улс төрийн соёлын боловсрол олгох тогтолцоогүйтэй шууд холбоотой	14.0%
	• ЖДҮ-ийн хэрэг, авлигад өртсөн байдал, кэйсүүд	8.8%
	• Иргэдэд мэдээ, мэдээлэл дутмаг байдгаас тэдний улс төрийн мэдлэг хомсдож, улмаар төрийн түшээдээ сонгох сонголт нь буруудаж байна	7%
	• Үндэсний эрх ашиг, хүн амын аж байдлыг дээшлүүлэхэд анхаардагтай холбоотой	3.5%
	• Хэвлэл мэдээлэл, олон нийтэд хүрэх хүртээмж ихэссэн	3.5%
	• Шинжлэх ухааны мэдлэг тааруу	3.5%
	• Цаг хугацааны асуудал байсан	1.8%
	• Хууль эрх зүйн хэрэгжилт сул, хуулийн өмнө тэгш байх зарчим алдагдсан	1.8%


Тэдгээр сөрөг нөлөөллийн өөрчлөлтийн шалтгаан тус бүрийг хувиар тооцон, улс төрийн соёл хэрхэн төлөвшиж байгааг 1-10 хүртэлх оноогоор (1-огт төлөвшөөгүй, 10-бүрэн төлөвшсөн) үнэлүүлэхэд 7-10 хүртэлх оноог аль ч шинжээч өгөөгүй ба бүгд 6 онооноос доош үнэлсэн байна. Тухайлбал, оролцогчдын ихэнх

буюу 51.3 хувь нь 2-3 оноо өгсөн бол, тэдний 28.2 хувь 4-5 оноо өгчээ. Энэ нь улс төрийн соёлын төлөвшил дундаас доош тэр тусмаа бүрэлдэх төдий шатандаа байна гэсэн тааруухан дүгнэлт хийхэд хүргэж байна (Зураг 6).

Огт төлөвшөөгүй (1)						Бүрэн төлөвшсөн (10)			
1	2	3	4	5	6	7	8	9	10

Харьцуулсан шинжилгээгээр тэдний өгсөн үнэлгээг эрхэлж буй ажил мэргэжилтэй нь харьцуулбал, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллаж буй шинжээчдийн 50 хувь, олон нийтийн байгууллагад ажиллаж буй шинжээчдийн 42.9 хувь нь улс төрийн соёл огт төлөвшөөгүй хэмээн үнэлсэнийг эндээс харж болно.

Зураг 6. Монгол Улсад улс төрийн соёл хэрхэн төлөвшсөн талаарх шинжээчдийн үнэлгээ
(1-10 оноо, хувиар)




Харин тэдний ажилласан жилийг улс төрийн соёлын төлөвшилд өгсөн үнэлгээтэй харьцуулбал 16-20 жилийн туршлагатай экспертүүдийн 90 хувь нь 2-3 оноо өгсөн бусдаас бүлгийнхээс илүү байна. Мөн улс төрийн соёлын төлөвшилд өгсөн үнэлгээг насны бүлгээр ангилавал, насны бүлэг буурах тусмаа үнэлгээ өсөх хандлага ажиглагдсан. Тухайлбал, 39 хүртэлх насныханы 40 хувь нь 5 оноо өгсөн бол, бусад насны бүлэгт 2-3 оноо өгсөн үнэлгээ давамгайлжээ. Ийнхүү үнэлгээ өгөх болсон эл шалтгааныг тодруулбал, боловсрол нимгэн, улс төрийн болон хууль эрх зүйн мэдлэг сул хүмүүс улс төрд орох болсон нь улс төрчдийн бие хүний төлөвшил муу, ёс суртахууны дутагдал буйтай холбоотой.

Зураг 7. Улс төрийн соёлын төлөвшилд өгсөн үнэлгээний шалтгаан, хувиар



Улс эх оронд хөгжлийн ахиц, хурд удааширч, нийгэм-эдийн засгийн болон улс төрийн тогтворгүй бодлого явуулдаг зэрэг нь ийнхүү төлөвшилд сэргөөр нөлөөлж буй хүчин зүйл болжээ. Судалгаанд оролцсон шинжээчид Монгол Улсын улс төрийн соёл «ихээхэн дордсон» хэмээн 3 хүн тутмын нэг нь үнэлсэн бол, 5 хүн тутмын нэг нь «огт өөрчлөлтгүй» гэсэн үнэлгээг өгчээ. Доорх зурагт харуулсан үнэлгээг багцлан үзвэл 53.8 хувь нь өмнөхөөс дордсон, 20.5 хувь нь өөрчлөлтгүй гэж дүгнэсэн нь улс төрийн соёлын түвшинд ахицтай эерэг өөрчлөлт гараагүй гэсэн ерөнхий дүгнэлт гарч буй нь үүнээс ажиглагдаж байна.

Зураг 8. Сүүлийн 5 жилд манай орны улс төрийн соёлын өөрчлөлтийн үнэлгээ (хувиар)



Монгол Улсад сүүлийн 5 жилд улс төрийн соёл дордож, огт өөрчлөлтгүй хэмээн үнэлэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж шинжээчид үзжээ. Тухайлбал, хувь хүний ёс суртахуунгүй үйл байдал, аминч үзэл, бизнес эрхлэгчид улс төрд их хэмжээгээр орох болсон зэрэг нь хүчтэй нөлөөлж буй гол хүчин зүйлс болжээ. Доорх хүснэгтээс бусад хүчин зүйлсийн нөлөөллийн талаар дэлгэрэнгүй харж болно.

Хүснэгт 5. Улс төрийн соёлын өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс, шалтгаан (хувиар)

Улс төрийн соёлын өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс, шалтгаан	Хувиа хичээсэн үзэл бодол, бизнес эрхлэгч нар улс төрд зүтгэж байна,	36.2
	Улс төрчдийн хариуцлагагүй үйлдлийн үр дагавар	14.9
	Засгийн газрын ёс зүйгүй байдал, ёс зүйгүй, ёс суртахуунгүй, хэт задгай бүдүүлэг байдалтай	14.9
	Авилгад өртсөн байдал, олон улсын авлигын болон ил тод байдлын индексээр байнга ухарч байгаа	8.5
	Хүчинтэй хувь	

Хөгжлийн асуудал түүнд нөлөөлж буй хүчин зүйлс нь зөвхөн тухайн улсын доторх асуудал биш.	8.5
Сонгогчийн боловсрол нимгэн	4.3
Сонгуулийн үр дүн, сонгуулиуд нөлөөлсөн. Ерөнхийлөгчийг зөв сонгосон үндэсний эрх ашгийг дээдэлдэг хүн гарч ирсэн.	4.3
Олон нийт, нийгмийн мэдээлэл авах, хайх, байр суурь үзэл бодлоо илэрхийлэх орон зай	4.3
Хууль эрх зүйн хэрэгжилт сул, хариуцлагын тогтолцоо улам дордсон.	2.1
Амьдрал, ажил хэрэг начир дээрээ илт зөрчилдсөн.	2.1

НИЙТ 100

Онолын үүднээс судалгааны дээрх үнэлгээг харьцуулбал, хүмүүсийн эрчимтэй нийгэмшлийн үе хэдийд тохиолдсноор нь улс төрийн соёлын дотоод ялгааг гаргах таамаглалыг дэвшүүлж болох юм. Харин эмперик судалгааны хувьд улс төрийн аливаа асуудалд хандах хандлагыг насны бүлгээр ангилах байдлаар улс төрийн соёлын ялгарал буй эсэхийн шинж тэмдгийг тогтоож мөн болно. Чингэхээр, улс төрийн соёл, ялангуяа «*том*» соёл нь тогтонги шинжтэй хэдий ч өөрчлөгдөж байдаг нь ойлгомжтой. Гэхдээ соёлын өөрчлөлтийн шинж чанар, механизм нь зөвхөн нийгэмшлийн үйл явцаас хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, ардчилсан нийгэмд төрж өссөн хүний нийгэмшлээс өөр шалтгаан, механизмаар дамжин соёл өөрчлөгдөх явдал гарч байгааг бид анхаарах нь зүйтэй. Энэ бүхэн нь социалист тогтолцооноос ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн орнууд, эсвэл удаан хугацаанд цэргийн дэглэм, хаант (авторитари) засаглалтай байгаад ардчилалд шилжсэн улс орнуудад насны бүх бүлгийн хүмүүс улс төр, эдийн засаг, нийгэм, оюун санааны цоо шинэ нөхцөлд гэнэт шилжин орсонтой шууд холбоотой түүхэн үйл явц юм.

Үүний нэг тод жишээ нь эрчимтэй нийгэмшлийн үе нь өмнөх дэглэмийн үед хэдийнээ нийгэмшиж, улмаар улс төрийн тодорхой үнэлэмжтэй болсон хүмүүсийн улс төрийн соёл огцом өөрчлөгдсөн явдал юм. Тодруулбал, өмнөх дэглэмийн үед илүү давуу эрхтэй, тодорхой байр суурьтай байсан маш олон хүмүүсийн хувьд улс төрийн үнэлэмж өмнөх үеийнхнээсээ эсрэгээр эргэсэн тохиолдол олон бий. Үүнээс улбаалан шилжилтийн нөлөөллөөр шинэ маягийн нийгэмшил бий болж, улмаар

хүмүүсийн зарим хэсэгт улс төрийн тодорхой үнэлэмжгүй аминч үзлийн хандлагатай, улс төрийн аливаа асуудалд нийгмийн доторх зонхилох уур амьсгалыг аялдан дагах хандлага үлэмж нэмэгдсэн хэмээн үзэж болно.

Үүнийг задлахул, нийгмийн сайн сайхан, шударга ёс, зөв төлөвшил гэхээсээ илүүтэй улс төрийн амьдралд ялангуяа улс төрчдөд «албан тушаал», «орлого», «эрх мэдэл», «байр суурь» гэх мэт хувийн эрх ашгийг эрхэмлэх хандлага нэн тэргүүний зүйл болон өөрчлөгдсөн. Хоёрт, зарим тодорхой хэсэгт улс төрийн асуудалд өөрт нь чухал хэмээн үзсэн бол ямар байр суурийг үл тоон өөрт ашигтай талаас нь ойлгож, дагалдах хэт аминч үзлийг чухалчлах, үнэлэмж бий болсон. Гуравт, улс төрийн аливаа сонголт хийхдээ аль нэг улс төрч, улс төрийн намын эрх ашгийн үүднээс хандах эрхэмлэлээс улбаатайгаар «нартай талыг дагаж амьдрах», «салхи аль зүгээс байгааг мэдрэх» зарчмыг баримтлах маягаар нийгмийн огцом шилжилтийн үед өөрөөр дахин нийгэмших эхлэл тавигдаж, бас төлөвшсөнийг харуулна. Үүний нэг илрэл бол, улс төрийн субъектуудын улс төрийн соёлын төлөвшлийн өнөөгийн байдалд гарсан өөрчлөлт юм. Тодруулбал, тухайн институт яаж, ямар янзтай бүрэлдэх, амьдрал дээр хэрхэн хэрэгжих, яаж үйлчлэх зэрэг нь гагцхүү соёлоос ихээхэн хамааралтай. Учир нь соёл бол шалтгаан, харин институт түүний үр дагавар нь байдаг гэсэн үг огт биш. Тэгэхээр соёл, институт хоёрын харилцаа холбоо их нарийн бөгөөд хэдийд аль нь илүү хөдлөнгө шинжтэй байна гэдгээс харилцан үйлчлэлийн шинж чанар нь хамаарна. Энэ талаар судалгаанд хамрагдсан шинжээчид улс төрийн соёлын төлөвшилд голлох үүрэг гүйцэтгэх дараах субъектуудыг чухал хэмээн тодорхойлжээ (Зураг 9).

Зураг 9. Улс төрийн соёлын төлөвшил голлох нөлөөтэй субъектууд (хувиар)



Улс төрийн соёлын төлөвшилд хамгийн чухал үүрэгтэй субъектэд улс төрийн нам (22.2%), тэргүүлэх ач холбогдолтой байгаа бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл (17.1%), иргэд сонгогчид (10.4%), төр, төрийн байгууллагууд, ИНБ-уудыг онцлох үүрэгтэй болохыг судалгаанд хамрагдсан шинжээчид тодорхойлсон байна.

Судалгааны энэхүү дүнгээр төрийн гурван өндөрлөгийг субъект тус бүрээр нь улс төрийн соёлын төлөвшлийн өнөөгийн байдлыг дараах үзүүлэлтээр үнэлүүлэхэд, тэдгээрийн өөрчлөлтийг сүүлийн таван жилийн нөхцөл байдалтай харьцуулан гаргахыг зорьсон юм.

Хүснэгт 6. Төрийн гурван өндөр албан тушаалтны
улс төрийн соёлын түвшин (үндсэн үзүүлэлт, хувиар)

Улс төрийн соёлын түвшин	а. Өнөөгийн байдлын үнэлгээ (сайн-3, дунд-2, муу-1); б. Өөрчлөлтийн үнэлгээ (ихээхэн сайжирсан-5, бага зэрэг сайжирсан-4, хэвэндээ-3, бага зэрэг дордсон-2, ихээхэн дордсон-1)	Ерөнхийлөгч	Ерөнхий сайд	УИХ-ын дарга	б. өөрчлөлтийн үнэлгээ	Ерөнхийлөгч	Ерөнхий сайд	УИХ-ын дарга
	а. өнөөгийн байдлын үнэлгээ							
Амласандаа хүрэх		1.7	1.9	1.8		2.5	2.9	2.7
Хүлээсэн үүргээ биелүүлэх		1.8	2.0	1.8		2.5	3.0	2.9
Хууль, журмыг баримтлах		1.8	2.1	2.1		2.5	2.8	2.7

Соёл, үнэт зүйл	1.8	1.9	1.8	2.5	3.0	2.9
Санхүүжилт хөрөнгө оруулалт	1.9	2.1	1.8	2.6	2.9	2.6
Шийдвэр гаргах үйл явц	1.9	2.2	2.0	2.6	3.1	2.8
Хариуцлага хүлээх	1.6	1.7	1.6	2.3	2.5	2.4

Эдгээр гурван субъектуудын улс төрийн соёлын төлөвшлийн *өнөөгийн байдлын үнэлгээ* 7 үзүүлэлтийн хувьд дунджаас дээгүүр үнэлэгдсэн авч Ерөнхий сайдын хувьд УИХ-ын дарга, Ерөнхийлөгчөөс үзүүлэлт тус бүр дээр *0.1-0.3 пунктээр* илүү үнэлгээ авсан байна. Харин улс төрийн соёлын *өөрчлөлтийн үнэлгээгээр* Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд хариуцлага хүлээх чадварын үзүүлэлтэд дунджаас доогуур үнэлгээтэй байна. Харин бусад үзүүлэлтүүдийн хувьд дээрх гурван субъектууд гурвуулаа дундаж үнэлгээ авсан. Улс төрийн соёлын төлөвшлийн өөрчлөлтийн үнэлгээгээр Ерөнхий сайдын хувьд УИХ-ын дарга, Ерөнхийлөгчөөс үзүүлэлт тус бүр дээр *0.2-0.5 пунктээр* илүү үнэлэгдсэн бол, шийдвэр гаргах үйл явцын үзүүлэлт дээр дунджаас дээгүүр үнэлэгдсэн.

Үүнийг тухайн субъектуудын албан тушаалын хувьд бус институцийнх нь хувьд 10 оноогоор үнэлүүлэхэд гурвуулаа дунджаас доогуур үнэлгээг авсан хэдий ч Засгийн газар *4.4 оноогоор* тэргүүлж, харин Ерөнхийлөгчийн институци *4.1 оноогоор* удаалсан нь УИХ (3.6 оноо)-аас *+0.5 пунктээр* илүү үнэлэгдсэн байна. УИХ-ын хувьд ийнхүү дунджаас нилээд доогуур үнэлэгдсэн нь өнгөрсөн сүүлийн 2 жилийн хугацаанд УИХ-ын нилээд олон гишүүд өөрсдийн мэдээлэлд ойр, албан тушаалын давуу байдлаа ашиглан ЗГ-ын жижиг дунд үйлдвэрийн сангаас өөрийн хамаарал бүхий компани, аж ахуйн нэгжүүдээр дамжуулан их хэмжээний зээл авч, түүнийг эргүүлэн төлөөгүй болон бусад авлига, албан тушаалын гэмт хэргүүдтэй холбогдсон нь ийнхүү доогуур үнэлэгдэхэд хүргэсэн байна. Улс төрийн соёлын төлөвшилд чухал нөлөөтэй институци болохын хувьд улс төрийн намуудад улс

төрийн соёлын төлөвшлийн өнөөгийн байдал, гарч буй өөрчлөлтийг үнэлүүлэхэд дараах байдал ажиглагдав.

Хүснэгт 7. Улс төрийн намуудын улс төрийн соёлын төлөвшлийн үнэлгээ
(үзүүлэлтээр, хувиар)

Улс төрийн намууд	а. Өнөөгийн байдлын үнэлгээ (сайн-3, дунд-2, муу-1), б. Өөрчлөлтийн үнэлгээ (ихээхэн сайжирсан-5, бага зэрэг сайжирсан-4, хэвэндээ-3, бага зэрэг дордсон-2, ихээхэн дордсон-1)				б. Өөрчлөлтийн үнэлгээ			
	Монгол	Ардчилсан Нам	МАХН	УИХ-д суудалгүй УТН-ууд	Монгол Ардын Нам	Ардчилсан Нам	МАХН	УИХ-д суудалгүй УТН-ууд
Амласандаа хүрэх	1.5	1.3	1.2	1.2	2.2	1.8	1.8	1.8
Хүлээсэн үүргээ биелүүлэх	1.4	1.5	1.2	1.2	2.1	2.0	2.0	2.0
Хууль, журмыг баримтлах	1.4	1.3	1.5	1.5	2.1	2.1	2.1	2.1
Соёл, үнэт зүйл	1.3	1.3	1.7	1.7	2.2	2.0	2.0	2.0
Санхүүжилт хөрөнгө оруулалт	1.4	1.3	1.2	1.2	2.1	2.0	2.0	2.0
Шийдвэр гаргах үйл явц	1.4	1.3	1.4	1.4	2.0	2.0	2.0	2.0
Хариуцлага хүлээх	1.3	1.2	1.3	1.3	2.0	1.9	1.9	1.9

Дээрх долоон үзүүлэлтээр үнэлэхэд улс төрийн намуудад дунджаас доогуур үнэлгээ авсан хэдий ч эрх баригч намын хувьд бусад намаас дөнгөж **+0.1 пунктээр** илүү байгаа нь тухайн улс төрийн намуудын улс төрийн соёлын төлөвшлийн өнөөгийн байдал хангалтгүй түвшинд байгааг шинжээчдийн судалгааны дүн

харуулж байна. Харин судалгаанд хамрагдсан улс төрийн намуудын улс төрийн соёлын төлөвшилд гарч буй өөрчлөлтийн үнэлгээгээр өмнөхөөс дордоогүй байгаа ба МАН-ын хувьд сүүлийн 5 жилд гарсан өөрчлөлт нь 7 үзүүлэлт тус бүрт дунджаар 0.7 пунктээр өссөн бол, Ардчилсан нам, МАХН-ын намын хувьд 0.5-0.7 пунктээр, бусад намын хувьд 0.6-0.8 пунктээр тус тус өссөн үзүүлэлт гарчээ. Гэхдээ энэхүү өөрчлөлтөд эрс өөрчлөлт байхгүй, өөрчлөлт ажиглагдахгүй шахам байгаа нь улс төрийн намууд дундаж үнэлгээнээс доогуур үнэлгээтэй байгааг эл судалгааны дүн харуулж байна. Тухайлбал, нам тус бүрээр бус улс төрийн институцийнх нь хувьд 10 оноогоор үнэлүүлэхэд дөнгөж 2.7 гэсэн үнэлгээг авсан нь улс төрийн намуудад улс төрийн соёлын төлөвшил институцийн хувьд «*маш хангалтгүй*» байгааг эл үнэлгээ харуулж байна.

Бидний хийсэн дараагийн шинжилгээ бол иргэний нийгмийн байгууллагуудын улс төрийн соёлын төлөвшлийн байдал юм. Монгол дахь иргэний нийгмийн байгууллагуудын улс төрийн соёлын төлөвшлийг тухайн субъектийн *амласандаа хүрэх, хүлээсэн үүргээ биелүүлэх, хууль, журмыг баримтлах, соёл, үнэт зүйлээ хадгалах, санхүүжилт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох, хариуцлага хүлээх чадвар* гэсэн долоон үзүүлэлтээр өнөөгийн байдал болон түүний өөрчлөлтийн үнэлгээг хийв. Чингэхэд дээрх долоон үзүүлэлтээс санхүүжилт-хөрөнгө оруулалт, хариуцлага хүлээх чадвар зэрэг хоёр үзүүлэлтээс бусад үзүүлэлтэд дунджаас дээгүүр үнэлэгдсэн. Харин улс төрийн соёлын төлөвшилд гарч буй өөрчлөлтийн хувьд бүх үзүүлэлт дунджаас доогуур үнэлгээ авч өмнөхөөсөө 0.4-0.7 пунктээр сайжирсан хэмээн дүгнэхэд хүрч байна. Үүнийг институцийнх хувьд үнэлэхэд улс төрийн соёлын төлөвшлийн өөрчлөлтийн үнэлгээний дундаж 4.2 оноогоор үнэлэгджээ.

Улс төрийн субъектуудын улс төрийн соёлын төлөвшилд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодруулахад, улс төр, хөрөнгө мөнгөний асуудалд хэт их орооцолдсон (23.6%), УИХ, ЗГ-ын гишүүдийн ёс зүйгүй, хариуцлагагүй, тогтворгүй байдал (32.7%), эх орон сэтгэлгээгүй, хүн ёсны хэм хэмжээ алдагдсан (16.4%), ИНБ мөн чанар нь алдагдсан, иргэдийн улс төрийн боловсрол сул (18.2%), эрх зүйн орчин хангалтгүй, хууль тэгш үйлчлэх зарчим алдагдсан (1.8%), сүүлийн 20 жилдээ өөрчлөлт гаргахгүй, байнга төлөвших замдаа явж байна (3.6%) гэсэн хүчин зүйлсүүдийг голлон дурдсан байна.

Хүснэгт 8. ИНБ-уудын улс төрийн соёлын төлөвшлийн үнэлгээ

(үзүүлэлт, хувиар)

ИНБ-үүд	а.өнөөгийн байдлын үнэлгээ	Амалсандаа хүрэх	1.9	Хүлэсэн үүргээ	1.6	Хууль, журмыг	1.7	Соёл, үнэт зүйл	1.5	Санхүүжилт хөрөнгө	1.4	Шийдвэр гаргах үйл	1.6	Хариуцлага хүлээх	1.4
	б.өөрчлөлтийн үнэлгээ	2.3	2.3	2.3	2.2	2.0	2.1	2.1							

а.Өнөөгийн байдлын үнэлгээ (сайн-3, дунд-2, муу-1), б.Өөрчлөлтийн үнэлгээ

(ихээхэн сайжирсан-5, бага зэрэг сайжирсан-4, хэвэндээ-3, бага зэрэг дордсон-2, ихээхэн дордсон-1)

Улс төрийн субъектуудын улс төрийн соёлын төлөвшилд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодруулахад, улс төр, хөрөнгө мөнгөний асуудалд хэт их орооцолдсон (23.6%), УИХ, ЗГ-ын гишүүдийн ёс зүйгүй, хариуцлагагүй, тогтворгүй байдал (32.7%), эх оронч сэтгэлгээгүй, хүн ёсны хэм хэмжээ алдагдсан (16.4%), ИНБ мөн чанар нь алдагдсан, иргэдийн улс төрийн боловсрол сул (18.2%), эрх зүйн орчин хангалтгүй, хууль тэгш үйлчлэх зарчим алдагдсан (1.8%), сүүлийн 20 жилдээ өөрчлөлт гаргахгүй, байнга төлөвших замдаа явж байна (3.6%) гэсэн хүчин зүйлсүүдийг голлон дурдсан байна. Эдгээрээс УИХ, Ерөнхийлөгч, хэвлэл мэдээлэл хэрэгсэл бусад институциэс илүү өндөр оноог авсан байна. Түүнчлэн дээрх субъектуудын улс төрийн соёлын төлөвшилд гарсан өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн гэж үзсэн байна. Тэгвэл, улс төрийн соёлын төлөвшилд чухал үүрэгтэй гэж үзсэн дээрх субъектүүдээс гадна бусад субъектуудад дараах үнэлгээг өгчээ. Үүнд: хууль сахиулах байгууллагууд (4.2), хэвлэл мэдээллийн хэрэгсэл (3.7), төрийн алба (3.9), сонгуулийн ерөнхий (3.9), нутгийн өөрөө удирдах байгууллага (3.8), батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгууллагууд (5.0), шүүх (3.3), иргэд, олон нийт сонгогчид (3.6) үнэлгээг тус тус өгсөн байна. Харин 10 онооноос буюу дунджаас доогуур үнэлгээтэй байгаа субъектуудээс зөвхөн батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгууллагууд л дундаж үнэлгээнд хүрсэн үзүүлэлттэй байна. Энэ бол улс төрийн үйл явцад оролцож буй субъектуудын улс төрийн соёлын төлөвшил нь *үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх, төрт ёсоо хүндэтгэх, ардчилал шударга ёсыг бэхжүүлэхэд* чухал хүчин

зүйл болж байдаг энэ нөхцөл байдал өнөөгийн Монгол Улсад улс төрийн соёлд эерэгээр нөлөөлөхүйц түвшинд байж чадахгүй байгааг харуулна.


Үүнээс дүгнэвэл, улс төрийн субъектуудын улс төрийн соёлын төлөвшилд хамгийн чухал үүрэгтэй субъектэд улс төрийн намыг тэргүүлэх ач холбогдолтой юм. Харин хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэд сонгогчид, төр, төрийн байгууллагууд, ИНБ-уудыг дараагийн онцлох үүрэгтэй субъект хэмээн үзэхийг эл судалгааны дүн харуулж байна. Түүнчлэн төрийн гурван өндөрлөгийг албан тушаалын хувьд биш харин институцийнх нь хувьд 10 оноогоор үнэлүүлэхэд дээрх 3 субъектын дундаж гурвуулаа дунджаас доогуур үнэлэгдсэн. Харин улс төрийн намуудыг улс төрийн институцийнх нь хувьд мөнн 10 оноогоор үнэлүүлэхэд дөнгөж 2.7 оноогоор үнэлэгдсэн нь улс төрийн намуудад улс төрийн соёлын төлөвшил институцийн хувьд *«хангалттай»* хэмжээнд үнэлэгдээгүй. Улс төрийн субъектууд дотроос ИНБ-ууд, ХМХ-үүд улс төрийн соёлын төлөвшлийн үнэлгээгэр дундаж үнэлгээнд хүрэхгүй байгааг энэхүү судалгааны үр дүн харуулсан.

Чингэхээр улс төрийн соёлын төлөвшилд голлох нөлөөтэй институциуд нь өнөөгийн байдлаар төлөвших бус *«бүрэлдэх»* шатандаа байна гэсэн ерөнхий дүгнэлтийг хийхэд хүргэж буйн дээр Нөгөөтээгүүр, шинжээчдийн судалгааны дүнгээр монголын өнөөгийн улс төрийн соёлын төлөвшил дундаас доош буюу бүрэлдэх төдий шатанд байгааг илтгэж буй. Улс төрийн соёлын төлөвшил хангалтгүй байгаагийн нэг шалтгаан нь улс төрийн боловсрол, мэдлэг нимгэн, улс төрийн туршлага дутмаг хүмүүс улс төрд орох болсонтой холбоотой. Мөн улс төрчдийн дунд бие хүний төлөвшил бүрэн төлөвшөөгүй, ёс суртахуун дутагдалтай, улс төрийн шийдвэр гаргахдаа дутуу дулимаг, хэт нэг талыг баримталсан бодлого шийдвэр гаргадагаас улс орны хөгжлийн хурд, ахиц дэвшил удааширч улмаар улс төрийн болон шийдвэр гаргах төвшний тогтворгүй бодлого зэрэг хүчин зүйлс сөргөөр нөлөөлөхөд хамгийн өндөр хүчин зүйлс болж байна. Сүүлийн 5 жилтэй харьцуулахад, Монгол Улсад улс төрийн соёл дордсон, огт өөрчлөлтгүй байгаа хэмээн үнэлэгдэх болсон шалтгааны нэг нь дээр дурдсан *хувиа хичээсэн, хэт аминчхан үзэл бодол* үлэмж дэлгэрэхийн хирээр бизнес эрхлэгчид улс төрд өөрсдийн эрх ашгийн төлөө зүтгэх, оролцох явдал ихэссэнтэй шууд холбоотой хэмээн шинжээчид дүгнэсэн явдал юм. Энэ бүхнээс үзвэл, улс төрийн соёлын субъектууд тэр дундаа төр, түүний институтэд итгэх иргэдийн итгэл, төрийг хүндэтгэх байдал *«маш хангалтгүй»* үнэлэгдсэн нь иргэдийн улс төрийн боловсрол хангалттай хэмжээнд төлөвшөөгүй байгаагаар шууд холбоотой.

iii. Улс төрийн соёлын шинж чанар, хэв маягын тухайд

Бид энэ хэсэгтээ улс төрийн соёлын хэв маяг, шинж чанарыг тодруулахыг зорив. Угтаа, соёл амьдралын янз бүрийн хүрээ, амьдралд аль нэг хэм хэмжээ, горим журмыг тодорхойлж, зөвлөж байдгийн адил улс төрийн соёл улс төрийн хүрээн дэх зан үйлийн болон «тоглоомын дүрэм»-ийн хэм хэмжээг тодорхойлж, бас зөвлөдөг. Өөрөөр хэлбэл, улс төрийн соёл тодорхой буюу хувь хүнд улс төрийн зан үйлийн удирдлага болгох зарчмыг олгодог. Мөн нийгмийн бүлэгт үнэт чанар, оновчтой учир шалтгааны системт бүтэц, институтүүд, газар байгууллагын нэгдэл, харилцан бодит хамтын үйл ажиллагааг хангагч улс төрийн хэм хэмжээ, хүсэл зоригийг олгодоогоороо онцлогтой. Тэр нь нийгмийн соёл ерөнхийдөө нийгмийн амьдралыг бүхэллэг, нэгдмэл шинжтэй болгодог шиг улс төрийн хүрээг бүхэл, нэгдмэл шинжтэй болгодог ажээ. Чухамхүү эл нөхцөл байдал, үзэл санааны улс төрийн соёлын суурь үнэт зүйлс нь аливаа нийгмийн улс төрийн системд амин чухал бөгөөд залгамж чанарыг хадгалдагаараа ач холбогдолтой. Үүнийг л бид улс төрийн соёлын хэв маяг, шинж чанараар нь тодорхойлон авч үзсэн юм. Ингэхдээ дараах байдлаар буюу Алмонд, Верба нарын санал болгосон улс төрийн соёлын 3 үндсэн хэв маяг болох (i) *өвгийн буюу уламжлалт хэв маяг*, (ii) *албатын хэв маяг*, (iii) *оролцооны хэв маягийг* онолын үндэслэл болгон авч, улс төрийн соёлын хэв маяг, шинж чанарыг ангилал үүсгэн тодруулсан юм. Ийнхүү хэв маягчлал үүсгэн судалгаанд оролцсон шинжээчдээр эдгээр хэв маягаас манай улсын улс төрийн соёлд ямар хэв маяг зонхилж байгааг тодруулахад дараахв дүр зураг гарсан юм (Зураг 10).

Зураг 10. Улс төрийн соёлын хэв маяг, хэв маягийн төрөл (хувиар)



Дээрхээс үзвэл, Монгол Улсад холимог улс төрийн соёлын хэв маяг давамгайлж байгааг шинжээчдийн судалгааны дүн харуулж байна. Эл судалгааны дүнгээс оролцооны улс төрийн хэв маяг хамгийн бага хувьтай байгаа нь улс төрийн үйл явцын шат бүрт нөлөө үзүүлэх идэвхтэй оролцоо хангалтгүй байгаа нь харагдана. Нөгөөтээгүүр, улс төрийн дээрх хэв маягууд бодит байдал дээр улс төрийн амьдралын олон талт, нарийн төвөгтэй шинжийг тусгаж чадахгүйн дээр бодит байдалд улс төрийн холимог хэв маягууд зонхилж буйг давхар харуулж байна. Жишээ нь: *уламжлалт-албатын, албат-оролцооны, албат-оролцооны* гэх мэт. Тэгвэл холимог улс төрийн соёлын хэв маяг дотроо *уламжлалт-албатын хэв маяг* өндөр хувьтай байгаа нь улс төрийн идэвх оролцоо, нөлөөлөл хангалтгүй хэмээн ерөнхийд нь дүгнэхэд хүрч байна (Зураг 10).

Энэ бүхэн нь улс төрийн соёлын чиг баримжааны хувьд *өрнө-дорнын, уламжлалт эсвэл холимог хэв маягийн* ангиллаар авч үзвэл, өнөөгийн Монгол Улсад улс төрийн соёлын аль алины холимог маягийн тэр ч бүү хэл улс төрийн соёлын аль нэг хэв маяг одоогоор төлөвшөөгүйг харуулж байна. Үүнд улс төрийн намуудын төлөвшил тааруу, улс төрчдийн хууль мөрддөггүй, ёс зүйгүй, хариуцлагагүй байдал, улс төрчид, албан тушаалтнуудтай хариуцлага тооцох механизм байхгүй зэрэг нь үүний гол шалтгаан болохыг илтгэнэ. Үүнээс үзэхүл, дорнын улс төрийн соёл огт байхгүй, үндэсний уламжлалт соёл зөвхөн 2.6 хувь байгаагаас үзвэл *холимог соёлын хэв маяг зонхилж*, улмаар үүнд аль нэг холилдсон хэв маяг биш, аль нь гэхийн аргагүй замбараагүй, төлөвшилгүй байдал нэгэнт бий болсныг шинжээчдийн үнэлгээ харуулж байна. Тодруулбал, дээрх нөхцөл шалтгаантай холбогдуулан монголын улс төрийн соёлын баримжааг төрөлжүүлвэл, шинжээчдийн 43.6 хувь нь улс төрийн соёлд төлөвшөөгүй хэмээн үзсэн нь өнөөгийн монголын улс төрийн соёлын баримжаа *«хангалттай»* төвшинд хүрээгүйг нотлон харуулна. Шинжээчдийн 43.6 хувь нь холимог улс төрийн соёлыг, 10.3 хувь нь өрнийн улс төрийн соёлыг, харин 2.6 хувь нь үндэсний уламжлалт улс төрийн соёлын баримжаа хэлбэршиж буйн хэмээн үзсэн. Ийнхүү улс төрийн соёл төлөвшөөгүй, харьцангуй сул төлөвшсөн гэж үзсэн шалтгаанд *улс төрийн намуудын төлөвшил тааруу, улс төрчдийн хууль мөрддөггүй, ёс зүйгүй, хариуцлагагүй байдал зонхилж, улмаар улс төрчид, албан тушаалтнуудтай хариуцлага тооцох механизм сул* байгаатай холбоотой гэж бид үзсэн. Үүнийг дараах байдлаар дэлгэрүүлбэл (Хүснэгт 9).

*Хүснэгт 9. Улс төрийн соёл төлөвшөөгүй,
харьцангуй сул байгаа шалтгаан (хувь, давтамжаар)*

Шалтгаан, хүчин зүйлс	Төрийн зүгээс баримталж буй бодлого шийдвэртэй холбоотой	7.0	20.0
	Эрх мэдлийн хуваарилалтын тэгш бус байдал	14.0	40.0
	Эл харилцааг зохицуулах эрх зүйн орчин сул, бүрдээгүй	3.0	8.6
	Улс төрийн намуудын төлөвшил тааруу	23.0	65.7
	Улс төрийн намуудын бодлого, хоорондын ялгаа байхгүй болсон	4.0	11.4
	Улс төрийн намуудын хөрөнгө санхүүжилт ил тод, нээлттэй бус	10.0	28.6
	Улс төрчдийн хууль ёс зүйгүй, хариуцлагагүй байдал	14.0	40.0
	Улс төрчид, албан тушаалтнуудтай хариуцлага тооцох механизм сул бүрдсэн	9.0	25.7
	Иргэд сонгогчдын идэвх, оролцоо сул	4.0	11.4
	Иргэд, олон нийтийн улс төрийн боловсрол тааруу	4.0	11.4
	Иргэд, сонгогчдын төлөөллөө сонгох шалгуур, үнэлэмж доогуур	5.0	14.3
	Улс орны эдийн засгийн тогтворгүй байдал	3.0	8.6

Улс төрийн соёлын төлөвшлийн эерэг, сөрөг үндсэн нөлөөлөгч хүчин зүйлсийг шинжээчдээр үнэлүүлэхэд, улс төрийн нам, хүчин (21.2%), төрөөс баримтлах бодлого, дүрэм (11.5%), хөрш орнуудын нөлөө (9.7%), олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан байдал (9.7%) улс төрчид (9.7%) маш чухал


нөлөөтэй гэж үзсэн нь бусад хүчин зүйлсээс илүү хувиар үнэлэгджээ. Үүнийг тус бүрээр дэлгэрүүлбэл улс төрийн соёлд эдгээр **үндсэн нөлөөлөгч хүчин зүйлс** бүгд сөргөөр нөлөөлж байгааг шинжээчдийн судалгааны хэд хэдэн үнэлгээ нотлон харуулсаныг онцлон тэмдэглэх нь зүйтэй (Зураг 11).

Зураг 11. Улс төрийн соёлд нөлөөлөгч үндсэн хүчин зүйлсийн үнэлгээ (хувиар)



Тухайлбал, улс төрийн соёлын төлөвшил, харьцангуй сул байгаад улс төрийн намын хөрөнгө санхүүжилт ил тод бус, улс төрчдийн ёс зүйгүй, хариуцлагагүй байдал болон хариуцлага тооцох механизм байхгүй зэрэг нь өндөр хувьтай байна. Харин улс төрийн субъектуудын улс төрийн төлөвшилд сөргөөр нөлөөлсөн байдалд мөн л УИХ, ЗГ-ын гишүүдийн ёс зүйгүй байдал, улс төрчид хөрөнгө мөнгөний асуудалд хэт их орооцолддог гэсэн үзүүлэлт голлон нөлөөлсөн гэж үзэж болно. Үүнээс улбаалан улс төрийн соёлын үндсэн төлөвшүүлэгч хүчин зүйлсийн хувьд улс төрийн соёлын аль түвшинд сул төлөвшсөнийг шинжээчид дараах байдлаар үнэлсэн.

Зураг 12. Улс төрийн соёлын төлөвшил сул байгаад нөлөөлсөн хүчин зүйлс (хувиар)



Тодруулбал, улс төрийн соёлын түвшний ангилалаар бол улс төрчдийн түвшинд болон улс төрийн системд улс төрийн соёлын төлөвшил алдагдсаныг гурван шинжээч тутмын нэг нь үнэлсэн байна. Үүнийг сүүлийн 5 жилтэй харьцуулахад улс төрийн соёлын дордсон байдалд хувиа хичээсэн үзэл бодол, бизнес эрхлэгчид улс төрд зүтгэх болсноор улс төрийн соёлын төлөвшилд сөргөөр нөлөөлж буй нэг чухал хүчин зүйл болсныг гэрчилнэ.

Дүгнэлт

Улс төрийн соёлын төлөвшлийн гол институцийн төлөвшилд бүх нам дунджаас доогуур үнэлгээ авсан нь улс төрийн соёлыг төлөвшүүлэгч үндсэн хүчин зүйлс тус улсад төлөвшөөгүй, сөрөг нөлөөлөл үзүүлж буй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Тиймээс үүнийг цаашид зохистой төлөвшүүлэхэд ямар бодлого, үйл ажиллагаа явуулах хэрэгтэй байгаа талаар судалгаанд хамрагдсан шинжээчдээс тодруулав. Чингэхэд Үндсэн хуулийн үнэт зүйлс зарчмыг дээдлэх, хариуцлагын хэм хэмжээг чанд баримтлах (29.7%), улс төрийн намуудыг төлөвшүүлэх, намын санхүүжилтийг тодорхой болгох (28.1%), иргэний эрх зүйн нийгэмшил, иргэдийн үүрэг оролцоог сайжруулах (20.3%) явдал улс төрийн соёлыг зохистой төлөвшүүлэхэд чухал үйл ажиллагаа болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Зураг 13. Цаашид улс төрийн соёлыг зохистой төлөвшүүлэх талаар бодлого, үйл ажиллагааны санал (хувиар)

1	ҮХ-ийн үнэт зүйлс, зарчмыг дээдлэх, хариуцлагын хэм хэмжээг чанд баримтлах Улс төрийн намуудыг төлөвшүүлэх, намын санхүүжилтийг тодорхой болгох	29.7 хувь 28.1 хувь
2	Иргэний эрх зүйн нийгэмшил, иргэдийн үүрэг оролцоог сайжруулах Боловсролын системийн хүнийг хүн болгон төлөвшүүлэх талаар хичээлийн хөтөлбөрт нэмж тусгах	20.3 хувь 9.4 хувь
3	Ил тод, нээлттэй шударга байдлыг бүх шатанд мөрдүүлэх, ардчилсан зарчим баримтлах Эрдэмтэн, судлаачдын үгийг сонсож, бодлогод тусгах	6.3 хувь 3.1 хувь
4	Хөгжлийн бодлогод неолиберал зах зээлийн эдийн засгийн хөгжлийн бодлого баримтлах Сонгууль хоорондын зайг сунгах	1.6 хувь 1.6 хувь

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл, улс төрийн соёлын төлөвшил нь улс орны хөгжил, эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаатай болох нь тодорхой. Угтаа улс төрийн соёлын энэхүү нөхцөл байдал Монгол Улсын нийгмийн хөгжлийг хойш татаж байгааг эл судалгаагаар илэрсэн. Тодруулбал, судалгаанд оролцогчдын **60.5** хувь өнөөгийн монголын улс төрийн соёл нийгмийн хөгжлийг хойш татаж байна гэж үзсэн бол, зарим талаар нийлнэ гэж 34.2 хувь нь хариулсанаас үзвэл нийгэм, эдийн засаг, соёлын хөгжил төлөвшил хоорондоо шууд хамааралтай гэдэгт шинжээчид санал нийлж буйн илрэл. Мөн улс төрийн соёл бүр үндэсний онцлогтой байх ёстой гэсэн үзэл баримтлалыг шинжээчдийн 2 хүн тутмын нэг буюу нийт судалгаанд хамрагдсан шинжээчдийн 51.3 хувь нь «бүрэн санал» нийлж, 38.5 хувь нь «зарим талаараа санал нийлж» буйш илэрхийлсэн байна. Нөгөө талаар тогтвортой хөгжил ардчиллын чанарыг бэхжүүлж (68.4%), нийгэм-эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр бол хүний хөгжил мөн (78.9%) гэдэгт бүрэн санал нийлсэн нь улс төрийн соёлын үзэл баримтлалд чухлаар хөндөгдөж буй гол илрэл гэж үзэж байна.

Нийгмийн өөрчлөлт, хөгжил нь маш олон хүчин зүйлтэй холбогдож, улмаар өөр хоорондоо нарийн сүлжилдсэн харилцан хамааралтай болох нь нотлогдож байна. Тиймээс бид эл судалгаандаа соёл, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, боловсрол зэргийн өөрчлөлт хам хувьсалын шинжтэй байх ёстой гэсэн таамаглалыг дэвшүүлсэн. Энэ таамаглалыг өнгөрсөн 20-оод жилийн туршид Монгол Улсад бий болсон нийгэм эдийн засгийн болон улс төр, хууль эрх зүйн томоохон өөрчлөлтүүд улс төрийн соёлд хэрхэн нөлөө үзүүлснийг үнэлүүлэхэд тодорхой үр дүн гарсан. Тодруулбал, эл шинжээчдийн үнэлгээгээр эдийн засгийн шинжтэй өөрчлөлтүүдээс хамгийн эерэг нөлөөлсөн хүчин зүйлд **чөлөөт зах зээлийн тогтолцоотой** болсныг онцолсон бол, улс төрийн тогтолцооны өөрчлөлтийн хувьд **бүх нийтийн чөлөөт сонгууль, олон намын тогтолцоотой** болсон нь улс төрийн соёлд хамгийн

ээрэгээр нөлөөлсөн хүчин зүйлсээр үнэлэгдэхэд хүргэжээ. Харин улс төрийн соёлд сөрөг нөлөөлсөн үйл явдалд улс төр-бизнесийн олгархи бүлэглэл үүссэн, сонгуульд эдийн засгийн олгархиуд өрсөлдөж, түүнээс үүдэлтэйгээр улс төрийн тогтолцоонд сөрөг нөлөө ихэссэнтэй холбоотой. Мөн соёл, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, боловсрол зэргийн өөрчлөлт хам хувьсалын шинжтэй байх ёстой гэсэн таамаглал батлагдсан ба эдийн засаг, улс төрийн суурь тогтолцоо зөв бүрдсэн ч хэрэгжилтийн гажуудал буй болсон боловсролын тогтолцооны тогтворгүй байдал, ёс зүйгүй улс төрчид бий болсон, хариуцлагын механизмгүй байдал зэрэг нь улс төрийн соёлын төлөвшилийг доройтуулах үндэслэл болсон байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ном зүй

- Баасансүрэн Д, Хатанболд О. Энхболд Д, ба бусад. (2020). *Монгол Улс дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе*. ред. Хатанболд О., Баасансүрэн Д. Уб, Монгол Улс, «Соёмбо принтинг» ХХК. ISBN 978-9919-9556-6-3
- УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. (2019). *«Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлох»*. Шинжээчдийн судалгааны тайлан. Уб, Монгол Улс, «Тод бичиг» ХХК.
- УТЭЗС, Философийн хүрээлэн, ШУА. (2020). *«Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага»*. Олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан. Уб, Монгол Улс, «Тод бичиг» ХХК.
- Фукуяама, Ф. (2014). *Төрийг төвхнүүлэхүй: XXI зууны засаглал, дэлхийн дэг журам*. орч. Гомбоүрэн Ц. Уб, Монгол Улс, «Нэпко» хэвлэлийн газар. ISBN 978-99973-66-04-7

**ЗАСАГЛАЛЫН ХЭЛБЭР МОНГОЛЧУУДЫН УЛАМЖЛАЛТ ЗАСАГ
ТӨРИЙН ТОГТОЛЦОО, СОЁЛ ИРГЭНШИЛ, ЛЕГИТИМЧЛЭЛТЭЙ
УЯЛДАХ ТУХАЙ.**

Д.Сүхболд
Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн дэд профессор

Хураангуй

Засаглалын зохистой хэлбэрийг тогтооход Монголчуудын уламжлалт засаг төрийн тогтолцоо, легитимчлэл, нүүдлийн соёл иргэншил, түүнээс өгөгдсөн ард түмний менталитет зэрэг суурь өгөгдлийн талаар шинжилж, тэдгээр хүчин зүйлд нийцсэн засаглалын ямар хэлбэр байж болох талаар өгүүлэв.

***Түлхүүр үг:** Засаглал, нүүдлийн соёл иргэншил, менталитет, засаг төрийн уламжлалт тогтолцоо, бүгд найрамдах улс, легитим шинж.*

Монгол дахь засаглалын зохистой хэлбэрийг тогтооход Монголын улс төрийн түүхэнд гарсан алдаа, оноо, түүхэн сургамж, Монголчуудын засаг төрийн уламжлалт тогтолцоо болон легитимчлэл, улс төрийн гол үзэл суртал, нүүдлийн соёл иргэншил, түүнээс өгөгдсөн ард түмний менталитет зэрэг хүчин зүйлийг тооцон үзэх зайлшгүй шаардлагатай. Иймээс тус өгүүллэгээр энэхүү асуудлыг тодруулж шинжлэх зорилгыг тавьсан болно.

Персийн түүхч Рашид-Адин, “Судрын чуулган” бүтээлдээ талын нүүдэлчин Арабуудыг эс тооцвол Монголчуудаас өөр нүүдлийн соёл иргэншилтэй улс энэ дэлхийд үгүй юм хэмээн тэмдэглэн үлдээжээ. Суурьшмал соёл иргэншил нь байгалийг өөрчлөх, байгальтай тэмцэлдэх арга хандлагатай байдаг бол нүүдлийн соёл иргэншил нь байгальд дасан зохицох, байгалийг аргадаж, байгалийн эрхшээлд өөрсдийн амьдралаа зохицуулж амьдардаг онцлогтой. Талын нүүдэлчин Монголчуудын хувьд эрт үеэс өргөн уудам нутагтай, жилийн дөрвөн улиралд өөртөө аль таатай өвөлжих, намаржих, хаваржих, зусах байгалийн өгөгдлийг хайж дураараа нутаг сэлгэж, нүүдэллэн амьдарч ирсэн. Ингэхдээ тархай бутархай овог,

аймаг, ханлигийн зохион байгуулалтаар, ямар нэгэн томоохон удирдагчид үл харьяалагдах байдлаар тал нутагт эрх чөлөөтэйгээр нүүдэллэн амьдарч ирсэн түүхтэй. Хэрэв аль нэг овог аймгийн удирдагч эрх чөлөөг нь хасах гэвэл давын өмнө эрх чөлөөгөө эрж, өөр удирдагчийн харьяалалд ордог. Эсвэл гэр бүлийнхээ хамт ой шугуйд амьдрахаар оддог. Тиймээс Монголчууд эрт үеэсээ ихэд эрх чөлөөг эдэлж ирсэн онцлогтой бөгөөд суурьшмал соёл иргэншил шиг газар тариалан эрхэлдэггүй учраас түүнд хадагдаж бөөнөөрөө шавж суудаггүй нүүдэлчин удамтай ард түмэн юм. Чухам энэ шалтгаанаас үүдэж эртний Монголчууд төвөөс зугтах буюу бие даах байгалийн өгөгдлийг авсан. Иймээс бидний Монголчуудыг нэгтгэх бодлого хамгийн чухал бөгөөд нэгтгэх бодлого амжилттай хэрэгжиж байсан үед Монголчууд мандан бадарч, дэлхийн татах хүчний төв нь болж байсан бол дотооддоо эрх мэдлийн төлөө өрсөлдөж задарч бутарсан үед, эсвэл гадны улсуудын хагалан бутаргах бодлогоос үүдэн тархай бутархай байсан үедээ Монгол төрийн гал голомт бөхөж, бусдын идэш болж байсан гашуун түүхийг бид хэзээ ч мартаж болохгүй. Монголын түүхэнд мандаж буурч байсан Хүннү, Сүмбэ, Нирун, Их Монгол улс, Их Юан улс, Богд хаант Монгол улс зэрэг нь бүгдээрээ нэгэн хүчтэй удирдагчийн төвлөрсөн зохион байгуулалтын дор байгуулагдаж байсан улсууд гэдгийг санах хэрэгтэй. 1911 онд Монголчууд Манжийн дарлалаас салж тусгаар тогтнолоо сэргээхдээ ч гэсэн Богд хааны нэгдсэн удирдлага дор нэгдэн нягтарч төр улсаа сэргээн мандуулсан бөгөөд Богд хааныг тойрон хүрээлсэн Богд Хаант Монгол улс байгуулагдсан явдал нь 1924 онд тогтсон ардын төр, 1992 онд байгуулагдсан ардчилсан Монгол улсын тулах цэг нь болсон гэдэгтэй хэн ч маргахгүй бизээ. Бусад үед, тодруулбал Их Нирун улс дотоодын хямрал болох хаад ноёдын хагарал хуваагдлаас шалтгаалж 555 онд мөхсөнөөр Монголчууд Түрэг угсааны улсуудын дарлалд 400 жил дарлагдсан бол Их Монголын эзэнт гүрэн задран бутрах эхлэл Чингис хааны залгамжлагчид болох Зүчи, Цагаадай, нар болон Өгөдэй Тулуй нарын хооронд үүссэн хаан ширээний төлөөх тэмцлээс үүдэлтэй. 1260 онд явагдсан хаан ширээний төлөөх Аригбөх, Хубилай нарын ширүүн тэмцлээс үүдэн Монгол гал голомт Бээжинд шилжсэн явдал, Их Юан улс мөхсөний дараах нэгдсэн төр удирдлагагүй улс төрийн бутралын үе, үүнээс шалтгаалан ар, өвөр, баруун Монгол гэж гурван хэсэгт хуваагдан Манжийн эрхшээлд орсон зэрэг түүхэн сургамжтай олон үйл явдлуудыг бид нэрлэж чадна. Тэгвэл бидний Монголчууд эрт үеэс чухам ямар онцлогтой засаглалын легитимчлэлийг хүлээн зөвшөөрч, ямар удирдагчийг тойрон хүрээлж, нэгдэн нягтарч, тэдний юунд итгэж

найдаж, юуг улс төрийн философи болгодог байсан бэ гэдэгт одоо анхаарлаа хандуулья.

Эртний Монголчуудын засаг төрийн уламжлалт тогтолцоо нь нэг хүний засаглалыг ардчилалтай хослуулах явдал байсан бол улс төрийн гол үзэл суртал нь нэгдүгээрт, шүтэн захирагдах ёс, хоёрдугаарт, мөнх тэнгэрийн үзэл буюу “тэнгэрчлэл” байв. Нэг хүний засаглалыг ардчилалтай хослуулна гэдэг Монголын түүхэн дахь бүхий л улсуудад эзэн хааны дэргэд зөвлөх эрх бүхий язгууртны болон цэцдийн хуралдай ажиллаж байснаар тодорхойлогдоно. Хэдийгээр хаанд хэмжээгүй эрх мэдэл төвлөрч байсан боловч алтан ургынхан болон цэцэн мэргэдээс бүрдсэн хуралдайгаас зөвлөгөө авч төрийн бодлогоо явуулдаг байжээ. Энэ нь Монголчууд эрт үеэс хааны засаглалыг тойрон нягтарч, төр улсын аливаа хэргийн хэлэлцэхдээ язгууртны хуралдайг хуралдуулах буюу бүгд хэлэлцдэг ардчилсан зарчмыг баримталж улс гэрээ төвшитгөдөг байсныг харуулж байна.

Эзэн хаадынхаа гарал үүслийг тэнгэр бурхнаас улбаатай гэж ойлгож байсан дорно дахины эртний улсуудын нэгэн адил Монголчууд өөрсдийн хаант төрийг мөн л ер бусын дээдийн ариун гэгээн гаралтай хэмээн өргөмжилж байв.¹ Монголын анхны төрт улс болох Хүннү нар эзэн хаанаа тэнгэрээс заяат Шаньюй, тэнгэр газар, нар, сараас заяат их Шаньюй гэх зэргээр өргөмжилж байжээ. Цаашлаад Монголын төр тэнгэрлэг язгууртай болох тухай өвөрмөц үзлийг “Монголын нууц товчоо”-нд яруу тодоор тодорхой өгүүлжээ. Монголын нууц товчооны эхний хэсэгт Чингис хааны язгуур нь дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно болох талаар домогчлон өгүүлсэн нь Чингис хааныг жирийн хүн бус, дээд тэнгэрийн хөвгүүн гэдгийг батлахад чиглэжээ. Ийнхүү Чингис тэргүүтэй хаадын удам угсаа мөнх тэнгэрээс үүдэлтэй гэсэн гэсэн үзэл санаа улам бүр хүчээ авч энэ нь XIII зуунд байгуулагдсан Их Монгол улсыг бэхжүүлэх гол үзэл суртлын легитим болоод зогсохгүй төр улсаа хуульчлан зөвтгөх, улмаар мөнх тэнгэрийн хүчээр ертөнц дэлхийг захирах эрхээ ч хуульчлан үндэслэх улс төрийн үзэл суртал болтлоо хөгжиж чаджээ. Мөнх хөх тэнгэр болон тэнгэр язгуурт хааны засаглалыг эртний Монголчууд хамгийн төгс удирдлага гэж үзээд түүнд засаглуулж болон засаглуулахад бэлэн байсан нь үнэмлэхүйн дээд мөнх тэнгэр минь, үнэнийг үнэн болгож заяасан тэнгэр минь, хамгийн дээд мөнх тэнгэр минь, хамаг бүгдийг заяасан тэнгэр минь, хөдлөхийн дээд хөх мөнх тэнгэр минь, хөдлөх бүгдийг заяасан тэнгэр минь гэх мэтээр тэнгэрийг олон зууны турш магтан тахисаар ирсэн явдлаар тодорхойлогдоно.²

¹ Ш.Бира “Монголын тэнгэрийн үзэл” 107-р тал УБ 2011

² Ш. Бира “Монголын тэнгэрийн үзэл” 108-р тал УБ 2011

Өдгөөгийн монголчууд өөрийн сайн сайхан яваагаа, амжилт, алдаа оноогоо төр засагтайгаа холбож, төрийн минь буян, төрийн минь сүлд өршөө, төр түмэн нүдтэй, төр төмөр нударгатай гэх мэтээр ярьдаг нь ч дээрх тэнгэрлиг язгуурт төртэй байсантай нь шууд холбоотой. Тэнгэрлиг язгуурт төр нь ч үүргээ сайн биелүүлж Монголчуудыг тархай бутархай үед нь нэгэн хүчтэй удирдлага дор төвлөрүүлж, ард олныг мөр бүтэн гэдэс цатгалан, байлгаж, ачлал энэрлийг үзүүлж бурууд хатуу, зөвд шударга урамшууллыг хүртээж, амар амгаланг тогтоож байсны хэрээр ард иргэд нь ч төр засаг, эзэн хаанаа тэнгэрчлэн шүтэж нэг ёсондоо шүтэн захирагдах ёс Монголын нийгэмд ноёрхож байв. Энэ нь угтаа дорно дахины деспотизмын онцлог бөгөөд эзэн хаан нь бурхан тэнгэрээс гаралтай учир асар их нэр хүндтэй, олон түмнээр хүрээлүүлсэн байдаг бол өрнө дахины деспотизмын онцлог нь ард иргэдээ үг дуугүй хүчээр захиран дарангуйлахад оршино. (Эртний Ром) Германы философич Ф.Гегелийн хэлсэнээр өрнө дорнын деспотизмын гол ялгаа нь энэ болой. Чухамхүү дорно дахины деспотизмын гол онцлог нь шүтэн захирагдах ёс³ байжээ. Монголчууд үе үеийн төрийн тэргүүнээ дээдлэн хүндэтгэж, дээд язгууртан, тэнгэр заяат хэмээн шүтэж, тэрхүү шүтлэгээ дагаж, захирах, захирагдах ёсыг чанд сахиж иржээ. Энэхүү шүтэн захирагдах ёс зөвхөн хаан, харц ардын хооронд төдийгүй тухайн үеийн Монголын нийгмийн бүхий л хүрээнд нэвтэрч монгол түмний оршин тогтнох ёс суртахууны нэгэн үнэлэмж болтлоо хөгжжээ. Их эзэн богд Чингис хаан XIII зуунд монгол туургатнаа нэгтгэсний дараа дараах айлтгалыг хийсэн байдаг. Үүнд: “хүү нь эцгээ хүндэтгэхээ, эцэг нь хүүгээ ачлахаа, эр нөхөр нь эхнэртээ итгэхээ, эхнэр нь нөхрийнхөө үгийг авахаа, багачууд нь ахмадыгаа хүлээн зөвшөөрөхөө, баян нь ядуугаа тэтгэхээ, дорд хүмүүс нь дээдсүүддээ хүндэтгэл үзүүлэхээ больсноос газар сайгүй яахын аргагүй эмх замбараагүй байдалд идэгдэж, эцэс төгсгөлгүй дур зоргоороо авирлах явдал ноёрхох болсон байв. Би үүнийг эцэс болгож, хууль ёс, дэг журмыг тогтоосон болой”⁴ хэмээжээ. Бас Их Засаг хуульд шүтэн захирагдах ёсыг хуульчилсан байдаг. “Хөвгүүн хүүхэд, хүүхэд, эцэг эхээ үл хүндлэгсэд, дүү нар багачууд, ах ихсээ үл хүндлэгсэд, гэргий нь эрийнхээ зарлигийг үл дагагсад болон харъяатан захирагчдаа үл хүндлэгсдийг хүндээр шийтгэмой” гэжээ. Монгол ёсоор бол үр хүүхэд нь эцэг эхээ, залуу үе нь ахмад үеэ, эхнэр нь эр нөхрөө, харц ард нь хаад ноёдоо, шавь нар нь номын багшаа шүтэж, тэрхүү шүтлэгээ дагаж үг дуугүй захирагдах ёстой⁵ аж. Иймээс “Шүтэн

³ Н.Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” УБ 1995 он 89-р тал

⁴ Н.Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” УБ 1995 он 90-р тал

⁵ “Чингисийн сургааль гэрээслэл” УБ 1991. 24-р тал

захирагдах“ ёс нь Монгол болон дорно дахины нийгмийн тогтолцооны үндэс болоод зогсохгүй бас улс орныг удирдах засаглалын легитим шинж нь болж байжээ.

Тэгэхээр нүүдлийн соёл иргэншилтэй, түүнээс улбаалсан эрх чөлөөг эрхэмлэдэг Монголчуудын хувьд нэгдэх, нягтрах шалтгаан нь удирдагчийн онцгой авьяас чадвар болох харизм, түүн дээр суурилсан төвлөрсөн нэгдмэл хүчтэй удирдлага болж таарч байна. Өөрөөр хэлбэл задрал бутрал, хуваагдал нь Монголчуудад гашуун түүхийн сургамжийг үлдээж, харин нэгдэл, нягтрал, төвлөрөл нь бидэнд олон их гүрэн байгуулах боломжийг олгоод зогсохгүй өнөөгийн Монгол улсын суурийг тавьсан гэдэгтэй хэн ч маргахгүй бизээ. Тэгвэл бидний Монголчуудыг нэгдэл нягтралтай байлгаж чадах засаглалын ямар хэлбэр байж болох вэ. Нэгдэл нягтрал засаглалын ямар хэлбэртэй уялдаж болох вэ. Зарим хүмүүс Үндсэн хуульт хааны засаглал Монголд тохиромжтой хэмээн үздэг. Гэвч энэ нь боломжгүй. Учир нь бид аль 1924 онд бүгд найрамдах засаглалыг сонгон авснаас гадна Япон, Англи шиг хаан ширээг үе улиран угсаа залгамжилж ирсэн хаангүй. Энэ тохиолдолд хэн нэгэн хүнийг хаанаар өргөмжиллөө гэхэд 1911 онд Монголчууд Богд хааныг хүлээн зөвшөөрч, нэгдэн нягтарч байсан шиг үйл явдал болохгүй нь тодорхой бөгөөд үүнээс үүдэн бидний дунд бүр их хагарал, хуваагдал үүсэх сөрөг үр дагавартай.

Харин парламентын засаглалын хувьд төрийн эрх мэдлийн хяналт тэнцэл алдагдах, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлүүд нэг намын гарт орох, намын дотоод сахилга бат, бусад эрх ашгийн зөрчил хуваагдлаас үүдэн Засгийн газар тогтворгүй болох, мэргэжлийн бус Засгийн газар бий болох, Монтескьегийн хэлсэнчлэн парламентаас тогтоосон хуулийн хэрэгжилт алдарч, нийгэмд дур зоргоороо авирлах явдал газар авдаг учраас талцал хуваагдлыг хамгийн их өөгшүүлдэг засаглалын хэлбэр юм. Монголчууд бид 1992 оны Үндсэн хуулиараа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гэсэн хоёр толгойтой гүйцэтгэх засаглалыг байгуулсан төдийгүй, тус бүрийн чиг үүрэг, хяналт тэнцлийн харьцааг зохицуулж өгч чадаагүйн улмаас нэгдсэн удирдлагагүй, үүрэг хариуцлага тодорхойгүй гүйцэтгэх засаглалтай болсон. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёр нэг намд харьяалагдаж буй үед хэн нь эцсийн шийдвэр гаргах гэсэн тэмцэл өрнөдөг бол Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёр өрсөлдөгч намынх бол Ерөнхийлөгч Засгийн газрын хооронд бие биенээ боомилох, улмаар гүйцэтгэх засаглалыг бусниулах дайн дэгддэг байна.⁶

⁶ Л.Мөнх-Эрдэнэ “Тэргүүнгүй төр: Улс төр, үндэстний асуудал, дээд боловсрол” 45 дахь тал. УБ.,2018

Хамгийн харамсалтай нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр гүйцэтгэх эрх мэдлийг хоёр толгойтой байлгадаг дээрх асуудлыг эцэслэн шийдвэрлэж чадсангүй, эсрэгээрээ Ерөнхий сайдад Засгийн газрын гишүүнийг томилж, чөлөөлж, огцруулах бүрэн эрх мэдлийг өгснөөр Засгийн газрыг тэргүүлэхээс бусад гүйцэтгэх засаглалын бүх чиг үүргийг хэрэгжүүлдэг Ерөнхийлөгчтэй намын эрх ашгийн зөрчлөөс үүдэн тэмцэлдэх, эсвэл хэн нь гол тоглогч байх вэ гэсэн талцал хуваагдлыг үүсгэдэг байдлыг таслан зогсоож чадсангүй.

Тэгвэл бүгд найрамдах засаглалын бас нэг салаа мөчир болсон Ерөнхийлөгчийн засаглал нь Монголчуудыг нэгдэл нягтралтай байлгаж чадах уу гэдэг дээр ярилцъя. Ерөнхийлөгчийн засаглал нь төрийн эрх мэдлийн хуваарилалт дээр үндэслэж бий болсон бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлүүд зөвхөн ард түмнээс угшилтай байдаг онцлогтой. Ард түмнээс сонгогдсон гүйцэтгэх засаглал нь парламентаас тусдаа байгуулагдаж, тусдаа оршин тогтнодог учир парламент нь засаглагч институт байхаа больж, улмаар парламентаас Засгийн газрыг байгуулах, дэмжих албагүй болсноор парламент нь улс төрийн намын, Засгийн газрын, Ерөнхий сайдын эрхшээл дарангуйллаас чөлөөлөгддөг байна. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалыг ийнхүү салгаснаар Улсын Их Хурал, Засгийн газар хоёр харилцан бие биенээ барьцаалдаг, дарамталдаг, халхалдаг, хамгаалдаг асуудал устахын дээр Засгийн газар байгуулах, хадгалахын тулд Улсын Их Хуралд байнгын олонх бүрдүүлэх асуудал үгүй болж, ингэснээр олонх, цөөнх, эрх баригч ба сөрөг хүчин гэж талцаж хуваагдах шаардлагагүй болдог.⁷ Тэдгээрийн хамтаар парламентад янз бүрийн бүлэглэл, фракц төрж Засгийн газрыг хүчгүйдүүлэх, төр улсыг тогтворгүйжүүлэх, хагарал хуваагдалд хүргэх явдал бүрмөсөн устах боломжтой юм. Эндээс харвал Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал нь Монголчуудын хувьд нэгдэл нягтралыг бий болгох боломжтой засаглалын хэлбэр болж таарч байна. Улмаар гадаад улстай гэрээ хэлэлцээр хийх, төсөв санхүүгийн төлөвлөгөө гаргах, хуваарилах, цэрэг армийг зохион байгуулах, улсыг батлах хамгаалах, иргэдийн эрх чөлөөг хангах, хамгаалах зэрэг олон тооны нарийн чимхлүүр, зааварчилгаа шаардсан ажлууд нь гүйцэтгэх засаглалын хамрах хэрэгт багтаж байдаг. Эдгээр бүх хэргийг удирдан зохион байгуулах эрхэм бол бүх ард түмнээс шууд сонгогдсон Ерөнхийлөгч байх бөгөөд тэрээр гүйцэтгэх засаглалын бүхий л хүч, энергийг өөртөө төвлөрүүлж, улс орноо нэгдмэл удирдлагаар

⁷ Мөн тэнд. 68 дахь тал.

хангаснаар үндэсний удирдагчийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжтой болох юм.

Энэхүү өгүүллэгийн зорилго нь засаглалын зохистой хэлбэрийг тогтооход Монголчуудын уламжлалт засаг төрийн тогтолцоо, легитимчлэл, нүүдлийн соёл иргэншил, түүнээс өгөгдсөн ард түмний менталитет зэрэг суурь өгөгдлийн талаар ярилцаж, тэдгээр хүчин зүйлд нийцсэн засаглалын ямар хэлбэр байж болох талаарх хэлэлцүүлэг юм. Тэгвэл засаглалын зохистой хэлбэрийг тогтооход нөлөөлөх бас нэгэн суурь хүчин зүйл бол манай орны байгаль, цаг агаар, газарзүйн орчны нөлөөлөл гэдгийг санах хэрэгтэй. Байгаль цаг агаар, газарзүйн орчны нөлөө нь тухайн улсын нийгэм эдийн засгийн хөгжилд төдийгүй хүн амын бие бялдар, сэтгэлзүйн онцлогт хүртэл нөлөөлдөг гэх онолууд цөөнгүй байдаг. Тодруулбал хүйтэн сэрүүн бүсэд амьдардаг ард иргэд ямарч орчинд дасан зохицох чадвартай, өлчир чийрэг, хурдан шаламгай хөдөлгөөнтэй, ажилсаг, ёс суртахууны хувьд өв тэгш, шударга ёсыг эрхэмлэдгээс гадна бие бялдын хөгжил сайтай байдаг ажээ. Эсрэгээрээ халуун дулаан бүсэд амьдардаг иргэд цалгар, назгай, удаан хөдөлгөөнтэй, залхуу хойрго, ёс суртахууны доголдолтой, бие бялдын хөгжил муутай байх явдал элбэг тохиолддог. Иймээс цаг агаарын ямар бүсэд амьдарч байна гэдгээс шалтгаалаад тэдэнд тогтоох хууль ялгаатай байх ёстой агаад хүйтэн сэрүүн бүсэд амьдрагчид амьдрах чадвар сайтай учраас тэдэнд чанга хатуу хууль зохихгүй, харин халуун дулаан бүсэд амьдрагчдад чанга хатуу хууль хэрэгтэй. Чанга хууль нь тэднийг амьдралаа өөд татахад нь түлхэц болох ёстой⁸ ажээ. Харамсалтай нь Монтескье цаг агаарын нөхцөлд тохируулсан хуулийн тухай л ярьснаас бус түүнд хамааруулах засаглалын хэлбэрийн тухай асуудлыг яриагүй юм. Тэгэхээр Монголчуудын эртнээс оршин суусаар ирсэн газар нутаг бол цаг агаарын эрс тэс нөхцөлтэй, жилийн дөрвөн улирлын зуныг эс тооцвол хүйтэн сэрүүн уур амьсгалтай нутаг. Тиймээс бидний Монголчууд ёс суртахууны хувьд шударга ёс, тэгш байдал, эрх чөлөөг эрхэмлэдэг, аливаа зүйлд дасан зохицох чадвар сайтай, бие бялдар болон сэтгэл зүйн тэсвэр тэвчээр сайтай улс ард түмэн юм. Монголын түүхэнд тодрон мандаж байсан эзэнт улс, түүнийг удирдаж байсан агуу хаадууд Монголчуудын энэхүү онцлогийг харгалзан үзэж засаглалаа явуулдаг байв. Жишээлбэл Хүннүгээс улбаалж хөгжсөн аравт, зуут, мянгатын систем бол Монголчуудын төвөөс зугтах, бие даасан эрх чөлөөг эрхэмлэдэг байгалийн өгөгдөлд нь тааруулсан цэрэг, засаг захиргаа, иргэний нэгдсэн тогтолцоо байв.

⁸ Барон де Монтескье “Хуулийн амин сүнс” орч. Т.Төмөрхүлэг. 321-322 дахь тал., УБ 2019

Чингис хаан бүх шашныг чөлөөтэй хэмээн зарлаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрхийг Шихихутагт бүх насаар нь өгөхдөө бурууд хатуу, зөвд зөөлөн байхыг үүрэгдэж, Их Монгол улсын бүх ард иргэдийг хийсэн ял, зэм, байгуулсан гавьяа шагналд нь дүйцэхүйц ял шийтгэлийг өгч мөн шагнаж байсан нь зөвхөн Монголчуудын дээрх нүүдлийн соёл иргэншлээс авсан байгалийн өгөгдөлд зориулсан засаглал байсныг бид ойлгох ёстой. Ийм учраас Монголчууд өдгөө оршин буй шударга бус явдал ноёрхсон бурангуй тогтолцоог жигшин зэвүүцэж байгаа юм. Ийм учраас талцал хуваагдлаар дүүрэн, шударга хариуцлагагүй тогтолцоог үзэн ядаж байгаа юм.

Монголчуудын хувьд ямар ч төрийн хэлбэрийг дарангуйлагч байдалд оруулахгүй байх, түүнийг өөрчилж чадах, энэ өөрчлөгдөх ёстой гэсэн төрөлхийн шударга ёсны зөн совинтой ард түмэн. Өөрөөр хэлбэл парламентын болон Ерөнхийлөгчийн засаглалын аль нь ч гэсэн дарангуйлагч хэлбэр уруу гажих юм бол түүнээс урьдчилан сэргийлж, шударга ёсны хяналтыг тавих чадвартай ухаалаг ард түмэн. Энэ тохиолдолд манайх шиг эрс тэс цаг агаарын нөхцөлтэй улсад гүйцэтгэх засаглал нь нэгдмэл удирдлагатай, түүний шийдвэр гүйцэтгэл хурдтай байх ёстой гэдэгт би санал нэгдэж байгаа. Парламентаас батлагдсан аливаа хуулийг маш хурдан шуурхай хэрэгжүүлэх асуудал гүйцэтгэх засаглал тогтвортой, нэгдмэл удирдлагаар хангагдсан эсэхээс ихэд шалтгаална. Цаг ямагт шаламгай үйлдэл шаарддаг гүйцэтгэх засаглалын энэхүү талыг олон хүнээс илүүтэй нэг хүн давуутай гүйцэтгэдэг. Харин хууль тогтоох эрх мэдлийн нэг хүнээс илүү олон хүн чадамгай хэрэгжүүлдэг.

Дүгнэж хэлэхэд өдгөөгийн Монголд засаглал нь легитимийн хямралд орж улс орныг удирдан жолоодох засаглалын оновчтой хувилбарууд яригдаж буй энэ үед язгуурын Монгол төрийн уламжлал, үнэт зүйлсийг дорвитой хэлэлцэх асуудлыг зөнд нь орхиж үл болно. Эртний Энэтхэгийн брахманизмын болоод буддизмын үзэл, эртний Хятадын Күнзийн болон легилизм, даогийн суртлууд одоог хүртэл Энэтхэг, Хятадын нийгэм, улс төрийн систем болон засаглалд нь тодорхой байр суурийг эзэлсээр ирсэн шиг⁹ эртний Монголчуудын засаг төрийн уламжлалт тогтолцоо болох нэг хүний засаглалыг ардчилалтай хослуулж ирсэн түүх, Монголчуудын улс төрийн гол үзэл суртал болох шүтэн захирагдах ёс, Чингис хааны билиг сургааль зэрэг Монголын уламжлалт улс төрийн үзэл

⁹ Хятадад одоо ч хүртэл маш чанга хатуу ял шийтгэлийн тогтолцоо үйлчилдэг нь легилизмын чанга хатуу ялын бодлогын үзэл сурталтай тодорхой хэмжээгээр холбоотой.

сургаалиуд ч гэсэн Монголын төр ёс болон нийгэмд тодорхой нөлөөллийг үзүүлсээр байх нь дамжиггүй.

Abstract

In determining the appropriate form of governance, the basics of Mongolia's traditional system of government, legitimacy, nomadic civilization, and the mentality of its people are analyzed, and what form of governance can be appropriate to those factors.

Keywords: *Governance, nomadic civilization, mentality, traditional system of government, republic, legitimacy.*

Ном зүй:

Ш.Бира “Монголын тэнгэрийн үзэл” УБ 2011

Н.Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” УБ 1995 он

Н.Хавх “Нийгмийн гүн ухаан” УБ 1997

Х.Сэлэнгэ “Чингэс хааны төрт ёсны үзэл” УБ 2018

Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан “Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал”
УБ 1997

И.Дашням. “Монгол улсын төр эрх зүйн түүх” тэргүүн боть УБ 2006

Барон де Монтескье “Хуулийн амин сүнс” орч. Т.Төмөрхүлэг УБ 2019

Л.Мөнх-Эрдэнэ “Тэргүүнгүй төр: Улс төр, үндэстний асуудал, дээд боловсрол”
УБ.,2018

Д.Лхагвасүрэн, Д.Сүхболд, Р.Ууганбаатар, М.Сайнбаяр, Д.Зоригтбаатар
“БНМАУ: Үндсэн хуулийн тайлбар философи” УБ 2020

Монгол улсын ШУА-Философийн хүрээлэн “Академич Ч.Жүгдэр ба Монголын
гүн ухаан, нийгэм - улс төийн сэтгэлгээний түүх” УБ 2017

**ОЛОН НИЙТИЙН УЛС ТӨРИЙН ШҮҮМЖЛЭЛТ БАЙДАЛ БОЛОН
БУРУУТГАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ
ТОДОРХОЙЛОХ НЬ**

Д.Уртнасан
МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн докторант

Хураангуй

Энэхүү өгүүлэлд улс төрийн буруутгалын менежмент болон улс төрийн буруутгалын хазайлт гэсэн онол, аргагүйг баримтлан олон нийтийн цинист байдлыг өдөөгч нийтлэг хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьж, улмаар улс төрийн засаглалын легитимт байдал алдагдах, улс төрийн туйлшрал, нийгэм улс төрийн орчин, улс төрийн дуулиан шуугиан зэрэг асуудлын хүрээнд тодорхой байр суурь дэвшүүлсэн болно.

Түлхүүр үгс: Улс төрийн буруутгал, улс төрийн буруутгалын хазайлт, засаглалын легитим чанар, улс төрийн итгэл

Удиртгал

Төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагаанд иргэд үнэлэлт дүгнэлт өгч, эргэх холбоотой ажиллах нь ардчилсан тогтолцоон дахь улс төрийн систем дэх хэвийн үйл явц боловч мэдээллийн сувгуудын ямар нэг мэдээллүүд, хэт улс төржүүлсэн агуулга бүхий хөтөлбөрүүд, популист улс төрийн арга хэмжээнүүд нь олон нийтийн дургүйцлийг төрүүлж, аажмаар улс төрөөс хүнийсэх нөхцөлийг бүрдүүлсээр байдаг ажээ. Иргэдийн цахим хэрэглээ өргөжиж нэмэгдэхийн хэрээр авч буй мэдээ мэдээлэл, илэрхийлж буй үзэл бодол зэрэг нь богино хугацаанд олон нийтийг хамрах болсон. Нийгэм, улс төрийн талаарх сөрөг хандлагууд давамгайлж байгаа нь төрийн аливаа үйл ажиллагаа, бодлого шийдвэрт эргэлзэх, шүүмжлэх, эсэргүүцэх байдлыг нэмэгдүүлэн, олон нийтийн сөрөг үнэлгээ, буруутгалаас зайлсхийн тулд улс төрчид хувийн тоглолтуудыг үзүүлсээр байна.

Аргазүй, үндэслэл, үндсэн үзэл санаа

Тус өгүүлэлд улс төрийн буруутгалын менежмент болон түүнээс зайлсхийх стратегийн төрөл зүйлсийг судалдаг улс төрийн шинжлэх ухааны шинэ тутамд хөгжиж байгаа судалгааны онол, аргазүйг үндэс болгохын хамт Монгол улс дахь холбогдох сүүлийн үеийн тоо баримт, статистик үзүүлэлтүүдээр баяжуулан эмпирик болон онолын судалгааг хослуулан, судалгааны ажлын эрдэм шинжилгээний ач холбогдлыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулахыг зорьсон.

Орчин цагт мэдээллийн олон сувгууд нээгдэж, үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болсон нь эерэг хандлагаас илүү сөрөг хандлагад мэдрэг байдаг хүний сэтгэлзүйн онцлогоос хамааран нийгэм, улс төрийн олон асуудлуудад цинистик байдлаар хандах нь түгээмэл болоод байна. Энэхүү нийгэм, улс төрийн үзэгдэл, үйл явцыг улс төрийн шинжлэх ухаанд тусгайлан судалдаг судлаачид бий болж, судалгааны онол аргазүйг боловсруулсаар байна. Учир нь интернэтийн нийгмийн орон зайд нийгмийн гишүүд болон засаглал хэрэгжүүлэгчдийн хоорондын зай холдох тусам нийгмийн зөрчил, хямрал үүсэж байдаг. Түүнчлэн олон нийтийн сэтгэлд нийцэхийн тулд улс төрч, төрийн өндөр албан тушаалтнуудын бодлого шийдвэрээ өөрчлөх, богино хугацааны “гал унтраасан” шинжтэй бодлого, үйл ажиллагаа явуулах зэрэг нь эргээд сөрөг үр дагавруудыг дагуулсаар байгаа тул энэхүү асуудлыг олон талаас нь ул суурьтай судлах нь чухал байна.

Оксфордын тайлбар тольд “Буруутгах” гэсэн нэр томъёог “муу эсвэл буруу зүйлийг хэн нэгэн хариуцах ёстой”, “ямар нэг муу эсвэл буруу зүйлд хариуцлага хүлээх, буруутгах нь зүйтэй гэж үзэх” гэсэн утгаар тайлбарласан байна.¹ Үүнээс харахад буруутгах гэдэг нь 1/ямар нэг муу, буруу зүйлтэй холбоо хамааралтай байх, 2/муу зүйл, буруу зүйлийг хэн нэгэнтэй холбох гэсэн хоёр агуулгын хүрээнд хэрэглэгддэг байна. Ийнхүү аливаа бие хүн ямар нэгэн нийгмийн асуудалд ч мөн өөрийн шүүлтийг тогтмол хийдэг бөгөөд шүүлтийн үр дүнд алдаатай гэсэн дүгнэлтэд хүрвэл уг алдааг хамаатуулах эзэн биеийг илрүүлэн буруутгах, түүнд тохирсон ямар нэг арга хэмжээ, хариуцлага тооцуулахаар байр сууриа илэрхийлэх, бусдыг уриалах, албан тушаалтан болон холбогдох байгууллагад хандах зэргээр үйл явцыг идэвхжүүлдэг.

¹ *Colour Oxford English Dictionary*. (2006). New York: Oxford University Press.

Зураг 1: Буруутгах үйл явц



Буруутгах хандлагын эцсийн үр дүн нь түүний илэрхийлэл байх бөгөөд нийгэм, улс төрийн амьдралд тусахдаа хүний зан байдал, эсэргүүцэл, улс төрийн оролцоо, улс төрийн хүчирхийлэл, хэвлэл мэдээллийн шүүмж, элит болон улс төрчдийг шүүмжлэх, төрд итгэх итгэл буурах зэрэг байдлаар илэрч байдаг.

Улс төрийн буруутгалын хувьд иргэдийн төр, улс төрч, улс төрийн нам, улс төрийн тогтолцоондоо сэтгэл хангалуун бус байгаагийн илрэл хэмээн харж болох ч үүний суурь шалтгаануудыг танин мэдэх нь асуудлын сөрөг талуудыг гүнзгийрүүлэхээс урьдчилан сэргийлэх давуу талыг олгож болох юм.

1. Улс төрийн засаглалын легитим чанар буурах


Засаглалыг ямар ч улс төрийн тогтолцооны үед иргэд, хүн ам өөр өөрийнхөөрөө үнэлж болох бөгөөд гагцхүү ардчилсан тогтолцооны үед тэрхүү байр сууриа ил тодоор, чөлөөтэй илэрхийлдэг. Засаглалыг “иргэд эергээр үнэлж, хүлээн авах, удирдуулах, захирагдахыг хүлээн зөвшөөрөх явдлыг засаглалын легитим шинж гэдэг. Легитим шинж нь засаглалын нэр хүнд, хүн амын дийлэнх олонхын дэмжлэг, тухайн улс орны бодит нөхцөлд нийцэж буй байдал, улс төрийн тулгуур үнэт зүйлүүдийн хүрэн дэх зөвшил зэрэгтэй холбоотой.”² Монгол улсын хувьд засаглалын легитим шинж нь засаглалын байгууламж, түүний үйл ажиллагаа нь иргэдийн үнэт зүйлстэй нийцэж байгаа байдлаас гадна иргэд ахуй амьдралд нь нөлөөлөх эдийн засгийн үр ашгийг илүүтэйгээр харгалзаж байгаа байдал судалгааны дүнгүүдээс харагдаж байна. Улс орны эдийн засаг тогтворгүй, иргэдийн аж амьдрал таруу, инфляц, ядуурлын түвшин, орлогын зөрүү зэрэг нийгэм, эдийн засгийн сөрөг үзэгдлүүд нь иргэдийн улс төр, төр засагтаа үнэлэлт

² Содном, Ш. (2020). *Улс төр судлалын онол, практикийн асуудлууд*. Улаанбаатар. хууд. 194)

өгөх хамгийн гол хэмжүүр болж байгаа бөгөөд энэ нь ардчилал бэхжиж байгаа улс орнуудад нийтлэг ажиглагддаг болохыг судлаачид олонтоо тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл тухайн дэглэмийн үед аж амьдрал сайн болсон гэж ард түмэн мэдрэх тусам дэглэмийн хүлээн зөвшөөрөгдөх байдал нэмэгддэг.

Олон нийтийн санаа бодлын тандалт судалгаагаар өнөөгийн амьжиргааны байдал зарим талаараа сайн зарим талаараа муу гэсэн үзүүлэлт хамгийн өндөр бөгөөд 60 хувиас дээш байгаа бол ноднин жилтэй харьцуулахад амьжиргааны байдал хэвээрээ байгаа гэдэг үзүүлэлт тогтмол өндөр байна. “Хямралаас улс орноо гаргаж чадахгүй байгаа эрх баригчдын чадваргүй байдал нь тэдгээр оронд хүн амаас засаглалын легитмийн үр ашигтай, хууль ёсны аргад итгэх итгэл алдагдахад хүрч байна”³

Зураг 1. Иргэдийн улс төрийн байгууллагад итгэх итгэл



Эх сурвалж: “Сант Марал” Сан Улс төрийн барометр* 4

³ Содном, Ш. (2020). *Улс төр судлалын онол, практикийн асуудлууд*. Улаанбаатар., хууд. 197)

* Улс төрийн тогтолцооны байгууллагад итгэх олон нийтийн санаа бодлын итгэдэггүй гэсэн үзүүлэлтийг бараг итгэдэггүй болон итгэдэггүй гэсэн хувийн нийлбэрээр тооцсон болно.

⁴ Сант Марал" Сан. (2010-2019). *Улс төрийн барометр*. Улаанбаатар.

Улс төрийн байгууллагуудад итгэх итгэлийн үзүүлэлт жил ирэх тусам буурч байгаа бөгөөд иргэдийн итгэлийг хамгийн бага төрүүлдэг байгууллагаар УИХ, хуулийн байгууллагууд, улс төрийн намууд байна. УИХ- д итгэдэггүй гэсэн үзүүлэлт 2010 онд 44,6% байсан бол 2019 онд 62,6% болж 18 нэгжээр, хуулийн байгууллагуудад итгэдэггүй гэсэн үзүүлэлт 2010 онд 54,8% байсан бол 2019 онд 55,7% болж 0,9 нэгжээр, улс төрийн намуудад итгэдэггүй гэсэн үзүүлэлт 2010 онд 58,5% байсан бол 2019 онд 73,7% болж 15,2 нэгжээр тус тус нэмэгдсэн байна. Энэ нь иргэд өөрсдийн сонгож байгуулдаг төрийн байгууллага болон улс төрийн сонголтоо хийдэг улс төрийн байгууллагатаа итгэл алдаж байгаа нь улс төрийн тогтолцоондоо мөн сөрөг үнэлгээтэй болох нөхцөл бүрдэж байна.

Манай улсын иргэд ардчилалд хэрхэн хандаж байгааг сүүлийн 10 жилд хийгдсэн улс төрийн барометрийн судалгааг харьцуулан үзэхэд өнөөгийн ардчилал болон улс төрийн тогтолцоо сэтгэлд нийцдэг гэсэн үзүүлэлтүүд тогтмол тоогоор буурч, нийцдэггүй гэсэн үзүүлэлтүүд 2010 онд 8.6% байсан бол 2019 онд 26.7% болж 18.1 нэгжээр нэмэгдсэн байна.

Төрийн бодлого олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байгаа учир иргэдийн төрд итгэх итгэл алдарч улмаар ардчиллыг тогтолцооных нь хувьд уг нөхцөл байдалд хүргэсэн хэмээн буруутгах хандлага ажиглагдаж байна. Улс төр судлаач До Чул Шин \Doh Chull Shin\ “Ардчилсан улс төрийн туршлага бага, ойлголт нимгэн иргэдийн хувьд өмнө нь тулгарч буй олон асуудал, хүндрэл бэрхшээлийг ардчилал эсвэл дарангуйлал аль аль нь шийдвэрлэх чадваргүй мэт байж болно. Энэхүү тодорхой бус байдалтай тулгарахад ардчиллын туршлагагүй иргэд ихэнх тохиолдолд ардчилсан болон авторитари улс төрийн хандлагыг хоёуланг нь хүлээн зөвшөөрдөг”⁵ гэж дүгнэсэн. Энэ нөхцөл байдал манай орны хувьд мөн ажиглагдаж байгаа нь улс төрийн системийн загвар болгонд манай улс орныг удирдах боломжийн хувьд өгсөн дүгнэлтийг үзэхэд парламент болон сонгуулиас үл хамаарах хүчтэй ерөнхийлөгчийг дэмжих байдал 2010 онд 57.2% байсан бол 2019 онд 71.3% болж 14.1 нэгжээр, ард түмнээс сонгогдсон хүмүүсээс бүрдсэн ардчилсан удирдлагын системийг дэмжих байдал 2010 онд 67.9% байсан бол 2019 онд 74% болж 6.1 нэгжээр тус тус нэмэгджээ.

2. Улс төрийн туйлшрал

Улс төрийн сонгуулийн дүнд нийгэм ялсан улс төрийн хүчин, нэр дэвшигчид болон түүнийг дэмжигчид, ялагдсан улс төрийн хүчин, нэр дэвшигчид

⁵ Улс төрийн боловсролын академи. (2005). *Зүүн Азын Барометр*. Улаанбаатар

болон түүнийг дэмжигчид гэсэн бүлгүүдэд хуваагддаг. Сонгуульд өрсөлдөж байгаа талууд зарим нь дахин сонгогдохын тулд, нөгөө хэсэг нь шинээр сонгогдохын тулд өөр өөрсдийн нөөц бололцоог бүрэн дайчилдаг. Ялагдсан тал ихэнх тохиолдолд ялагдлынхаа учир шалтгааныг сонгуулийн зохион байгуулалт, эсрэг улс төрийн хүчний хөндлөнгийн нөлөө, шударга бус байдал зэрэг бусад хүчин зүйлсээс хайж, тэдгээрт буруутгалыг өгдөг. Хувь хүмүүс ашиг орлого болон эерэг хандлагаас илүү алдагдал, сөрөг хандлагад мэдрэг байдаг сэтгэлзүйн онцлог нь дээрх нөхцөл байдлыг улам бүр өдөөж өгдөг. Туйлширсан байдал нь сонгогчид, өрсөлдөгч хоёр талууд өөрсдийгөө илүү давуу гэж үзэх, хуваагдмал байдлыг дэврэгдэг улс төрийн манлайлал зэргээс үүдэлтэй. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь хүртэл хоёр талд хуваагдан нэр дэвшигчдийг дэмжих хандлагатай байдаг. Эдгээр мэдээллийн хэрэгслүүд нь дэмжигч улс төрийн лидерийн үйл ажиллагааг олон нийтэд эергээр түгээхээс гадна эсрэг талын нэр дэвшигчийн мэдээллийг байнга хуурамч мэдээлэл болгон цацах нь хямралыг гүнзгийрүүлдэг. Туйлшрал гүнзгийрвэл сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн нийгмийн бослого хөдөлгөөн өрнөж, эмх замбараагүй байдал газар авдгийг Монгол УИХ-ын сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн “2008 оны 07 сарын 01”-ны жагсаал цуглаан болон 2020 оны 59 дэх удаагийн АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн 2021 оны 01-р сарын 06-ны өдөр болсон АНУ-ын Капитолийн ордонд болсон хүчирхийллийн дайралт зэргээс харж болохоор байна.

Түүнчлэн улс төрийн буруутгал дахь туйлшралын нэг хэлбэр нь улс төрийн бодлогын алдааг улс төржүүлэх үйл ажиллагаа байдаг. Улс төрийн бодлого зөв зүйтэй, хэрэгцээтэй байсан ч мөн чанар, урт хугацааны үр ашгийг нь бус зөвхөн өөрийн бүлгийн эрх ашгийн үүднээс хандах үед голчлон илэрдэг. Энэ чиглэлийн судлаачид гурван төрлийн менежментийг тодорхойлсон байна.⁶

1. Олон нийтийн үндсэн үнэт зүйлсийг зөрчсөн үйл явдлыг илрүүлэх: Олон нийтийн үнэт зүйл бол улс төрийн аливаа үйл явцын гол төв болдог. Шударга ёс, ардчилал, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал зэрэг нь улс төр болон олон нийтийн анхаарлын төвд оршиж байдаг бөгөөд эдгээр асуудлыг тодруулах, тодотгох замаар үнэт зүйлсэд аюул учруулж байна гэж олон нийтэд итгүүлэх үйл ажиллагаанууд зохион байгуулдаг.

⁶ Brandstrom, A., Kuipers, S., & Dales, P. (2005 оны 04 14-15). *The politics of blame management in Scandinavia after the Tsunami disaster*. <https://ecpr.eu>: <https://ecpr.eu/Filestore/PaperProposal/7b2f97fa-181e-408c-980f-bdd04c6043f7.pdf>-ээс Гаргасан

2. Бодлого болон үйл явдлыг үйл ажиллагааны доголдол эсвэл тухайн бүс нутагт нүүрлэж байгаа асуудал болгож илрүүлэх: Процессыг илүү өргөн хүрээтэй, олон нийтийн анхаарлыг татахын тулд зарим улс төрийн тоглогчид өөрт ашигтайгаар эргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хууль ёсны институт, тухайн асуудалд хандаж байгаа олон нийтийн хандлага зэргийг ашигладаг.
3. Нэг хүний болон бүлгийн оролцоотойгоор тухайн үйл явдал болсныг илрүүлэх: Улс төрийн хямралыг олж тогтоосны дараа хариуцлагатай холбоотой асуудлыг шууд гаргаж тавьдаг.
3. Нийгэм, улс төрийн вакуум орчин

Орчин цагт мэдээлэл, харилцаа холбооны олон урсгалууд нийгмийн амьдралын бүхий хүрээнд нөлөөтэй болж байгаа бөгөөд ялангуяа цахим хэрэглээ сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөн нэмэгдсээр байгаа билээ. “2019 онд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас ХЗДХЯ, ГБХЗХГ, НҮБ-ын хүүхдийн сан, Фэйсбүүк зэрэг байгууллагуудтай хамтран “Нийгмийн сүлжээ ба зохистой хэрэглээ” форумыг зохион байгууллаа. Монгол Улсад өнөөгийн байдлаар фэйсбүүкийн 2,2 сая идэвхтэй хэрэглэгч байдаг. Үүний 2,1 сая нь гар утсаараа интернэтэд холбогдон нийгмийн сүлжээ ашиглаж байна. Нийт хүн амын 70 хувь нь сошиал орчинд мэдээлэл солилцож, бусдад түгээж байгаа нь бусад орны жишигтэй харьцуулахад өндөр үзүүлэлт гэдгийг ХХМТГ-ын дарга Б.Чинбат хэлсэн үгэндээ онцоллоо”⁷, түүнчлэн “манай улсын нэг иргэн сард дунджаар 5 сэтгэгдэл бичиж, 16 пост дээр like дарж, 3 пост share хийдэг”⁸ гэсэн судалгаа байгаа нь Монголчуудын дунд цахим хэрэглээ өндөр байгааг илэрхийлж байна. Ийнхүү цахим мэдээллийн сүлжээний хэрэглээ Монгол улсад өндөрсөж, түүнийг улс төр, бизнес, нийгмийн бүхий л хүрээнд хамгийн өргөн үзэл бодлоо илэрхийлэх индэр болгон ашиглаж байна.

Мэдээлэл хүртэх, түгээх суваг ийнхүү тэлсэн ч мэдээллийн урсгал, тэр дундаа нийгэм, улс төрийн талаарх мэдээлэл сөрөг хандлагаар тархаж улс төрч бол муу, улс төр бол бохир гэсэн олон нийтийн хандлагыг нэмэгдүүлсээр байна. Энэ нь нийгмийн стрессийн түвшнийг нэмэгдүүлээд зогсохгүй улс төрч, төрийн өндөр албан тушаалтны олон нийтэд таалагдах гэсэн аливаа улс төрийн акцын шалтгаан болж байна. Тэдний хувьд олон нийтэд таалагдаж байж дараагийн сонгуульд ялалт байгуулах тул богино хугацаат хүчин зүйлсээр улс төр хийх нь ихсэж байгаа нь

⁷ <http://cita.gov.mn/?p=11879>

⁸ www.ikon.mn (Б.Даваабазар, ikon.mn 2019.04.02)

сүүлийн жилүүдийн Монголын улс төрийн амьдралд ажиглагдсан улс төрийн үйл явцуудаас харагдаж байна. Энэ үзэгдлийг “political paralysis” буюу “улс төрийн саажилт” гэсэн нэр томъёогоор илэрхийлэх болсон.

Улс төрийн вакуум орчин удаан хугацаагаар тогтоход ард иргэд улам бүр улс төрчдийн хэлсэн үг бүрд эргэлзэж, хийсэн үйлдэл бүрийг буруутгах хандлага нэмэгддэг. “Улс төрийн коммуникаци хөгжих хирээр үл итгэх байдал буюу цинизм тэлж байна. Учир нь ард иргэд улс төрийн коммуникацийг ашиглан хэвлэл мэдээллийн салбараар улс төрчид өөрсдийгөө зарах үйлдлээс өөр зүйл хийхгүй байна гэж боддог болж байгаа.”⁹


4. Улс төрийн дуулиан шуугиан

Иргэд болон улс орны нийгэм- эдийн засаг, улс төр соёлын хүрээний олон чухал асуудлуудад улс төрийн нэг нам, эдийн засгийн явцуу бүлгүүдийн ашиг сонирхолд нийцсэн бодлого шийдвэр гаргах, хээл хахууль, авлигын хэрэгт холбогдох, иргэдийн олон эрхүүдийг зөрчих зэрэг нөхцөлүүдийг бүрдүүлсэн тогтолцоотой төр шударга бус байдал, авлигыг дэмжих, улс төр, эдийн засаг, нийгмийн суурийг нь хууль, эрхзүйн хүрээндээ бүрдүүлэх нь иргэдийн шударга ёс, тэгш байдал, ардчилсан тогтолцоондоо итгэх итгэлийг улам бүр бууруулдаг. Энэ талаар талаар судлаач О.Хатанболд “Авлигын тухайд сүр дуулиан ихтэй цөөн улс төрчдийг шалгасан гэх мэдээллүүд гардаг боловч, улс төрийн шинжтэй шоунаас хэтэрч авлигыг бүх төвшинд бууруулах бодит үр дүнгээ өгөхгүй байгаа учраас авлигын үзүүлэлтүүд олигтой багасахгүй байна. Харин ч нийгмийг айдас хүйдэст автуулах, хаглан бутаргах, зарим сөрөг үр дагавартай болж байгааг иргэд анхааруулж байгаа билээ”¹⁰ гэж үзсэн.

⁹ *Улс төрийн мэдээлэл харилцаа*. (2021). Улаанбаатар: Удам соёл, хууд. 75)

¹⁰ Хатанболд, О. (2017). *Ардчиллыг ойлгохуй ба судлахуй Монгол орны Жишээн дээр*. Улаанбаатар: "Соёмбо принтинг" ХХК, 129.

Зураг 17. Монгол улсын авлигын индекс*



Эх сурвалж: www.transparency.org¹¹

Монгол улсын байгалийн баялаг эдийн засгийн эргэлтэд орсонтой холбоотойгоор сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд улс төрч, төрийн өндөр албан тушаалтнуудын авлига, хээл хахуул, офшор дансны хэргүүд, гадаад дахь өндөр зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, ашигт малтмалын ордуудыг тойрсон маргаантай асуудлууд нь нийт улс төрийн хүрээнийхний нэр хүндийг унагаасан.

Мөн “Эрх баригчдаас амлаж сурталчилж буй иргэдийн амьдрал ахуйг сайжруулах талаарх ажил үйлс /ажлын байр, нийгмийн халамж, цалин тэтгэвэр зэргийг нэмэгдүүлэх г.м/, өөрчлөлтийн хэмжээ далайц анхандаа ихээхэн найдлага төрүүлж, дараа нь тэр хүсэн хүлээж байсан найдлага нь харсаар байтал хөсөрдөхтэй зэрэг багагүй сөргөлдөөнтэй байдал үүсгэж, ард түмний гамшигт байдлыг улам нэтрээх хандлагатай байдаг аж.” Төрийн бодлого мөн чанарынхаа хувьд зөв зохистой байхын тулд оролцож буй субъектүүдийн тэгш оролцоо чухал хэдий ч ардчилал бэхжиж амжаагүй байгаа манайх шиг улсын хувьд улс төр эдийн засгийн явцуу бүлэг үүсэж, корпорацийн сонирхлоо хамгаалан тодорхой хүрээнд төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд үлэмж нөлөө үзүүлдэг. Энэ үзэгдлийг Чехийн улс төр судлаач Михал Клима клиентелизм гэж тодорхойлсон байна. Төрийн хууль тогтоох байгууллага нь иргэд төлөвлөлөөрөө дамжуулж байгуулдаг төлөөллийн байгууллага бөгөөд энэхүү үйл явц нь улс төрийн намаар дамжин хэрэгждэг. Өөрөөр хэлбэл улс төрийн нам бол төр болон иргэний нийгмийг холбогч гүүр байх учиртай. Харин намууд олгархи бүлгийн гарт орж клиентелист болох үед төрөөс гарах хууль тогтоомж, бодлого цөм тухайн бүлгийн эрх ашгийг

* Авлигын индекс: 0-100 оноогоор авлигын түвшнийг хэмждэг ба 0 нь маш их авлигатай, 100 оноо нь маш цэвэр байгааг илэрхийлнэ.

¹¹ Хишигням, Б. (2019). 90 оноос хойшхи нийгмийн зарим үзэгдэлд хийсэн сэтгэлзүйн шинжилгээний үр дүн. In *Монгол дахь эрдчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2019/* (pp. 297-299). Улаанбаатар: "Адмон принт" ХХК, 275.

хамгаалсан байдаг. Ийнхүү улс төрийн намууд клиентелист болж ирэхийн цагт олгархи бүлэглэлийн эрх ашгийг хамгаалахын тулд төрийн эрх мэдлийг авах гэж улайран сонгуулийн хэтийдсэн амлалт өгч сонгуульд оролцдог. Гэвч амлалтдаа хүрч чадаагүй учир иргэдийн үл итгэх байдал улам нэмэгддэг.

Улс төрч, нам, төр, төрийн бодлого зэрэгт чиглэсэн улс төрийн буруутгалын хүрээ хязгаар нэмэгдэхийн хэрээр түүнээс зайлсхийх аргазүй боловсрогдож, хэрэглэгдэж байдаг. 1986 онд судлаач Weaver “Улс төрийн буруутгалын хазайлт” гэсэн судалгааны ажилдаа онолын саналыг анх дэвшүүлсэн. Тэрээр “Улс төрчид олны таашаалд нийцсэн үйлдэл үзүүлэхээсээ илүүтэйгээр олон нийтэд таалагдаагүй үйлдлийн буруутгалаас зайлсхийх, түүнийг хазайлгах, хүчийг нь сулруулахад анхаарлаа хандуулдаг. Энэ нь сонгогчдын бодит эсвэл болзошгүй алдааг эерэг үйлдлээс илүүтэйгээр мэдэрдэг “сөрөг хандлага”-с үүдэлтэй. Улс төрчдийг улс төрийн онцлог стратегийг хэрэгжүүлэхэд хүргэдэг бөгөөд үүнд хэлэлцэх асуудлын хязгаарлалт, золигт гаргах, хариуцлагыг бусдад тохох, асуудлын голоос алга болох зэрэг орно.”¹²

Улс төрийн буруутгалын хазайлт нь гэм бурууг хөнгөвчлөх болон гэм бураагаас зайлах давуу талыг бүрдүүлэхийг хэлнэ. Тус арга хэмжээг авахын тулд 1/ улс төрийн аливаа үйлдлийг буруутгахаас өмнө, 2 /улс төрийн үйлдэл нь буруутгагдсаны дараа гэсэн хоёр үндсэн арга хэлбэртэй байдаг.

Улс төрийн аливаа үйлдлийг буруутгалаас өмнө дараах байдлаар хазайлтыг бүрдүүлж болдог.

- Бурууг тодорхойлоход саад болох нөхцөлөөр хангах: Засгийн газрын төвөгтэй бүтэц, зохион байгуулалт, шийдвэр гаргахад олон янзын бүлгийн оролцоог бүрдүүлэх зэрэг нь улс төрийн буруутгалын оноолтыг бүдгэрүүлдэг.
- Бурууг улс төрийн үйл ажиллагаанд шилжүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг: Буруутгах элементэд нь бус үндэслэлд нь нөлөөлдөг.

Харин улс төрчид улс төрийн аливаа үйлдэл нь буруутгагдсаны дараа зайлсхийх эсвэл хөнгөрүүлэх зорилгоор дараах байдлаар боломжийг бүрдүүлж болдог.

- Танилцуулах стратеги: Цаг хугацаа, огцом өөрчлөлт, тайзны менежмент, маргаан зэргийг ашигладаг. Тухайлбал, үндэслэлтэй шалтаг гаргах, итгэл төрүүлэх, анхаарлыг бусад зүйлд хандуулах

¹² Weaver, R. K. (1986). The Politics of Blame avoidance. *Journal of Public Policy*, Volume 6, Issue 4, 371-398

- Агентлагийн стратеги: Албан тушаалтнууд, институтүүдийг буруутгалаас зайлсхийлгэх оролдлого бөгөөд албан ёсны хариуцлагыг харьяаллын байгууллагууд болон албан тушаалтанд хуваарилах арга зам юм.
- Бодлогын стратеги: Ямар нэг үйл ажиллагаа, зохион байгуулалтын удирдан чиглүүлэх үүргийн урд хэн нэгнийг тавихаас илүүтэйгээр хийж байгаа зүйлийнх нь агуулгыг тавьдаг.

Дүгнэлт ба хэлэлцүүлгийн асуудал

Улс төрийн асуудал нь нийгмийн нийтлэг үнэт зүйл, ашиг сонирхлыг хөндөж байдаг тул ямагт олон нийтийн анхаарлын төвд оршин байдаг. Олон нийт өөрийн байр суурь, шүүмжлэлт байр сууриа илэрхийлэх байдал нь улс төрчийн эерэг үйл ажиллагаа, бодлого, шийдвэрээс илүү сөрөг хүчин зүйлсэд мэдрэг байдаг нь олон нийтийн улс төрийн үнэлэмж, үйл байдалд нөлөөлж байдаг.

Өнөөгийн ардчилсан тогтолцоо, төр, засгийг дэмжиж буй эсэхийг тодорхойлох чухал үзүүлэлт нь нэгд, өмнөх коммунист дэглэмд өгөх сөрөг үнэлгээ, хоёрт, өнөөгийн нийгэмд улс төрийн илүү их эрх чөлөө эдэлнэ гэсэн төсөөлөл, гуравт, өмнөх дэглэмээс өвлөн авсан саад бэрхшээлийг даван туулахад удаан хугацаа хэрэгтэй гэдгийг ухамсарладаг тэвчээрт байдлыг илэрхийлдэг байна.

Сонгуулийн үр дүнтэй холбоотойгоор улс төрийн хүчнүүд, тэдний дэмжигчдийн хуваагдмал байдал улс төрийн бодлого, шийдвэрийг хэт улс төржүүлэх байдал олонтаа ажиглагддаг бөгөөд мэдээллийн сувгуудыг өргөнөөр ашиглан олон нийтийн улс төрийн зан байдал ба хандлагад нөлөөлөх олон төрлийн үйл ажиллагааг кампанит ажил болгон зохион байгуулдаг нь иргэдийн тэнцвэртэй мэдээлэл авах сувгуудыг хааж, тэднийг улс төржүүлсэн мэдээллийн хаалттай орчинд оруулж байна.

Улс төрийн нам, улс төрч, төрийн өндөр албан тушаалтнууд нь улс төрийн нэр хүнд ба сонгуулиар дахин сонгогдох эрмэлзлэлтэй нь холбоотойгоор олон нийтэд таалагдах үйлдэл, шийдвэр гаргах, түүнчлэн гаргасан бодлого шийдвэрээ олон удаа өөрчлөх зэрэг нь нийгэмд сөрөг үнэлгээг илүү төрүүлдэг байна. Үүний үр дүнд олон нийтийн сөрөг үнэлгээ, улс төрийн буруутгалаас зайлсхийх болон түүнийг хазайлгах стратегиудыг улс төрчид хэрэгжүүлэх болсон нь улс төрийн шинжлэх ухааны судалгааны шинэ тутамд хөгжиж буй сонирхолтой сэдэв болж байна.

Номзүй

"Сант Марал" Сан. (2010-2019). Улс төрийн барометр. Улаанбаатар.

Brandstrom, A., Kuipers, S., & Dales, P. (2005 оны 04 14-15). The politics of blame management in Scandinavia after the Tsunami disaster. <https://ecpr.eu:https://ecpr.eu/Filestore/PaperProposal/7b2f97fa-181e-408c-980f-bdd04c6043f7.pdf>-ээс Гаргасан

Colour Oxford English Dictionary. (2006). New York: Oxford University Press.

Kenan, R. S., & Hood, C. (2005). Blame Avoidance with Adjective? Motivation, Opportunity, Activity and Outcome. RCPR Joint Session, Blame Avoidance and Blame Management Workshop. Cranda.

Weaver, R. K. (1986). The Politics of Blame avoidance. Journal of Public Policy, Volume 6, Issue 4, 371-398.

Ричард, Р. (2005). Азийн үнэт зүйлс, пост-коммунист өв болон улс төрийн итгэлцэлд үзүүлэх женерик нөлөө: агуулга аргазүйн анализ. У. т. академ-Д, Зүүн Азийн Барометр /Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа (хуудсд. 119-138). Улаанбаатар.

Содном, Ш. (2020). Улс төр судлалын онол, практикийн асуудлууд. Улаанбаатар.

Улс төрийн боловсролын академи. (2005). Зүүн Азын Барометр. Улаанбаатар.

Улс төрийн мэдээлэл харилцаа. (2021). Улаанбаатар: Удам соёл.

Хатанболд, О. (2017). Ардчиллыг ойлгохуй ба судлахуй Монгол орны Жишээн дээр. Улаанбаатар: "Соёмбо принтинг" ХХК.

Хишигням, Б. (2019). 90 оноос хойшхи нийгмийн зарим үзэгдэлд хийсэн сэтгэлзүйн шинжилгээний үр дүн. Монгол дахь эрдчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2019/ (хуудсд. 297-299).-Д Улаанбаатар: "Адмон принт" ХХК.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ УЛС
ТӨР, ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ШИНЖИЛГЭЭ /1992-2020/**

Э.Гэрэлт-Од
МУБИС-ийн НХУС-ийн
Нийгмийн ухааны тэнхимийн багш

Хураангуй

Энэ өгүүлэл нь 1992 оноос хойших УИХ-ын сонгуулиудад хэрэглэсэн сонгуулийн тогтолцоо, сонголт, нийгэм-улс төрийн үр дагаварт шинжилгээ хийлээ. Тодруулбал, Монголын улс төрд нэг нам давамгайлсан намын систем тогтож, сонгогчдын улс төрийн боловсролд ахиц гараагүй, сонгогчдын санал гээгдэж, сонгогчдын улс төрийн оролцоо, төлөөлөл буурч, улс төрд мөнгө нөлөөлж буй нь сонгуулийн тогтолцооны үр дагавар гэсэн таамаглалыг сонгуулийн нээлттэй өгөгдлийг санд тулгуурлан шалгалаа. Иймээс цаашид Монголд улс төрийн институцийг төлөвшүүлэх, ил тод байдлыг хангах, сонгогчдын оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх, сонгуулийн санхүүжилтийг бууруулахад нөлөөлөх сонгуулийн тогтолцоо нь холимог болохыг тодорхойлж, зөвлөмж боловсруулсан юм.

Түлхүүр үг: Монгол улс, УИХ, сонгуулийн систем, улс төрийн нам, сонгогчдын оролцоо, төлөөлөл, сонгуулийн санхүүжилт, нам, намын систем

Оршил

Монгол улс 1990 онд нэг намтай авторитар улс төрийн тогтолцооноос олон намтай, хүний эрхийг хүндэтгэсэн, чөлөөт ардчилсан сонгуультай нээлттэй улс төрийн тогтолцоог сонгоод даруй 30 жил болжээ. Энэ хугацаанд парламентыг 9 удаа зохион байгуулсан. Харин 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш байнгын ажиллагаатай УИХ-ыг дөрвөн жил тутам нийт найман удаа сонгож байгуулаад

байна. Гэвч сонгуулийн дүн парламент, улс төрийн нам¹, намын систем² сонгогчдын сэтгэл зүй сөргөөр нөлөөлж³ иргэдийн улс төрийн намд итгэх итгэл суларч⁴, сонгуульд их мөнгө зарцуулсан нам, нэр дэвшигч ялалт байгуулахад нөлөөлдөг болжээ⁵. Үүний шалтгааныг УИХ-ын сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцоо (мажоритар) гэж үзэж байна. Учир нь Монгол улс 2012 оны сонгуульд ганц удаа сонгуулийн холимог тогтолцоог 48/28 буюу олонх, дийлэнх давамгайлсан хувилбар, бусад долоон сонгуулийг олонх, дийлэнхийн тогтолцооны хувилбаруудыг ашиглаж иржээ.

Иймээс 1992 оноос хойших УИХ-ын сонгуулиудын нээлттэй өгөгдлийн сан, Монгол улсын Үндсэн хууль, УИХ-ын сонгуулийн хуулиуд, ҮХЦ-ийн шийдвэр болон судалгааны бүтээл, зөвлөмжүүдийг судалсан юм. Мөн УИХ-ын сонгуулийн тогтолцооны өөрчлөлт, түүний нийгэм, улс төрийн үр дагаврыг улс төрийн системийн болон харьцуулсан аргаар судалж, Монголын улс төрийн орчинд тохирох, институцийн төлөвшилт болон ардчиллыг дэмжих сонгуулийн тогтолцоог санал болгох зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Сонгуулийн тогтолцооны онол, арга зүй.

Санал хураалт явуулах замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явцыг сонгууль гэдэг⁶. Ардчилсан нийгэмд сонгууль нь сонгогчдын оролцоо, төлөөллийг хангах нийгмийн зөвшилцөл юм. Сонгуулийн тогтолцоо гэж сонгогч хэдэн саналтай байх, саналаа хэнд өгөх, саналыг парламентад ямар аргаар суудал хуваарилах зэргийг багтаасан арга, дүрмийг хэлдэг.⁷ Дэлхий дээр сонгуулийн тогтолцооны мажоритар, пропорциональ гэсэн үндсэн хоёр хэлбэр байдаг бөгөөд

¹ Залуучуудын санал бодлын судалгаа. ОУБНХ. Улаанбаатар 2020 он. https://www.iri.org/sites/default/files/mongolia_ned_youth_poll_2020_-_public_deck_mongolian_final.pdf

² Монголын намын системийн институтчлэл. Дефакто институт, КАС. Улаанбаатар 2020. http://defacto.mn/wp-content/uploads/2020/09/instuchlel_tailanB5_ok%D0%9501.pdf

³ Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалтын судалгаа. 2016 оны 8 сарын 16-26. https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-_august_2016_-_public_deck_mon.pdf

⁴ Улс төрийн намуудын төлөвшил, өнөөгийн нөхцөл байдал. Судалгааны тайлан. Монголын дипломатын академи. Улаанбаатар. 2019 он. <http://mirim.mn/wp-content/uploads/2020/02/Songuuli-Sudalgaanii-tailan-2019.pdf>

⁵ УИХ-д сонгогдсон 75 гишүүн бусад нэр дэвшигчээс 3,6 дахин их мөнгийг зарцуулжээ. <https://ikon.mn/n/1zyx>

⁶ Election. Britannica encyclopaedia. <https://www.britannica.com/topic/election-political-science>

⁷ Electoral system. Britannica encyclopaedia. <https://www.britannica.com/topic/electoral-system>

улс орнууд өөрийн улс төр, нийгмийн нөхцөлд тохируулан 150⁸ гаруй аргыг хэрэглэж байна.

Сонгуулийн тогтолцоо нь дараах гурван гол үүргийг гүйцэтгэдэг. Үүнд сонгогчдын өгсөн саналд үндэслэн нам, нэр дэвшигчдийн суудлын тоог тогтоох, хоёрт иргэд сонгосон төлөөлөгчидтэйгээ хариуцлага тооцох хэрэгсэл, гуравт эрх мэдлийн төлөө өрсөлдөгчид сонгогчидтойгоо харьцах арга замыг сонгох хөшүүрэг болдог. Гэхдээ ихэнх судлаачид сонгуулийн тогтолцоо нь сонгуулийг хэрхэн зохион байгуулахыг тодорхойлсон ерөнхий ойлголт бөгөөд тойрог ямар байх, сонгогч саналаа яаж өгөх, намуудын кампанит ажлын стратеги ямар байх, нэр дэвшигч хэн байх, намын бодлого ямар байх, сонгогчдын саналыг хэрхэн татах, авсан саналыг парламентад хуваарилах зэрэг олон асуудлыг багтаасан ойлголт гэж тайлбарладаг. Тиймээс сонгуулийн тогтолцоо бол өргөн хүрээтэй, улс төрийн тогтолцоонд нөлөөлдөг чухал асуудал юм.

Сонгуулийн тогтолцоог сонгохдоо дараах нийтлэг зарчмуудыг харгалзаж үзэхийг судлаачид санал болгодог. Тухайлбал судлаач Б.Рейли⁹ сонгуулийн тогтолцоог сонгохдоо шударга төлөөллийг хангах; сонгуулийн үйл ажиллагаа иргэдэд хялбар, үр дүн нь утга учиртай байх; эв нэгдлийг хангах хөшүүрэг болох; тогтвортой, шуурхай ажиллагаатай засгийн газар бүрдүүлэх; засгийн газарт хариуцлага тооцох боломж; сонгогдсон төлөөлөгчидтэй хариуцлага тооцох боломж; улс төрийн намуудыг бэхжүүлэх; хууль тогтоох байгууллагад сөрөг хүчин байх, түүний хяналтыг дэмжих; сонгуулийн үйл явцыг тогтвортой байлгах; олон улсын стандартыг тус тус харгалзах зөв гэж гэж үзсэн. Харин судлаач Д. Хоровиц сонгуулийн тогтолцоо нь санал, суудлын харьцаа, сонгогчдын өмнө хүлээх хариуцлага, засгийн газрын тогтвортой байдал, сонгуульд ялагчыг хэрхэн тооцох, үндэстэн хоорондын болон шашин хоорондын эвлэрэл, цөөнхийн төлөөллийг дэмжих гэсэн зургаан зарчмыг харгалзаж үзэх ёстой¹⁰ гэж үзсэн.

Гэвч сонгуулийн тогтолцоо нь дээрх асуудлыг нэг дор бүрэн шийдэх боломжгүй. Учир нь сонгуулийн тогтолцоо бүр өөрийн давуу ба сул талуудтай.

⁸ Ж.Бямбадорж. Сонгох эрх ба Монгол улсын сонгуулийн тогтолцоог шинэчлэх асуудал. Шинэ толь сэтгүүл.№28, 1998 он.

⁹ Б.Рейли. Монгол улсын сонгуулийн тогтолцооны шинэчлэл, тогтолцооны хувилбарууд. Монгол улс. НҮБХХ. 2010 он.

¹⁰ Donald L. Horowitz. Electoral systems and their goals: a primer for decision-makers.2003 <https://aceproject.org/ero-en/topics/electoral-systems/E6ElectoralSystemsHorowitz.pdf>

Иймээс сонгуулийн тогтолцоог сонгох нь судалгаанд тулгуурласан улс төрийн шийдэл юм.


Улс төрийн шинжлэх ухаанд сонгуулийн тогтолцоог олонх, дийлэнхийн буюу ялагч бүхнийг авдаг **мажоритар**, хувь тэнцүүлэх буюу **пропорционал** гэсэн хоёр үндсэн арга байдаг ч сонгогчдын өгсөн саналыг нам, нэр дэвшигчийн хууль тогтоох байгууллагад авах суудлын тоонд хуваарилж байгаагаар нь олонх, дийлэнхийн (*plurality/majority*), хувь тэнцүүлэх (*proportional-PR*), *холимог (mixed), бусад*¹¹ хэмээн ангилж болно.

1. *Олонх, дийлэнхийн тогтолцоо.* Энэ тогтолцоо нь түгээмэл хэрэглэдэг таван хувилбартай бөгөөд олонхийн (*plurality*) буюу нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүн ялах дүрэмтэй харьцангуй олонхийн (*First past the post-FPTP*), багц саналын (*Block voting-BV*), мажоритар буюу үнэмлэхүй олонхийн гэж нийт хүчинтэй саналын талаас илүү хувийг авсан нэр дэвшигч ялах дүрэм үйлчилдэг хоёр шаттай тогтолцоо (*Two round-TRS*), альтернатив (*Alternative vote-AV*) болон намын багц санал (*Party block vote-PBV*) тогтолцоо тус тус багтана.
2. *Хувь тэнцүүлэх тогтолцоо.* Хувь тэнцүүлэх тогтолцооны зорилго нь намын авсан саналыг хууль тогтоох байгууллагын суудалд зориудаар хувь тэнцүүлэн хөрвүүлэхэд оршдог. Хувь тэнцүүлэх тогтолцооны үндсэн хоёр хувилбарт намын жагсаалт (*List PR*), шилжих дан санал (*Single transposable vote-STV*) тогтолцоо тус тус орно. Эдгээр бүх хувилбарт улс нэг тойргоор сонгуулийг зохион байгуулдаг.
3. *Холимог тогтолцоо.* Холимог тогтолцоог олонх дийлэнх болон хувь тэнцүүлэх тогтолцооны аль алиных нь эерэг шинжүүдийг нэгтгэх оролдлого хэмээн ойлгож болно. Холимог тогтолцоонд өөр өөр томъёололтой сонгуулийн хоёр тогтолцоог зэрэгцүүлсэн (*Parallel system-PS*) болон холимог (*Mixed Member Proportional-MMP*) гэсэн хувилбартай. Үүнд санал өгөх сонгогчид ижил байх бөгөөд төлөөлөгчдийг гол төлөв нэг мандаттай тойрог бүхий харьцангуй олонхийн болон намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлэх системийг хослуулан сонгодог.

¹¹ Electoral system (ACE project) <https://aceproject.org/ace-en/topics/es/esd/esd01/esd01c/default>

4. *Бусад*. Сонгуулийн олонх/дийлэнх болон хувь тэнцүүлэх аргуудаас өөр үл шилжих дан санал (*Single non-transferable vote-SNTV*), хязгаарлагдмал санал (*Limited vote-LV*), борда санал (*Borda count-BC*) гэсэн аргуудыг хэлдэг.

Зураг 1. Улс орнуудын сонгуулийн тогтолцоо¹²



Улс орнуудын 46 хувь нь олонх/дийлэнхийн тогтолцоо, 36 хувь нь хувь тэнцүүлэх тогтолцоо, 15 хувь нь холимог тогтолцоо, 3 хувь нь бусад гэсэн тогтолцоог тус тус ашиглаж байна.

Сонгуулийн аль нэг тогтолцоо, ямар нэг улсад яв цав тохирох боломжгүй гэж дээр өгүүлсэн. Учир нь тогтолцоо бүр давуу болон сул талтай. Сонгуулийн олонх дийлэнхийн болон хувь тэнцүүлэх гэсэн үндсэн хоёр тогтолцоо дараах давуу болон сул талтай.

Хүснэгт 1. Олонх, дийлэнхийн тогтолцооны давуу ба сул тал

Давуу тал	Сул тал
- Энгийн ойлгомжтой - Тогтвортой засгийн газар - Шууд сонгох - Тойргийн сонгогчдын хариуцлага - Намуудыг цөөрүүлдэг	- Санал гээгддэг - Цөөн төлөөллөөр олонх болдог - Саналын жин нөлөөлөл алдагддаг - Популистууд гарах - Парламентч тойргийн сонгогчдоос хараат - Нутгархаг сэтгэл зүй - Намын сахилга хариуцлага сулардаг

Хүснэгт 2. Хувь тэнцүүлэх тогтолцооны давуу ба сул тал

¹² Electoral system. ACE project <https://aceproject.org/ace-en/topics/es/esd/default>

Давуу тал	Сул тал
▪ Санал гээгддэггүй ▪ Саналын төлөөлөл алдагддаггүй ▪ Улс төрийн хүчний зохистой харьцаа хангагддаг ▪ Парламент ёс хөгжих ▪ Намуудын төлөвшилд сайн нөлөөтэй ▪ Хариуцлага хүлээх субъект тодорхой ▪ Улс төрийн соёл боловсролын өндөр төвшин	▪ Хэт олон сул нам бий болох ▪ Жижиг намууд парламентад орж ирэх ▪ Тогтворгүй засгийн газар ▪ Бие даасан нэр дэвшигчдэд халгаатай ▪ Намчирхах сэтгэлзүй нэмэгдэх ▪ Орон нутгийн төлөөлөл, ашиг сонирхлыг хангах чадвар сул ▪ Сонгогчдоос гишүүнд хяналт тавих боломж сул

Аливаа улс орон өөрийн улс төрийн орчин, институцийн төлөвшил, сонгогчдын боловсрол зэрэг асуудлыг сайтар судалж байж өөрт тохирсон сонгуулийн тогтолцоог сонгох учиртай. Учир нь ардчилал хөгжих эсэхэд сонгуулийн тогтолцоогоо зөв сонгосон эсэх, сонгуулийн хуулиа сайн боловсруулсан эсэх, сонгуулиа хуулийн хүрээнд зохион байгуулж чадсан эсэхээс шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл, Сонгуулийн ямар тогтолцоо сонгохоос шалтгаалж нам, намын систем, парламент, засгийн газар, сонгогчид төлөвшдөг, улмаар ардчилал тодорхойлогддог ажээ.

УИХ-ын сонгуулийн тогтолцоо, эрх зүйн орчин

Монгол Улс чөлөөт, ардчилсан сонгуулийн гучин жилийн түүхтэй ч, байнгын ажиллагаатай УИХ-ыг 1992 оноос хойш дөрвөн жил тутам бүх нийтийн санал хураалтаар сонгож байгуулж ирлээ. Сонгуульд 18-аас дээш насны сонгуулийн эрх бүхий иргэд оролцдог. Учир нь 1948 онд НҮБ-ын баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21.3 зүйлд “*Ард түмний хүсэл зориг бол засаг төрийн үндэс мөн. Мөн хүсэл зориг нь бүх нийтэд сонгуулийн тэгш эрх эдлүүлэх үндсэн дээр санал хураалтыг нууцаар хураах, эсхүл саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр бусад хэлбэрийг ашиглах замаар тогтмол, хуурамч бус сонгууль явуулахад илэрлээ олно*”¹³ гэж заасан нь дэлхий нийтээр сонгох эрхийг хэрэгжүүлэх гол арга болсон юм.

¹³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948 он. <https://www.legalinfo.mn/law/details/1271>

1992 онд баталсан шинэ Үндсэн хуулийн 3.1 зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”¹⁴ гэж хуульчилсан. Хожим УИХ 2003 онд “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.1-д “Сонгуулийн тогтолцоо, үйл явцын журмыг иргэдийн бие даасан оролцоог хангаж, чадварлаг УИХ бүрдүүлэхэд чиглүүлж боловсронгуй болгоно”¹⁵ гэж заасан. Гэвч сонгуулийн тогтолцоонд ахиц дэвшил гараагүй өнөөг хүрчээ.

Тодруулбал, өнгөрсөн хугацаанд Монгол улс УИХ-ын сонгуулийн тогтолцоог 1992, 1996, 2005, 2011, 2015, 2016, 2019 онуудад нийт 7 удаа өөрчилжээ. Үүнээс тавыг нь хуулийг шинэчлэн найруулж, хоёрыг нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байжээ. Өөрчлөлт бүр ээлжит сонгууль өмнө байсан бөгөөд сонгуулийн хуулийг сайжруулах нэртэй эрх баригч намын улс төрийн бодлого байсан.

1. Анхны хууль¹⁶-ийг УИХ 1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан. Хуулийн 8.1 зүйлд Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно гэж заасан. Энэ нь сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцооны (Block voting) хувилбар юм. Хожим 1996 онд ээлжит сонгуулиас 2 сарын өмнө уг хуулийн 8.1 зүйлийг “сонгуулийг нэг мандат бүхий тойргоор зохион байгуулж явуулна” гэж өөрчилсөн нь сонгуулийг жижгэрүүлсэн нэг тойрог, нэг мандаттай (FPTP) тогтолцоо юм. Энэ тогтолцоог 1996, 2000, 2004 онуудад хэрэглэсэн байдаг.
2. Хоёр дахь хууль¹⁷-ийг УИХ 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан. Хуулийн 4.2 зүйлд Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно. 28.1 зүйлд Нам, эвсэл нь олон мандаттай тойрогт тухайн тойрогт ногдох мандатын тооноос илүүгүй хүний нэрийг дэвшүүлнэ гэж заасан. Энэ нь 1992 онд хэрэглэсэнтэй ижил олонх, дийлэнхийн тогтолцооны (Block voting) хувилбар бөгөөд Монгол улс сонгуулийн тогтолцооны шинэтгэлээс ухарсан үйлдэл байсан.

¹⁴ Монгол Улсын Үндсэн Хууль. 1992 он. <https://www.legalinfo.mn/law/details/367>

¹⁵ Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. 2003 он. <https://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

¹⁶ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 1992 он. <https://www.gec.gov.mn/>

¹⁷ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2005 он. <https://www.gec.gov.mn/>

3. Гурав дахь хууль¹⁸-ийг УИХ 2011 оны 12 сарын 15 өдөр баталсан. Хуулийн 4.8 зүйлд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд 76 гишүүнийг сонгоно. 4.9 зүйлд Энэ хуулийн заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг улс төрийн намын жагсаалтаас тус тус сонгоно гэж заажээ. Сонгуулийн энэ тогтолцоо нь олонх дийлэнхийн болон хувь тэнцүүлсэн тогтолцоог зэрэгцүүлэн (Paralell system) хэрэглэсэн анхны бөгөөд сүүлчийн тохиолдол байсан.
4. Дөрөв дэх хууль¹⁹-ийг УИХ 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан. Энэ хууль нь УИХ, Ерөнхийлөгч болон орон нутгийн сонгуулиудыг нэг хуулиар зохицуулах оролдлого байсан бөгөөд сонгуулийн тогтолцоог өмнөх хуультай ижил 48/28 гэсэн холимог тогтолцоог дахин баталсан. Гэвч Үндсэн хуулийн Цэц 2016 оны 4 сарын 22-ны өдрийн 05-р тогтоолоор Сонгуулийн хууль Үндсэн хууль зөрчсөн²⁰ гэж үзсэн тул УИХ 2016 оны 5 сарын 5-ны өдөр УИХ уг тогтоолыг хэлэлцээд ээлжит сонгуулиас 2 сарын өмнө хуулийн 7.1 дэх заалтыг Сонгууль нь олонхийн /мажоритар/ тогтолцоотой байна гэж өөрчилсөн.
5. Тав дахь хууль²¹-ийг УИХ 2019 оны 12 сарын 20 өдөр баталсан. Хуулийн 4.3 зүйлд Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно гэж заасан нь мөн л 1992, 2008 онд хэрэглэсэн Олонх, дийлэнхийн тогтолцооны олон мандатын том тойргийн (Block voting) хувилбарыг дахин хуульчилжээ.


¹⁸ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2011 он. <https://www.legalinfo.mn/law/details/351>

¹⁹ Сонгуулийн тухай хууль. 2015 он. <https://www.legalinfo.mn/law/details/12178>

²⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 05 дугаар тогтоол. <https://www.legalinfo.mn/law/details/11847?lawid=11847>

²¹ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2019 он. <https://www.legalinfo.mn/law/details/14869>

Зураг 2. УИХ-ын сонгуулийн хуулиуд ба тогтолцооны өөрчлөлтүүд



Дээрх сонгуулийн хуулиуд болон тогтолцооны өөрчлөлтүүдээс харахад Монгол улс 1992 оноос хойш УИХ-ын сонгуулийг найман удаа зохион байгуулахдаа сонгуулийн Олонх, дийлэнхийн тогтолцооны нэг мандаттай жижиг тойргийн (FPTP) хувилбарыг 1996, 2000, 2004, 2016 онд, олон мандаттай томсгосон тойргийн (BV) хувилбарыг 1992, 2008, 2020 оны УИХ-ын сонгуулиудад хэрэглэжээ.

Харин түүхэндээ анх удаа 2012 онд сонгуулийн холимог тогтолцоог 48/28 хувилбараар хэрэглэсэн. Энэ нь УИХ-ын 76 мандатын 48-г олон мандаттай томсгосон мажоритар 26 тойргоос, 28 мандатыг улс нэг тойргоос намын жагсаалтыг сонгох холимог хувилбар юм. Угтаа энэ холимог хувилбар нь Олонх, дийлэнхийн тогтолцоог 63 хувиар, хувь тэнцүүлсэн тогтолцоог 37 хувиар зэрэгцүүлэн хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, сонгуулийн тогтолцооны давуу болон сул талуудыг тэнцвэржүүлээгүй юм.

2011 онд сонгуулийн холимог тогтолцоог сонгох улс төрийн шалтгаан байсан. Энэ нь 2008 оны УИХ-ын сонгуулийн дараах “7 сарын 1”-ны үйл явдал бөгөөд сонгуулийн дүнг эсэргүүцсэн улс төрийн жагсаал болж нэлээдгүй хохирол амсаж байсан. Үүний дараа УИХ дахь МАХН (одоогийн МАН), АН-ууд “стандарт бус” эвслийн засгийн газар байгуулан сонгогчдын санал гээдэг энэ тогтолцоог хэрэглэхгүй байх, улс төрийн намуудыг төлөвшүүлэх, сонгуулийг мөнгөний нөлөөллөөс салгах, эмэгтэйчүүдийн оролцоо төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор холимог тогтолцоог баталсан юм. Ямартаа ч 2012 оны УИХ-ын сонгуулиар сонгогчид мажоритар тойргийн нэр дэвшигч болон улс нэг тойрог гэсэн намын жагсаалтаас сонголт хийсэн, гадаадад оршин суугаа иргэд түүхэндээ анх удаа УИХ-ын сонгуульд оролцох эрхийг нээгдсэн, УИХ-д 11 эмэгтэй сонгогдсон зэрэг сонгогчдын оролцоо, төлөөлөл нэмэгдсэн.

Дээрх сонгуулийн тогтолцооны өөрчлөлтүүдийг дүгнэхэд ерөнхийдөө олонх, дийлэнхийн тогтолцооны хувилбаруудыг хэрэглэж ирсний улмаас нийгэм, улс төрийн орчинд дараах өөрчлөлтүүд гарчээ.

Нэг. Институцийн төлөвшил. Сонгуулийн Олонх, дийлэнхийн тогтолцооны нэг онцлог нь зарим үед парламентад нэг нам давамгайлсан “супер мажоритар” олонх бүрдэх боломжийг олгодог. Өнгөрсөн сонгуулиудын дүнг харахад 1992, 2000, 2016, 2020 оны сонгуулиар УИХ-д МАН үнэмлэхүй олонхийн суудлыг авсан байдаг.

Хүснэгт 3. УИХ-д сонгогдсон нам, бие даагчдын суудлын тоо²²

№	Сонгуулийн жил	МАН	АН	Бусад	Бие даагчид	Нийт
1	1992 он	70	5		1	76
2	1996 он	25	50		1	76
3	2000 он	72	1	1	2	76
4	2004 он	36	36		4	76
5	2008 он	45	28	2	1	76
6	2012 он	26	34	13	3	76
7	2016 он	65	9	2	1	76
8	2020 он	62	11	2	1	76

Дээрх хүснэгтийг харахад Монгол улсад сонгуулийн тогтолцооноос үүдэлтэй давамгайлагч нэг намтай намын систем тогтож байна. Энэ нь МАН бөгөөд өөрийн нүсэр бүтэц, уламжлалт тогтолцоогоо хадгалсаар байгаа, улс төрийн тавцанд хүчтэй хэвээр байгаа шалтгаан нь сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцоо болж байна. Учир нь МАН 1992, 2008, 2020 онууд олон мандаттай том тойргоор, 2000, 2016 онуудад нэг тойрог нэгт мандаттай жижгэрүүлсэн тогтолцоонд тус тус ялалт байгуулжээ.

АН 1996, 2004 онуудад УИХ-ын сонгуулийг нэг тойрог нэгт мандаттай жижгэрүүлсэн тогтолцоогоор зохион байгуулахад эвсэж ялалт байгуулсан. Эндээс харахад АН сонгуульд амжилттай өрсөлдөх, олон суудал авах ганц боломж нь МАН-ын эсрэг хүчтэй эвсэл байгуулах бөгөөд энэ нь саналаа хуваахгүй байхгүй байх боломж болж байна. Өөрөөр хэлбэл, АН сонгуульд эвсэл байгуулж оролцсон

²² Sumati Luvsandendev, (2018) Voters ‘voices II. Ulaanbaatar. 25p.

үедээ л хүчтэй өрсөлдөгч болдог, бусад үед дандаа ялагддаг зүй тогтол харагдаж байна. Мөн АН нь сонгуулийн тогтолцооноос үүдэлтэй органик бус нэгдлүүдийн түүх байна. Тодруулбал 1990 оны АИХ-ын сонгуулийн дараах МЧХН, БНН-ууд нэгдэж НН (Нэгдсэн нам), 1992 оны УИХ-ын сонгуулийн дараах МоАН, НН, МСМН, МҮДН-ууд нэгдэж МҮАН (Монголын Үндэсний Ардчилсан нам), 2000 оны УИХ-ын сонгуулийн дараах МҮАН, МСДН, МШАН, МУСМН, МоАН, МУНН²³ гэх нийт 12 намын нэгдэл юм. Нэгдэл бүр сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцооны шууд үр дагавар байсан. Энэ үзэгдлийг улс төрийн ухаанд М.Дювержигийн хууль²⁴-иар тайлбарладаг. Гэвч институцчиж амжаагүй улс төрийн намуудад олон дийлэнхийн тогтолцоо нь хоёр намын системийг биш, харин нэг нам давамгайлсан намын системийг тогтоход нөлөөлж байх²⁵ талтай. Учир нь сонгуулийн тогтолцоо нь намын институцлалыг дэмжихгүй, хоёр намын систем тогтоход саад болсоор байна гэж үзэж байна.

Хоёр. Сонгогчдын оролцоо. Сонгуулийн тогтолцооноос үүдэлтэй сонгогчдын оролцоо бүрэн хангагдахгүй байгаа, ялангуяа гадаадад оршин суугаа сонгогчид саналаа өгөх боломж олгохгүй байгаа нь ноцтой асуудал байсаар байна.

Хүснэгт 4. Сонгогчдын оролцоо²⁶

№	Сонгууль	Сонгуулийн насны иргэдийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Сонгуулийн ирц
1.	1992 он	1,202,704	1,085,129	95.6%
2.	1996 он	1,218,549	1,147,260	92.1%
3.	2000 он	1,364,862	1,247,033	82.4%
4.	2004 он	1,472,372	1,279,516	82.2%
5.	2008 он	1,607,825	1,542,617	76.46%
6.	2012 он	1,882,035	1,840,824	67.28%
7.	2016 он	1,998,823	1,911,047	73.58%
8	2020 он		2,003,969	73,6%

²³ Монголын Ардчилсан нам. <https://mn.wikipedia.org/>

²⁴ Duverger's law. Oxford reference. <https://www.oxfordreference.com/view/10.1093/oi/authority.20110803095737871>

²⁵ Pavel Maskarinec. The 2016 Electoral Reform in Mongolia: From Mixed System and Multiparty Competition to FPTP and One-Party Dominance. Journal of Asian and African Studies. 2018, Vol. 53(4) 511–531

²⁶ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн (1992-2016). Сонгуулийн Ерөнхий хороо. Улаанбаатар хот. 2017 он. 6 тал.

Дээрх хүснэгтээс харахад УИХ-ын сонгуулийн ирц буурах хандлага байна. Сонгогчид хүнийг биш бодлого сонгодог тогтолцоонд шилжвэл хэн нэр дэвшихээс үл хамааран хөгжлийн бодлого сонгох, нам “бодлогын нам” болж төлөвших боломж бүрдэх юм. Сонгогчид сонгуульдаа идэвхгүй оролцож байгаа шалтгааныг намууд таалагдахгүй, сонгох нэр дэвшигч байхгүй, эсхүл сонгуулийн санал өгөх өдөр өөр газар байсан, гадаадад байгаа зэрэг шалтгаан байдаг. Тэгвэл эдгээр шалтгааныг сонгуулийн тогтолцоог өөрчлөх замаар шийдвэрлэх боломжтой.


Мөн сонгогчийн бүртгэлийн тогтолцоо нь улс төрийн маргаан дагуулдаг, сонгуульд бүрт шинэчлэн сонгогчийн нэрийн жагсаалтыг шинээр гаргадаг, хэдэн иргэн хуулийн дагуу нэрийн жагсаалтаас хасагддаг, гадаадад сурч, ажиллаж буй иргэдийн тоо тодорхойгүй байсаар байна. Үүнийг мөн л сонгуулийн Олонх, дийлэнхийн тогтолцооны сул тал гэж үзэж байна. Тухайлбал, гадаадад ажиллаж, амьдарч байгаа сонгогчдын сонгох эрх нь өнөөдрийг хүртэл зөрчигдсөөр байна. Монгол улс түүхэндээ ганцхан удаа 2012 оны УИХ-ын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор зохион байгуулахад гадаадад буй сонгогчдын сонгох эрх нээгдсэн байдаг. Уг сонгуулиар гадаад дахь 39 дипломат төлөөлөгчийн газар санал хураахад 4276 иргэн бүртгүүлснээс 2779²⁷ сонгогч оролцож санал өгөх эрхээ эдэлсэн байдаг. Мөн сонгуульд оролцохгүй байгаа иргэдийн ихэнх нь 40-өөс доош насны залуус²⁸ байгаа бөгөөд тэд сонгуульд оролцох сонирхолгүй, санал өгөөд ч нэмэргүй гэх хандлагатай байдаг нь сонгуулийн тогтолцооны сөрөг үр дагавар байна.

Гурав. Сонгогчдын төлөөлөл. УИХ-ын легитим чанарыг нэмэгдүүлэхийн тулд аль болох сонгогчдын санал УИХ-д тусаж байх тогтолцоог сонгох хэрэгтэй. Гэтэл сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцооны сул тал нь цөөнхийн дэмжлэгтэйгээр парламент бүрдэж, сонгогчдын санал ихээр гээгдэхэд нөлөөлдөг.

Зураг 4. УИХ-д туссан сонгогчдын санал

²⁷ Монгол Улсын Их хурлын сонгуулийн дүн. (1992-2016 он) Сонгуулийн ерөнхий хороо. УБ., 2017. <https://gec.gov.mn/>

²⁸ Улсын Их хурлын сонгуулийн санал хураалтын дүн шинжилгээ. ҮСХ. 2016 он. <http://1212.mn/>



1992-2004 оны УИХ-ын сонгуулиудад УИХ нийт сонгогчдын 52-58 хувийн саналаар бүрдэж байсан бол 2008 оноос хойш сонгогчдын 41-49 хувийн саналаар бүрдэж байжээ. Өөрөөр хэлбэл УИХ-ын легитим чанар суларч байна.

Мөн сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцоо нь ялагч бүхнийг авдаг тул тухайн тойрогт мандатын тоогоор хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог. Бусад нэр дэвшигчдийн санал орхигддог. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүн цөөхөн саналаар сонгогдож суудлын тоо, сонгогчдын дэмжлэг хоёр зөрөх магадал их байдаг. Үүнийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 5. Сонгогчдын дэмжлэг ба УИХ дахь суудал


УИХ-ын сонгууль	МАН				Ардчилсан нам			
	Сонгогчдын дэмжлэг	УИХ дахь суудал		Зөрүү	Сонгогчдын дэмжлэг	УИХ дахь суудал		Зөрүү
1992 он	58.23%	70	92.1%	+33.9%	27.89%	5	6.6%	-21.3%
1996 он	40.49%	25	32.9%	-7.6%	47.92%	50	65.8%	+17.9%
2000 он	51.57%	72	94.7%	+43.2%	15.21%	1	1.3%	-13.9%
2004 он	49.08%	36	47.4%	-1.7%	45.27%	36	47.4%	+2.1%
2008 он	45.46%	45	59.2%	+13.8%	37.1%	28	36.8%	-0.3%
2012 он	33.59%	26	34.2%	+0.6%	35.93%	34	44.7%	+8.8%
2016 он	45.53%	65	85.5%	+40.0%	33.54%	9	11.8%	-21.7%
2020 он	45.19%	62	81.6%	+36.4%	24.31%	11	14.5%	-9.8%

Дээрх хүснэгтээс харахад сонгогчдын санал багахан савлахад УИХ-д МАН-ын төлөөлөл хэт өндөр болж байсан байна. Үүнд:

МАХН-ын (одоогийн МАН) хувьд 1992 оны УИХ-ын сонгуульд сонгогчдын 58,23 хувийн дэмжлэг авсан УИХ-ын нийт суудлын 92 хувийг авч байсан байна. Мөн 2000 оны УИХ-ын сонгуульд сонгогчдын 51,57 хувийн дэмжлэг авсан ч УИХ-ын нийт суудлын 94,7 хувийг, 2016 оны УИХ-ын сонгуульд сонгогчдын 45,53 хувийн дэмжлэг авсан ч УИХ-ын нийт суудлын 85,2 хувийг, 2016 оны УИХ-ын сонгуульд сонгогчдын 45,19 хувийн дэмжлэг авсан ч УИХ-ын нийт суудлын 81,6 хувийг тус тус авчээ.

Харин АН-ыг дэмжсэн сонгогчид болон УИХ дахь суудлын зөрүү нь МАН-тай харьцуулахад бага байна. Мөн МАН, АН, бусад намуудын сонгуулиар авсан дэмжлэг буюу намын бодит рейтингт урт хугацаандаа өөрчлөлт орж байна. МАН-ын рейтинг 33-58 хувийн дэмжлэг авч байгаа бөгөөд буурах хандлагатай байна. МАН-ын дундаж рейтинг 46.14 хувь байна. Харин АН-ын рейтинг 15-47 хувь байсан бөгөөд дунджаар 33.39 хувийн дэмжлэгтэй бол бусад нам, бие даагчид дунджаар 19.38 хувь байна.

Зураг 5. Улсын хэмжээнд намуудын дэмжлэг



2020 оны УИХ-ын сонгуулийн дүнгээс харахад МАН, АН-уудын рейтинг дунджаар 21 хувийн зөрүү байгаа ч, сонгуулийн тогтолцоо хэн ялалт байгуулахыг тодорхойлж байна. Сонгуулийн түүхийг харахад МАН нь АН-аас 1992 онд 30 хувь, 2000 онд 16 хувь илүү, 2004 онд 4 хувь, 2008 онд 8 хувь, 2016 онд 12 хувь, 2020 онд 11 хувиар тус тус илүү дэмжлэг авчээ. Харин АН нь МАН-аас 1996 онд 7 хувь, 2012

онд 2 хувь илүү дэмжлэг авч түүхэндээ хоёрхон удаа илүүрхэж байжээ. Гуравдагч хүчний дэмжлэг 2000, 2012 онуудад өсөж байсан бөгөөд сүүлийн гурван сонгууль дараалан тогтвортой байна.

Дөрөв. Сонгуулийн санхүүжилт. Монгол улсад сонгуулийн зардал жилээс жил, сонгуулиас сонгуулийн хооронд нэмэгдэж байна.

- 1992 онд 137 сая, 1996 онд 209 сая, 2000 онд 1 тэрбум 841 сая, 2004 онд 1 тэрбум 558 сая төгрөг байсан.²⁹
- 2008 онд улс төрийн нам, нэр дэвшигчид бүгд нийлээд 7.9 тэрбум төгрөгөөр сонгуулийн кампания санхүүжүүлж байсан.³⁰
- 2012 онд 36.8 тэрбум төгрөгийг нам, нэр дэвшигчид зарцуулсан.³¹
- 2016 оны оны УИХ-ын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдийн нийт 34,4 тэрбум төгрөг зарцуулсан.³²
- 2020 оны УИХ-ын сонгуульд намууд 8,2 тэрбум, нэр дэвшигчид 67,2 тэрбум нийт 75,4 тэрбум төгрөг зарцуулжээ.³³

Дээрх албан ёсны тоо нь бодит зардал биш байх магадлалтай. Учир нь нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардал нуугдмал, санхүүжилт ил тод бус байгаа нь сонгуулийн Олонх, дийлэнхийн тогтолцооноос шууд хамааралтай бөгөөд нам, нэр дэвшигчийн өөрийгөө таниулах зорилготой сонгуулийн ба сонгуулийн бус жилүүдэд зардал нэмэгдсээр байна. Үүнд нь УИХСТХ-ийн 37.3 зүйлд заасан ... 200 хүртэлх сонгогч тутамд нэг ухуулагчтай байж болох заалт, мөн 7 бүлэгт заасан сурталчилгаа нь бүхэлдээ их хэмжээний зардал гаргаж өрсөлдсөөр байна.

2012 оноос хойш УИХ-ын сонгуулийн тухай хуулиар сонгогчийн саналыг худалдаж авахыг хориглож ирсэн ч бодит байдал дээр сонгогч, нэр дэвшигч хоёрыг мөнгө холбож байна. Эдгээрийг сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцооны сул тал гэж мөн үзлээ. Учир нь сонгуулийн эл тогтолцоо нь ялалт байгуулахын тул нам, нэр дэвшигчдийг их хэмжээний хөрөнгө зарцуулахыг шаарддаг юм.

Монгол улс 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиас эхлэн сонгуулийн зардлын дээд хязгаарыг тогтоох ирсэн. 2016 оны УИХ-ын ээлжит сонгуулийн жилд

²⁹ Сонгуулийн санхүүжилтийн үнэлгээний судалгаа <https://www.sanal.mn/story/71/2008-05-27>

³⁰ Сонгуулийн санхүүжилт: асуудал ба шийдэл судалгаа. СБТ. 2015 он

³¹ Сонгуулийн санхүүжилт: асуудал ба шийдэл судалгаа. СБТ. 2015 он

³² 2016 оны УИХ-ын сонгуулийн санхүүжилтийн мониторинг. ННФ. 2016 он

³³ 2020 оны УИХ-ын сонгуульд улс төрийн нам, нэр дэвшигчдийн зардлын тайлан. УАГ. 2020 он

нам эвсэл 4.4 тэрбумаар тогтоож байсан бол 2020 оны ээлжит сонгуулийн зардлын дээд хэмжээг 5.9 тэрбумаар тогтоожээ. 2020 онд УИХ-ын сонгуульд 29 тойрогт нэр дэвшигчийн зардлыг 367 сая (Сүхбаатар аймаг)-аас 775 сая (Нийслэлийн Баянгол дүүрэг) байхаар тогтоосон³⁴. Намууд 9,6 тэрбум төгрөг³⁵ зарцуулах хязгаарыг тогтоосон. Харин 2020 оны УИХ-д сонгогдсон 75 гишүүн сонгуулийн зардалд нийтдээ 27.3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Энэ нь нийт зардлын 40 хувь байна. Өөрөөр хэлбэл, УИХ-д сонгогдсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардал дунджаар 363 сая төгрөг бол сонгогдож чадаагүй 469 нэр дэвшигчийн сонгуулийн зардал дунджаар 101 сая төгрөг байгаа нь 3.6 дахин их мөнгө³⁶ байна. Энэ нь УИХ-д зөвхөн мөнгөтэй нам, нэр дэвшигч л сонгогдох боломж илүү байгааг нотлон харуулж байна. Мөн улс төрийн намууд санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлэх³⁷ үүргээ хэрэгжүүлэхгүй байсаар байна.

Цаашид Монгол Улс УИХ-ын сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцоог өөрчлөхгүй бол төлөвшөөгүй улс төрийн намууд шударга бусаар өрсөлдөж, мөнгөтэй нам, нэр дэвшигч л сонгуульд ялж, улмаар сонгогчдын улс төрийн улс төр, намд итгэх итгэл буурч, аажимдаа ардчилсан нээлттэй улс төрийн тогтолцоог хямруулсаар байх бололтой.

Сонгуулийн тогтолцооны шинэтгэл хийх санаачлага

Уул нь 30 жилийн хугацаанд УИХ-ын сонгуулийн тогтолцоог шинэчлэх, хувь тэнцүүлсэн тогтолцоог тодорхой хэмжээгээр хэрэглэж болох талаар саналууд нэлээд гарч, дотоод гадаадын судлаачид Монголын улс төрийн онцлогт тохирсон дараах саналуудыг өгч байжээ. Үүнд:

1. 1998 онд Ж.Бямбадорж 1996 оны УИХ-ын сонгуульд хэрэглэсэн жижгэрүүлсэн нэг тойрог-нэг мандат (FPTP) тогтолцоо сонгогчдын хүсэл зоригийг хамгийн бага тусгасан, мөнгө нөлөө нэмэгдэж, УИХ дахь намын үүргийг сулруулж байна. Иймээс УИХ-ыг хувь тэнцүүлж (пропорционал) сонгох аргаар бүрдүүлдэг тогтолцоонд шилжих

³⁴ Монгол Улсын Их хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ. Монгол Улсын Үндэсний Аудиторын А/23 тоот тушаал. <https://news.mn/r/2267364/>

³⁵ Нам эвслийн сонгуулийн зардлыг 5,9 тэрбум байхаар тогтоолоо. <https://news.mn/r/2267364/>

³⁶ УИХ-д сонгогдсон 75 гишүүн бусад нэр дэвшигчээс 3.6 дахин их мөнгийг сонгуульд зарцуулжээ <https://ikon.mn/n/1zyx>

³⁷ Монголын улс төрийн намын тухай хууль. 2005 он. <https://www.legalinfo.mn/law/details/508>

шаардлагатай байна. Гэхдээ сонгуулийг улс нэг тойрог болгож зохион байгуулж, сонгогч дэмждэг нам, эсхүл тухайн намаас нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө. Нам, нэр дэвшигчийн төлөө зэрэг өгсөн ч болно. Дээрхийн алинаар нь өгсөн ч энэ саналыг тухайн намын төлөө өгсөн саналд тоолно. Харин нэг намын төлөө санал өгөөд өөр намын нэр дэвшигч эсхүл бие даан нэр дэвшигчийн төлөө өгч болохгүй. Улсын хэмжээгээр намуудын төлөө өгсөн саналд нь хувь тэнцүүлж Улсын Их Хурлын гишүүний суудлыг хуваарилна. Тухайн намд оногдсон суудалд тэр намаас нэр дэвшигчдийн хэнийг нь сонгох вэ гэдгийг нэр дэвшигчдийн сонгогдох дарааллыг нам нь биш сонгогч шийдвэрлэж байгаа хэрэг юм. Нам сонгогчдын 3-9 хувийн санал авч байж суудал хуваарилалтанд оролцох эрхтэй болох нь зөв³⁸ гэж үзжээ.

2. 1999 онд судлаач Н.Цолмонтаяа УИХ-ын сонгуулийн хуулийг боловсронгуй болгоход пропорционал системийн аль нэг хувилбарыг сонгуулийн хуульд тусгахын хамт сонгуулийн тойрогт улс төрийн намуудаас нэр дэвшигдэн өрсөлдөх боломжийг хангах нь зүйтэй³⁹.
3. 2005 онд УИХ сонгуулийн тогтолцооны олонх дийлэнх⁴⁰ болон хувь тэнцүүлэх⁴¹ тогтолцооны үр өгөөжийг судалж, зөвлөмж боловсруулж байсан ч 2005 оны УИХСТХ-ийг батлахдаа уг судалгааг огт ашиглаагүй юм.
4. 2009 онд профессор Д.Ноолон Монгол улс мажоритори сонгуулиас хуримтлуулсан туршлага дээр суурилан сонгуулийн системээс хүлээгдэх дараах үр дүнгийн талаар зөвшилцөх хэрэгтэй бөгөөд сонгуулийн системийн хувьд 50/50 хувийн харьцаатайгаар сонгуулийн мажоритар /FРТР/, пропорционал тогтолцоог хослуулж хэрэглэх, пропорционал тогтолцоондоо 4%-ийн босгыг тавих нь оновчтой гэж дүгнэсэн. ⁴²
5. 2010 онд судлаач Бенжамин Рейли УИХ-ын сонгуулийг холимог системээр зохион байгуулах УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг

³⁸ Ж.Бямбадорж. Сонгох эрх ба Монгол улсын сонгуулийн тогтолцоог шинэчлэх асуудал. Шинэ толь сэтгүүл. №28, 1998 он.

³⁹ Н.Цолмонтаяа. Сонгуулийн тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох асуудалд. Шинэ толь сэтгүүл. №25, 1999 он.

⁴⁰ УИХ-ын сонгуулийн олонхи дийлэнхийн тогтолцоог боловсронгуй болгох нь . Бодлогын зөвлөмж, 2005 он;

⁴¹ Монгол улсад сонгуулийн хувь тэнцүүлсэн системийн аль хувилбар илүү тохиромжтой вэ? Бодлогын зөвлөмж. 2005 он

⁴² Д.Ноолон. “Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэтгэл” Бодлогын баримт бичиг. Фрейдрих Эбэрт Сан. 2009 он.

нэмэгдүүлэх бүрэн боломжтой байна. Үүнд, УИХ-ын 26 тойрогт “нэг мандат, нэг суудал” зарчмаар 26-г нь сонгож, үлдсэн 50-ийг нь намуудын нэрээр авсан саналын хувиар бодож суудал хуваарилах хувилбар, эсвэл УИХ-ын сонгуулийг 76 тойрогт сонгогч нэг нам, нэг нэр дэвшигч /сонгосон намын нэр дэвшигч байх албагүй/-ийн төлөө санал өгнө. 50+1 хувийн санал авсан нэр дэвшигч шууд УИХ-д сонгогдож, үлдсэн суудлыг намын авсан саналаар хувь бодож хуваарилах боломжтой гэж зөвлөж байжээ.

6. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд УИХ дахь МАН, АН-ууд “Улсын Их хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө” хэлэлцэж байсан ч баталж чадаагүй юм. Харин Үндсэн хуулийн 21.4 зүйлд “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно”⁴³ гэж баталсан.

УИХ-ын сонгуулийн тогтолцооны өөрчлөлтүүдээс харахад цаашид олонх, дийлэнхийн тогтолцоог хэрэглэсээр байвал:

1. Давамгайлагч нэг намын систем тогтож, улс төрийн бусад намууд хүчээр уусах, эсвэл тэдэнтэй хамтран ажиллах, олонхи нь парламентын гадна үлдэж улс төрийн нөлөөллийн хувьд хүч муутай бүлэглэл төдийгөөр оршин тогтноход хүрэх юм. Энэ байдал нь нам, намын системийн институтчлэлийг удаашруулна.
2. Сонгогчид бодлогыг бус хүн харж сонголтоо хийнэ. Энэ тохиолдолд тойрогт хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн нэр дэвшигч ялалт байгуулсаар байх болно. Сонгуулийн үр дүнг мөнгө тодорхойлсоор байх болно.
3. УИХ-ын гишүүд сонгогчиддоо таалагдаж, улсын хөрөнгө оруулалт татсаар байх ба хөгжлийн бодлогыг үндэсний хэмжээнд төлөвлөх, зарцуулах боломжгүй болно.

⁴³ Монгол улсын Үндсэн хууль. 1992 он. (21.4 хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан) <https://www.legalinfo.mn/law/details/367>

4. Гадаадад амьдарч байгаа болон хуулиар эрхээ хасуулсан сонгогчдын бүртгэл нууц байгаа, залуу сонгогчдын оролцоо нэмэгдэхгүй байснаар сонгогчдын оролцоонд ахиц гарахгүй.
5. Сонгогчдын санал гээгдэж, зарим тохиолдолд УИХ-д “супер мажоритар” олонхи буюу нэг нам хэт олон суудлыг авсаар байх болно.

Иймээс сонгуулийн тогтолцоог өөрчлөх талаар дараах бодлогын асуудлууд байгааг авч үзье. Үүнд:

1. Монгол улсын сонгож хүний эрхийг хүндэтгэсэн, чөлөөт, нээлттэй ардчилсан тогтолцоо нь ард түмэн засгийн эрхийг баталгаажуулах, тогтолцоогоо өөрчлөх шаардлага байнга тулгардаг. Иймд Үндсэн хуулиар олгогдсон эрх бидэнд байгаа нь сонгуулийн тогтолцоог өөрчлөх үндэслэл мөн.
2. Олон намын тогтолцоо нь парламентын засаглалын үндэс. Монгол улс Парламентийн засаглалтай улс орны хувьд нам, намын системийн төлөвшилд сонгуулийн тогтолцоо сөргөөр нөлөөлж байгаа нь сонгуулийн тогтолцоог өөрчлөх үндэслэл мөн.
3. УИХ-ын сонгуулиудын дүнгээс харахад сонгогчдын оролцоо, төлөөлөл буурч байна. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх нь сонгогчдын оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх, УИХ-ын легитим чанарыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.
4. УИХ-ын 8 удаагийн сонгуулийн үр дүнд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байна. 2012 оноос хойш УИХ-ын сонгуулийн хуульд эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан 20 хувийн квотыг хэрэглэж байгаа ч, Олон улсын болон Азийн орнуудын дунджаас доогуур байсаар байна.
5. Монгол улс 30 жилийн турш УИХ-ын сонгуулийн тогтолцоог өөрчлөх оролдлого хийснээс хэтэрсэнгүй. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх тухай яриа сонгууль бүрийн дараа яригдаад намжиж байна.
6. Гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдийн сонгох эрхийг нээх хэрэгтэй. Учир нь тэдгээр иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх боломжийг хаасаар байгаа нь сонгуулийн тогтолцоог өөрчлөх хэрэгцээ мөн.

Иймд УИХ сонгуулийн тогтолцоог сонгохдоо дараах зарчимд анхаарах хэрэгтэй. Үүнд, улс төрийн институцийн төлөвшил, сонгуулийн ил тод байдал, сонгогчдын оролцоог хангахыг чармайх хэрэгтэй.

Нэг. Институцийг төлөвшүүлэх

Намуудыг төлөвшүүлэх. Монгол улс анх 1990 онд Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хуулийг баталж байсан. Хожим 2005 онд Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн баталсан ч, намуудын төлөвшлийг дэмжсэн эрх зүйн шинэтгэл үгүйлэгдэж байна. Үүнд мэдээж Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн санхүүжилтийн тухай хууль, холимог тогтолцоотой сонгуулийн хуулиудыг шинэчлэн батлах шаардлага байсаар байна. 2019 онд Монгол улс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Уг нэмэлтүүд намын төлөвшилд дэмжлэг болохуйц эрх зүйн орчныг шаардаж байгаа.

Эмэгтэйчүүд, залуучуудын оролцоо, төлөөлөл. Монгол улс 2015 он гэхэд Парламентын түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг 30-аас доошгүй байлгах үүрэг хүлээж байсан ч энэ үүрэг хангагдаагүй. Шалтгаан нь улс төрийн намуудын манлайлал дутагдаж байгаа. Анх 2005 оны УИХ-ын сонгуулийн хуульд “*нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэй байх*” хуулийн заалт орж байсан ч, уг заалтыг хэрэглэхгүйгээр 2007 оны 12 сард УИХ дахь намууд цуглаж байсан. 2011 оны шинэчлэн найруулсан УИХ-ын сонгуулийн хуульд нэр дэвшигчийн 20-аас доошгүй хувь эмэгтэйчүүдийн төлөөлөл байхаар баталсан 2015 оны Сонгуулийн хуульд 30 хувь болгож баталсан ч, 5 сарын дараа буюу 2016 оны 5 сарын 5-ны өдөр УИХ мөн уг заалтыг бууруулж 20 болгосон. Мэдээж сонгуулийн тогтолцооны шинэтгэл эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг. 2012 оноос хойш УИХ дахь эмэгтэйчүүдийн хувь 14, 2016 онд 17 хувь болж өссөн.

Хоёр. Ил тод байх

Шударгаар өрсөлдөх. Монгол улсад хэдийгээр бүх нийтийн, тэгш, шударга, ардчилсан сонгууль болдогч, эрх баригч ба сөрөг хүчний намууд, мөнгөтэй ба мөнгөгүй намууд, нэр дэвшигчид, монополийг дэмжсэн төрийн санхүүжилт, зуучийн үүргээ мартсан хэвлэл мэдээлэл зэрэг олон асуудал сонгуулийг шударга бус болгож байна. Иймд намын болон сонгуулийн эрх зүй нь шударга өрсөлдөөнийг дэмжсэн байхаар шинэчлэх, пропорционал тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай.

Санхүүжилтийг ил болгох. Монголын улс төрийг бохир болгон буй асуудлын нэг нь санхүүжилт, түүний ил тод байдлыг хангах асуудал. Өнгөрсөн 30 гаруй жилийн турш огт уг асуудлыг шийдвэрлэгдээгүй нь өнөөдөр сонгуулийг мөнгө тодорхойлдог болсон. Намууд санхүүжилтээ нуудаг, сонгогчид намууд, нэр дэвшигчдийн хайр халамжийг хүлээдэг болсон. Иймээс Улс төрийн санхүүжилтийн тухай хуулийг шинээр батлах, хэрэгжүүлэх, улс төрийн намын болон сонгуулийн хуулиудыг бага зардлаар өрсөлддөг байх үзэл баримтлалд нийцүүлж батлах шаардлагатай.

Ёс зүйтэй байх. Хуулийг сахин биелүүлдэг нам, улс төрч бол Монголын улс төрийн тулгамдсан асуудлын нэг бөгөөд энэ бол улс төрийн соёлын суурь асуудлын нэг. Цаашид улс төрийн намууд улс төрийн шинэ соёлын тээгч хариуцлагатай институт болж төлөвшихөөс нааш энэ асуудлыг шийдвэрлэхэд бэрх байна.

Гурав. Оролцоог хангах

Идэвхтэй оролцуулах. Сонгогчдын ирцийг нэмэгдүүлэх, гадаадад амьдарч буй сонгогчдын сонгох эрхийг хүндэтгэх, оролцох боломжоор хангах, сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг нээх, урьдчилж саналаа өгөх боломжоор хангах зэрэг асуудлууд байсаар байна.

Мэдээллээр хангах. Сонгуулийн үеэр нам, нэр дэвшигчдийн мэдээллийн үнэ бодит байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, Олон нийтийн радио телевизийн үүрэг оролцоог нарийвчлан зохицуулж, шаардлагатай болж сонгогчийн эрхийн хүндэтгэх, сонгох эрхийг хангахын тулд үнэн зөв, бодитой мэдээллээр хангахуйц зохицуулалтыг хийх шаардлага байсаар байна.

Дээрх сонгогчдын төлөөлөл, ил тод байдал, оролцоог хангахуйц сонгуулийн тогтолцоо нь хувь тэнцүүлсэн хувилбарыг ашигласан холимог тогтолцоо юм. Иймээс цаашид Монгол улс сонгуулийн холимог тогтолцоог тэр дундаа олонх дийлэнхийн хувилбар 50 хувь, хувь тэнцүүлсэн хувилбар 50 хувь байхаар сонгуулийн тогтолцооны шинэтгэл хийх хэрэгтэй. Энэ саналыг Монголд судалгаа хийсэн Д.Ноолон (ХБНГУ), Б.Рейли (Австрали) нар мөн санал болгосон байдаг.

50/50 хувь байх холимог сонгуулийн тогтолцоо нь дараах ач холбогдолтой.
Үүнд:

1. Намууд бодлогын нам болж төлөвшүүлэх,
2. Сонгогч дан ганц нэр дэвшигч бус давхар намын бодлого, төлөвшилтийг харж саналаа өгөх,

3. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг ил тод байдлыг хангах,
4. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг бууруулах,
5. УИХ дахь эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх,
6. Сонгуулийн олонхийн/мажоритар болон пропорционал тогтолцооны давуу болон сул талуудыг тэнцвэржүүлэх,
7. Сонгогчийн санал хүчтэй савлахгүй байх, УИХ дахь төлөөлөл тэнцвэртэй байх ач холбогдолтой.

Эцэст сонгосон сонгуулийн тогтолцоогоо тогтвортой хадгалах нь чухал юм.

Дүгнэлт.

Иймээс 1992 оноос хойших УИХ-ын сонгуулиудын нээлттэй өгөгдлийн сан, Монгол улсын Үндсэн хууль, УИХ-ын сонгуулийн хуулиуд, ҮХЦ-ийн шийдвэр, намуудын байр суурь болон болон судалгааны бүтээл, зөвлөмжүүдийг судалж үзээд дараах дүгнэлтийг хийлээ.

1. Монгол улсын хүний эрхийг хүндэтгэсэн, чөлөөт, нээлттэй ардчилсан тогтолцоо нь ард түмэн засгийн эрхийг баталгаажуулах, тогтолцоогоо өөрчлөх шаардлага байнга тулгардаг. Иймд Үндсэн хуулиар олгогдсон эрх бидэнд байгаа нь сонгуулийн тогтолцоог өөрчлөх үндэслэл мөн.
2. Монгол улс Парламентийн засаглалтай улс орны хувьд нам, намын системийн төлөвшилд сонгуулийн тогтолцоо сөргөөр нөлөөлж байгаа нь сонгуулийн тогтолцоог өөрчлөх үндэслэл мөн.
3. УИХ-ын сонгуулиудын дүнгээс харахад сонгогчдын оролцоо, төлөөлөл буурч байна. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх нь сонгогчдын оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх, УИХ-ын легитим чанарыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.
4. Гадаад ажиллаж, амьдарч буй иргэдийн сонгох эрхийг нээх хэрэгтэй. Учир нь тэдгээр иргэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх боломжийг хаасаар байгаа нь сонгуулийн тогтолцоог өөрчлөх хэрэгцээ мөн.
5. Сонгуулийн холимог тогтолцоо хэрэглэх хэрэгтэй. Энэ нь олонх дийлэнхийн болон хувь тэнцүүлэх тогтолцооны давуу болох сул талуудыг тэнцвэржүүлэх ач холбогдолтой. Сонгуулийн хувь тэнцүүлэх хэсэгт УИХ-

д суудал хуваарилах босгыг 4 хувь байхаар тусгах нь оновчтой гэж үзэж байна.

Abstract

This article analyzed the implications of socio-politics of electoral systems and results of the SGH (parliament) elections since 1992. In particular, it examined the hypothesis that the impacted electoral system changes on political parties and party system in Mongolian politics based on open data of Parliamentary elections. In last 30 years, there are a lack of voter education, less votes recieved by elected MPs, decreased turnouts, and finally these are influenced a one party dominated political system. Therefore, this article recommended a parallel system as a better electoral system for SGH that will support political institutions, transparent and participation and representation in Mongolian politics.

Keywords: *Mongolia, State Great Hural (Parliament), electoral system, voters' participation, election finance, representation, political party and party system*

Ашигласан материал

Donald L. Horowitz. *Electoral systems and their goals: a primer for decision-makers.*

2003 <https://aceproject.org/ero-en/topics/electoral-systems/E6ElectoralSystemsHorowitz.pdf>

Duverger's law. Oxford reference.

<https://www.oxfordreference.com/view/10.1093/oi/authority.20110803095737871>

Election. Britannica encyclopaedia. <https://www.britannica.com/topic/election-political-science>

Electoral system (ACE project) <https://aceproject.org/ace-en/topics/es/esd/esd01/esd01c/default>

Electoral system. ACE project <https://aceproject.org/ace-en/topics/es/esd/default>

Electoral system. ACE project <https://aceproject.org/ace-en/topics/es/esd/default>

Electoral system. Britannica encyclopaedia.

<https://www.britannica.com/topic/electoral-system>

Electoral system. Britannica encyclopaedia.

<https://www.britannica.com/topic/electoral-system>

Josep M. Colomer. *It's parties that choose electoral systems (or Duverger's Laws Upside Down)* <https://econ-papers.upf.edu/papers/812.pdf>

Pavel Maskarinec. *The 2016 Electoral Reform in Mongolia: From Mixed System and Multiparty Competition to FPTP and One-Party Dominance.* *Journal of Asian and African Studies.* 2018, Vol. 53(4) 511–531

Sumati Luvsandendev, (2018) *Voters 'voices II.* Ulaanbaatar. 25p.

Б.Рейли. *Монгол улсын сонгуулийн тогтолцооны шинэчлэл, тогтолцооны хувилбарууд.* Монгол улс. НҮБХХ. 2010 он.

Гадаадад ажиллаж, амьдарч, суралцаж буй Монгол иргэдийн нэгдсэн өргөдөл. <https://www.trends.mn/n/6713>

Д.Ноолон. “Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэтгэл” Бодлогын баримт бичиг. Фрейдрих Эбэрт Сан. 2009 он.

Дэлхийн аль улсад Монголчууд олноор амьдарч байна вэ? <https://ikon.mn/n/u9h>

Ж.Бямбадорж. *Сонгох эрх ба Монгол улсын сонгуулийн тогтолцоог шинэчлэх асуудал.* Шинэ толь сэтгүүл. №28, 1998 он.

Залуучуудын санал бодлын судалгаа. ОУБНХ. Улаанбаатар 2020 он. https://www.iri.org/sites/default/files/mongolia_ned_youth_poll_2020_-_public_deck_mongolian_final.pdf

Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019). Конрад Аденауэр сан. УБ., 2019.

Монгол улсад сонгуулийн хувь тэнцүүлсэн системийн аль хувилбар илүү тохиромжтой вэ? Бодлогын зөвлөмж. 2005 он

УИХ-ын сонгуулийн олонхи дийлэнхийн тогтолцоог боловсронгуй болгох нь. Бодлогын зөвлөмж, 2005 он

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. 2003 он. <https://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн (1992-2016) СЕХ. Улаанбаатар., 2017 он.

Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 1992 он. <https://www.gec.gov.mn/>

Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2005 он. <https://www.gec.gov.mn/>

Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2011 он.

<https://www.legalinfo.mn/law/details/351>

Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2019 он.

<https://www.legalinfo.mn/law/details/14869>

Монгол Улсын Үндсэн Хууль. <https://www.legalinfo.mn/law/details/367>

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 05 дугаар тогтоол.

<https://www.legalinfo.mn/law/details/11847?lawid=11847>

Монголын Ардчилсан нам. <https://mn.wikipedia.org/>

Монголын намын системийн институтчлэл. Дефакто институт, КАС.

Улаанбаатар 2020. [http://defacto.mn/wp-](http://defacto.mn/wp-content/uploads/2020/09/instuchlel_tailanB5_ok%D0%9501.pdf)

[content/uploads/2020/09/instuchlel_tailanB5_ok%D0%9501.pdf](http://defacto.mn/wp-content/uploads/2020/09/instuchlel_tailanB5_ok%D0%9501.pdf)

Монголын улс төрийн намын тухай хууль. 2005 он.

<https://www.legalinfo.mn/law/details/508>

Н.Цолмонтуяа. Сонгуулийн тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох асуудалд.

Шинэ толь сэтгүүл.№25, 1999 он.

Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалтын судалгаа. 2016 оны 8 сарын 16-26.

[https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-](https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-_august_2016_-_public_deck_mon.pdf)
[_august_2016_-_public_deck_mon.pdf](https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-_august_2016_-_public_deck_mon.pdf)

Сонгуулийн тухай зарим ойлголт, товч тайлбар. УБ.,2008

Сонгуулийн тухай хууль. 2015 он. <https://www.legalinfo.mn/law/details/12178>

ТАНИЛЦ: 1992-2016 он хүртэл УИХ-ын сонгуулийн тойрог хуваалт ба үр дүн

<https://ikon.mn/n/1ra9>

УИХ-д сонгогдсон 75 гишүүн бусад нэр дэвшигчээс 3,6 дахин их мөнгийг

зарцуулжээ. <https://ikon.mn/n/1zyx>

Улс төрийн намуудын төлөвшил, өнөөгийн нөхцөл байдал. Судалгааны тайлан.

Монголын дипломатын академи. Улаанбаатар. 2019 он.

[http://mirim.mn/wp-content/uploads/2020/02/Songuuli-Sudalganii-tailan-](http://mirim.mn/wp-content/uploads/2020/02/Songuuli-Sudalganii-tailan-2019.pdf)
[2019.pdf](http://mirim.mn/wp-content/uploads/2020/02/Songuuli-Sudalganii-tailan-2019.pdf)

Улсын Их хурлын сонгуулийн санал хураалтын дүн шинжилгээ. ҮСХ. 2016 он.
<http://1212.mn/>

Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948 он.
<https://www.legalinfo.mn/law/details/1271>

Хүний эрхийн түгээмэл тунхаглал. <https://www.legalinfo.mn/law/details/1271>

Э.Гэрэлт-Од. Д.Бямбажав. Олон мандаттай том тойргоос авах СУРГАМЖ
<https://ikon.mn/opinion/1u27>

Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эсвлийн
зардлын тайлан. ҮАГ. Монгол Улс. 2020 он. <https://audit.mn/?p=9633>

Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн зардлын дээд хэмжээг тогтоолоо
<https://ikon.mn/n/1xd5>

2020 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦ, ҮР ДҮН**Д.Түмэнжаргал**МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш**Г.Эрдэнэбаяр**МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбар,
Философи, шашин судлалын тэнхимийн дэд профессор**Хураангуй**

Ардчиллын үнэт зүйлсэд тогтмол, чөлөөт шударга сонгууль, олон ургальч үзэл, улс төрийн хүлээцтэй байдал, олон намын тогтолцоо, хүчтэй иргэний нийгэм, иргэдийн оролцоо, хүний эрх, тэгш эрх, тайлагнах ёс, нийтэд ил тод байх, эдийн засгийн эрх чөлөө, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэхэд хяналт тавих, хуульд захирагдах зэрэг олон асуудлуудыг багтааж авч үздэг. Эдгээрээс харахад олон намын тогтолцоо, олон ургальч үзэл нь ардчилсан тогтолцоотой улс орнуудад заавал байх ёстой.

Монгол улсад болж өнгөрсөн УИХ-ын 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 оны нийт 8 удаагийн сонгууль нь зохион байгуулагдсан цаг үеийн өвөрмөц онцлог, эдийн засгийн байдал, намын болон төрийн бодлого шийдвэр, нийгмийн цаг үеийн уур амьсгал, сонгуулийн тогтолцоо, сонгуулийн хуулийн өөрчлөлт зэргээс хамаарч өөр өөрийн өвөрмөц онцлогуудтай байсан. Энэ өгүүллийн хүрээнд 2020 оны УИХ-ын сонгуулийг зохион байгуулсан үйл явц, түүний үр дүн, цаашид анхаарах асуудлуудын талаар авч үзнэ.

Түлхүүр үг: ардчилал, ардчилсан сонгууль, сонгуулийн байгууллага, сонгуулийн зарчим, нам, сонгогчдын оролцоо, УИХ-ын сонгууль.

Нэг. 2020 оны УИХ-ын сонгуулийн эрх зүйн зохицуулалт

Монгол улсын 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн 3-р зүйлд: "Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцон, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих

*төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ". 16-р зүйлд: "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно"*¹ гэж ардчилсан сонгуулийг хуульчлан бататгасан байдаг.

Монгол Улсад УИХ-ын сонгуультай холбоотой харилцааг анх 1992 онд батлагдсан хуулиар зохицуулж эхэлсэн бөгөөд 2005, 2011 онд шинэчлэн баталж байсан. Монгол улсын 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012 оны сонгуулиуд нь УИХ-ын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг тус тусдаа, бие даасан хуулиар зохицуулж байсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн, УИХ-ын болон орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн сонгуулийг зохион байгуулж явуулах журмыг хамтад нь нэг хуулиар зохицуулсан байсан. Хуулийн дагуу УИХ-ын, аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг явуулсан. Энэ явцад олон хүндрэл үүсэж байсныг сонгууль зохион байгуулсан бүх шатны байгууллага, сонгогч, нэр дэвшигчид, сонгуульд оролцогч нам, эвслээс илэрхийлж байсан. Дээрх гурван төрлийн сонгууль нь тус тусын зохион байгуулалтын онцлог шинж чанартай бөгөөд тухайн сонгуулийн онцлогт тохирсон хуулийн зохицуулалттай байх шаардлагатай байдаг. Гэтэл нэг хуулиар зохицуулсан нь хууль хэрэглээний хувьд хүндрэл үүсгэж, улмаар Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг сонгуульд оролцогчид өөр өөрийнхөөрөө тайлбарлаж хэрэглэх, үүнээс үүдэн маргаан үүсэх, иргэд, сонгогчдод ойлгомжгүй байдал бий болох зэрэг цөөнгүй хүндрэл гарч байсан. Ийм учраас УИХ-ын сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж, боловсронгуй болгох шаардлагатай болсон.

Ингээд 2020 оны УИХ-ын сонгуулийг 2019 оны 12-р сарын 20-ны өдөр шинэчлэн баталсан УИХ, Ерөнхийлөгч, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хуулийг тус тусад нь баталсан хуулийн хүрээнд зохион байгуулж явуулсан.

Сонгуулийн хууль эрх зүйн хүрээ нь 1992 онд батлагдсан Монгол улсын ардчилсан Үндсэн хууль, 2019 оны 12-р сарын 20-нд батлагдсан УИХ-ын

¹ Монгол улсын Үндсэн хууль. 1992 он

сонгуулийн хууль, 2006 оны сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон СЕХ-ны журам зэргээс бүрдэж байна.² Мөн түүнчлэн Сонгуулийн хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн асуудлаар Монгол улсын Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийн ажлыг зохион байгуулж явуулахад шаардлагатай дүрэм, журам, аргачилсан заавар, үлгэрчилсэн загвар, маягтууд батлан гаргадаг. Эдгээрийг эрх зүйн бусад акт гэж үздэг. Энэ дүрэм, журам, заавар, маягтыг 2020 оны УИХ-ын сонгуулийн ажлыг явуулахдаа дагаж мөрдсөн.

Монгол улсад Улсын Их Хурлын сонгууль, Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль тус тус 8 удаа явагдаж өнгөрсөн.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд УИХ-ын 2020 оны найм дахь удаагийн сонгуулийг Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн дагуу амжилттай зохион байгуулсан.

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг хууль эрх зүйн шинэ орчинд олон мандаттай томсгосон тойргоор зохион байгуулсан. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01-р сарын 30-ны өдрийн 15-р тогтоолоор *“Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай”* тогтоож өгсөн. Тодруулбал, 2020 оны 01-р сарын 30-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2020 оны УИХ-ын сонгууль нийт 29 тойрогтой байхаар тогтоосон. Мөн орон нутагт 20 тойрог, нийслэлд 9 тойрог байхаар тогтоосон.

Тойрог хуваарилсан байдлыг тодруулбал:

1. Дундговь, Говьсүмбэр аймгийн нэгтгэн сонгуулийн 6-р тойрог
2. Багахангай, Багануур, Налайх дүүргийг нэгтгэн сонгуулийн 21-р тойрог
3. Баянзүрх дүүргийн 4, 5, 6, 8, 13, 14, 15, 16, 18, 25, 26 дугаар хороог нэгтгэн сонгуулийн 22-р тойрог

² Холбогдох бусад хуулиудад Улс төрийн намын тухай хууль, Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн аудитын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон шүүх засаглал, хэвлэл мэдээллийг зохицуулах бусад хууль тогтоомжууд орно.

4. Баянзүрх дүүргийн 1, 2, 3, 7, 9, 10, 11, 12, 17, 19, 20, 21, 22, 23, 24, 27, 28 дугаар хороог нэгтгэн сонгуулийн 23-р тойрог
5. Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 20, 22, 24, 26, 32, 33, 34, 35, 36, 37, 41 дүгээр хороог нэгтгэн сонгуулийн 27-р тойрог
6. Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 21, 23, 25, 27, 28, 29, 30, 31, 38, 39, 40, 42, 43 дугаар хороог нэгтгэн сонгуулийн 28-р тойргийг тус тус байгуулахаар болов.
7. Бусад аймаг болон нийслэлийн бусад дүүргүүд тус бүрдээ сонгуулийн нэг, нэг тойрог байхаар зохицуулсан байна.

Хүснэгт №1. 2020 оны УИХ-ын сонгуулийн тойрог хуваарилсан байдлыг харуулбал:³

Аймгийн нэр	Мандатын тоо	Хүн амын тоо
Баян-Өлгий	3	103,765
Говь-Алтай	2	58,280
Завхан	2	73,088
Увс	3	83,617
Ховд	3	88,447
Архангай	3	95,994
Баянхонгор	3	88,359
Булган	2	61,794
Орхон	3	103,217
Өвөрхангай	3	116,645
Хөвсгөл	3	134,371
Говьсүмбэр	2	17,489
Дундговь		46,820
Дархан-Уул	3	104,238
Дорноговь	2	69,560

³ <https://ikon.mn/n/1so2>

Өмнөговь	2	69,124
Сэлэнгэ	3	109,255
Төв	3	95,045
Дорнод	2	82,295
Сүхбаатар	2	62,611
Хэнтий	3	77,664
Нийт	52	1,741,678

Дүүргийн нэр	Мандатын тоо	Хүн амын тоо
Багануур	2	29512
Багахангай		4399
Налайх		37608
Баянзүрх	5	343619
Баянгол	3	226869
Сонгинохайрхан	5	321150
Сүхбаатар	3	145335
Хан-Уул	3	178919
Чингэлтэй	3	157258
Нийт	24	1,444,669

УИХ-ын сонгуулийн мандатын хуваарилалтыг хийхдээ нийслэлд 24 мандат, орон нутагт 52 мандат байхаар тогтсон. Үүнээс харахад нийслэлээс 4 мандатыг хасч, орон нутагт нэмсэн байна. Тойрог, мандатын хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, байршил, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг харгалзсан гэж үзсэн. Гэхдээ энэ нь тойргийн хэмжээг ингэж харилцан адилгүй зааж, орон нутагт мандатын тоог нэмж, нийслэлээс тойрог, мандатын тоог хасаж тогтоосон нь зарим сөрөг үр дагаврыг бий болгож болох юм. Тухайлбал, тойргийн тооноосоо шалтгаалж нийслэлд хөрөнгө оруулалт бага очиж, нийслэлийн хөгжил, бүтээн байгуулалт багасах, 1992 онд нийслэлд хүн амын 26.6% амьдарч

байхад мандатын 26.3% ногдож байсан бол одоогийн байдлаар Хүн амын 45 хувь нь амьдардаг нийслэлийн иргэдийн УИХ-д төлөөлөх хувь 31 хувь байгаа нь тэгш эрхийн зарчмыг зөрчиж байна. Энэ үүднээсээ ч УИХ-ын 76 мандатаас нийслэл Улаанбаатар хотод 24 тооны мандат хуваарилсан нь Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2, 2-р зүйлийн 1-д “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” гэснийг тус тус зөрчиж байна гэж үзэж зарим хуульчид Үндсэн хуулийн цэцэд хандсан байна.

Хүснэгт №2. 2020 оны УИХ-ын сонгуулийн тойрог, мандатын тоо

№	Тойргийн дугаар	УИХ-ын суудлын тоо (мандатын тоо)
1	Нэгдүгээр тойрог	3
2	Хоёрдугаар тойрог	3
3	Гуравдугаар тойрог	3
4	Дөрөвдүгээр тойрог	3
5	Тавдугаар тойрог	2
6	Зургаадугаар тойрог	2
7	Долоодугаар тойрог	2
8	Наймдугаар тойрог	2
9	Есдүгээр тойрог	2
10	Аравдугаар тойрог	3
11	Арваннэгдүгээр тойрог	2
12	Арванхоёрдугаар тойрог	2
13	Арвангуравдугаар тойрог	2
14	Арвандөрөвдүгээр тойрог	3
15	Арвантавдугаар тойрог	3
16	Арванзургаадугаар тойрог	3
17	Арвандолоодугаар тойрог	3
18	Арваннаймдугаар тойрог	3
19	Арванесдүгээр тойрог	3
20	Хорьдугаар тойрог	3
21	Хориннэгдүгээр тойрог	2
22	Хоринхоёрдугаар тойрог	2

23	Хорингуравдугаар тойрог	3
24	Хориндөрөвдүгээр тойрог	3
25	Хоринтавдугаар тойрог	3
26	Хоринзургаадугаар тойрог	3
27	Хориндолоодугаар тойрог	2
28	Хориннаймдугаар тойрог	3
29	Хоринесдүгээр тойрог	3
Нийт 29 тойрог		76 суудал

2019 оны 12-р сарын 20-нд батлагдсан Монгол Улсын “Их Хурлын сонгуулийн тухай” хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газар сонгогчдын нэрсийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хэсэг тус бүрээр гаргаж, цахим хуудастаа хуулийн хугацаанд байршуулан, сонгогчдын нэрсийн жагсаалтыг үйлдэх, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, нягтлан шалгах, давхардлыг арилгах ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган ажилласан.

Мөн 2011 онд батлагдсан “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт заасны дагуу Тагнуулын ерөнхий газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, тус Хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн хамтарсан Ажлын хэсэг санал авах, тоолох төхөөрөмж, бүртгэлийн техник хэрэгсэл, програм хангамжийг шалган туршиж, баталгаажуулж гэрчилгээ олгосон. Санал авах, тоолох болон бүртгэлийн техник хэрэгсэл, програм хангамжийг шалган туршиж баталгаажуулах ажиллагаанд сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, Төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулж зохион байгуулсан.

Хоёр: 2020 оны УИХ-ын сонгуулийн үйл явц, үр дүн

Монгол улс 1992 онд ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш УИХ-ын сонгуулийг 8 удаа зохион байгуулсан. Ингэхдээ 1990 он, 2012 оны сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсныг эс тооцвол ихэнхдээ мажоритар тогтолцоогоор явуулж ирсэн. Тодруулбал, 1992, 2008, 2020 оны УИХ-ын сонгуулийг олон мандаттай томсгосон тойрог бүхий мажоритар тогтолцоогоор, харин 1996, 2000, 2004, 2016 оны УИХ-ын сонгуулийг нэг мандаттай мажоритар тогтолцоор тус тус явуулж ирсэн.

2020 оны УИХ-ын сонгууль нь 2019 оны 12-р сарын 20-ны өдөр шинэчлэн найруулж баталсан “УИХ-ын сонгуулийн тухай” хуулийн эрх зүйн шинэ орчны хүрээнд олон мандаттай томсгосон 29 тойргоор зохион байгуулж явуулсан.

Энэ удаагийн сонгууль нь цар тахлын үеийн онцгой нөхцөлд явагдсанаараа онцлог сонгууль болж өнгөрсөн. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх журмыг мөрдүүлж, хэрэгжилтийг нь хангах талаар Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажилласан.

2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн бэлтгэлийг хангахад Улсын Их Хурал, Засгийн Газар, Сангийн яам, Эрчим хүчний яам, Улсын Дээд шүүх, Эрүүл мэндийн яам, Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, Татварын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Гаалийн ерөнхий газар, бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Монгол шуудан төрийн өмчит хувьцаат компани, үүрэн телефоны компаниуд, Төр, засгийн үйлчилгээний автобааз, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар, МИДАС төрийн бус байгууллага, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд идэвхтэй дэмжиж, хамтран ажилласан.

Хүснэгт №3. 2020 оны УИХ-ын сонгуульд ажилласан салбар, хэсгийн хороодын тоо⁴

№	Утга	2020 оны УИХ-ын сонгууль
1	Сонгуулийн тойрог	29
2	Салбар хороо	337
3	Хэсгийн хороо	2070

⁴ges.gov.mn (Монгол улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт)

4	Нийт ажилласан төрийн албан хаагчдын тоо	35772
---	--	-------

Энэ удаагийн сонгуулийг улсын хэмжээнд сонгуулийн төв байгууллага, нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн 21 сонгуулийн хороо, сум дүүргийн 337 сонгуулийн хороо, 2070 хэсгийн хороо, мэдээллийн технологийн 27 баг зохион байгуулж явуулсан. Нийт 35772 төрийн албан хаагч сонгуулийг бүхэлд нь зохион байгуулж явуулсан.

График №1. 2020 оны УИХ-ын сонгуульд оролцсон нам эвслийн тоо⁵




Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд 13 нам, 4 эвсэл, 121 бие даан нэр дэвшигч нийт 606 нэр дэвшигч бүртгүүлж, хуулийн хугацаанд сурталчилгаагаа хийж өрсөлдсөн. УИХ-ын сонгуульд нийт 606 нэр дэвшигчийг бүртгэж нэр дэвшигчийн үнэмлэх олгосноос 19.9 хувь нь буюу 121 нь бие даан нэр дэвшигч, 24.9 хувь нь буюу 151 нь эмэгтэй нэр дэвшигч байна. Үүнд: Монгол Ардын Нам - 76, Ардчилсан Нам - 76, Монголын Ногоон Нам - 15, Та бидний эвсэл - 74, ШИНЭ эвсэл - 72, Зөв хүн электорат эвсэл - 53, Ард Түмний Нам, Эх Орончдын Нэгдсэн Нам, Ард Түмнээ Хайрлая Нам, Их Эв Нам тус бүр 1, Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам - 13, Хөгжлийн Хөтөлбөр Нам - 7, Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл - 34, Зон Олны Нам - 30, Дэлхийн Монголчууд Нам - 3, Ард Түмний Олонхийн Засаглал Нам - 24, Гэр Хороолол Хөгжлийн Нам - 4 хүн нэр дэвшүүлж сонгуульд оролцсон.

⁵ ges.gov.mn (Монгол улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт)

Нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө дуусгасан. Энэ удаагийн УИХ-ын сонгуулийн сурталчилгааг нам, эвсэл, нэр дэвшигчид өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлд Засгийн газраас баталсан журмын дагуу цахим орчин, хэвлэл мэдээлэл, зурагт самбар, радио, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглаж уулзалт цуглааныг иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй, ариутгал, халдваргүйжүүлэлт, хамгаалалтын хэрэгсэлтэйгээр зохион байгуулсан.

График №2. 2020 оны УИХ-ын сонгуульд ялалт байгуулсан нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн тоо ⁶



Улсын Их Хурлын энэ удаагийн сонгуульд Монгол Ардын намаас 62, Ардчилсан намаас 11, “Та бидний эвсэл”-ээс 1, “Зөв хүн электорат” эвслээс 1, бие даан нэр дэвшигч 1 хүн тус тус УИХ-ын гишүүнээр сонгогдсон.

Мөн Улсын Их Хурлын гишүүдийн 38 нь анх удаа сонгогдсон, 13 нь буюу 17.1 хувь нь эмэгтэй, хамгийн ахмад нь 66 настай, хамгийн залуу нь 33 настай байна. Нийт гишүүдийн 14 (18.42%) нь хуульч, эрх зүйч, 21 (27.63%) нь эдийн засагч, 12 (15.79%) нь инженер, агрономич, 14 (18.42%) нь улс төр, нийгмийн ухаан, урлаг, утга зохиолын, 9 (11.84%) нь эмч, багш, 6 (7.89%) нь бусад мэргэжлийн хүн байна.

⁶ Мөн тэнд

2020 оны УИХ-ын сонгуульд маш олон буюу 606 нэр дэвшигч оролцсон. Түүн дотроо бие даан нэр дэвшигчид өмнөх сонгуулийн жилүүдээс харьцангуй олон буюу 121 байсан. Мөн улс төрийн жижиг намууд нэгдэж, хүчээ нэгтгэн нийлж эвсэл болж оролцсон. Улс төрийн жижиг намууд дангаараа сонгуульд оролцохыг илүүд үзээгүй бөгөөд хүчээ нэгтгэж сонгуульд оролцохыг эрмэлзсэн нь харагдаж байна. Иймдээ ч УИХ-д хоёр эвсэл тус бүр нэг нэг суудал авсан. Мөн түүнчлэн энэ удаагийн сонгуульд УИХ-д Монгол Ардын Нам 62 суудал эзэлж олонхи болж танхимыг бүрдүүлсэн юм.

Ардчилсан нам дотоод ардчилалгүйгээс ялагдал хүлээсэн. Зарим гишүүдээ хөөж явуулах, зарим нэр дэвшигчдийг намдаа элсүүлэх гээд нам дотроо хагаралдаан ихтэй, зөрчилтэй байсан нь нөлөөлсөн. Мөн УИХ-ын сонгуулийн үйл ажиллагаандаа анхаарал хандуулалгүй нэр дэвшиж буй гишүүдээсээ авдаг хандиваа өсгөж, хэт их гишүүдийн хандивын араас хөөцөлдөж дотроо хагарал бий болгосон. Нам дотроо эв нэгдэлтэй байж сонгуулийн үйл ажиллагаандаа нухацтай, бодлоготой хандаж чадаагүйгээс ялагдал хүлээсэн. Мөн түүнчлэн намын дарга С.Эрдэнэ УИХ-ын сонгуулийн сурталчилгаа дундаа ч ороогүй байхад хариуцлагагүй мэдэгдэл хийж ард түмний дунд төөрөгдөл, талцал, бухимдал зэргийг бий болгосон ч бас ялагдахад нөлөө үзүүлсэн.

2020 оны 6 дугаар сарын 24-ний өдөр болсон Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий 2003969 иргэн саналаа өгөхөөр нэрийн жагсаалтад бүртгэгдсэн байна.

График №3. УИХ-ын сонгуулийн зарим тоо баримт (2020 он)⁷

№	Утга	2020 оны УИХ-ын сонгууль
1	Нийт хүн ам	3296866
2	Сонгуулийн насны хүн ам	2129122
3	Нэрийн жагсаалтад бичигдсэн хүн ам	2003969
4	Сонгууль өгсөн хүн амын тоо	1475780

⁷gec.gov.mn

2020 оны УИХ-ын сонгууль өгөхөөр бүртгүүлсэн 2003969 сонгогчдоос 1475780 сонгогч буюу сонгогчдын 73.6 хувь нь сонгуульд оролцож саналаа өгсөн байна. Энэ өмнөх сонгуулийн жилүүдтэй харьцуулбал сонгогчдын оролцоо маш өндөр байсан гэж үзэж байна. Монголын сонгогчдын оролцоо жилээс жилд өсч, сонгогчдын улс төрийн ухамсар дээшилсээр байна. Энэ удаагийн сонгуулийн дутагдалтай тал нь мөн л гадаадад суугаа Монгол улсын иргэдээ сонгууль өгөх эрхийг хязгаарласан. 2020 оны УИХ-д сонгуульд гадаад суугаа Монгол улсын иргэд санал өгөх эрх нь хаалттай байсан нь өмнөх дутагдлаа давтсан. Монгол улсын Үндсэн хуульд заасны дагуу Монгол улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн асуудал хэвээр байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль нь аянга цахилгаантай, аадар бороотой, үер устай мөн өндөржүүлсэн бэлэн байдлын амаргүй нөхцөлд болсон хэдий ч иргэд, сонгогчид иргэний улс төрд оролцох үүргээ ухамсарлан маш идэвхитэй буюу 73.64 хувийн ирцтэй сонгуульд оролцсоноороо тус тус онцлогтой сонгууль болж өндөрлөсөн. Мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газарт тодорхой эрх мэдлийг өгсөн. Үүнтэй холбоотойгоор сонгогчид маань Засгийн газрыг хэний гарт өгөх вэ? гэдгийг маш сайн бодолцож сонголтоо хийсэн. Мөн У.Хүрэлсүхийн Засгийн газарт итгэл хүлээлгэж, хийж буй ажлыг нь үргэжлүүлэх боломж олгох сонирхол сонгогчдын дийлэнхид байсан болов уу. Мөн МАН-ын уриа болох “Хүчээ нэгтгэе”, “багаар нь дэмжье” гэх мэт урианууд нь сонгогчдод нөлөөлсөн.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлаас хамаарч улс орнуудын нийгэм эдийн засгийн байдал хүндэрсэн энэ хүнд үед өөр хүчин гаргаж шинэ Засгийн газар бүрдүүлж аз сорихыг хүсээгүй нь мэдээж энэ сонгуулийн үр дүнгээс харагдсан. Би дээр дурьдсан. Монголын ард түмэн У.Хүрэлсүхийн Засгийн газарт маш их итгэл хүлээлгэж байна. Энэ удаагийн сонгуулиар ялалт байгуулсан нь МАН мундаг сайндаа биш. У.Хүрэлсүх гэдэг хүнд, мөн түүний Засгийн газарт өндөр итгэл хүлээлгэсний үр дүн. Мөн түүнчлэн коронавирусыг эх орондоо дотроо алдалгүй тогтоон барьж ард түмнээ энэ цар тахлаас хамгаалж чадахуйц ажил хийж байгаа нь ард түмний дэмжлэгийг авах гол шалтгаан нь болсон. Иймд МАН, У.Хүрэлсүхийн Засгийн газар ард түмнийхээ өндөр итгэлийг алдалгүй маш сайн ажиллах шаардлагатай.

Мөн түүнчлэн бас тулгарсан асуудал бол автомат машинаар уншсан саналыг будлиантай хэмээн хэсэг бие даан нэр дэвшигчид гомдол гаргаж хэвлэлийн бага хурал зарласан. Ийм учраас дахин гараар тоолох ажлыг зохион байгуулсан юм. Үүнийг тодруулбал,

Сум, дүүргийн сонгуулийн хороо харьяа бүх хэсгийн 50 хүртэл хувийг нь санамсаргүй сонголтын аргаар сонгож, хяналтын тооллого хийхээр хуульд заасны дагуу 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдөр 22:00 цаг болмогц сонгуульд оролцож байгаа нам, эвслийн ажиглагчдаар сум, дүүргийн харьяа хэсгийн дугааруудыг сугалуулан сонгогдсон хэсгүүдэд хяналтын тооллого хийв.

Улсын хэмжээний сонгуулийн 2070 хэсгийн 42 хувь буюу 846 хэсэгт хяналтын тооллого хийхэд санал тоолох төхөөрөмжийн үр дүнгийн тайлангийн дүн хяналтын тооллогын дүнтэй тохирсон тухай аймаг, нийслэлийн сонгуулийн хороод мэдээлсэн.

Харин Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал хураалтын үр дүнтэй холбогдуулан зарим нам, эвсэл, нэр дэвшигчдийн зүгээс Монгол Улсын Ерөнхийлөгчид болон Сонгуулийн ерөнхий хороонд хандаж гаргасан гомдол, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Сонгуулийн ерөнхий хороонд өгсөн үүрэг даалгаврын дагуу сонгуулийн 12 тойргийн 164 хэсэгт нэмэлт хяналтын тооллого хийхэд санал хураалтын дүнтэй тохирсон. Ямар нэг зөрүү гараагүй байна.

Нэмэлт хяналтын тооллогыг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн 645 ажиглагчийг оролцуулан цагдаагийн хамгаалалт, тагнуулын байгууллагын хяналтын дор зохион байгуулсан. Гомдол гаргасан нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн ажиглагчид хяналтын тооллогын дүнг хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурсан. Мөн сонгуулийн 164 хэсэгт нэмэлт хяналтын тооллогыг зохион байгуулах ажилд төрийн 2,247 албан хаагч оролцож ажилласан юм

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль нь хэдийгээр өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлд явагдсан ч ОХУ-ын “Монголия сегодня”, БНХАУ-ын “Синхуа”, “Жэнь минь жибао”, АНУ-ын “Блүүмбэрг”, “Ассошиэйтэд пресс”, Японы “Асахи”, “Киодо цүшин”, Францын “Франс медиа эженси”, БНСУ-ын “Брийк ньюс Кореа”, Катарын “Аль жазира” зэрэг гадаад орны хэвлэл мэдээллийн 11 байгууллагын 14 сурвалжлагч, Монгол Улсын хэвлэл мэдээллийн 72 байгууллагын 380 сурвалжлагч, хэвлэл мэдээллийн ажилтнууд сурвалжилж мэдээллийг цаг тухайд нь шуурхай дамжуулж хамтарч ажилласан. Мөн түүнчлэн АНУ, Австрали, Япон, Англи, Энэтхэг Улсын ажиглагчид болон сонгуульд оролцож буй нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдээс томилогдсон 100 гаруй мянган

ажиглагчид Хэсгийн хороонд бүртгүүлэн, санал авах байруудад ажиглалт хийсэн байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын сонгуулиудыг олон мандаттай томсгосон тойргоор болон нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явуулж ирсэн. Энэ тогтолцоо нь улс төрийн хоёр хүчин ээлжилж төрийн эрхийг барих боломжийг бүрдүүлдэгээрээ онцлогтой. Түүн дотроо мажоритар тогтолцоогоор сонгууль зохион байгуулж явуулахдаа томсгосон тойргийг сонгож явуулж байгаа нь нэг том намыг дэмжих нөхцөл боломжийг бий болгодог учраас нэг намын олонхи болох эсхүл хоёр том нам ээлжлэн төрийн эрхийг барьж байгаа сонгуулийн тогтолцоотой холбоотой.

Монгол улсад сонгуулийн хэд хэдэн тогтолцоог туршиж хэрэглэсэн. Монгол улсын ихэнхи сонгуулиудад хэрэглэж ирсэн, нутагшсан тогтолцоо бол олонхийн мажоритар тогтолцоо юм. Энэ тогтолцоо нь хэн илүү санал авсан нэр дэвшигч ялалт байгуулдаг, сонгогчдод энгийн ойлгомжтой зэргээрээ хамгийн дөхөмтэй, хэрэглэхэд хялбар тогтолцоо болох нь харагдаж байна. Мажоритар тогтолцооны сөрөг үр дагаврууд нилээдгүй ажиглагдаж байна. Тухайлбал сонгогчдын санал маш ихээр гээгддэг болох холбогдох судалгаануудаас харагдаж байна. Мөн олон жижиг намуудыг төрд гарах боломжийг хааж зөвхөн хоёр намын тоглолт маягийн хэлбэрт шилжиж байна. Энэ нь олон намын өрсөлдөөнтэй байх чанарыг үгүй хийж байна гэх мэт олон алдаа дутагдлууд байгааг олж харлаа.

Гэхдээ дэлхий нийтэд төгс тогтолцоо байхгүй. Хэрэв боловсронгуй тогтолцоо байдаг бол бүх улс орон түүнийг сонгоно. Боловсронгуй сонгуулийг тогтолцооны эрэл хайгуул үргэлжилсээр байна. Мажоритар системийг холимог тогтолцоогоор сольсоноор асуудал шийдэгдэхгүй. Сонгуулийн аль ч тогтолцоонд эерэг болон сөрөг талууд бий. Дэлхийн улс орнуудад сонгууль явуулдаг 150 шахам арга байдаг. Эндээс харахад улс орон бүр өөр өөрийн онцлогт тохирсон тогтолцоог сонгож хэрэглэх нь чухал.

Тухайн төр барьж буй улс төрийн нэг хүчин ямар бодлого барьж ажиллаж байна, ардчиллын үнэт зүйлсийг алдагдуулж байна уу, ард түмний эрх, эрх чөлөө, язгуур ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж байгаа зэргээс ихээхэн хамаарна. Хэрэв нэг нам үнэмлэхүй олонх болж олон жил оршин тогтновол ардчиллын үнэ цэнэ, үнэт зүйлс алдагдах магадлалтай. Ардчиллын эрүүл мэнд **бүх нийтийн, шууд, тэгш, чөлөөт** ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг хэрэгжилт алдагдах, хүчтэй сөрөг хүчин байхгүйгээс хяналт тавих, хариуцлага тооцох механизм үгүй болно. Бүр цаашилбал ардчиллаар халхлагдсан дарангуйлал бий болох аюултай.

Монголын ард түмэн сонголт хийхдээ Засгийн газрыг Монгол ардын намд өгөх үү, Ардчилсан намд өгөх үү гэхээсээ илүү С.Эрдэнэд өгөх үү, У.Хүрэлсүхэд өгөх үү. Улс төрийн намыг нь бус хүнийг харж сонголт хийсэн байх талтай. Мөн У.Хүрэлсүхийн Засгийн газарт итгэл хүлээлгэж, хийж буй ажлыг нь үргэжлүүлэх боломж олгох сонирхол сонгогчдын дийлэнхид байсан болов уу. Мөн МАН-ын уриа болох “Хүчээ нэгтгэе”, “багаар нь дэмжье” гэх мэт урианууд нь сонгогчдод нөлөөлсөн. Зарим нэр дэвшигчид мундаг сайндаа ард түмний олонхийн саналыг авч УИХ-ын гишүүн болоогүй. Багаар нь дэмжиж өмнөх Засгийн газрын бодлого үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийлгэх сонирхол ард түмэнд байсан учраас зарим нэг хүсээгүй нэр дэвшигчдээ дугуйлж багаар нь сонгоход хүрсэн.

Эцэст нь 2020 оны УИХ-ын сонгуулийн онцлогийг дүгнэн хэлэхэд:

1. Дэлхий нийтийг цочроосон цар тахлын үед болж байгаагаараа,
2. Маш олон бие даан нэр дэвшигчид өрсөлдсөнөөрөө,
3. Улс төрийн жижиг намууд дангаараа биш маш олон жижиг намууд эвсэл болж хүчтэй өрсөлдсөнөөрөө,
4. Маш олон шинэ, залуу нэр дэвшигчид өрсөлдсөнөөрөө цар тахлын үед, тухайн сонгуулийн өдөр, аадар бороо, мөндөртэй байсан ч Монголын сонгогчид хамгийн өндөр идэвхитэй сонгуульд оролцсоноороо,
5. Монголын залуу сонгогчид өндөр идэвхи гаргаж ухамсартай сонголт хийснээрээ,
6. Сонгуулийн үр дүнгийн 50 хувьд дахин гараар тооллого хийж баталгаажуулснаараа
7. Нилээдгүй олон шинэ УИХ-ын гишүүд төрснөөрөө тус тус онцлогтой сонгууль болж өндөрлөсөн.

Энэхүү өгүүлэлд дурьдсан дээрх асуудлуудыг авч үзэхэд 2020 оны УИХ-ын сонгууль нь өмнөх сонгуулиудын туршлагаа улам баяжуулсан, ардчилсан үзэл санаа нэвт шингэсэн, ардчиллын үндсэн зарчмуудын хүрээнд явагдсан сонгууль болсон гэж үзэж байна.

Abstract

Democratic value includes regular, free and fair elections, pluralism, political tolerance, a multi-party system, strong civil society, civic participation, human rights, equality, accountability, public transparency, economic freedom, and control over the

abuse of power, and the rule of law. This shows that a democratic countries must have a multi-party system and pluralism.

A total of eight parliamentary elections were held in Mongolia in 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, and 2020. Each election had its own characteristics, depending on the specifics of the time, the economic situation, party and state policies and decisions, the current social climate, the electoral system, and changes in the electoral law. This article discusses the process of organizing the 2020 Parliamentary Elections, its results, and the issues to be addressed in the future.

Key words : *Democracy, Democratic Election, Election law, Electoral institution, Electoral principle, Party, Voter's participation, The State Great Hural election.*

Ашигласан эх сурвалж

Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 1992

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 1996

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2005

Сонгуулийн төв байгууллагын тухай хууль. УБ., 2006

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2008

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2008

Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик \эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл\ . УБ., 2009

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль. УБ., 2011

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2011

Сонгуулийн баримт бичгийг бүртгэх, хүлээлцэх журам. УБ., 2012

Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем. УБ., 2012

Монгол улсын Сонгуулийн тухай хууль. УБ., 2015

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт" (*Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон*)

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2019

<https://www.gec.gov.mn/>

<https://ikon.mn/n/1so2>

Хавсралт №1. УИХ-ын сонгуулийн зарим тоо баримт

№	Утга	2020 оны УИХ-ын сонгууль
1	Сонгуулийн тойрог	29
2	Салбар хороо	337
3	Хэсгийн хороо	2070
4	Сонгуульд оролцсон нам, эвсэл	13 нам, 4 эвсэл
5	Нийт нэр дэвшигч	606
6	Үүнээс нам, эвслээс нэр дэвшигч	485
7	Бие даан нэр дэвшигч	121
8	Сонгуулийн зардал	20.500.000000
9	Сонгууль товлон зарласан он, сар, өдөр	2020.02.01
10	Сонгууль болсон он, сар, өдөр	2020.06.24

Хавсралт №2. 2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүн

1	1 дүгээр тойрог	Ёндонпэрэнлэйн БААТАРБИЛЭГ	21849	48.08	Монгол Ардын Нам
2		Жамъянгийн МӨНХБАТ	21478	47.26	Монгол Ардын Нам
3		Ганзоригийн ТЭМҮҮЛЭН	20204	44.46	Монгол Ардын Нам
4	2 дугаар тойрог	Хавдисламын БАДЕЛХАН	23379	46.81	Монгол Ардын Нам
5		Телуханы АУБАКАР	22662	45.37	Монгол Ардын Нам
6		Буланы БЕЙСЕН	22448	44.94	Ардчилсан Нам
7	3 дугаар тойрог	Гомбожавын ЗАНДАНШАТАР	24029	53.06	Монгол Ардын Нам
8		Дашдондогийн ГАНБАТ	21427	47.31	Ардчилсан Нам
9		Амгалангийн АДЪЯАСҮРЭН	19076	42.12	Ардчилсан Нам

10	4 дүгээр тойрог	Цогт-Очирын АНАНДБААЗАР	15624	52.99	Монгол Ардын Нам
11		Жадамбын БАТ-ЭРДЭНЭ	14305	48.52	Монгол Ардын Нам
12	5 дугаар тойрог	Бямбасүрэнгийн ЭНХ-АМГАЛАН	14801	52.18	Монгол Ардын Нам
13		Шатарбалын РАДНААСЭД	14235	50.19	Монгол Ардын Нам
14	6 дугаар тойрог	Сүхбаатарын БАТБОЛД	14091	50.23	Монгол Ардын Нам
15		Гомпилдоогийн МӨНХЦЭЦЭГ	10175	36.27	Монгол Ардын Нам
16	7 дугаар тойрог	Хаянгаагийн БОЛОРЧУЛУУН	16798	46.55	Монгол Ардын Нам
17		Цэдэвийн СЭРГЭЛЭН	16245	45.02	Монгол Ардын Нам
18	8 дугаар тойрог	Борхүүгийн ДЭЛГЭРСАЙХАН	21238	67.49	Монгол Ардын Нам
19		Төмөртоогогийн ЭНХТҮВШИН	17411	55.33	Монгол Ардын Нам
20	9 дүгээр тойрог	Цэдэндамбын ЦЭРЭНПУНЦАГ	18828	49.63	Монгол Ардын Нам
21		Балжиннямын БАЯРСАЙХАН	14350	37.83	Монгол Ардын Нам
22	10 дугаар тойрог	Содномын ЧИНЗОРИГ	32808	61.62	Монгол Ардын Нам
23		Дуламдоржийн ТОГТОХСҮРЭН	30020	56.39	Монгол Ардын Нам
24		Гочоогийн ГАНБОЛД	23560	44.25	Монгол Ардын Нам
25	11 дүгээр тойрог	Нанзадын НАРАНБААТАР	15929	49.64	Монгол Ардын Нам
26		Дашдэмбэрэлийн БАТ-ЭРДЭНЭ	15239	47.49	Ардчилсан Нам
27	12 дугаар тойрог	Жамбын БАТСУУРЬ	19451	58.88	Ардчилсан Нам
28		Наянтайн ГАНИБАЛ	17395	52.65	Ардчилсан Нам

29	13 дугаар тойрог	Жаргалтулгын ЭРДЭНЭБАТ	22865	46.61	Монгол Ардын Нам
30		Чинбатын УНДРАМ	22583	46.04	Монгол Ардын Нам
31		Дамдинсүрэнгийн ӨНӨРБОЛОР	19412	39.57	Монгол Ардын Нам
32	14 дүгээр тойрог	Жигжидийн БАТЖАРГАЛ	18531	42.32	Монгол Ардын Нам
33		Цэвэгдоржийн ТУВААН	16125	36.82	Ардчилсан Нам
34		Нямаагийн ЭНХБОЛД	15842	36.18	Монгол Ардын Нам
35	15 дугаар тойрог	Одонгийн ЦОГТГЭРЭЛ	26644	61.00	Ардчилсан Нам
36		Чимэдийн ХҮРЭЛБААТАР	22562	51.65	Монгол Ардын Нам
37		Баттогтохын ЧОЙЖИЛСҮРЭН	21378	48.94	Монгол Ардын Нам
38	16 дугаар тойрог	Ширнэнбаньдын АДЬШАА	22549	52.30	Ардчилсан Нам
39		Бөхчулууны ПҮРЭВДОРЖ	18578	43.09	Ардчилсан Нам
40		Сандагийн БЯМБАЦОГТ	18464	42.83	Монгол Ардын Нам
41	17 дугаар тойрог	Цэрэнпилийн ДАВААСҮРЭН	33783	54.08	Монгол Ардын Нам
42		Лхагвын МӨНХБААТАР	29351	46.98	Монгол Ардын Нам
43		Лувсанцэрэнгийн ЭНХ-АМГАЛАН	27931	44.71	Монгол Ардын Нам
44	18 дугаар тойрог	Ухнаагийн ХҮРЭЛСҮХ	25356	71.01	Монгол Ардын Нам
45		Лувсаннамсрайн ОЮУН-ЭРДЭНЭ	25169	70.48	Монгол Ардын Нам
46		Бадмаанямбуугийн БАТ-ЭРДЭНЭ	19887	55.69	Монгол Ардын Нам
47	19 дүгээр тойрог	Болдын ЖАВХЛАН	24026	53.28	Монгол Ардын Нам

48		Гонгорын ДАМДИННЯМ	22347	49.56	Монгол Ардын Нам
49		Баагаагийн БАТТӨМӨР	19824	43.96	Монгол Ардын Нам
50	20 дугаар тойрог	Дамбын БАТЛУТ	22621	49.52	Монгол Ардын Нам
51		Норовын АЛТАНХУЯГ	19595	42.90	Бие даан нэр дэвшигч
52		Сайнхүүгийн ГАНБААТАР	17034	37.29	"ТА БИДНИЙ ЭВСЭЛ" /МАХН- ИЗНН-МУНН/
53	21 дүгээр тойрог	Сайнбуянгийн АМАРСАЙХАН	21969	68.66	Монгол Ардын Нам
54		Цэндийн САНДАГ-ОЧИР	15576	48.68	Монгол Ардын Нам
55	22 дугаар тойрог	Баттөмөрийн ЭНХБАЯР	36364	45.08	Монгол Ардын Нам
56		Батсүхийн САРАНЧИМЭГ	25228	31.28	Монгол Ардын Нам
57	23 дугаар тойрог	Жигжидсүрэнгийн ЧИНБҮРЭН	41004	52.58	Монгол Ардын Нам
58		Хүрэлбаатарын БУЛГАНТУЯА	35472	45.49	Монгол Ардын Нам
59		Энхтайваны БАТ-АМГАЛАН	30870	39.59	Монгол Ардын Нам
60	24 дүгээр тойрог	Дамдины ЦОГТБААТАР	25333	39.43	Монгол Ардын Нам
61		Цэндийн МӨНХ-ОРГИЛ	23637	36.79	Монгол Ардын Нам
62		Цэрэнжамцын МӨНХЦЭЦЭГ	20584	32.04	Монгол Ардын Нам
63	25 дугаар тойрог	Төмөрбаатарын АЮУРСАЙХАН	33356	48.28	Монгол Ардын Нам
64		Мөнхөөгийн ОЮУНЧИМЭГ	27339	39.57	Монгол Ардын Нам
65		Жамъянхорлоогийн СҮХБААТАР	23365	33.82	Монгол Ардын Нам
66	26 дугаар тойрог	Хассуурийн ГАНХУЯГ	50073	48.27	Монгол Ардын Нам

67		Жамбалын ГАНБААТАР	48624	46.87	Монгол Ардын Нам
68		Салдангийн ОДОНТУЯА	27143	26.16	Ардчилсан Нам
69	27 дугаар тойрог	Хишгээгийн НЯМБААТАР	32962	56.65	Монгол Ардын Нам
70		Бадарчийн ЖАРГАЛМАА	24867	42.74	Монгол Ардын Нам
71	28 дугаар тойрог	Ням-Осорын УЧРАЛ	53651	65.54	Монгол Ардын Нам
72		Долгорсүрэнгийн СУМЪЯАБАЗАР	36785	44.94	Монгол Ардын Нам
73		Пүрэв-Очирын АНУЖИН	32031	39.13	Монгол Ардын Нам
74	29 дүгээр тойрог	Ганибалын АМАРТҮВШИН	37476	42.11	Монгол Ардын Нам
75		Даваажанцангийн САРАНГЭРЭЛ	37457	42.09	Монгол Ардын Нам
76		Тогмидын ДОРЖХАНД	24449	27.47	"ЗӨВ ХҮН ЭЛЕКТОРАТ" эвсэл

THE DEVELOPMENT AND TRANSFORMATION OF THE MONGOLIAN PARTY SYSTEM, 1992–2020

Pavel Maškarinec

Department of Political Science, Faculty of Arts,
Jan Evangelista Purkyně University in Ústí nad Labem, Czech Republic

Introduction

Since its democratization in 1990 (see Fish 2001; Fritz 2002; Fritz 2008; Fish and Seeberg 2017; Aagaard Seeberg 2018), Mongolia has held eight elections (1992–2020) to its unicameral parliament – the Great State Khural. Previously, Mongolia's electoral system has attracted only scant attention in comprehensive comparative studies of electoral institutions (Maškarinec 2017; Maškarinec 2019a; Jacob and Schenke 2020) and of politics generally (Croissant 2007; Reilly 2007; Croissant and Schächter 2010; Croissant and Völkel 2012), although Mongolia is one of the few countries (if not the only one) of post-communist Asia which experienced successful long-term democratization and consolidation (Fish 2001; Fritz 2002; Schneider and Schmitter 2004; Soni 2013). The success of these processes was not precluded even though the country lacked the many prerequisites which are normally considered favourable for democratization (see Fish 1998).

At the same time, and contrary to many post-communist countries of Central and Eastern Europe which transitioned to democratic systems with proportional representation at the national level, Mongolian voters chose their representatives through plurality-majority or semiproportional electoral systems (with exceptions of elections of 2012). More importantly, since Mongolia's democratic transition in 1990, frequent changes have been characteristic of its electoral system. So, as well as in previous elections, also Mongolian electoral politics in last parliamentary election of 2020 was affected by a reform adopted by the parliament half-a-year before the election. An amendment to the act on elections into Mongolia's legislature introduced for the 2020 election plurality vote in multi-member districts (MMDs), the so-called unlimited vote,

or multiple vote (like in the years 1992 and 2008), instead of first-past-the-post (FPTP) system in single-member districts (SMDs) used in 2016. In contrast, Mongolia used a specific modification of the two-round (TR) plurality-majority system in the elections of 1996, 2000 and 2004, and a mixed-member majoritarian (MMM) system in 2012.

More importantly, as most of the electoral systems tended to exaggerate disproportionality (see below) and favour the two largest parties, the post-communist Mongolian People's Party (MPP)¹ and the Democratic Party (DP), Croissant and Völkel (2012) classified Mongolia between 1990 and 2008 as having a two-party system with one dominant party and, similarly, Reilly (2007) considered Mongolia as having a two-party system between 1992 and 2004 (especially in 2004). However, although the tendency to bipolarization of Mongolian electoral politics was interrupted in the election of 2012, when the introduction of the MMM reoriented the party system (for the first time in Mongolian history) to multipartism (see Maškarinec 2019b), the implementation of the FPTP in 2016 suggested possible restoration of bipartism (see Radchenko and Jargalsaikhan 2017).

Finally, while all previous Mongolian elections resulted in power alternation between governing and opposition parties, the parliamentary election in 2020 brought about one novelty, namely the second landslide victory of the MPP in a row. Thus, not only did MPP retain its dominant party status (with the exception of the 2012 election, the post-communists never received less than 40% of the vote), but for the first time, an incumbent party managed to retain a one-party government for the following electoral term, which suggests future possible transformation of the Mongolian party system.

The aim of this chapter is to analyse the effects of the electoral reforms in all Mongolian elections between 1992 and 2020 by analysing national and district-level results. Especially, we address the question to what extent the pattern of the electoral competition (at the electoral level, as well as at the level of representation) has changed between elections, with regard to the type of electoral system, and whether the shape of the party system still varies between asymmetrical or more symmetrical two-party competition (as suggested Croissant and Völkel [2012]), or has transformed in another

¹ The Mongolian People's Party (MPP) is the former ruling party which had governed the country during the whole non-democratic period. Between 1924 and 2010 the MPP used the name Mongolian People's Revolutionary Party (MPRP). However, in November 2010, the party congress decided to rename the party to the Mongolian People's Party (MPP). In this chapter, we use the label of MPP for the former MPRP.

direction. Due to the frequent electoral engineering, Mongolia could serve as a very useful case for testing development of electoral competition and party system types.

Methods and research design

We take different approaches to studying electoral competition at the level of Mongolian electoral districts.² First, we use the Gallagher (1991) disproportionality index (LSq Index) to measure the disproportionality of an electoral outcome, i.e., the difference between parties' shares of the votes and their shares of the seat in parliament. Second, we use Laakso and Taagepera's (1979) effective number of parliamentary parties (*ENPP*) as a measure of parliamentary fragmentation, and effective number of electoral parties (*ENEP*), calculated in each district, as a measure of concentration in the distribution of votes across parties.

Third, we use Siaroff's (2000) typology of party systems to analyse the shape and transformation of Mongolian party system. As mentioned Croissant and Völkel (see 2012: 238–239), despite some criticism, this typology offers several advantages, compared for instance to famous Sartori's (1976) typology of competitive party systems. More importantly, Siaroff's (2000) typology takes into account the absolute and relative size of the parties, and, in contrast to Sartori's (1976), it offers a clear definition of quantitative indicators (below), thus enabling the classification of individual party systems.

Siaroff uses the number of parties with at least 3% of the seats (P3%S variable) to distinguish between three overall categories of party systems: (1) two-party systems; (2) moderate multiparty systems; and (3) extreme multiparty systems. However, in the next step, Siaroff expands the categories, using three additional factors (the two-party seat concentration—2PSC; the seat ratio between the first and second party—SR1:2; the seat ratio between the second and third party—SR2:3), into more precise eight different types of party systems.

² In the elections under TRS (1996, 2000, 2004) and FPTP (2016) there were 76 SMDs, while in the elections under unlimited vote there were 26 MMDs ($M = 2-4$ in 1992 and 2008; $M = 1-3$ in the nominal tier of the MMM in 2012), or 29 MMDs in 2020 ($M = 2-3$), respectively.

Table 1. Siaroff's typology of party systems

Party system type		Classification criteria
Two-party system		$P3\%S = 2-3$; $2PSC \geq 95\%$
Two-and-half-party system		$P3\%S = 3-5$; $2PSC = 80-9\%$; $SR1:2 < 1.6$; $SR2:3 \geq 1.8$
Moderate multiparty system with one dominant party		$P3\%S = 3-5$; $SR1:2 \geq 1.6$
Moderate multiparty system with two main parties		$P3\%S = 3-5$; $SR1:2 < 1.6$; $SR2:3 \geq 1.8$
Moderate multiparty system with a balance among the parties		$P3\%S = 3-5$; $SR1:2 < 1.6$; $SR2:3 < 1.8$
Extreme multiparty system with one dominant party		$P3\%S \geq 6$; $SR1:2 < 1.6$
Extreme multiparty system with two main parties		$P3\%S \geq 6$; $SR1:2 < 1.6$; $SR2:3 \geq 1.8$
Extreme multiparty system with a balance among the parties		$P3\%S \geq 6$; $SR1:2 < 1.6$; $SR2:3 < 1.8$
Operationalization		
P3%S	Number of parties winning at least 3% of the filled parliamentary seats.	
2PSC	Sum of the percentage of seats for the two parties obtaining the most seats in parliament.	
SR1:2	Ratio obtained by comparing the seats of the party with the largest number of seats to the seats of the party with the second-largest number of seats.	
SR2:3	Ratio obtained by comparing the seats of the party with the second largest number of seats to the seats of the party with the third largest number of seats.	

Source: Adapted from Siaroff (2000: 69–71).


Notes: When calculating the effective number of parties, the parties running in the coalition are counted as one entity. Similarly, independent MPs are counted as one entity in the case of the P3%S indicator, and in Table, independent MPs are listed in parentheses.

Fragmentation and concentration of Mongolian electoral competition in a historical perspective

After the transition to democracy in 1990, Mongolian political competition was characterized by contestation between the former ruling party, MPP, which had governed the country since 1921, and political parties established after 1990 (parties of the so-called “democratic camp”). However, while the post-communist MPP inherited an extensive organizational structure from the communist period and also preserved high electoral support within the country’s (especially rural) population (see Gluchowski and Grotz 2001: 495–509; Rossabi 2009: 236–250), the opposition was characterized by frequent establishing and merging of parties (see Fritz 2008: 775–782; Radchenko and Jargalsaikhan 2017: 1038–1041).

Nevertheless, these changes in the political landscape were largely enacted by the same political leaders, who were merely switching from existing groups to new ones. The permanent fragmentation of the party spectrum was also facilitated by the absence of any substantial ideological or programmatic differences between Mongolia’s main parties (see Barkmann 2005: 58–60; Prohl and Sumati 2008: 372–382; Sumati 2009: 99–106). Overall, electoral systems generally favoured the larger parties, as evidenced, for instance highly disproportionate electoral outcomes measured by Gallagher (1991) disproportionality (LSq) Index (Figure 1). This index is especially useful for comparing proportionality across electoral systems and across time. In Mongolia, the LSq Index was the lowest in 2004 and 2012 parliamentary elections (reaching 2.16 or 2.84) and the highest in 2000 and 2016 elections (equalling 33.19 or 32.91), although also in 1992 and 2020 elections the value of LSq Index approached 30. So, low disproportionality does not go hand in hand with the type of electoral system, but rather the fragmentation of the “democratic camp” was decisive for the shape of the party system and disproportionality of electoral outcomes.

Figure 1. Gallagher’s disproportionality index for parliamentary elections, 1992–2020




Source: SEC (2020), author’s own calculations.

Note: 2012 (PR): LSq Index value in the proportional (list) tier; 2012 (N): LSq Index value in the nominal (district) tier.

Figure 2 presents the percentage of the votes and seats received by the two nationally strongest parties (the MPP and the DP, or its predecessors). The results demonstrate that the tendency to rise of two-party competition was (at the level of representation) interrupted only in 2012 elections (especially in proportional tier), and only in this election the combined share of seats of the top two parties fell below 90%. However, comparison of seats received by two strongest parties suggested asymmetrical competition between top two parties as in half of elections (1992, 2000, 2016, 2020) only one party, the MPP, received the vast majority of the seats. More importantly, the tendency to symmetrical two-party competition, which was strengthened by the establishment of the DP in 2000,³ almost disappeared in last two elections.

³ The Democratic Party (DP) was established in 2000 by a merger of several parties established after the Mongolian democratization in 1990, especially the Mongolian National Democratic Party (MNDP), the Mongolian Social Democratic Party (MSDP), the Mongolian Democratic Party (MDP), the Mongolian Believers’ Democratic Party (MBDP), and the Mongolian Democratic Renewal Party (MDRP) (see Sanders 2010: 209–210).

Figure 2. The vote for the top two parties, 1992–2020




Source: SEC (2020), author's own calculations.

- Wahlke, John C. (1971): Policy Demands and Systems Support: The Role of the Represented, in *Modern Parliaments: Change or Decline?* See Loewenberg 1971.

САНАЛ ХУДАЛДАН АВАЛТ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ: УЛС ТӨРИЙН АСУУДАЛ

Б.Эрдэнэдалай

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

О.Батзаяа

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн магистрант

Түлхүүр үг: Ардчилал, сонгуулийн зарчим, сонгуулийн тэгш эрх, сонгох эрх, сонгогдох эрх, улс төрийн авлига

Санал худалдан авалтын тухай

Ардчилсан нийгэмд сонгуулийн зарчмуудыг хэрэгжүүлж, хангаснаар ардчиллын чанар, бэхжилтийг хангаж улс төрийн орчин соёлтой, авлигаас ангид байж улс төр дэх тэгш боломж, өрсөлдөөн, шударга ёсыг хангах нөхцөл бүрдэнэ. Улс төрийн нам болон нэр дэвшигчид сонгуульд өрсөлдөхөд сонгогчдын саналыг худалдан авахад зарцуулсан мөнгөө эргэн олж авахын төлөө ажилладаг.

Зураг 1. Олон улсад санал худалдан авалтыг хориглосон эсэх²



² International IDEA. <https://www.idea.int/data-tools/question-view/558>

Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэнгийн дээрх судалгаанд хамрагдсан 179 улсын 163 улсад сонгогчдын санал худалдаж авахыг эрүүгийн болон сонгуулийн тухай хуулиар хоригложээ. Гэхдээ хуулиар хориглосон ч дээрх улсуудад санал худалдан авалтын үйл ажиллагаа явагддаггүй гэж ойлгож болохгүйг гэдэг нь энэ чиглэлээр хийгдсэн судалгааны бүтээлүүдэд гарч буй тохиолдол, дүнгээс харж болно. Тухайлбал, Монгол Улсад сонгогчдын саналыг худалдан авахыг Сонгуулийн тухай хуулиар хориглосон ч сонгуулийн бус үед маш олон төрлийн санал худалдан авалтын үйл ажиллагааг улс төрчид болон нэр дэвшихээр горилогчид хийсээр байгаа юм.

Сүүлийн 20 гаруй жилд эрдэм шинжилгээний болон хэвлэл мэдээллийн салбарт "санал худалдаж авах" гэсэн нэр томъёог судалж, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх болон арилгах вэ гэсэн агуулгатай олон тооны бүтээлүүд гарчээ. Үүнтэй холбоотойгоор санал худалдан авалтын тухай олон тодорхойлтууд гарсан билээ. Эдгээр тодорхойлолтод "улс төрийн албан тушаалыг материаллаг болон материаллаг бус зүйлээр солилцох", "улс төрийн нам, нэр дэвшигч, төлөөлөгч, дэмжигчээс сонгогчдод саналаа өгөхөд нөлөөлөх, эсхүл боломжоо сайжруулахын тулд үүнийг хийхээс татгалзах, материаллаг болон материаллаг бус зүйлээр барьцаалах, урамшуулах аливаа хэлбэр" зэргээр олонтоо дурьдан тодорхойлсон байна. Эндээс *сонгуульд ялалт байгуулахын тулд хэн нэгэнд санал өгөх, эсвэл тодорхой байдлаар санал өгөхөөс татгалзсан тохиолдолд шууд болон амласан шагналын аливаа үр дүнг санал худалдан авах* гэж үзэж болно. Ихэнх ардчилсан орнуудад санал худалдаж авах нь сонгуулийн зөрчил гэж тооцогддог. Тэдгээр улсуудад эрх зүйн зохицуулалтаас гадна, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, амьжиргааны түвшнийг нэмэгдүүлэх зэрэг олон аргуудыг ашигласан байна.

Транспаренси интернэшнл олон улсын байгууллагаас 2019 онд хийсэн судалгаа³-нд "Улс төрийн авлигын үндсэн шалтгааны нэг нь сонгуулийг урвуулан ашиглах явдал бөгөөд үүнд улс төрийн намуудыг хууль бусаар санхүүжүүлэх, сонгогчдын саналыг худалдан авах, сонгуулийн кампанит ажлын үеэр хуурамч мэдээ тараах зэрэг орно" гэж тодорхойлжээ. Энэхүү Латин Америк болон Карибын тэнгисийн улсуудын иргэдээс авсан судалгаанд оролцогчдын 52-53% нь

³ Transparency International. *Political Integrity Lacking in Latin America and the Caribbean, Especially around Elections*. 2019

Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, парламентын гишүүдийг хамгийн их авлигад өртсөн бүлэглэл, институт гэж үзсэн байна.

Хүснэгт 1. Санал худалдан авалтын тухай судалгааны дүн

(Транспаренси интернэшнл 2019)

Улсын нэр	Судалгааны дүн
Латин Америк болон Карибын тэнгисийн улсууд	4 иргэн тутмын 1 нь сүүлийн таван жилийн хугацаанд үндэсний, бүс нутгийн эсвэл орон нутгийн сонгуульд хээл хахууль авч санал өгч байсан.
Мексик	2 иргэн тутмын 1 нь саналаа өгөхдөө хээл хахууль авсан, 1/4 нь санал өгөхдөө дарамтад өртдөг.
Доминиканы Бүгд Найрамдах Улс	Иргэдийн 46 хувь нь санал худалдан авалтад оролцож байсан.
Бразил, Колумб	Иргэдийн 40 хувь нь санал худалдан авалтад оролцож байсан.
Тринидад ба Тобаго, Гайана, Ямайка	Иргэдийн санал худалдан авалтад оролцож байсан нь энэ бүс нутагтаа хамгийн бага нь юм.
Венесуэл	5 иргэн тутмын 1-ээс илүү нь бие даан, нууцаар саналаа өгч чаддаггүй, дарамтад өртдөг.

Санал худалдан авалтын эсрэг дорвитой арга хэмжээ авахгүй бол сонгуулийн авлига гаарч, эцэстээ иргэд саналаа чөлөөтэй, нууцаар гаргах эрхийг санал худалдан авагчдад алдах юм. Энэ нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын 1990 оны Копенгагений баримт бичиг⁴-ийн 7.4 дэх хэсэгт заасан сонгогчийн санал нууц байх зарчмыг ноцтой зөрчиж байгаа явдал юм.

Санал худалдан авалтад нөлөөлж буй хүчин зүйлс

⁴ OSCE. 1990 Copenhagen Document. <https://www.osce.org/odihr/elections/14304?download=true>

Санал худалдаж авах асуудал газар авч буйд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд:

- Сонгогчдын үнэмлэхийг унших төхөөрөмжийг нэвтрүүлэх, сонгуулийн дүнг цахимаар гаргах зэрэг технологийн шинэчлэлтүүд орсон нь сонгуулийн дүнг будлиулдаг уламжлалт хэлбэрүүдийг эрс багасгасан юм. Тиймээс улс төрчид сонгуулийн үр дүнг хуурамчаар үйлдэх нь технологийн эсрэг үзэгдэл болж байгаа учраас тэд саналынхаа хариуд мөнгө, хоол хүнс, хувцас, бусад бэлэг дурсгалын зүйлээр сонгогчдыг хууран мэхлэх арга хэрэглэж байна.
- Сонгуульд ямар ч аргаар хамаагүй ялалт байгуулахыг хүсдэг улс төрчдийн чармайлт хоёр дахь хүчин зүйл юм. Улс төрчид засгийн эрхэнд гарсныхаа дараа олж авна гэж найдаж буй асар их эрх мэдэл, эд баялгийн төлөө санал худалдаж авах үйл ажиллагаанд их ач холбогдол өгч оролцдог. Хэрэв энэ үйл ажиллагаанд оролцохгүй л бол өрсөлдөгчид нь мөн адил санал худалдаж авч байгаад сонгуульд ялалт байгуулж давуу талыг олж авах вий гэсэн болгоомжлол үүсдэг. Иймээс энэ асуудал нь ялангуяа "том" улс төрийн намуудын дунд төрөл бүрийн уралдаан болж хувирсан билээ.
- Гурав дахь хүчин зүйл бол улс орны ардчиллын хөгжил болон ядуурлын түвшин⁵гээс хамааралтайгаар санал худалдан авалтын үйл ажиллагаа явагддаг. Ардчиллын хөгжлөөр сул буюу ардчиллыг бэхжүүлж амжаагүй байгаа улсууд, Африкийн ядуу улсууд зэрэгт энэ үйл ажиллагаа их эрчимтэй хийгддэг, иргэд нь улс төрчдийн өгч буй мөнгө, бэлэг, амлалтад итгэн саналаа худалдах нь элбэг байна.

Санал худалдан авалтаас үүсч буй зарим асуудлууд

Олон улсад санал худалдан авалтын үйл ажиллагааг хориглох, хянах зохицуулалтын арга хэмжээг тухайн улсын онцлог, сонгуулийн системийн шинж чанарт тохируулж нарийвчлан оновчтой зохицуулахгүй бол дараах тооцоолоогүй үр дагавар, эрсдэлд хүргэж болдог байна.


Тухайлбал:

⁵ Frederic C. Schaffer, ed, Elections for Sale: The Causes and Consequences of Vote Buying, Boulder/CO 2007.

- Санал худалдан авах нь хүний суурь эрх болох сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн үйлдэл болдог.
- Тухайн улсын ардчиллын хөгжлийг хойш татаж ардчиллын бэхжилтэд сөргөөр нөлөөлдөг.
- Сонгуулийн тэгш, шударга өрсөлдөөний зарчим алдагдаж сонгуульд нэр дэвшигчдийн дунд тэнцвэргүй өрсөлдөөн үүснэ.
- Хэрэв сонгогчдын саналыг худалдан авах мөнгөгүй бол “бодлого”-оор өрсөлдөх гэж буй жижиг болон шинээр байгуулагдсан улс төрийн намууд болон бие даан нэр дэвшигчид парламентад сонгогдох боломжгүй болно.
- Санал худалдан авалтын үйл ажиллагаанд их хэмжээний мөнгө зарцуулж сонгогдсон хойноо төрийн албанд мэргэжлийн бус хүн томилох, төрийн өмчийг зарах, хувьчлах, байгалийн баялгийн өгөөжийг хамаарал бүхий этгээдэд болон өөрийн санхүүжүүлэгчдээ ашиглуулах, өгөх зэргээр нийт иргэдийн хүртэх баялгийг хэсэг бүлэгт ашиглуулж анх зарцуулсан мөнгөө эргэж олж авдаг.
- Улс төрийн санхүүжилтэд тавих хяналт, түүнд тавих олон талын оролцоог хангахгүй бол сонгуулийн зардал улам өсдөг.
- Санал худалдан авалтын үйл ажиллагаа нь сонгогчдын зан үйлд сөргөөр нөлөөлдөг. Сонгогчид нэр дэвшигчдээс мөнгө, бэлэг авах сонирхолтой болдог. Хэрвээ сонгогчдын саналыг худалдан авах үйл ажиллагаа хийгдэхгүй бол дараагийн удаа сонгуульд оролцож, саналаа өгөхгүй байх нь элбэг. Ингэснээр сонгуулийн ирц хүрэхгүй байх, хүрсэн тохиолдолд нэр дэвшигчид цөөн хүний саналаар ялалт байгуулж, санал гээгдэж, төлөөлөх чадвар буурдаг.
- Иргэд сонгуулиас сонгууль бүрт санал худалдан авалтын үйл ажиллагаанд автаж, түүний золиос болсноороо уг үйлдлийн эсрэг ажиллаж буй судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудын нөлөөллийн үйл ажиллагааг тоохгүй, үл ойшоох хандлага илэрч, байдал улам дорддог.
- Санал худалдан авалтын эсрэг арга хэмжээ авахгүй бол эцэстээ иргэд саналаа чөлөөтэй, нууцаар гаргах эрхээ санал худалдан авагчдад алдах, тэдэнд санал өгөөгүйн төлөө дарамтлуулах, заналхийлүүлэх ч аюултай.

Санал худалдан авалтыг хэрхэн хориглох вэ?

График 2. Санал худалдан авалт явагддаг зарим улсууд⁶



(Тайланд улсын жишээ)

Санал худалдан авалтыг хуулиар шууд хориглосноор дараах эрсдэлүүд үүсдэг байна. Жишээ нь, Тайландад⁷ 1997 онд сонгуулийн ардчилсан зарчмуудыг хангах, улс төрд нөлөөлж буй мөнгөний нөлөөг багасгах, санал худалдан авалтыг хязгаарлах зэргээс шалтгаалж Үндсэн хуулийг шинээр баталсан. Уг хууль батлагдсаны дараа 2001 онд болсон сонгуульд нэр дэвшсэн олон тооны нэр дэвшигчид санал худалдан авсныхаа төлөө хариуцлага тооцуулж, шийтгүүлсэн байна. Бусад ардчилсан орнуудтай адилаар Тайландад санал худалдан авалтын эсрэг хийсэн үр нөлөөтэй ажил болж хууль зөрчигчдийг илрүүлсэн сайшаалтай боловч нэр дэвшигчид санал худалдан авалтын дараах шинэ хэлбэрүүдийг даруй хэрэгжүүлжээ.

- Сонгогчдын саналыг худалдан авахад хуулийн дагуу шийтгүүлэх эрсдэл үүсдэг тул сонгогчдын саналыг худалдан авахгүйгээр, орон нутгийн сонгуулийн ажилтнуудыг худалдан авдаг.

⁶ Latin American Public Opinion Project (LAPOP) -Americas Barometer Survey 2012.
https://www.researchgate.net/publication/323082978_An_Empirical_Analysis_of_Vote_Buying_Among_the_Poor_Evidence_from_Elections_in_the_Philippines_forthcoming_in_Southeast_Asia_Research/figure/s?lo=1

⁷ Frederic C. Schaffer, ed, Elections for Sale: The Causes and Consequences of Vote Buying,

Boulder/CO 2007

- Сонгогчдын саналыг худалдан авч болохгүй болсон гэсэн дээрх шалтгааны улмаас улс төрийн намд элсүүлж буй нэрээр намын гишүүдэд мөнгөн урамшуулал өгдөг. Тухайлбал, Тайландын Рак Тай намд 11 сая гишүүн элссэний ихэнх нь тухайн намд элссэнийхээ төлөө тодорхой хэмжээний мөнгөн урамшуулал авсан байна.
- Бүх сонгогчдын саналыг худалдан авч чадахгүй ч саналаа худалдаж байгаа сонгогчдын авч буй мөнгөний хэмжээ их үнэтэй болсон. Тайландын банкууд сонгуулийн кампанит ажлын үеэр гүйлгээнд оруулсан мөнгөний хэмжээ өссөн нь 25 тэрбум бат (ойролцоогоор 1 тэрбум доллар) байсан буюу 1996 оны сонгуулийн үеэр зарцуулагдсан мөнгөнөөс даруй 5 тэрбум батаар илүү байсан байна. Товчхондоо нэр дэвшигчид цөөн санал худалдаж авсан боловч худалдаж авсан санал нь илүү үнэтэй байв.
- Сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх, нэр дэвшигчдийг хэрхэн, ямар үзүүлэлтийг харж сонгоход анхаарах шаардлагатай болсон. Сонгуулийн насны бүх иргэдийг сонгуульд саналаа заавал өгөх үүрэгтэй гэж хуульдаа зааснаар сонгуулийн ирц сайжирсан. Ингэж саналаа заавал өгөх үүрэгтэй гэж заасан нь олон тооны сонгогчдын саналыг худалдан авахын тулд их мөнгө зарцуулж нийт үнийг өсгөх тул намууд, нэр дэвшигчид санал худалдан авахын төлөө их мөнгө зарцуулж биш, харин бодлогоор өрсөлдөх магадлалтай гэж үзсэнтэй холбоотой ч сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх хэрэгтэй болсон байна.

Тайланд улсын 2011 оны 7 сард болсон сонгуулийн үеэр тус улсын сонгуулийн төв байгууллагад 1920 орчим санал гомдол ирсэн нь тийм их тоо биш, харин ч энгийн үзэгдэл болсон байв. Сонгуулийн санал худалдаж авах үйл явц улам ширүүсч 300 бах (10 доллар)-аас 3000 бах (100 доллар) болон өссөн талаарх мэдээлэл байв. Өөрийн намын дэмжигчиддээ ID карт өгөн урамшуулах, санал өгсөн эсэхийг ID картаараа дараа нь шалгадаг ба хэнд, хэдэн санал өгсөн нь маш тодорхой болдог нарийн тактик юм. Тайландын сонгуулийн төв байгууллага маш сайн хяналтыг хэрэгжүүлдэг ба цагдаа нар болон орон нутаг, тойрог дахь хүмүүсээс мэдээллэгч олж аван санал худалдан авахтай холбоотой мэдээллийг тэдний тусламжтайгаар хүлээж авдаг. Мөн сонгууль дууссаны дараа ялалт байгуулсан намтай холбоотой гомдол их ирдэг учраас эрх баригч намыг шалгах арга замуудыг хэрэгжүүлэн санал худалдан авахтай холбоотой хуульд заасан арга хэмжээг авдаг.

Эндээс санал худалдан авалтыг хуулиар шууд хориглоход давхар үүсдэг сөрөг асуудлуудыг нухацтай авч үзэх ёстойг харуулж байна.

Санал худалдан авалтын талаарх хийсэн судалгаа

Санал худалдан авалтын үйл ажиллагааг тухайн улсын сонгуулийн насны нийт иргэдэд тэр бүр зориулж хийдэггүй байна.

- Амьжиргааны түвшин дунджаас доогуур амьдралтай иргэд, өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг эхчүүд, анх удаа саналаа өгөх гэж буй залуу сонгогчид, ахмад настнууд зэрэг нийгмийн халамж, анхаарал шаардлагатай сонгогчдын саналыг худалдан авахын төлөө ажилладаг.
- Аль нэг улс төрийн намын гишүүн биш, улс төрийн намын гишүүн байсан ч тухайн намдаа саналаа өгдөггүй, эсвэл улс төрийн тогтсон үзэл баримтлалгүй “хөвөгч” сонгогчдын саналыг худалдан авахын төлөө ажилладаг.
- Хот болон хөдөө орон нутгийн сонгогчдын саналыг худалдан авах мөнгө болон бэлгийн хэмжээ өөр байна. Хотод оршин суудаг сонгогчдын саналыг худалдан авах арга нарийн, илүү их хөрөнгө зарцуулдаг. Харин хөдөө орон нутагт оршин суудаг сонгогчдын саналыг худалдан авах нь илүү хялбар, бага өртөгөөр шийдэгдэх тохиолдол гардаг.
- Улс төрийн хувьд өөрийн гэсэн үзэл баримтлалтай, боловсрол болон амьжиргааны түвшин боломжийн сонгогчдын саналыг худалдан авахыг оролддоггүй, бага тохиолддог байна.

Хэдийгээр дээрх тохиолдлуудад ямар онцлогтой сонгогчийн саналыг худалдаж авах оролдлого хийх вэ гэдгээс гадна дараах сонирхолтой асуудал ажиглагдсан юм. Энэ нь зарим маш олон тооны хүн амтай улсын сонгогчдын зарим хэсэгт нь мөнгө, бэлэг тараах нь нийт үнийн дүнгээрээ цөөн тооны хүн амтай улсын сонгогчдод бүгдэд нь мөнгө, бэлэг тараахаас их үнийн дүнтэй байдаг байна.

Эндээс мөнгөний хэмжээ нь өөр өөр байж болно. Тухайлбал, Филиппиний нэгэн ядуу хорооллын иргэд 2002 оны орон нутгийн сонгуулийн үеэр ердөө 30 песо (US 60 cents) хүртжээ. Мөн 1996 оны Кувейтийн парламентын сонгуульд санал өгөх

үнэ 3000 динар (US\$10,000) давсан⁸ гэж мэдээлж байв. Тайландад 1996 оны сонгуулиар нэг өрхийн дундаж санал 678 бат (27 доллар) байсан ч Бангкок хотын оршин суугчид хөдөөгийн оршин суугчдаас 2 дахин их үнэтэй байсан байна. Грект цыганууд нэг санал тутамд 16 орчим доллар авдаг⁹. ОХУ-д сонгогчдод 2000 оны сонгуульд саналаа өгөхөд 50-100 рубль (2-4 ам доллар) санал болгосон. Мексикийн олон сонгогч 2000 оны сонгуульд нэг санал тутамд 250-500 песо (25-50 ам доллар)¹⁰ авч байжээ.

Бразилд “Санал худалдан авалтын эсрэг хууль”-ийг 1999 онд баталсан. Тухайн үедээ 170 сая хүн амтай (дэлхийн 5-д орох олон хүн амтай) улсын хувьд нийт сонгогчдын 6% буюу 6 сая хүн 2000 оны сонгуульд санал худалдан авахын тулд өгсөн мөнгийг авсан¹¹ гэжээ. Энэ хуулиар 2000-2008 оны хооронд санал худалдан авсан хотын захиргааны 667, муж болон холбооны 31 улс төрчид, төлөөлөгчдийг эргүүлэн татсан¹² байна. Бразилд энэхүү хууль батлагдахаас өмнө авлигын түвшин маш өндөр хэмжээнд хүрч асуудал хурцаар тавигдаж, Транспаренси интернэшнл байгууллагын гаргадаг авлигын индексийн үзүүлэлтээр тогтмол байр ухарч, улс орны хөгжилд асуудал үүсч эхэлсэн. Иргэдийг авлигын эсрэг үйлдэл, санал худалдан авалтын эсрэг уриалсан томоохон кампанит ажлуудыг иргэний нийгмийн байгууллагууд санаачилсныг хэвлэл мэдээллийн байгууллагууд хүчтэй дэмжин сонгогчдын боловсролыг нэмэгдүүлж, саналаа худалдах биш, “санал бол сонгогчийн сонголт байх ёстой” гэсэн мессежийг маш олон хүнд хүргэж байсан жишээтэй. Хэдийгээр Бразил улс ардчиллыг амжилттай хэрэгжүүлж байгаа гэж дүгнэгддэг ч санал худалдан авалтын эсрэг ажиллаж буй сайн туршлага бүхий улсад хараахан орж чадахгүй байна.

⁸ Agence-France Press. 1996.

⁹ Marantzidis and Mavrommatis. Political Clientelism and Social Exclusion. The Case of Gypsies in the Greek Town of Sofades. 1999. 448

¹⁰ Frederic C. Schaffer, ed, Elections for Sale: The Causes and Consequences of Vote Buying, Boulder/CO 2007.

¹¹ Frederic C. Schaffer, ed, Elections for Sale: The Causes and Consequences of Vote Buying, Boulder/CO 2007.

¹² Simeon Nichter, Vote Buying in Brazil. From Impunity to Prosecution, Paper presented at the Conference “Ruling Politics. The Formal and Informal Foundations of Power in New Democracies”, Cambridge/MA 2011.

Санал худалдан авалтад хүлээлгэх хууль зүйн хариуцлага, зохицуулалт (зарим улсын жишээн дээр)

Дэлхий дээр сонгуулийн санал худалдан авахыг хориглодог 167 улс байгаагаас дараах дөрвөн улсыг сонгож эрх зүйн зохицуулалтыг судаллаа. Эрх зүйн бүлийн хувьд:

1. Англо-Саксон
2. Ром-Германы (Монгол улс энэ бүлд хамаарагддаг)
3. Эх газрын болон жишгийн эрх зүйн системийн холимог
4. Пост-социалист улсуудаас тус тус нэг улсыг сонгож санал худалдан авалтыг ямар хуулиар шийддэг, мөн ямар хариуцлага хүлээлгэдэг талаарх харьцуулсан анализ хийлээ.

Америкийн Нэгдсэн Улс

Сонгуулийн санал худалдан авахыг хориглодог эсэх- Тийм

Сонгогчийн саналыг худалдан авч хэн нэгэнд өгүүлэх, бусдын эсрэг өгүүлэх, өгүүлэхгүй байх, эсвэл санал болгох болон өөрийн саналыг хэн нэгэн нэр дэвшигчид өгөх, өгөхгүй байхаар саналаа худалдсан тохиолдолд тус заалтыг үндэслэж торгох эсвэл **нэгээс илүүгүй жил хорих**, эсвэл хоёуланг нь зэрэг хэрэглэж болно. Хэрэв зөрчил нь санаатайгаар үйлдэгдсэн бол торгох болон **хоёроос илүүгүй жил** хорих эсвэл хоёуланг нь зэрэг хэрэглэж болно¹³.

Холбооны Бүгд Найрамдах Герман улс

Сонгуулийн санал худалдан авахыг хориглодог эсэх- Тийм

Европын парламент эсхүл холбооны парламент, хотын захиргааны сонгуулийн алинд ч бай саналаа худалдах, худалдан авсан нь батлагдсан тохиолдолд 5-аас илүүгүй жил хорих эсвэл торгууль төлнө¹⁴.

¹³ АНУ-ын эрүүгийн болон эрүүгийн процессын хуулийн 29-р бүлэг - Сонгууль болон улс төрийн үйл ажиллагаа хэмээх 18-р заалт

¹⁴ ХБНГУ-ын эрүүгийн хуулийн 108-р зүйлийн е хэсэг. 1998 онд батлагдаж 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон.

Япон улс

Сонгуулийн санал худалдан авахыг хориглодог эсэх- Тийм

Сонгуулийн санал худалдан авсан тохиолдолд 3-аас доошгүй жил албадан хөдөлмөр эрхлүүлэх эсвэл эрхлүүлэхгүйгээр хорих, эсхүл 500.000 иен (12.500.000 төг)-ээс ихгүй хэмжээний мөнгөөр торгох ял хүлээлгэнэ¹⁵.

Бүгд Найрамдах Чех улс

Сонгуулийн санал худалдан авахыг хориглодог эсэх- Тийм

Ард нийтийн санал асуулга (референдум), сонгуулийн үеэр хэн нэгнийг сонгуульд санал өгөх эрхийг нь эдийн засаг болон эд материал, эсвэл ашиг хүргэж болох бусад тохиолдлоор тухайн сонгогч өөрийгөө бие даасан байдлаар илэрхийлэх чөлөөт хүсэл зоригийнх нь эсрэг санал өгүүлсэн тохиолдолд тухайн этгээдийг 6 сараас 3 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ¹⁶.

Эндээс сонгуулийн гэмт хэргийг дээрх дөрвөн улс нь эрүүгийн хуулиар шийтгэдгээс гадна, хорих ял оноодгоороо ижил байна. Хэдийгээр сонгуулийн санал худалдан авах байдал ихэвчлэн ядуу буурай орнуудад түгээмэл ажиглагддаг ч, тухайн орнуудын эрх зүйн орчин, хууль зөрчигчдийг шийтгэх хууль зүйн механизмууд давхар сул байгааг онцлох нь зүйтэй. Латин Америкийн барометр, Азийн барометр судалгааны төвүүдээс явуулсан 2015 оны судалгаагаар судалгаанд оролцогчдоос дараах асуултыг асуусан байна.

Танд сонгуульд нэр дэвшигч эсвэл улс төрийн намаас ямар нэгэн зүйл санал болгож байсан уу? гэсэн тус асуултад “байнга”, “хааяа”, “үгүй” гэсэн гурван хариултын аль нэгийг сонгох боломжтой байсан бөгөөд “байнга” болон “хааяа” хэмээх хариултыг тийм гэдгээр тооцон судалгааны дүнг гаргажээ. Судалгаанд Кени, Нигер, Сенегал, Ботсвана зэрэг улсуудад сонгуулийн санал худалдан авалт хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь нэг талаас дээрх улсуудын эрх зүйн орчин сул, нөгөө талаас нийгэм эдийн засгийн байдал хүнд, иргэний нийгэм төлөвшөөгүй

¹⁵ Япон улсын 1950 онд баталсан Олон нийтийг хамруулсан сонгуулийн тухай хууль, 2011 онд 35 дугаар шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт орсон.

¹⁶ Бүгд Найрамдах Чех улсын 2009 оны эрүүгийн хуулийн 351-р хэсэг “Бэлтгэл үеийн саад ба сонгуулийн явц болон референдум” гэсэн гарчигтай.

зэрэг шалтгаанууд байж болох талтай. Жишээлбэл, хэдийгээр санал худалдан авалт өндөртэй улсуудад орж байгаа ч Нигер улсад санал худалдан авалт хориотой. 2010 оны Сонгуулийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн нэмэлт, өөрчлөлтөд дараах зүйлийг дурджээ.

Сонгууль товлосон өдрөөс хойш ямар ч үед,

а) нэр дэвшигч эсвэл бусад этгээд авлига авсан, эсвэл тухайн этгээдэд авлигын нөлөө үзүүлэх зорилгоор шууд болон шууд бусаар мөнгө өгсөн,

б) тухайн сонгуульд саналаа өгсөн эсвэл санал өгөхөөс татгалзсан бусад этгээд; эсвэл сонгогч энэ хэсгийн (а)-д заасан хугацаанд авлига, мөнгө хүлээн авах, бусад аливаа ажилд оролцсон бол 100,000 найра (326 доллар) эсвэл 12 сарын хорих ялаар шийтгэх, эсвэл хоёулаа хариуцлага хүлээх болно гэж заажээ.

Улс төрийн намуудын 2018 оны ёс зүйн дүрэмд "... бүх улс төрийн намууд, тэдгээрийн төлөөлөгч дараах үйл ажиллагаанд оролцохгүй. Сонгогчийн саналыг худалдаж авах, хахууль, бэлэг, шагнал, талархал өгөх, мөн сонгуулийн албаны хүмүүст мөнгөний болон материаллаг нөхцөл санал болгохыг хориглоно" гэж зааж өгсөн ч санал худалдан авалт нь Нигерт өргөн тархсан хэвээр байна.

Дүгнэлт

Сонгогчдын саналыг худалдан авах ажиллагааг сонгуулийн болон сонгуулийн бусад үед хориглох эрх зүйн зохицуулалт олон улсад түгээмэл ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч сонгогчдын саналыг худалдаж авахын тулд тараадаг бэлгийг гараас гарт өгөхөө больж байна. Энд технологийн дэвшлийг ашиглаж гар утсыг нэгжээр цэнэглэх, данс руу мөнгө шилжүүлэх зэрэг аргуудыг хэрэглэдэг болсон. Хуулийн хүрээнд энэ асуудлыг шийдэхэд хүндрэлтэй болж байгаа. Нэр дэвшигчийн кампанит ажлын төлөөлөгч эсвэл намын гишүүд бэлгийг тараахгүйгээр тэдэнтэй хамаарал бүхий төрийн бус байгууллага, сайн дурын хороод, сангууд, тухайн нутаг орныг сайн мэддэг жирийн иргэд бэлгийг тараадаг болсон зэрэг нь олон улсад хэдийгээр эрх зүйн зохицуулалтаар санал худалдан авалтыг хориглож байгаа ч засгийн эрхийг гартаа авахын төлөө намууд болон нэр дэвшигчид улам бохир аргуудыг ашиглаж байгааг харуулж байна.

Нөгөө талаараа, санал худалдан авах ажиллагаа сонгогчдын зан үйлд асар сөргөөр нөлөөлөх болоод байгаа. Тухайлбал:

- Шилжилт хөдөлгөөн хийсэн байсан иргэд мөнгө, бэлэг авах гэж сонгуулийн өмнөхөн гэртээ ирдэг.
- Саналаа худалдсан сонгогч дараагийн удаа нэр дэвшигчдээс илүү өндөр үнэтэй зүйл хүсдэг.
- Санал худалдан авах буюу сонгогчдод бэлэг тараах уулзалт, өдөрлөгт өөрийн биеэр очиж бэлэг авахыг чухалчилдаг болдог.
- Боловсрол болон эдийн засгийн түвшин доогуур сонгогчдод санал худалдах нь тэдэнд тулгамдсан тухайн асуудлыг багахан ч болов шийддэг тул сонгуулийн үеийг хүлээдэг.

Эцэст нь, саналаа худалдсан сонгогчид саналаа худалдаагүй сонгогчдын ирээдүйг хохироодог буюу сонгох эрхийг зөрчдөг гэх мэт ардчиллын баталгаа, сонгуулийн суурь зарчмуудыг хэрэгжүүлэх, бэхжүүлэх боломжгүй зан үйлүүд сонгогчдод хэвшиж байна.

Жич: Монгол дахь санал худалдан авалтын онцлог, хэлбэр, арга, хууль бус үйл ажиллагаануудын талаарх судалгааг энэхүү өгүүллийн үргэлжлэл болгож дараагийн удаад бэлэн болгох болно.

Abstract

In this article taken what is vote buying, why the political parties and candidates want to buy voter's vote, what is the purpose of vote buying and conclusions of anti vote buying system. Vote-buying in its literal sense is simple of political interests. Candidates "buy" and citizens "sell" votes, as they buy and sell daily common use items.

Ашигласан ном, материал

Frederic C. Schaffer, ed, Elections for Sale: The Causes and Consequences of Vote Buying,

Boulder/CO 2007

International IDEA. Is there a ban on vote buying?. www.idea.int

Latin American Public Opinion Project (LAPOP) -Americas Barometer Survey 2012

Marantzidis and Mavrommatis. Political Clientelism and Social Exclusion. The Case of Gypsies in the Greek Town of Sofades. 1999

OSCE. Copenhagen Document. 1990

Simeon Nichter, Vote Buying in Brazil. From Impunity to Prosecution, Paper presented at the Conference “Ruling Politics. The Formal and Informal Foundations of Power in New Democracies”, Cambridge/MA 2011

Transparency International. Political Integrity Lacking in Latin America and the Caribbean, Especially around Elections. 2019

АНУ-ын эрүүгийн болон эрүүгийн процессын хуулийн 29-р бүлэг - Сонгууль болон улс төрийн үйл ажиллагаа хэмээх 18-р заалт

Бүгд Найрамдах Чех улсын 2009 оны эрүүгийн хуулийн 351-р хэсэг “Бэлтгэл үеийн саад ба сонгуулийн явц болон референдум” гэсэн гарчигтай.

ХБНГУ-ын эрүүгийн хуулийн 108-р зүйлийн е хэсэг. 1998 онд батлагдаж 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон.

Япон улсын 1950 онд баталсан Олон нийтийг хамруулсан сонгуулийн тухай хууль, 2011 онд 35 дугаар шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт орсон.

МОНГОЛ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН КВОТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Д.Ундрах

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Б.Болорчимэг

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн байдал, хуульчилсан квотын хэрэгжилтийг судлахын сацуу квотын механизмыг нутагшуулах талаар зарим саналыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үгс: жендер, Монголын эмэгтэйчүүд, улс төрийн оролцоо, квотын арга

Удиртгал

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж “хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн зарлан тунхагласнаас хойш 8 удаагийн төрийн эрх барих дээд байгууллагын сонгуульд ард нийтээрээ оролцлоо.¹ Ардчилсан тогтолцоо руу шилжих үйл явц өрнөж эхлэсэн он жилүүдэд олон намын тогтолцоо бий болж, иргэний нийгмийн дуу хоолой бэхжиж төрийн бус байгууллагууд тэр дундаа эмэгтэйчүүдийн санаачлагатай ТББ-ууд олноор төрөн гарч эмэгтэйчүүд иргэний эрх, улс төрийн эрх, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг дуугарч тэмцэж эхэлсэн. Гэвч шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо төдийлөн

¹ Монгол Улсын Үндсэн Хууль. 1992.УБ

хангалттай төвшинд хүрч чадахгүй байгаа энэ үед Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог квотоор хангах механизм, түүний хэрэгжилтийн өнөөгийн байдлыг тодруулан гаргахыг энэхүү судалгааны ажлын хүрээнд зорьлоо.

Квотын механизм

Улс төрд идэвхтэй оролцож байгаа эмэгтэйчүүдийн тооны өсөлт ихээхэн удаан байгаатай холбоотойгоор, улс төрд тэдний тэнцвэрийг хангахаар олон төрлийн арга хэмжээг авдаг. Үүний нэг нь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх квотын системийн механизм бөгөөд квотоор дамжуулан тэдний оролцоог баталгаажуулснаар дэлхийн хэмжээнд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл аажмаар нэмэгдэж байгаа билээ.

Квот нь анх улс орнуудын дотоодод эрэгтэй, эмэгтэй хүмүүс шийдвэр гаргах түвшинд тэгш эрхтэй оролцох зарчим дээр нэгдсэнээс үүдэлтэй. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966) , Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ийн конвенц (1979), Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1946) мөн НҮБ-ын дэлхийн эмэгтэйчүүдийн 4-р их хурлын “Бээжингийн үйл ажиллагааны төлөвлөгөө” (1995) зэрэг олон улсын гэрээ конвенц, тунхаг баримт бичгүүдээр “ардчилал, түүний зөв зохистой хэрэгжилтэнд” эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн шийдвэр гаргах түвшинд тэгш оролцох боломжийг хангах тусгай арга хэмжээ авахыг засгийн газруудад уриалснаар квотын систем хэрэгжих гараагаа эхэлсэн байна.

Засгийн газар, парламент болон орон нутгийн зөвлөл гэх зэрэг сонгогдох болон томилогдон ажилладаг байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд квотын гол зорилго оршино. Өргөн хэрэглэгддэг квотын гурван гол төрөл байдаг ба эдгээр нь *хуульчилсан*, *суудал хадгалах* болон *намын квот* юм².

Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо ба квотын өнөөгийн байдал

Монгол улсад 1921 онд Ардын хувьсгал ялж, 1924 онд БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийг батлахдаа эмэгтэйчүүдийн сонгох сонгогдох эрхийг баталгаажуулсан байдаг. Тус Анхдугаар Үндсэн Хуулийн Нэгдүгээр бүлэгт Монголын жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь хэмээгээд тус бүлгийн

² Krook M. L. 2009. Quotas for Women in Politics: Gender and Candidate Selection Reform Worldwide, 3-35. Oxford University Press

арван нэгдүгээр зүйлд :“Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино”гэж заасан байна.³ Ийнхүү эмэгтэйчүүдийн эрх, сонгох сонгогдох эрх БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулиар анх баталгаажсанаас хойш 1940, 1960 оны Үндсэн хуулиудаар дахин баталгаажиж иржээ. 1960-1980 оны хооронд эмэгтэйчүүд нийгэмд эзлэх тодорхой байр суурьтай, нийгмийн идэвхтэй гишүүн байж, төрийн захиргааны болон улс төрийн удирдах ажил тодорхой хэмжээнд хийж байсан байна.⁴ Мөн 1924 онд МАХН-тай хамт Монголын Эмэгтэйчүүдийн холбоо байгуулагдаж, төсвөөс санхүүжиж байжээ. Тухайн үед социалист үзэл суртлын нөлөө хүчтэй байсан тул бүх нийтийн тэгш эрхийг тунхаглахын сацуу эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний төлөөллийн квотыг 25% хүргэх бодлого хэрэгжиж байжээ. Үүний үр дүнд Ардын Бага хуралд 1931 онд сонгогдсон депутатуудын 30% нь эмэгтэйчүүд байсан түүх байна. Хэдий эмэгтэйчүүд тодорхой хэмжээний байр сууринд хүрсэн боловч, улс төр, ялангуяа шийдвэр гаргах түвшний бүх албан тушаалд зөвхөн эрчүүд томилогддог байв.⁵

Монголд социалист тогтолцоо нуран унаж, ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэн шилжилтийн он жилүүдийн эхэнд 1992 оны анхны Үндсэн хууль батлагдаж эмэгтэйчүүдийн сонгох сонгогдох эрх хадгалагдан үлдсэн хэдий ч шилжилтийн өмнөх үеийн 23%-иас 1992 оны анхны УИХ-д эмэгтэй гишүүдийн эзлэх хувь ердөө 3.9%⁶ болтлоо буурчээ.⁷

Хэдий тийм боловч Монгол оронд өрнөсөн улс төрийн үйл явцад эмэгтэйчүүд идэвхитэй оролцсоор байсан бөгөөд иргэний нийгмийн дуу хоолой болох анхны ТББ-ууд 1990-ээд оноос байгуулагдаж эмэгтэйчүүдийн үндсэн эрх, улс төрийн эрх, оролцоог дээшлүүлэхэд анхаарлаа хандуулж үйл ажиллагаагаа чиглүүлэх болжээ.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, квотын тухай ярих үед квотыг нэвтрүүлэхэд оролцдог гурван гол тоглогч болох *иргэний нийгмийн байгууллага, улс төрийн элитүүд, олон улсын байгууллагын* аль аль нь Монголд нөлөөллөө үзүүлсэний дүнд квотыг хэрэгжүүлэх үндсэн 4 хэрэгцээ шаардлагын нэг болох

³ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Анхдугаар Үндсэн Хууль. 2007.УБ

⁴ Alan J. K. Sanders. 2017 Historical Dictionary of Mongolia. 882-889. Boulder: Vol II. (Fourth Edition)

⁵ United Nations Development Fund for Women: Country Report. 2001. Country Report. 53-63. New-York-UN

⁶ Одгэрэл Б., 2014. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд Монголын эмэгтэйчүүдийн оролцоо: төлөв байдал, чиг хандлага харьцуулсан шинжилгээ). УБ

⁷ United Nations Development Fund for Women: Country Report. 2001. Country Report. 53-63. New-York-UN

эмэгтэйчүүд улс төрийн оролцоогоо нэмэгдүүлэхийн тулд дотоодын ТББ-ууд олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах байдлаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлж эхэлсэн байна. Монголын эмэгтэйчүүдийн хувьд 1995 онд зохион байгуулагдсан Дэлхийн Эмэгтэйчүүдийн олон улсын дөрөвдүгээр бага хурлын дараагаар Бээжингийн тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаж, үүнд 189 орон гишүүнээр элссэн үйл явдлын нөлөө их байв. Дэлхийн Эмэгтэйчүүдийн олон улсын дөрөвдүгээр бага хуралд оролцсон нь дэлхий нийтийн хэм хэмжээ, үзэл баримтлал, шинэ дэвшилтэт үзэл санааг Монголдоо нэвтрүүлэх сэдлийг хүчтэй төрүүлсэн байна. Энэ хурлын дараа анхны ТББ-уудын эвсэл, холбоодын зүгээс 1996 оны сонгуулийн өмнө квотыг нэвтрүүлэх нь эмэгтэйчүүдийн манлайллыг шийдвэр гаргах түвшинд гаргахад нөлөөлөх гол хүчин зүйл хэмээн санал тавьж ⁸ улс төрийн намуудад эмэгтэйчүүдийн төлөөллийн квот тогтоох саналыг дэвшүүлж, улс төрийн намууд болон сонгогчдод хандан эмэгтэйчүүдийг сонгуульд олноор нэр дэвшүүлэх уриалга гаргажээ. Эдгээр үйл ажиллагааны дүнд 1996 мөн 2000 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшиж сонгогдсон эмэгтэйчүүдийн тоог 1992 оныхтой харьцуулахад бараг 10.5% болж өссөн байна. Мөн иргэний нийгмийн дуу хоолой улам идэвхжих болж 1990 оны сүүл гэхэд 30 гаруй эмэгтэйчүүдийн ТББ бүртгэгдсэн байдаг байна.

Хүснэгт 1. Эмэгтэйчүүдийн улс төрийн шийдвэр гаргах түвшинд эзлэх байр суурь, 1997 он

	Нийт	Эмэгтэй
Монгол улсын ерөнхийлөгч	1	0
Улсын Их Хурлын Дарга	1	0
Улсын Их Хурлын Дэд Дарга	1	0
Ерөнхий Сайд	1	0
Улсын Их Хурлын Гишүүд	76	8
Засгийн газрын гишүүд	9	1
Төрийн нарийн бичгийн дарга нар	9	0
Элчин сайдууд	22	0

Эх сурвалж: United Nations Development Fund for Women: Country Report. 2001

⁸ Tsetsejgargal Ts. Women's NGO in Mongolia and their role in Democratization, VNU Journal of Social Sciences and Humanities 28, No.5E (2012)1-12

1990-ээд оны сүүл үед олон эмэгтэйчүүд төрийн дээд шатны байгууллагуудад ажиллах болсон ч шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл харьцангуй бага хэвээр байсан юм.

Монголд квот нэвтэрсэн хууль эрх зүйн орчин хэрхэн бүрэлдсэнийг тоймловол, бидний судалгааны гол сэдэв болох квотыг Монголд нэвтрүүлэх эхэн үеийн тоглогч нь эмэгтэйчүүдийн хөдөлгөөн болох ТББ-аас эхэлж энэ нь улмаар өргөжиж “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т 2000 он гэхэд төр засгийн, төв орон нутгийн сонгуульт ба томилолтын удирдах дээд албанд эмэгтэйчүүдийн төлөөллийг 20-иос доошгүй хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн ч тухайн үеийн хууль тогтоомж, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх механизм, чадавхи дутмаг байснаас шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөлд төдийлөн өөрчлөлт гараагүй байна. Мөн 2000 оны сонгуулийн өмнө эмэгтэйчүүдийн ТББ-ын эвсэл нэгдлээс улс төрийн намуудад илүү олон эмэгтэйчүүдийг сонгуульд нэр дэвшүүлэхийг уриалж байсан юм. Учир нь 1992-1996 оны сонгуулиар сонгогдсон 3 эмэгтэй гишүүдийн төлөөлөл хангалттай байгаагүйгээс гадна тэдний үзүүлэх нөлөө харьцангуй бага байсан юм. Тухайн үед эмэгтэйчүүдийг зайлшгүй шийдвэр гаргах түвшинд оролцуулах ёстой гэхээсээ илүү хүйсийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлэх, нийгмээс эмэгтэйчүүдийн хүртэх ашгийг нэмэгдүүлэх тал дээр илүү анхаарч байсан цаг үе байв. Мөн энэ үед сонгогчдын хандлага намыг сонгох байснаас үүдэлтэй нэр дэвшигчийн жагсаалтанд эмэгтэйчүүдийг оруулах нь тун төвөгтэй байсан юм.⁹

Монголд улс төрийн квотыг нэвтрүүлэх замаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хангах нийгмийн захиалга аяндаа бий болсон гэж нэг талаар үзэж болох юм. Учир нь ардчилсан тогтолцоонд шилжих, зах зээлийн эдийн засагт дасан зохицох, ажил орлоготой байх, хувь хүн өөрөө өөрийгөө хариуцах шаардлага тулгарахын цагт нийгмийн стресс, бухимдал, архидалт дээд цэгтээ хүрч хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл маш өндөр хувьд хүрсэн. Иймд жендерийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлэх, хууль тогтоомжуудыг шинэчлэх бодит шаардлага тулгарсан. Улмаар эмэгтэйчүүдийн ТББ-дын зүгээс багагүй хүчин чармайлт гаргаж Шинэ Үндсэн хуулийн үзэл санааны дагуу хууль тогтоомжуудийг шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд жендерээр

⁹ United Nations Development Fund for Women: Country Report. 2001. Country Report. 53-63. New-York-UN

ялгаварласан хууль тогтоомжийг хянаж нягтлан, нэмэлт өөрчлөлт оруулж, эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн үйлдлийг “хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг эрүүгийн гэмт хэрэг”-т тооцон эрүүгийн ял хүлээлгэх агуулга бүхий заалтуудыг шинэчлэн найруулж Эрүүгийн хуулинд оруулсан байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулинд хүүхэд асрах чөлөөг зөвхөн эхэд олгож байсныг эцэгт нь мөн адил олгож болох заалтыг 2003 онд нэмж оруулсан ажээ.

Цаашилбал, Засгийн Газраас 1996 онд баталсан “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг орчин үеийн хөгжлийн чиг хандлага болон бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн “Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” болгон өөрчилж 2002 онд Засгийн газрын 274 дүгээр тогтоолоор баталсан боловч эхний шат төдийлэн амжилттай болж чадаагүй нь хөрөнгө санхүүжилт, техникийн нөөц бололцоо, хариуцсан хувь хүн байгууллага байхгүй байсантай холбоотой байв.

Хожим 2006 оны нэгдүгээр сард Засгийн Газрын V тогтоолоор хоёрдугаар шатны буюу 2006-2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн стратегийг баталжээ. Мөн Жендерийн Тэгш байдлыг хангах Үндэсний Зөвлөлийг Жендерийн Тэгш Байдлыг Хангах Үндэсний Хороо болгон өргөжүүлж, хорооны даргаар Монгол Улсын Ерөнхий Сайд ажиллах болжээ. Тус хороо байнгын ажиллагаатай ажлын албатай болсон нь жендерийн асуудлыг хариуцсан үндэсний нэгж, механизмтай болсноороо маш том давуу талыг бий болгосон юм¹⁰.

Мөн Жендерийн Тэгш Байдлыг Хангах Үндэсний Хороо байгуулагдсаны дараа гарсан нэгэн томоохон дэвшил бол 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 28-р зүйлийн II заалт болох “Нам эвслээс нэр дэвшүүлэх” гэдэг хэсэгт: “...Нам эвслээс нэр дэвшигчийн 30-аас¹¹ доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна” гэсэн заалт оруулсан явдал юм. Сонгуулийн хуулинд оруулсан энэ заалт нь *хуульчилсан квот* бөгөөд аливаа улс орны хууль, Үндсэн хууль, сонгуулийн тухай хууль зэрэгт энэхүү квот тусгалаа олж байж цааш хөгждөг байна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх хүчин чармайлтын хүрээнд квотын системийг албан ёсоор Сонгуулийн хуулиндаа тусгасан нь Монгол улсын хувьд ардчиллаа бэхжүүлэх, жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн

¹⁰ Цэцэгжаргал Ц., 2009. XX зууны Монголын эмэгтэйчүүд XX зуунд хувьсал, өөрчлөлт. УБ

¹¹ Монгол Улсын УИХ-ын Сонгуулийн тухай хууль. 2005. УБ

нэгэн томоохон алхам байсан бөгөөд квотын хувьд хуульчлагдсан нь томоохон амжилт болсон юм.


Гэвч төд удалгүй энэхүү дэвшилд маш том ухралтыг авчирсан үйл явдал болсон. Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал, оролцоог улс төрийн элитүүд болсон намын лидерүүд тийм ч их дэмжихгүй байсны уршигаар 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн УИХ-ын сонгуулийн тухай хуулиар өмнө дурдсан “Нам, эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна” гэсэн заалтыг хүчингүй болгожээ. Энэ өөрчлөлтийг дагаад Монгол улсын гадаад нэр хүнд ардчилсан орнуудын хувьд ардчиллаас ухралт хийсэн гэдэг нэр хочийг ихээхэн дагуулах болсон¹². Үүгээр ч зогсохгүй нь Монгол улсын төр “Мянганы хөгжлийн зорилт”, “Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль” зэрэг хуулиудын зорилтоос буцсан, бүхэлдээ эрх тэгш байдлыг хангах ардчилсан зарчмаасаа ухарсан алхам болсон юм.



Сонгуулийн хуулийн энэ өөрчлөлтөөс улбаалаад Монгол улс ардчиллын түүхэндээ ухралт хийсэн орны тоонд багтах болсон төдийгүй 2008 оны парламентийн сонгуулийн үр дүнд 3 эмэгтэй гишүүн сонгогдсон нь дээрхийг мөн батлана.

¹² Otgoo Jargal. 2012. Mongolian Women's Participation in Politics. Available at <https://futurechallenges.org/local/mongolian-womens-participation-in-politics>

График 1. УИХ-д нэр дэвшсэн болон сонгогдсон байдал /хүйсээр/ 1992-2020




Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий Хороо

Хүснэгт 2. Эмэгтэйчүүдийн улс төрийн шийдвэр гаргах өндөр албан тушаалд эзлэх байр суурь (2021он)

	Нийт	Эмэгтэй
Монгол улсын ерөнхийлөгч	1	0
Улсын Их Хурлын Дарга	1	0
Улсын Их Хурлын Дэд Дарга	2	1
Ерөнхий Сайд	1	0
Улсын Их Хурлын Гишүүд	76	13
Засгийн газрын гишүүд	16	4
Төрийн нарийн бичгийн дарга нар	14	1
Аймаг, нийслэл засаг дарга нар	22	0
Элчин сайдууд	31	1

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо

График 2. Монгол Улсын Парламентад суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 1992-2020



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо

Дээрх ухралтаас хойш 2011 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 27-р зүйлийн “Нам эвслээс нэр дэвшүүлэх” гэдэг хэсгийн 27.2 дахь заалтанд “....20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна” гэсэн томъёоллыг оруулсан байна. Мөн 2019 оны 12 дугаар сарын 20-ний өдөр баталсан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн “Нам эвслээс нэр дэвшүүлэх” хэмээх заалтын 30.2-т “Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна” гэж хуульчилжээ. Улмаар Орон нутгийн Сонгуулийн тухай хуулинд мөн л 2020 оны 1 дугаар сарын 30-ний 29.2-р зүйлд “нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна” гэсэн заалт оруулжээ.

Эдгээр өөрчлөлтүүдийн дараах Монгол улсын “Жендерийн тэгш байдлын индекс” байнга ухарсан үзүүлэлттэй гарч байна. Тухайлбал, 2018 онд 149 орноос 58-р байранд байсан бол 2020 оны тайланд 153 орноос 79-р байранд оржээ¹³.

Дэлхийн хэмжээнд сүүлийн 30 жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн квотыг өөр өөрийн улс орондоо нэвтрүүлэн хэрэгжүүлэх үйл явц маш хүчтэй өрнөсөн бөгөөд 1989-2008 оны хооронд нийт 149 оронд квотын систем нэвтрээд байна.

Сүүлийн 15 жилийн дотор улс үндэстнүүдийн парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэхэд ихээхэн дэвшил гарсан. 1995 онд дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүд нийт парламентын гишүүдийн 11,3%-ийг эзэлж байсан бол 2005 онд

¹³ World Economic Forum.2020. 2021. The Global Gender Gap Report. Geneva: World Economic Forum

энэ тоо 16% болж өсчээ¹⁴. Харин 2021 оны байдлаар дэлхийн хэмжээнд хууль тогтоох байгууллагын 25.5%-ийг эмэгтэйчүүд эзлэх болсон байна. Дэлхийн хэмжээнд хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг бүсчлэн авч үзвэл Европын улс орнууд хамгийн өндөр буюу бүсийн хэмжээнд 44.5% үзүүлэлттэй тэргүүлж байна¹⁵.

Эмэгтэйчүүдийн квот нь улс төрийн шинжлэх ухаанд маш шинэлэг бөгөөд одоо хүртэл бүрэн судлагдаагүй судалгааны объект хэвээрээ байна. Квотыг яагаад хэрэгжүүлэх ёстой вэ? Квот шаардлагатай юу гэдэг хэлэлцүүлгүүд өрнөж, судлаачдын дунд хэлэлцүүлгийн халуун сэдэв болсоор байна¹⁶. Улс орнууд өөр өөрийн орны онцлог, хууль тогтоомж, улс төрийн тогтолцоо, сонгуулийн тогтолцоо зэргээсээ хамаарч квотын 3 төрөл болох хуульчилсан квот, намын квот, суудал хадгалах квотыг хэрэгжүүлж иржээ.

Монгол улсын хувьд хуульчилсан квотыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг боломжийн хэмжээнд бэхжүүлжээ. Хуульчилсан квотын угтвар нөхцөл болж иргэний нийгмийн байгууллагууд 1992 оноос бие даан үйл ажиллагаа явуулж эхлэн олон улсын байгууллага, улс төрийн элитүүдийн урт удаан хугацааны хамтын ажиллагааны үр дүнд анх 2005 оны 1 дүгээр сарын 28-нд шинэчлэн батлагдсан Монгол улсын улс төрийн намын тухай хууль нь “намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлдэг ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох” тухай зааж өгснөөр эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хууль эрх зүйн хүрээнд зохицуулж, улс төрийн амьдралд оролцох боломжийг нээж өгсөн томоохон хууль эрх зүйн баримт бичиг болсон байна. Энэ нь квотын хувьд институцийн түвшинд хэрэгжиж эхэлсэн хэрэг бөгөөд 2005 оны 12 дугаар сарын 29 онд батлагдсан Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулинд “нам, эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувьд эмэгтэйчүүд” байна гэсэн заалт оруулсан нь Монгол улсын хувьд хуульчилсан квот болсон юм.

¹⁴ Төгөлдөр Я., 2013. Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хөгжил, хандлага.УБ

¹⁵ Inter-Parliamentary Union. 2021. Women in Politics: New data shows growth but also setbacks available at <https://www.ipu.org/news/women-in-politics-2021>

¹⁶ Dahlerup, Drude and Freidenwall, Lenita. 2005. Quotas as a Fast Track to Equal representation for Women: Why Scandinavia is No Longer the Model. International Feminist Journal of Politics. Vol 38 no3 available at https://www.researchgate.net/publication/248994967_Quotas_as_a_Fast_Track_to_Equal_Representation_for_Women_Why_Scandinavia_Is_No_Longer_the_Model

Мөн 2005 оны УИХ-аас баталсан 25 дугаар тогтоолоор Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг баталж, 2015 он гэхэд улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог 30 хувь болгож нэмэгдүүлэх зорилт тавьж, үйл ажиллагааныхаа зарчим болгохыг зааж өгсөн байдаг. Мөн Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 2-р бүлэг 8 дугаар зүйлд: Улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдлын баталгаа гаргаж 8.3-р зүйлд, улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна гэж оруулж өгсөн байна.

Улмаар институцын түвшинд Монгол Улсын Засгийн Газар Жендерийн тэгш эрхийг хангах хууль батласантай холбогдуулан жендерийн эрх тэгш байдлыг хангах 2013-2016 оны стратегийг 2013 оны 1 дүгээр сарын 26-нд баталжээ. Цаашилбал Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016 оны 02 дугаар 05-нд баталж “нийгмийн хөгжил дэвшилд жендерийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх зорилт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэх)-ийг боловсруулж, 2017 оны Засгийн газрын 129-р тогтоолоор баталсан байна.

Дэлхийн улс орнуудад хуульчилсан квотоос гадна, намын сайн дурын квотыг ихээхэн хэрэгжүүлж буй практик байна. Намын сайн дурын квот гэдэг нь хуульчилсан квоттой харьцуулахад зайлшгүй Үндсэн хууль, Сонгуулийн хууль зэрэгт нэмэлт өөрчлөлт оруулалгүйгээр улс төрийн намууд сайн дурын үндсэн дээр дотоод дүрэм журамдаа квотыг нэвтрүүлж хэрэгжүүлэх боломжтойгоороо хялбар юм. Намууд квотыг хэрэгжүүлэхдээ өрсөлдөгчөө буулгаж авах, эсвэл улс төрийн нэр хүндээ эргүүлэн авах, сонгогчдын итгэл үнэмшилийг сэргээх, өрсөлдөгч нам нь квотыг хэрэгжүүлж эхэлбэл өрсөлдөж хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийн дэмжлэгийг авах замаар олон сонгогчидтой болох зэрэг стратегийн зорилгоор ихэвчлэн уг квотыг хэрэгжүүлдэг байна¹⁷. Монголд намын сайн дурын квотыг хэрэгжүүлэх оролдлогууд бага багаар гарч байна. Улс төрийн намуудаас Ардчилсан Намын дэргэдэх “Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо” нь удирдах байгууллагадаа 20 хувийн квот тогтоосон бөгөөд уг квотоор тус намын Үндэсний Зөвлөлдөх Хороонд 32 эмэгтэй гишүүн сонгогдох болжээ. Мөн УИХ-ын болон орон нутгийн

¹⁷Krook M. L.2009. Quotas for Women in Politics: Gender and Candidate Selection Reform Worldwide, 3-35. Oxford University Press

сонгуулиудад тодорхой тооны эмэгтэй нэр дэвшигчид оролцож ирсэн Монгол Ардын Хувьсгалт Намын дэргэд “Монголын ардчилсан социалист эмэгтэйчүүдийн холбоо” үйл ажиллагаа явуулдаг. Тус холбооноос 2005 оны зургадугаар сард хуралдсан МАХН-ын XXIV Их хурлаар “Намын бүх шатны сонгуульт байгууллагад нэр дэвшигчдийн 25-иас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна” гэсэн заалтыг намын дүрмэнд оруулан батлуулжээ. Хөдөлмөрийн Үндэсний 2018 оны 3 дугаар сарын 25-ны ээлжит бус их хурлаар батлагдсан Намын дүрмийн 4-р бүлэгт намын удирдлага хэсэгт мөн тус намын их хурлын төлөөлөгчдийг сонгохдоо 30-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүн байх зарчмыг баримтална гэсэн заалт оруулсан байгаа юм¹⁸.

Суудал хадгалах квот нь хууль тогтоох байгууллагад төлөөлөл болох эмэгтэйчүүдэд зориулан тодорхой хэмжээний суудал шууд хуваарилан өгөхийг хэлнэ¹⁹. Үүнийг Үндсэн хуулиар болон өөр бусад хууль тогтоомжуудаар зохицуулдаг билээ. Суудал хадгалах квот өнөөгийн манай улс төрийн тогтолцоонд хараахан нэвтрээгүй байна.

Одоогоор дэлхийн улс орнуудын квот хэрэгжилтийн үр дүнг харвал 1997-2018 оны хооронд квоттой орнуудын парламент дах эмэгтэй төлөөлөл 12% байснаа даруй 2.1 дахин нэмэгдэж 25.5%-д хүрчээ.²⁰ “Мөн энэ хооронд 100 гаруй улс жендерийн квотыг нэвтрүүлсэн нь сүүлийн 30 жилд улс төрд гарсан маш том үйл явдал, хөгжил болж байна”²¹ гэж квотын судлаачид дүгнэсэн байна. Гэхдээ улс орнууд квотыг хэрэгжүүлэх бодит хөшүүрэг механизмыг мөн хуульчилдаг болохыг анхаарах нь зүйтэй. Монгол дах квотын хэрэгжилтийг дүгнэж үзвэл дараахь байдал ажиглагдаж байна.

1. Сонгуулийн тогтолцоо

Монгол улсад хуульчилсан квот үйлчилж байгаа ч сонгуулийн тогтолцоо нь квотыг хангах, дэмжих чиглэлд төдийлөн ээлтэй биш харагдаж байна. Тухайлбал, 1992 оны УИХ-ын олон мандаттай томсгосон тойргоор, 2000-2004 оны сонгууль 1

¹⁸ <http://www.hunnam.mn/>

¹⁹ Krook M. L. 2009. Quotas for Women in Politics: Gender and Candidate Selection Reform Worldwide, 3-35. Oxford University Press

²⁰ Inter-Parliamentary Union. 2021. Women in Politics: new data shows growth but also setbacks available at <https://www.ipu.org/news/women-in-politics-2021>


²¹ Hughes, M. M. and Krook, M. L. and Paxton, P. 2015. Transnational Women's Activism and Global Diffusion of Gender Quotas. International Studies Quarterly 59, 357-372

мандаттай 76 тойргоор явагдсан. Хуульчилсан квотыг 2005 оны Сонгуулийн тухай хуулинд тусгасан хэдий ч удаах сонгууль буюу 2008 оны сонгуулийг олон мандаттай томсгосон 26 тойргоор хийж 3 эмэгтэй гишүүн сонгогдсон нь нийт гишүүдийн 3.9%-тэй тэнцэх болсон. Харин 2012 оны сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулан зохион байгуулж нийт сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо 10-д хүрсэн нь (1 гишүүн сүүлд нэмэгдэж) 1992 оноос хойш байгаагүй амжилт юм. Мөн парламентын түүхэнд 1992 оноос хойш холимог хэлбэрээр хийсэн анхны сонгууль болж томсгосон мажоритар 26 тойргоос 48 нэр дэвшигч, 28 нэр дэвшигчийг намын жагсаалтад бичигдсэн дарааллаар пропорциональ хэлбэрээр сонгожээ. Холимог тогтолцоо нь олонхын дүрмээр суудал хуваарилахад үүссэн пропорциональ бус үр дүнг хувь тэнцүүлэх замаар залруулдаг. Удаах 2016 оны сонгуулийг 1 мандаттай 76 тойргоор, 2020 оны сонгуулийг 2-3 мандаттай томсгосон 29 тойргоор тус тус зохион байгуулсан.

Ийнхүү УИХ-ын сонгуулийг нийт 8 удаа зохион байгуулсан боловч квотын хууль батлагдсанаас хойш ердөө цор ганц удаа холимог хувь тэнцүүлэх байдлаар сонгууль явуулснаас бусад цаг хугацаанд байнга мажоритар 1 мандаттай, эсвэл томсгосон олон мандаттай тогтолцоог ашиглаж сонгууль явуулсаар байгаагийн үр дүнд МАН эсвэл АН гэсэн 2 намын хооронд улс төрийн гол өрсөлдөөн явагдаж дээрх намууд бараг энэ тоглоомын дүрэмдээ хэт дадлагажаад байгаа мэт дүр зураг харагдаж байна. Транспаренси Интэрнэшнл байгууллагын 2017 оны авлигын төсөөллийн индекст Монгол Улс 180 орноос 103-т жагссан байх ба 0 (авлига их)-ээс 100 (авлига бага) оноо авахаас 30 оноо авчээ²². Учир нь намууд Азийн сангаас 2010 онд хийсэн судалгаагаар авлигад өртсөн байдлаараа 16 байгууллагын 5-рт жагссан байдаг бол 7 жилийн дараа 2-рт жагсах болжээ. Гэтэл хуульчилсан квотыг хэрэгжүүлж буй ихэнхи орнууд сонгуулиа пропорционал тогтолцоогоор зохион байгуулж мөн нэр дэвшигчийн хаалттай жагсаалтыг ашигладаг байна.

График 3. Дэлхий дахин дахь сонгуулийн тогтолцоо ба эмэгтэйчүүдийн төлөөлөл

²² Ардчилал ба Сонгуулийн Тусалцааны Хүрээлэн.ба, Нээлттэй Нийгэм Форум.2018.Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин. УБ



Дээрх графикт үзүүлсэнчлэн судлаач П.Норрисын судалгаагаар парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн дундаж нь 2005 оны байдлаар:

- Сонгуулийн мажоритар тогтолцоотой 72 улсад 10.5%,
- Холимог тогтолцоотой 36 улсад 13.6%,
- Пропорционал тогтолцоотой 67 улсад 19.6% байна.

Тэр дундаа олон мандаттай том тойргийн (Block vote) тогтолцоотой 10 улсад эмэгтэйчүүдийн төлөөллийн дундаж 7.4% байжээ²³.

2. Нэр дэвших үйл явц

Монгол улсын сонгуулийн тогтолцоо нь өөрөө квотыг хэрэгжүүлэх талд үйлчлэх байдал нь тун сул байгаа тухай дээр дурьдсан. Гэвч холимог тогтолцоогоор зохион байгуулсан 2012 оны сонгуулиар намуудын нэр дэвшигчийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг эрэмбэлэх дүрэм үйлчилдэггүйн сацуу нэр дэвших үйл явц нам дотор хэрхэн зохион байгуулагддаг тухайд тодорхой зохицуулалт байхгүй, эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийн эдийн засгийн чадавхи ихээхэн нөлөөтэй байгаа нь харагдаж байна.

Тэгвэл олон улсад нэр дэвшүүлэх үйл явцад тогтсон тодорхой дүрэм журам ашигладаг. Тухайлбал, нэр дэвшигчийн жагсаалтанд босоо болон хэвтээ эрэмбэлэх дүрмийг ашиглана. Босоо эрэмбэлэх дүрмээс тодруулбал:

1. “Судалт тахь буюу зиг заг хувилбар”-нэр дэвшигчийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг сөөлжилж бичнэ. Энэ аргыг ногоон нам болон

²³ <https://ikon.mn/opinion/1v0l> Э.Гэрэлт-Од, Д.Бямбажав, 2020.04.23

социал демократ чигийн намууд их ашигладаг. (Боливи, Коста Рика, Эквадор, Франц, Кения, БНСУ, Лесото, Ливи, Никарагуа, Сенегал, Тунис, Зимбабве)

2. Жагсаалтын эхний 2 нэр дэвшигч ижилхэн хүйстэй байж болохгүй (Бельги)
3. Нэр дэвшигчийн жагсаалтын дарааллын 5 хүн тутамд 40:60 харьцааг баримтлах (Испани)
4. Гурван нэр дэвшигч бүрийн 1 нь эмэгтэй байх (Аргентин, Индонези, Серби, Тимор-Лесте)²⁴ гэх мэт.

Гэтэл одоогоор манайд энэ эрэмбийн дүрэм огт байхгүй байгаагаас гадна намуудын санхүүжилт ихээхэн далд хэлбэртэй, үүнээс улбаалаад эмэгтэйчүүд улс төрд тэгш нөхцөлөөр оролцож өрсөлдөх боломж хязгаарлагдмал байгаа явдал юм. Сонгуульд нэр дэвшихийн тулд эмэгтэйчүүд, залуучууд янз бүрийн бэрхшээлтэй тулгардаг ба түүний дотор эдийн засгийн нөөц боломж хомс байдаг нь гол бэрхшээл болж байна. Одоогийн УИХ-ын 76 гишүүдийн 13 нь эмэгтэй гишүүн байгаа ба манай улс эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоогоор дэлхийн 144 орноос 107-д жагсаж байна. Улс төрийн намын тухай хуульд жендерийн тэгш байдлын зарчмыг баталгаажуулсны зэрэгцээ насаар ялгаварлахгүй, адил тэгш боломж олгох тухай тусгасан байдаг. Түүнчлэн нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20- иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна (СТХ-ийн 126.2 дахь хэсэг) гэсэн хуулийн заалт байвч, сүүлийн сонгуулиудын жишээнээс харахад намууд жендерийн квотыг зөрчөөгүй боловч эмэгтэй нэр дэвшигчдийг сонгогдох магадлал багатай тойргуудад өрсөлдүүлсэн нь бодит байдалд жендерийн тэгш байдлыг хангах улс төрийн хүсэл зориг дутаж буйн илрэл болно²⁵.

3.Квотыг хэрэгжүүлээгүй нөхцөлд авах хориг арга хэмжээ

Монгол улсад аливаа улс төрийн намын хувьд квотыг хэрэгжүүлээгүй нөхцөлд авах хариуцлага, хориг арга хэмжээ одоогоор тодорхой төлөвшөөгүй байна. Одоогоор олон улсад квотыг хэрэгжүүлээгүй тохиолдолд: (1) нэр дэвшигчдийн жагсаалтыг сонгуулийн менежментийг хариуцдаг нэгж хүлээн авахгүй байх, (2) санхүүгийн торгууль ногдуулах ба урамшуулал олгох гэсэн хоёр механизмыг хэрэгжүүлж байна²⁶.

²⁴Inter-Parliamentary Union. 2014. Atlas of Electoral Gender Quotas. Geneva: Inter-Parliamentary Union

²⁵ <https://www.idea.int/sites/default/files/publications/political-finance-in-mongolia-MN.pdf>

²⁶ Inter-Parliamentary Union. 2014. Atlas of Electoral Gender Quotas. Geneva: Inter-Parliamentary Union

Харин манай улсын хувьд УИХ-ын сонгуулийн тухай хуулинд квот хангаагүй нөхцөлд авах арга хэмжээний тухай заалт үгүйгээс гадна ерөнхий татгалзах үндэслэлүүдийг оруулсан байна. Үүнд:

- 33.1.1. Энэ хуульд заасан хугацаанд нэр дэвшүүлэх ажиллагааг явуулаагүй;
- 33.1.2. Энэ хуульд заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;
- 33.1.3. Өөр намын гишүүнийг нэр дэвшүүлсэн зэрэг заалтаар хязгаарлагджээ.

ДҮГНЭЛТ

Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог квотын механизмаар хангах бодлого, үйл явцын хэрэгжилтэд хийсэн судалгааны явцад Монгол Улс нь квотыг нэвтрүүлэх тал дээр хууль эрх зүйн орчин хангалттай бүрдсэн боловч квотыг хэрэгжүүлэх зохицуулалт дутагдалтай байгаа нь харагдаж байна. Улмаар хуульчилсан квотыг 2005 оноос эхлэн нэвтрүүлсэн ч дэлхийн зорилтот парламентын гишүүдийн 30% эмэгтэй гишүүдээр бүрдүүлэх гэсэн үзүүлэлтээс харьцангуй хоцрогдолтой төдийгүй уг үзүүлэлтээр 2021 оны Азийн орнуудын дундаж төлөөллийн хувь болох 20.4%-д ч хүрээгүй байна.

Квот нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн хэдий ч квотыг хэрэгжүүлэх хөшүүрэг механизмууд байхгүй. Батлагдсан хууль эрх зүйн бичиг баримтуудыг харахад чамгүй урт жагсаалт гарах хэдий ч Монгол Улсад хэрэгжүүлж буй квотын цаана дүр эсгэх сэдэл (*empty gestures*) байгааг нотлоход хялбар байна. Аливаа хуулийг хэрэгжүүлэхэд дагалдах хуулиуд батлагдаж, хэрэгжүүлэх механизмуудыг тодорхой байх шаардлагатай байдаг. Монгол улсын хувьд хэдийгээр хуульчилсан квоттой боловч Улсын их хурлын сонгуулийн тухай хуулинд улс төрийн намаас нэр дэвшүүлэх эмэгтэй нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтыг эрэмбэлэх заалт, нэр дэвшигчийг бүртгэх, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэлд квотын тухай зүйл заалт байхгүй, квотыг хэрэгжүүлээгүй тохиолдолд авах хориг арга хэмжээний тухай зохицуулалт байхгүй, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах заалтанд дурьдагдаагүй байна.

Монголд улс төрийн намын санхүүжилт далд байдаг тухай Транспаренси Интэрнэшнл байгууллагын 2017 оны авлигын төсөөллийн индекст дурьдсанчлан намуудын санхүүжилт жендерийн квотын хэрэгжилтэнд ч саад бэрхшээл учруулж

байна. Иймээс улс төрийн намын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар намуудын санхүүжилтийг ил тод болгох суурь механизмыг төлөвшүүлэх шаардлагатай байна.

Сонгуулийн тогтолцоог өөрчлөх, квотыг хэрэгжүүлэх болон бусад улс төрийн намуудын төлөөллийг хангах пропорциональ тогтолцоог цаашид нэвтрүүлэх бодит шаардлага бий болжээ. Энэ чиглэлд Сонгуулийн Ерөнхий Хороо аливаа нам эвслээс ангид ажиллах чиг үүрэг бүхий байгууллагын хувьд квотыг хариуцсан нэгж байгуулан ажиллаж сонгуулийн үед квотын хэрэгжилтийг хангах, хориг арга хэмжээ авах, мөн урамшуулал, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх боломж харагдаж байна.

Улс төрийн нам, улс төрийн элитийн түвшинд, мөн эмэгтэйчүүдийн байгууллагуудад хандсан квотыг тойрсон эрдэм шинжилгээ, судалгаа, ухуулан таниулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, иргэний нийгмийн идэвхитэй дуу хоолойг бэхжүүлэх шаардлага тулгамдаж байгааг тэмдэглэн хэлэх байна.

НОМ ЗҮЙ

Монгол Улсын Үндсэн Хууль. 1992.УБ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Анхдугаар Үндсэн Хууль. 2007.УБ

Цэцэгжаргал Ц., 2009. XX зууны Монголын эмэгтэйчүүд XX зуунд хувьсал, өөрчлөлт. УБ

Монгол Улсын УИХ-ын Сонгуулийн тухай хууль. 2005. УБ

Ардчилал ба Сонгуулийн Туслалцааны Хүрээлэн.ба, Нээлттэй Нийгэм Форум.,2018. Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин. УБ

Одгэрэл Б., 2014.Улс төрийн шийдвэр гаргах түвшинд Монголын эмэгтэйчүүдийн оролцоо: төлөв байдал, чиг хандлага харьцуулсан шинжилгээ). УБ

Төгөлдөр Я.,2013. Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хөгжил, хандлага. УБ

Krook M. L.2009. Quotas for Women in Politics: Gender and Candidate Selection Reform Worldwide, 3-35. Oxford University Press

Alan J. K. Sanders. 2017 Historical Dictionary of Mongolia. 882-889. Boulder: Vol II. (Fourth Edition)

United Nations Development Fund for Women: Country Report. 2001. Country Report. 53-63. New-York-UN

- Tsetsegjargal Ts. Women's NGO in Mongolia and their role in Democratization, VNU Journal of Social Sciences and Humanities 28, No.5E (2012)1-12
- World Economic Forum.2020. 2021. The Global Gender Gap Report. Geneva: World Economic Forum
- Inter-Parliamentary Union. 2021. Women in Politics: New data shows growth but also setbacks available at <https://www.ipu.org/news/women-in-politics-2021>
- Dahlerup, Drude and Freidenwall, Lenita. 2005. Quotas as a Fast Track to Equal representation for Women: Why Scandinavia is No Longer the Model.International Feminist Journal of Politics. Vol 38 no3 available at https://www.researchgate.net/publication/248994967_Quotas_as_a_Fast_Track_to_Equal_Representation_for_Women_Why_Scandinavia_Is_No_Longer_the_Model
- Inter-Parliamentary Union. 2021. Women in Politics: new data shows growth but also setbacks available at
- Hughes, M. M. and Krook, M. L. and Paxton, P. 2015. Transnational Women's Activism and Global Diffusion of Gender Quotas. International Studies Quarterly 59, 357-372
- Inter-Parliamentary Union. 2014. Atlas of Electoral Gender Quotas. Geneva: Inter-Parliamentary Union
- <http://www.hunnam.mn/>
- <https://ikon.mn/opinion/1v0l> Э.Гэрэлт-Од, Д.Бямбажав , 2020.04.23
- <https://www.ipu.org/news/women-in-politics-2021>
- Otgoo Jargal. 2012. Mongolian Women's Participation in Politics. Available at <https://futurechallenges.org/local/mongolian-womens-participation-in-politics>
- https://www.researchgate.net/publication/248994967_Quotas_as_a_Fast_Track_to_Equal_Representation_for_Women_Why_Scandinavia_Is_No_Longer_the_Model
- <https://www.ipu.org/news/women-in-politics-2021>

**МОНГОЛ УЛС БА БНСУ-ЫН ГАДААД БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРГАХ
ҮЙЛ ЯВЦ: ХАРЬЦУУЛСАН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Т. Заяа
Хүмүүнлэгийн Их Сургууль,
Олон улсын харилцаа, нийгэм судлалын тэнхимийн багш

Хураангуй

Энэхүү өгүүллийн гол зорилго нь Монгол Улс болон БНСУ-ын гадаад бодлогын асуудлыг зохицуулсан тус тусын Үндсэн хуулийн зохицуулалтыг харьцуулан судлахад оршино. Ийнхүү харьцуулахдаа хоёр улсын эртний түүх, соёл, уламжлал, газар зүйн, геополитикийн байршил, засаглалын хэлбэр, гадаад бодлогын зорилт, түүний чиглэл, гадаад бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх субъектуудын хоорондын ялгаа, ижил төсөөтэй зүйл, үүний учир шалтгааныг тухайлан авч үзсэн болно.

Түлхүүр үг: Үндсэн хууль, дотоод бодлого, гадаад бодлого, шийдвэр гаргалт, засаглал

Удиртгал

Монгол Улс, БНСУ-ын хувьд урт удаан түүхэн харилцаатай бөгөөд МЭ 400 онд Нирун, Гурё улсууд анх дипломат харилцаа тогтоосноор хоёр улсын харилцааны эхлэл тавигдсан гэж үздэг.

Монгол, Солонгосын харилцаа нь эдгээр хоёр үндэстэн арьс өнгө, хэл, түүх, соёл, бөө мөргөл, шашны нийтлэг угсаа гарвалаар холбогддог гэсэн нийтлэг үзэл дээр үндэслэгддэг. XIII-XIV зууны үед Гурё гүрэн Их Монгол Улсад алба барьж, хоёр улс ойр дотны харилцаатай байсан¹. Солонгосын түүхэнд 31 дэх хаан болох

¹ “Монгол, Солонгосын түүх болон Зүүн Хойд Азийн хамтын ажиллагаа” ОУЭШХ-ын үеэр Элчин сайд Жон Жэ Намын илтгэл (2019.07.05); http://overseas.mofa.go.kr/mn-mn/brd/m_297/view.do?seq=761265

Гоу Мин 19 насандаа Монгол нутгаас хатнаа сонгож байсан зэрэг түүхэн олон баримт байдаг. Хоёр улс найрамдлын гэрээ байгуулж, хоёр талын худалдааг дэмжиж байсан түүх ч бий. Мөн Солонгос хүн төрөхдөө нуруун дээрээ хөх толботой төрдөг. Гурё, Жусоны гэрлэх заншилд Монголын нөлөө ихээр үлдсэн зэрэг нь хоёр улс түүх, соёлын нягт холбоотой байсныг гэрчилнэ.

Энэхүү хамтын ажиллагаа нь Манжийн үед, дараа нь Монголын түүхэн дэх коммунист засаглалын үед тасалдахад хүрсэн. Монгол Улс, БНСУ 1990 оны 3 дугаар сарын 26-нд дипломат харилцаа тогтоов. Энэ бол 31 жилийн тэртээ болсон Монголын ардчилсан хувьсгалын ач байлаа. Тэр үеэс хойш Монгол, Солонгосын хоёр талын харилцаа хоёр ард түмний ашиг сонирхлын тусын тулд эрчимтэй хөгжиж ирсэн.

Ялангуяа сүүлийн жилүүдэд Монгол Улс, Өмнөд Солонгостой харилцах харилцаа улам өргөжиж, цар хүрээний хувьд улам гүнзгийрч, одоо Монгол Улсын "гуравдагч хөрш" стратегийн шийдвэрлэх хэсэг болж байгаа. БНСУ-тай “найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримтлах”² нь МУ-ын төрийн гадаад бодлогын чухал чиглэлийн нэг байдаг.

Эдүгээ Монгол Улс, БНСУ-ын харилцаа “Иж бүрэн түншлэл”-ийн түвшинд улс төр, эдийн засаг, хэл, соёл, хүмүүнлэг, аялал жуулчлал, бизнес, хөрөнгө оруулалт зэрэг бүхий л салбарт өргөжин хөгжиж байна. 2020 онд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг өргөнөөр тэмдэглэн өнгөрүүлэв³.

Судалгааны арга зүйн хувьд харьцуулалтын аргыг ашигласан болно. Ингэхдээ түүх, соёл, газар зүй, геополитик, засаглалын хэлбэр зэргийг харгалзан үзсэн болно. Түүнчлэн хоёр улс нь адилхан ардчилсан дэглэмтэй улсууд бөгөөд БНСУ нь дарангуйллын дэглэмээс ангижирч, ардчилсан улс болсон байдаг бол Монгол Улс коммунист засаглалаас хөгжиж эхэлж буй ардчилалд шилжсэн байдаг.

Мөн геополитикийн хувьд хоёр улс Зүүн хойд азийн бүс нутагт харьяалагддаг. Монгол Улс ОХУ, БНХАУ гэсэн хоёр том цөмийн гүрэнтэй хөрш зэргэлдээ оршдог. Үүний зэрэгцээ БНСУ нь БНАСАУ-аас цөмийн аюул

² МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал (2011) 14.2-р зүйл

³ МУ-ын ЗГ, БНСУ-ын ЗГ хоорондын хамтын ажиллагаа; <https://mof.gov.mn/article/entry/Korea>

заналхийлдэг бүс болох Солонгосын хойгт байрладаг зэрэг нь дээрх хоёр улсын гадаад бодлого, гадаад бодлогын шийдвэр гаргах механизмдыг судлах үндэс болсон.

Монгол Улс, БНСУ-ын гадаад бодлого

Монгол Улс үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдал, геополитикийн байршил, бусад зайлшгүй шаардлагын улмаас “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт нь байдаг ба тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх, чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах нь нэн чухал юм” хэмээн Гадаад бодлогын үзэл баримтлалдаа тодорхой зааж өгсөн байдаг⁴. Харин МУ-ын Үндсэн хуулийн 10-р зүйлд: “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”, “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн зааж өгсөн нь БНСУ-ын Үндсэн хуулийн дээр дурьдсан холбогдох зохицуулалттай нийцэж байна. БНСУ бол хуваагдмал үндэстэн бөгөөд БНСУ-ын Үндсэн хуулийн 4-р зүйлд “БНСУ нь нэгдэхийг эрэлхийлсэн, эрх чөлөө, ардчиллын зарчимд үндэслэсэн энхийн замаар нэгдэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ”⁵ хэмээн заасан байдаг ба ингэхдээ Үндсэн хууль болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг мөрдлөгө болгож, нэгдэн орсон олон улсын гэрээг БНСУ-ын дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх талаар заажээ⁶.

Үүнээс үзэхэд, БНСУ-ын хувьд БНАСАУ-тай нэгдэх асуудал нь гадаад бодлогынх нь нэн тэргүүний зорилго нь байдаг ба олон улсын яриа, хэлэлцээний тусламжтайгаар энх тайвнаар нэгдэхийг чухалчилдаг байна. Энэ нь тус улсын үндэсний ашиг сонирхлын нэг хэсэг байдаг ба Үндсэн хуулиараа энэ тухай тодорхойлоод зогсохгүй түүнийг ямар субъект хэрэгжүүлэхийг мөн зааж өгчээ.

Үндсэн хууль болон төрийн дотоод, гадаад бодлого

⁴ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал (2011)

⁵ Constitution of the Republic of Korea (1987) Art.4

⁶ Constitution of the Republic of Korea (1987) Art.6

Үндсэн хууль бол аливаа улсын дотоод дахь нийгмийн харилцааг зохицуулсан суурь хууль байхаас гадна бүрэн эрхт, тусгаар тогтносон улсын бэлгэ тэмдэг нь юм. Тус хуулиар тухайн улсын төрийн байгууламж, засаглалын хэлбэр, төрийн эрх мэдлийн хувиарлалт, төрийн байгууллага, түүний засаглалын эрх зүйн үндсийг бүрдүүлдэг.

Үндсэн хууль нь улс орон бүрийн төрийн бодлогын хамгийн дээд эрх зүйн илэрхийлэл бөгөөд гадаад бодлого нь төрийн дотоод бодлогын үргэлжлэл нь байдаг. Аливаа гадаад бодлогын үзэл баримтлал, зарчим нь Үндсэн хуулиас улбаалан гардаг. Тухайлбал, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг ямар албан тушаалтан, хэрхэн тодорхойлох, хэрэгжүүлэх, ингэхдээ ямар эрх эдлэж, үүрэг хүлээдэг тухай Үндсэн хуулиудад зааж өгөх нь элбэг. БНСУ, Монгол Улсын хувьд ч адил юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 25.2-т УИХ нь “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”⁷ бүрэн эрхтэй хэмээн заажээ.

Төрийн бодлого нь үндсэндээ дотоодын хууль тогтоомж, үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй дотоодын хууль тогтоомжоор зохицуулагддаг дотоод үйл явцыг хамардаг бол гадаад бодлого нь олон улсын эрх зүйгээр зохицуулагддаг олон улсын болон гадаад үйл явцтай холбоотой байдаг. Гэхдээ дотоод, гадаад бодлогын хувьд бие биенээсээ хамааралтай тул ямарваа зааг ялгааг гаргах боломжгүй юм. Аливаа улсын гадаад бодлого нь үндсэндээ дотоод бодлогоос хамаардаг.

Үндсэн хуулиар дотоод, гадаад бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх эрх бүхий субъект, байгууллагуудын бүрэн эрхийг баталгаажуулж өгдөг. Үүнд тухайн улсын төрийн тогтолцоо чухал ач холбогдолтой. Жишээлбэл, АНУ нь Үндсэн хуулийн ерөнхийлөгчийн засаглалтай бөгөөд Ерөнхийлөгч нь гадаад бодлогын шийдвэрийг эцэслэн гаргадаг. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь гадаад бодлогын шийдвэр гаргахад мөн чухал үүрэг гүйцэтгэдэг⁸. Харин ОХУ-д - Ерөнхийлөгч⁹, Хятадад - Коммунист нам¹⁰ гэх мэт.

Монгол Улсын хувьд УИХ бол төрийн эрх барих дээд, хууль тогтоох байгууллага бөгөөд (МУ-ын үндлэн хууль, 1992) энэ утгаараа гадаад бодлогыг

⁷ Монгол Улсын Үндсэн хууль (1992) 25.2-зүйл.

⁸ US Constitution (1787). Article 2. Section 2

⁹ Конституция РФ (1993). Статья 80.3, 80

¹⁰ Constitution of People's Republic of China (1982). Preamble

тодорхойлогч субъект нь бөгөөд БНСУ-ын ерөнхийлөгчийн засаглалтай учир тэрээр дотоод, гадаад бодлогыг тодорхойлдог байна¹¹.

Монгол Улсын Үндсэн хууль ба гадаад бодлого

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь Монгол Улсад шашин шүтэх, эс шүтэх, үг хэлэх эрх чөлөө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, сонгох, сонгогдох гэх мэт эрх чөлөөг баталгаажуулж, төлөөллийн ардчиллыг тогтоожээ.

Хэвлэлийн эрх чөлөө, салшгүй эрх, аялах эрх чөлөө болон бусад эрхийн хувьд Барууны үндсэн хуулиудтай ижил төстэй зүйл олон.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Монгол улс бол парламентын засаглалтай улс бөгөөд "Улсын Их Хурал" нэртэй парламент бол төрийн эрх барих дээд байгууллага мөн (20-р зүйл).

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу гадаад бодлогын шийдвэрийг Монгол Улсад хэрхэн гаргадаг вэ? (Үндсэн хууль дахь зохицуулалт)

Монгол Улсад Улсын дотоод, гадаад бодлогын үндэсийг *Улсын Их Хурал* (парламент) тодорхойлдог (25.2-р зүйл). Ийнхүү Монголын парламент Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 оны Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хоёр чухал баримт бичгийг баталсан байдаг.

Монгол Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага нь Монгол Улсын *Ерөнхийлөгч, засгийн газар* юм. Ерөнхийлөгч *Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг* даргална (33.10-р зүйл). Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь гадаад бодлогын асуудлаар Ерөнхийлөгчийн зөвлөх байгууллага юм. Монгол Улсын Засгийн газар төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлнэ (38.8-р зүйл).

Гадаад бодлогын асуудлаарх *парламентын* бүрэн эрх (Үндсэн хуулийн 25-р зүйл):

- улсын хил тогтоох (25.9-р зүйл) ;

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох (25.10-р зүйл);

¹¹ Constitution of the Republic of Korea (1987). Art. 66-67, 72-73

- Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах (25.15-р зүйл);

- 25-р зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох (25.18-р зүйл).

Дээр дурдсанчлан Монгол Улсын *Ерөнхийлөгч* бол гадаад бодлогыг хэрэгжүүлдэг субъект юм. Түүнээс гадна түүнд гадаад бодлоготой холбоотой зарим эрх мэдэл байдаг. Жишээлбэл, “ерөнхийлөгч нь гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах” (33.1.4-р зүйл), “Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах”, “Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах” (33.1.5-6-р зүйл), “Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна” (33.2-р зүйл) гэсэн Үндсэн хууль дахь зохицуулалтууд хамаарна.

Засгийн газар төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлнэ (38.8-р зүйл). Түүнчлэн Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээг байгуулж, улмаар парламентаар соёрхон батлах, улмаар Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах, хүчингүй болгоход оролцдог олон улсын гэрээг байгуулж, хэрэгжүүлдэг (38.9-р зүйл).

Дүгнэж хэлэхэд Монгол Улсад гадаад бодлогын шийдвэр гаргах гол байгууллага нь парламент бөгөөд Ерөнхийлөгч нь зөвхөн бэлгэдлийн шинжтэй юм.

БНСУ ба гадаад бодлого (Үндсэн хууль дахь зохицуулалт)

БНСУ-ын Үндсэн хууль нь 1948 оны 7-р сарын 17-нд батлагдаж, 1987 оны 10-р сарын 29-нд шинэчлэгдсэн.

Доктор Чин-О Югийн боловсруулсан Өмнөд Солонгосын 1948 оны анхны Үндсэн хууль нь парламентын болон ерөнхийлөгчийн хосолсон засаглалын тогтолцоог бүрдүүлсэн. Энэ нь Ерөнхийлөгчид төрийн тэргүүний гүйцэтгэх үүрэг, Үндэсний Ассамблейгаас шууд сонгогдох, гүйцэтгэх эрх мэдлийг кабинеттайгаа

хуваалцах боломжийг олгосон¹². 1919 оны БНСУ-ын Түр засгийн газрын Үндсэн дүрэм (Constitutional Charter of the Provisional Government) нь 1948 оны Үндсэн хуулийн суурь нь болсон байдаг. Үндсэн хуулиндаа 10 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг.

БНСУ-ын Үндсэн хуульд оруулсан сүүлчийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зарим талаар хязгаарласан. Тэрээр долоон жилийн хугацаатай дахин сонгогдох ямар ч боломжгүй болсон ба иймээс нэг танхимтай хууль тогтоох байгууллага, Засгийн газрын танхимын тогтолцоог бүрдүүлсэн юм¹³.

БНСУ-ын Ерөнхийлөгч нь төрийн гадаад бодлогод гол байр суурийг эзэлдэг. Үүнийг Үндсэн хуулийн зохицуулалтаас харж болно. Жишээлбэл, ерөнхийлөгч нь шаардлагатай гэж үзвэл дипломат ажиллагаа, үндэсний батлан хамгаалах, нэгдмэл байдал болон улс үндэстний хувь заяатай холбоотой бусад асуудлыг бүх нийтийн санал асуулгаар шийдвэрлэхээр өргөн мэдүүлж болно (72-р зүйл), Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд төрийг гадаад улсад төлөөлөх (66.1-р зүйл), Үндсэн хуулийн хараат бус байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, залгамж чанарыг хамгаалах (66.2-р зүйл), эх орноо энх тайвнаар нэгтгэх ажлыг чин сэтгэлээсээ хэрэгжүүлэх, олон улсын гэрээг соёрхон батлах, дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх жуух бичгийг хүлээн авах, итгэмжлэх (73-р зүйл); дайн зарлах, энх тайвныг тогтоох, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх (74-р зүйл), Зэвсэгт хүчний зохион байгуулалтыг тогтоох, төрийн зөвлөлийн гишүүн байх зэрэг бүрэн эрхтэй (88.3-р зүйл).

Гадаад бодлогын асуудлаар БНСУ-ын Ерөнхийлөгчөөс гадна Үндэсний Ассамблей нь дайн зарлах, зэвсэгт хүчнийг гадаад улс руу илгээх, харийнхны хүчийг БНСУ-ын нутаг дэвсгэр дээр байршуулахыг зөвшөөрөх эрхийг эдэлдэг. Ассамблей нь харилцан туслалцаа үзүүлэх, аюулгүй байдлын талаархи гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах, олон улсын байгууллагуудтай гэрээ байгуулах, энх тайван, найрамдал, худалдаа, навигацийн асуудал, энхийн гэрээ, төрөөс ард иргэддээ эдийн засаг, санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар шийдвэр гаргах гэх мэт бүрэн эрхийг эдэлдэг (60-р зүйл) гэх мэт.

¹² Namkoong, Keun, Kyung-ho Cho, and Sangmook Kim, eds. Public administration and policy in Korea: its evolution and challenges. Vol. 25. Taylor & Francis, 2017

¹³ Kwak, Jun-Hyeok, and Leigh Jenco, eds. Republicanism in Northeast Asia. Routledge, 2014.

БНСУ дахь ерөнхийлөгчийн засаглал нь гадаад бодлогын шийдвэр гаргах гол хүчин зүйл болдог. Ийм учраас БНСУ нь олон улсад бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг даган биелүүлдэг олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүн юм. Гадаад бодлоготой холбоотой шийдвэрийг гаргахдаа иргэдийн (жишээ нь бүх нийтийн санал асуулга явуулах) болон бусад засаг захиргааны нэгжүүдийн байр суурийг харгалзан үзсэний үндсэн дээр гаргадаг нь тухайн улсын нэг онцлог юм.

Гадаад бодлогын шийдвэрт нөлөөлдөг өөр нэг хүчин зүйл бол БНСУ-ын эдийн засгийн хөгжил юм. Эдийн засгийн хөгжил нь өндөр хөгжилтэй орнуудын адил гадаад бодлогынх нь гол үндэс нь болдог.

Монгол Улс, БНСУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтын харьцуулалт

Монгол Улс, БНСУ-ын Үндсэн хуулиудыг харьцуулж үзвэл засаглалын хэлбэр, түүний дотор гадаад бодлогод шийдвэр гаргалттай холбоотой ялгаа байгаа нь харагдана.

Эдгээр ялгааг Хавсралт 1-ээс харна уу.

Монгол Улс, БНСУ-ын төрийн тогтолцоо

Бүгд Найрамдах Солонгос Улс бол ерөнхийлөгчийн засаглалтай ардчилсан улс юм. Ерөнхийлөгчийн засаглал бол засгийн газрын тэргүүн хууль тогтоох салбараас тусдаа гүйцэтгэх засаглалыг удирддаг ардчилсан, бүгд найрамдах засаглал юм.

БНСУ-д гүйцэтгэх засаглал нь сонгогдож, хууль тогтоох байгууллагын өмнө хариуцлага хүлээдэггүй тул түүнийг огцруулах асуудал түвэгтэй байдаг. Энэ тохиолдолд импичментээр огцруулах нь олонтоо.

Ерөнхийлөгчийн засаглал нь засгийн газрын тэргүүн сонгогдсон хууль тогтоох байгууллагын итгэлийг олж засгийн эрхэнд гарч ирдэг парламентын засаглалтай ихэвчлэн зөрчилддөг.

Монгол Улс болон БНСУ-ын ерөнхийлөгчийн эрх мэдлийг гадаад бодлогын салбарын зарим харьцуулалтаас үзвэл:

- *Шууд сонгууль* - Солонгосын ерөнхийлөгчийг ард түмэн шууд сонгодог. Энэ нь шууд бусаар сонгууль явуулах аргаас илүүтэйгээр Ерөнхийлөгчийн эрх

мэдлийг хууль ёсны болгодог. Гэсэн хэдий ч энэ нь ерөнхийлөгчийн засаглалтай улсад байх ёстой зайлшгүй шинж биш юм. Зарим улсад ерөнхийлөгчийг шууд бусаар сонгодог практик байдаг (жишээ нь 2019 оны Үндсэн Хуулиар Куба Улсын Ерөнхийлөгчийг Үндэсний Ассамблей буюу Парламент нь сонгож байхаар зохицуулжээ¹⁴). Монгол Улсын Ерөнхийлөгчийг мөн ард иргэдээс шууд сонгодог боловч Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд ихээхэн хязгаарлалт тавьдаг. Тэр утгаараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх бэлгэдлийн шинжтэй байдаг. Ийм төрлийн хязгаарлалт нь хагас зуун жилийн турш нэг хүн улс, үндэстнийг захирч байсан социализмын үеийн практиктай холбоотой байж мэднэ^{15*}. Нэг хүний засаглалаас зайлсхийхийн тулд парламентын бүгд найрамдах улсын хөгжил дэвшлийн замналыг сонгосон гэж хэлж болх юм.

- *Эрх мэдлийн хуваарилалт* - Солонгосын Үндсэн хуулиар ерөнхийлөгч болон хууль тогтоох байгууллага нь зэрэгцсэн бүтэцтэй юм. Энэхүү бүтэц нь эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, нэг нь нөгөөгөө хянах, шалгах боломжийг олгодог бий болгосон. Монгол Улсын хувьд гадаад бодлогыг тодорхойлох, шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх бүрэн эрхийг УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар эдэлдэг. Монголын тогтолцоонд Ерөнхийлөгч, Засгийн газрын аль аль нь УИХ-ын өмнө хариуцлага хүлээдэг.

- *Хурд ба шийдэмгий байдал* - Солонгосын Ерөнхийлөгч аливаа өөрчлөлтийн талаар түргэн хугацаанд шийдвэр гаргах боломжтой байдаг. Тухайлбал, ерөнхийлөгч Мүн Жэ Инийн Ковид-19 цар тахлын үеэр гаргасан шийдвэрүүд нь бага хугацаанд, түргэн шуурхай, шийдэмгий байдлаар гарсан гэж үзэж болно. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд эрх мэдлийн хуваарилалт нь тогтолцоог улам бүр удаашруулах магадлалтай байдаг. Монгол улсын хувьд гадаад бодлогын асуудлаар аливаа шийдвэр гаргалт нь цаг хугацаа шаардсан, урт хугацаанд үргэлжлэх яриа, сонсгол, хэлэлцүүлэг зэргийг шаарддаг. Ковид-19-тэй ижил тохиолдолд Ерөнхийлөгч Засгийн газар одоогийн төсвөө тодотгож, бүсээ чангалах бодлого баримтлах ёстой гэж үзсэн боловч Засгийн газар ийм тодотгол хийх шаардлагагүй гэж мэдэгдсэн зэрэг шийдвэр уялдахгүй байх тохиолдлууд гарах эрсдэлтэй юм.

¹⁴ 2019 оны Кубын шинэ Үндсэн хуулийн 740 дүгээр зүйлд Кубын Үндэсний Ассамблей буюу парламент нь Куба улсын Ерөнхийлөгч, тэргүүн дэд Ерөнхийлөгч, 5 дэд ерөнхийлөгчийг сонгоно гэж заажээ.

^{15*} Тухайлбал, Ю.Цэдэнбал Монгол Улсыг 40 жил удирдсан байдаг.

• *Тогтвортой байдал* – БНСУ-ын Ерөнхийлөгч нь Монгол Улсын Ерөнхий сайдаас илүү тогтвортой ажиллах нөхцлөөр хангагдсан. 2020 онд Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Ерөнхий сайдыг хугацаанаас өмнө огцруулах боломжтой болсон байдаг¹⁶. Энэ нь төрийн бодлогын залгамж чанар, улс төрийн тогтвортой бус байдлыг бий болгох эрсдэлтэй.

Үндсэн хуулийн дагуу Солонгосын Ерөнхийлөгч гадаад бодлоготой холбоотой өргөн хэмжээний эрх мэдэлтэй. Жишээлбэл, Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн бөгөөд гадаад улс орнуудад улсаа төлөөлнө. Ерөнхийлөгч нь Төр, Үндсэн хуулийн хараат бус байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, залгамж чанарыг хамгаалах үүрэг, хариуцлага хүлээнэ. Ерөнхийлөгч олон улсын гэрээ байгуулж, соёрхон батална; дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх жуух бичгийг хүлээн авах, илгэмжлэх; дайн зарлаж, энх тайвныг тогтоох бэрэн эрхтэй. Мөн ерөнхийлөгч нь Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

Монгол Улс, БНСУ-ын Үндсэн хуулиуд дахь гадаад бодлогын шийдвэр гаргалттай холбоотой ижил төстэй зохицуулалтууд

Хоёр улсын үндсэн хуулинд хоёр үндэстний түүхэн онцлог шинжтэй холбоотой онцлог заалтууд байдаг. Тухайлбал, БНСУ-ын шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Солонгосын хойгийг энхийн замаар нэгтгэхийг илэрхийлэх, “эх орноо энх тайвнаар нэгтгэхийг эрмэлзэх” үүргийг хүлээсэн байна. Солонгос улсыг нэгтгэх бодлого нь тус улсын Үндсэн хуулинд “БНСУ нэгдэхийг эрмэлзэж, эрх чөлөө, ардчиллын зарчимд үндэслэн энхийн замаар нэгдэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ”¹⁷ зэргээр тусгалаа олсон.

Геополитикийн нөхцөл байдлаас үл хамааран хоёр улсын үндсэн хуулиудад гадаад бодлогыг хэрэгжүүлэх асуудлаар ижил төстэй зохицуулалт байгааг харж болно. Ялангуяа, энэ нь олон улсын эрх зүйд илүүтэйгээр хамаарах юм. Монгол улсын үндсэн хуулинд: “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”¹⁸ гэж заасан абйдаг бол БНСУ-ын Үндсэн хуулинд “Бүгд Найрамдах Солонгос Улс олон улсын энх тайвныг хадгалахын төлөө хичээн чармайж,

¹⁶ 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн 40 гаруй хувийг 2020 онд өөрчилсөн байдаг ч гадаад бодлогын асуудал үүнд хөндөгдөөгүй хэвээр үлдсэн.

¹⁷ Constitution of the Republic of Korea (1987) Art.4

¹⁸ Монгол Улсын Үндсэн хууль (1992) 10.1-р зүйл

түрэмгийллийн дайнаас татгалзана¹⁹”.Үндсэн хууль болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн дүрэм журмын дагуу зохих ёсоор байгуулагдаж, тунхагласан гэрээнүүд нь БНСУ-ын дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр байна”.

БНСУ-ын Үндсэн хуулинд шийдвэр гаргахдаа цэргийн эрх мэдлийг хязгаарлах, харин Монгол Улсын Үндсэн хуулинд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарласан шинжтэй зохицуулалт байгаа нь монгол улсад үйлчилж байсан коммунист үзэл санааны үлдэц юм.

1915 оны Монгол Улсын тухай гурван талт Хиагтын гэрээ, 1924 оны Орос-Хятадын найрамдлын гэрээнд Монгол Улсыг гадаад гүрний нэг хэсэг хэмээн хүчээр хуульчилж байсныг иш үндэс болгон “Монгол Улс олон улсын гэрээ, Үндсэн хуультай нь үл нийцэх бусад баримт бичгийг дагаж мөрдөж болохгүй” гэх мэтчилэн Монгол Улсын Үндсэн хуулийн заалт байдаг. Монгол Улс 1911 онд Манжийн эзэнт гүрнээс хараат бус байдлаа тунхаглаж, 10 жилийн дараа 1921 онд дахин тусгаар тогтнолоо олсон байдаг.

Дүгнэлт

Солонгос улсын хувьд Ерөнхий сайд хууль тогтоох байгууллагад бус Ерөнхийлөгчид ажлаа тайлагнадаг. Харин ерөнхийлөгч нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ялгаатай нь гадаад бодлогын асуудлаар олон зөвлөх зөвлөл (Ахмад төрийн түшмэдийн, эдийн засгийн зөвлөл, нэгдэх асуудлаарх гэх мэт) байгаа нь олон давуу талтай байна. Ерөнхийлөгч дангаар дур мэдэн шийдвэр гаргах боломжгүй ба ерөнхийлөгчид зөвлөх үүрэгтэй мэргэжлийн, туршлагатай түшмэдээс бүрдсэн зөвлөлүүд ажиллаж байдаг байна.

Монгол Улсад 1992 оны Үндсэн хуулиар гадаадын цэргийн хүчийг нутаг дэвсгэртээ байрлуулахыг хориглосон бол БНСУ нь АНУ-тай цэргийн эвслийн гишүүн бөгөөд өөрийн нутаг дэвсгэр дээр гадаадын цэргийн баазтай байж болохыг хуульчилсан. Үндсэн хуулийн энэхүү заалт нь холбогдох үндэстнүүдийн гадаад бодлогыг магадгүй хязгаарлаж болох талтай юм.

БНСУ-ын хувьд Ерөнхийлөгч нь гадаад бодлогын шийдвэр гаргалтанд гол үүрэг гүйцэтгэгч байдаг бол Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн дагуу УИХ гол

¹⁹ Constitution of the Republic of Korea (1987) Art.5.1

тоглогч болж байна. Хоёр улсын Үндсэн хуулиуд түүх, геополитик, амьдарлын хэв маяг зэргээс хамааран өөр өөрийн гэсэн онцлогтой байна.

Хавсралт 1. Монгол Улс, БНСУ-ын Үндсэн хуулиуд дахь гадаад бодлоготой холбоотой зохицуулалтын харьцуулалт

	Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль	БНСУ-ын 1987 оны Үндсэн хууль
Ерөнхий зарчим, зорилго	10-р зүйл 1. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. 2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. 3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. 4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй. 11-р зүйл 1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн. 2. Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.	4-р зүйл Бүгд Найрамдах Солонгос Улс нэгдэхийг эрэлхийлж, эрх чөлөө, ардчиллын зарчимд тулгуурлан энхийн замаар нэгдэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. 5. 1 Бүгд Найрамдах Солонгос Улс олон улсын энх тайвныг хадгалахын төлөө хичээн чармайж, бүх түрэмгийлэлтэй дайнаас татгалзах болно. (2) Зэвсэгт хүчинд үндэсний аюулгүй байдал, газар нутгаа хамгаалах ариун үүрэг даалгавар өгч, улс төрийн төвийг сахисан байдлыг хадгална. 6.1 Үндсэн хууль болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн дүрмийн дагуу зохих ёсоор байгуулагдаж, тунхагласан гэрээнүүд нь БНСУ-ыг дотоодын хууль тогтоомжоор зөөлрүүлж байгаатай адил үр нөлөө үзүүлнэ. 6.2 Гадаадын иргэдийн статусыг олон улсын хууль, гэрээнд заасны дагуу баталгаажуулна.
	25-р зүйл УИХ 1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн	60-р зүйл Үндэсний Ассамблей (1) Үндэсний Ассамблей нь харилцан туслалцаа үзүүлэх эсвэл харилцан аюулгүй байдлын талаархи гэрээг байгуулах, соёрхон батлахыг

Парламентын бүрэн эрх	онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 1/хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах; 2/төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох; 15/Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах; 17/Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах; 18/энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох.	зөвшөөрөх эрхтэй; олон улсын чухал байгууллагуудтай холбоотой гэрээ; найрамдал, худалдаа, навигацийн гэрээ; бүрэн эрхт байдлыг хязгаарлахтай холбогдсон гэрээ; энхийн гэрээ зэргийг байгуулах; 2) Үндэсний Ассамблей нь дайн зарлах, зэвсэгт хүчнийг гадаад улс руу илгээх, харийнхны хүчийг БНСУ-ын нутаг дэвсгэрт байрлуулахыг зөвшөөрөх эрхтэй.
Ерөнхийлөгчийн бүрэн эрх	30-р зүйл Ерөнхийлөгч 1.Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. 33-р зүйл 1.Ерөнхийлөгч дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах; 5/Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн	66-р зүйл Ерөнхийлөгч (1) Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн бөгөөд гадаад улсуудтай харилцахдаа улсаа төлөөлнө. (2) Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн хараат бус байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, залгамж чанарыг хамгаалах тал дээр үүрэг, хариуцлага хүлээнэ. (3) Ерөнхийлөгч нь эх орноо энх тайвнаар нэгтгэх асуудлаар чин сэтгэлээсээ хандах үүрэгтэй. (3) Гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч тэргүүтэй Гүйцэтгэх засаглал хариуцна. 67-р зүйл (1) Ерөнхийлөгчийг бүх нийтийн, тэгш, шууд сонгуулиар сонгох ба ард

	томилох буюу эгүүлэн татах; 6/Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах; 9/Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх; 10/Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх; 11/бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах; 12/Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно. 2.Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. 1.Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна.	түмнээс нууцаар санал хураалт явуулна. 72-р зүйл. Ерөнхийлөгч шаардлагатай гэж үзвэл дипломат ажиллагаа, үндэсний батлан хамгаалах, нэгдэх болон үндэсний хувь заяатай холбоотой бусад бодлогыг үндэсний санал асуулгад өргөн мэдүүлж болно. 73-р зүйл. Ерөнхийлөгч олон улсын гэрээ байгуулж, соёрхон батална; дипломат төлөөлөгчдийг итгэмжлэх, хүлээн авах, илгээх; дайн зарлаж, энх тайвныг тогтооно. 74-р зүйл (1) Ерөнхийлөгч нь Үндсэн хууль, хуульд заасан нөхцлөөр Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.
	33-р зүйл Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 1.10Монгол Улсын үндэсний аюулгүй	91-р зүйл Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (1) Зөвлөл нь үндэсний аюулгүй байдал,

Үндэсний аюулгүйн байдлын Зөвлөл	байдлын зөвлөлийг тэргүүлэх;	гадаад, дотоод болон цэргийн бодлогыг боловсруулахдаа Төрийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээс өмнө Ерөнхийлөгчид зөвлөгөө өгөх зорилгоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг байгуулна. (2) Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааныг Ерөнхийлөгч даргална.
Засгийн газрын бүрэн эрх	38-р зүйл Засгийн газар 8) төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх	89-р зүйл Төрийн зөвлөл 2. Дайн зарлах, энх тайван тогтоох болон гадаад бодлогын бусад чухал асуудлууд;
Ардчилсан, тайван замаар нэгдэх зөвлөл/ Advisory Council on Democratic and Peaceful Unification	Монголд ийм зөвлөл байхгүй	92-р зүйл (1) Энхийн замаар нэгдэх бодлого боловсруулах талаар Ерөнхийлөгчид зөвлөгөө өгөх зорилгоор Ардчилсан, тайван замаар нэгдэх зөвлөл байгуулж болно.
Ахмад төрийн түшээдийн зөвлөл /Advisory Council of Elder Statesmen	Монголд ийм зөвлөл байхгүй	90-р зүйл Ахмад төрийн түшмэдээс бүрдсэн Ахмад төрийн түшээдийн зөвлөлийг байгуулж, төрийн чухал асуудлаар Ерөнхийлөгчид зөвлөгөө өгөх зорилгоор байгуулж болно. • Төрийн эрхийг хамгийн сүүлд барьж байсан ерөнхийлөгч нь Ахмад төрийн түшмэдийн зөвлөлийн дарга байна: Хэрэв байхгүй байгаа бол одоо байгаа Ерөнхийлөгч даргыг томилно.
Үндэсний эдийн засгийн зөвлөл/National Economic Advisory Council	Монголд ийм зөвлөл байхгүй	93-р зүйл. Үндэсний эдийн засгийг хөгжүүлэх чухал бодлого боловсруулах талаар Ерөнхийлөгчид зөвлөгөө өгөх Үндэсний эдийн засгийн зөвлөлийг байгуулж болно.

Ном Зүй

Mongolia in the Twentieth Century: Landlocked Cosmopolitan. Edited by Stephen Kotkin and Bruce A. Elleman. New York, 1999.

Namkoong, Keun, Kyung-ho Cho, and Sangmook Kim, eds. Public administration and policy in Korea: its evolution and challenges. Vol. 25. Taylor & Francis, 2017.

Kwak, Jun-Hyeok, and Leigh Jenco, eds. Republicanism in Northeast Asia. Routledge, 2014.

Тумурчулуун Г. “Процесс принятия внешнеполитических решений в малых государствах: на примере Монголии” (1999) г. Москва.

Hermanns, Heike. "National role conceptions in the 'Global Korea' foreign policy strategy." The Korean Journal of International Studies 11, no. 1 (2013); Retrieved from <http://www.kjis.org/journal/view.html?uid=6&vmd=Full&>

Legislation

Монгол Улсын Үндсэн хууль (1992)

БНСУ-ын Үндсэн хууль (1987); retrieved from <http://constitutionnet.org/country/republic-korea>.

Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн тухай (1992)

Хиагтын 3 улсын гэрээ (1915)

МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал (2011)

Цахим эх сурвалж:

https://www.unikorea.go.kr/eng_unikorea/

<https://www.mois.go.kr/eng/a01/engMain.do 2>.

http://overseas.mofa.go.kr/mn-mn/brd/m_297/view.do?seq=761265

**ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА, АРГА ЗҮЙГ ХӨГЖЛИЙН
БОДЛОГО БОЛОВСРУУЛАЛТАД ХЭРЭГЛЭХ НЬ**

Т.Есүхэй

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн дадлагажигч багш

Хураангуй

Хурдацтай хөгжиж буй дэлхийн олон орнууд хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах тусгайлсан арга зүй, хандлагыг нэвтрүүлэн түүнийгээ улам хөгжүүлж төрийн бодлого төлөвлөлтдөө ашиглаж байна. Цаашид хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад анхаарах асуудлуудыг судлах нь Монгол улсын хөгжлийг зураглан, хөгжлийн үйл явцыг удирдах боломжийг нээж өгөх юм. Бодлогын баримт бичиг нь нийгэмд хэрэгжиж буй арга хэмжээнүүдийг залж чиглүүлдгийн хувьд ямар агуулгаар хэрхэн бичигдсэнээс хамаарч засгийн газар өөрт буй хүний нөөц, санхүүгийн нөөцөө зарцуулдаг билээ. Тиймээс төрийн үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай нэн тэргүүний алхам бол бодлогын баримт бичиг боловсруулах арга зүйдээ шинэчлэлт хийж, нийгэмд тулгамдаж буй хэрэгцээ шаардлагаа зөв үнэлж, бодлогын баримт бичгээ чанартай боловсруулах шаардлагатай билээ.

Түлхүүр үгс: Хүний эрх, хөгжил, хөгжлийн бодлого, бодлогын үр дүн, үр нөлөө, арга хэмжээ, хэрэгцээнд суурилсан хандлага, хандивт суурилсан хандлага, хүний эрхэд суурилсан хандлага

Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй гэдэг нь хүний эрхийг хамгаалах, хангахад чиглэсэн, олон улсын хүний эрхийн стандарт, хэм хэмжээнд суурилсан, хөгжлийн процессыг зураглах үйл явц юм. Энэ хандлага нь хөгжлийн асуудалд нэн тулгамдаж буй эрх мэдлийн тэгш бус хуваарилалт, ялгаварлан гадуурхалт зэрэг тэгш бус байдлын асуудлуудыг бууруулахад онцгой ач холбогдолтой.

Зөвхөн хүмүүнлэгийн ажиллагаа нь хүний эрхийг хамгаалахад хангалтгүй. Хүний эрхэд суурилсан хандлага арга зүйн дагуу олон улсын хууль тогтоомжоор бэхэжсэн хүний эрхийг хамгаалах үүргийг сахиулах, төлөвлөгөө,

хөтөлбөр, бодлого болон хөгжлийн процессыг хүний эрхийг хамгаалахад чиглүүлэх ач холбогдолтой. Мөн энэ нь үүрэг бүхий хүмүүсийг ил тод, нээлттэй, хариуцлагатай байлгах, маргинал бүлгүүдийг татан оролцуулах болон хөгжлийн процессыг тогтвортой болгох сайн талтай.

Хүйтэн дайн дууссанаас хойш хүний эрх нь хөгжлийн хамгийн чухал аспект болж эхэлсэн бөгөөд 1993 оны Вений Дэлхийн хүний эрхийн уулзалт, 2000 оны Мянганы чуулга уулзалт, 2003 оны Хөгжил, хүний эрх хоёрын харилцан хамаарлын талаарх Дэлхийн чуулган зэрэг хурлууд Хүний эрхэд суурилсан хөгжлийн арга зүйг хэлэлцэж тунхагласан байдаг.

Хөгжлийн бодлого төлөвлөлтөд хүний эрхэд суурилсан хандлагыг ашигласнаар бодлогын үр шим иргэдэд ялгаатайгаар хүртэх байдал буурч, бодлого хэрэгжүүлэхэд ашиглаж буй нөөцийг зөв зохистой хуваарилахад өндөр ач холбогдолтой. Уламжлалт арга зүйтэй харьцуулахад төлөвлөх, боловсруулах шинжилгээний арга зүйн хувьд ярвигтай ч гэсэн эцсийн үр дүнд гарах бодлого нь үр өгөөжтэй, иргэдэд ээлтэй бодлогууд боловсруулагддаг.

Хэдий менежментийн ухаанаар хэрэгжүүлэх, хянах, үнэлэхэд дөхөм байхаар бодлогоо боловсруулдаг ч бодлогын арга хэмжээ, зорилго, зорилт зэрэг агуулга нь хэрэгцээнд суурилсан, аль эсвэл хандивт суурилсан байх нь нийтлэг. Ингэснээр бодлогын үр шим тэгш шударга хүртэхгүй, статистик тоо баримт сайн үр дүн үзүүлсэн ч гэсэн тухайн асуудал нийгэмд бүрэн шийдэгдэж чадахгүй, тэгш бус байдлыг улам нэмэгдүүлэх хандлага ажиглагдаж байна. Тэгш бус байдлыг бууруулж, бодлогын үр шимийг иргэн бүрд үр дүнтэйгээр хүртээхэд Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй онцгой ач холбогдолтой. Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг ашигласнаар тухайн асуудал ямар шалтгаанаас үүсэж байгааг олж тогтоохдоо тогтолцооны түвшинд суурь шалтгааныг хайж, гарц, шийдлийг олохдоо тухайн хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх зарчмыг баримталснаар иргэн бүрд ээлтэй, хүмүүнлэг нийгмийг бүтээхэд хувь нэмрээ оруулах юм.

Хөгжлийн талаарх үзэл хандлагууд хүний эрхтэй харьцуулахад тийм ч гүнзгий суурьтайгаар хөгжөөгүй бөгөөд Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар эдийн засгаа нөхөн сэргээхэд дэлхийн улс орнууд анхаарч эхэлсэнтэй уялдан эдийн засагчдын үзэл хандлага ноёлдог. Эдийн засагчдаар ноёлуулсан хөгжлийн талаарх хандлага нь улсын макро үзэгдлүүдэд анхаарч эдийн засгийн өсөлт, шилжилтийг бий болгоход нөөцөө зохистой хуваарилахад анхаардаг. (Sano, 2000)

Хүний эрхэд суурилсан хандлага арга зүйг хөгжлийн бодлогод ашиглах талаарх оролдлогыг зарим иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанаас бусад бодлогуудад төдийлөн авч хэрэгжүүлээгүй байгаа бөгөөд тусдаа салбар хэмээн үзэж хариуцаж ажилладаг төрийн институтууд ихэвчлэн тусдаа үйл ажиллагаа явуулж байна. Олон улсын түвшинд ч гэсэн хөгжлийн бодлогыг өөр, өөр нэгжүүд хариуцаж ажиллах нь элбэг байгаа бөгөөд жишээлбэл хөгжлийн бодлогын асуудлыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Дэлхийн Банк зэрэг байгууллага хариуцдаг бол хүний эрхийн асуудлыг Хүний Эрхийн Комиссарын газар хариуцаж ажилладаг.

Хүний Эрхэд Суурилсан Хандлага арга зүйгээр хөгжлийн бодлогыг боловсруулснаар:

- Иргэд өөрийн эрхээ хангуулах чадвартай болно.
- Төр буюу ард иргэдийн өмнө үүрэг хүлээгчдийн үйл ажиллагааг иргэдийн эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалахад чиглүүлнэ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хандлага арга зүйг задлан шинжилж бодлогуудын агуулга, арга хэмжээнүүдэд шинжилгээ хийж, дараах харьцуулалтыг хийж болох бөгөөд бодлогын арга хэмжээнүүдээр нь харгалзан үндсэн 3 ангилж болох бөгөөд үүнд:

- Хандивт суурилсан арга зүй
- Хэрэгцээнд суурилсан арга зүй
- Хүний эрхэд суурилсан арга зүй

Арга зүй бүр нь дор бүрнээ онцлог чанаруудтай бөгөөд давуу болон сул талуудтай. Гэсэн хэдий ч хөгжлийн бодлого төлөвлөлт, боловсруулалтын шинжилгээнд буюу бодлогын хувилбарыг сонгохдоо ихэвчлэн Хандивт суурилсан арга зүй эсвэл Хэрэгцээнд суурилсан арга зүйг сонгох нь элбэг байна.

Хүний эрх нь хангах, хамгаалуулах зэрэг олон төрлийн арга хэмжээг төрөөс шаарддаг тул хүний эрхэд суурилсан хандлага арга зүйг ашиглан бодлого боловсруулахад явцад хэрэгжүүлэхэд тодорхой, ойлгомжтой арга хэмжээ боловсруулах нь тулгамддаг хамгийн том асуудал болдог. Зарим хүний эрхийн асуудлууд хэрхэн хангагддаг талаарх үнэлгээ, шалгуур өнөөг хүртэл тодорхойгүй байх нь ч бий. (Sano, 2000)

Хүснэгт 1. Бодлого төлөвлөлтийн хандлага, арга зүйн харьцуулалт

Хандивт суурилсан арга зүй	Хэрэгцээнд суурилсан арга зүй	Хүний эрхэд суурилсан арга зүй
Үр дүнд бус, орцод анхаарна	Үр дүнд бус, орцод анхаарна	Хэрэгжүүлэх үйл явц, үр дүнд анхаарна
Хандив, тусламжийг нэмэгдүүлэхийг чухалчилна	Хэрэгцээг хангахыг чухалчилна	Хүний эрхийн нөхцөл байдлыг үнэлэхэд анхаарна
Баян чинээлэг бүлэг, ядуу буурайдаа туслах ёстой	Хэрэгцээг хууль ёсны дагуу шаардаж байгаа мэтээр авч үзнэ	Хувь хүмүүс болон бүлгүүд өөрийн хуулиар баталгаажсан эрхээ, үүрэг хүлээгчдээс шаардана
Хувь хүмүүсийг хохирогчтой адилтган авч үзнэ	Хувь хүмүүсийг хөгжлийн үйл явцын объект, хөндлөнгийн оролцогч гэж үзнэ	Хувь хүмүүс болон бүлгүүдийг өөрийн эрхээ шаардах чадвартай болгоно
Хувь хүмүүс халамж, туслалцаа хүртэнэ	Хувь хүмүүс халамж, туслалцаа хүртэнэ	Хувь хүмүүс туслалцаа нэхэмжилнэ
Асуудлын өнгөц илрэлд анхаарна	Асуудлын өнгөц шалтгаанд анхаарна	Асуудлын үүдэл болсон суурь, тогтолцооны шалтгаан болон илрэлд анхаарна.

Монгол улсын хөгжлийн зарим асуудлуудын шийдлийг Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйгээр шинжилж үзвэл:

Кейс 1: Монгол улсын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, орлогын тэгш бус байдлын асуудлыг бодлого төлөвлөлтийн хандлага, арга зүйн ангиллуудаар шинжилж үзвэл уг асуудлыг шийдвэрлэхдээ Монгол улсад “Цалинтай ээж” хөтөлбөр, “Хүүхдийн мөнгө” зэрэг халамжийн хөтөлбөрүүд, мөн хүүхдээ асран гэртээ сууж хөдөлмөр эрхэлж чадаагүй хугацаанд нийгмийн даатгалыг нөхөн төлөх нөхцөл олгох зэрэг арга хэмжээг зонхилон авч хэрэгжүүлдэг ч төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа билээ. Гэвч эдгээр арга хэмжээнүүд нь хэрэгцээнд суурилсан арга зүйгээр боловсруулагдсан бөгөөд

санхүүгийн болон тэтгэвэр тогтоолгох хэрэгцээг хангахыг чухалчилжээ. Гэвч энэ нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хангалттай нэмэгдүүлэхгүй, цалин орлогын зөрүүг ойртуулж чадахгүй байгаа нь суурь шалтгааныг олж илрүүлээгүй байгаагаас үүдэж буй юм. Хүний эрхэд суурилсан хандлага арга зүйгээр уг асуудлын суурь шалтгааныг эрэлхийлбэл уг асуудал нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн зах зээл дээр эрэгтэй хүнтэй адил хэмжээнд үнэлүүлж чадахгүй ялгаварлан гадуурхагдах зэрэг асуудлаас үүдэж байна. Эмэгтэйчүүд хүүхэд төрүүлж, хүүхдээ асран, өсгөхдөө өөрийн ажил, карьераа орхигдуулдаг бөгөөд хүүхэд асрахыг зөвхөн эмэгтэйчүүдийн үүрэг хэмээн ойлгодог уламжлалт ойлголттой шууд хамааралтай байна. Тиймээс уг ойлголтыг бууруулах үүднээс хүүхэд асрах чөлөө, тэтгэмжийг эцэг эх ээлжилж авахыг хуульчлах боломжтой. Ингэснээр уламжлалт ойлголтыг халахад түлхэц үзүүлж, гагцхүү эмэгтэй хүн өөрийн ажил, карьерыг золиослон хүүхдээ харах биш гэр бүлийн эцэг эх аль аль нь уг хариуцлагыг тэнцвэртэйгээр үүрч, шинээр ажилд авахдаа хүүхэд төрүүлээд ажлаа завсарддаг тул эмэгтэй ажилчин авахгүй гэх мэт ажил олгогчоос тавьдаг зарим асуудлуудыг ч шийдвэрлэх боломжтой.

Кейс 2: Улаанбаатар хотын хамгийн том тулгамдсан асуудлуудын нэг болох замын түгжрэлийг шийдвэрлэх гэж оролдохдоо бид шинэ зам, гүүр барих, өргөсгөх ажлыг голчлон хэрэгжүүлдэг бөгөөд зарим тохиолдолд дугаарын хязгаарлалтын арга хэмжээг санаачлан хэрэгжүүлдэг. Эдгээр арга хэмжээнүүд нь мөн л иргэдийн автомашин унах хэрэгцээг хангахад чиглэн хэрэгцээнд суурилсан хандлага арга зүйг ашигласан нь харагдаж байна. Хэдий зам гүүр нэмж барьдаг хэдий ч жилээс жилд замын түгжрэл улам нэмэгдсэн үү гэснээс буурсангүй. Иймээс энэхүү хэрэгцээнд суурилсан арга зүйгээр боловсруулагдсан бодлогын арга хэмжээ бодит үр дүнд хүрээгүй байна. Харин хүний эрхэд суурилсан хандлага арга зүйгээр шинжилж үзэхэд нэгдүгээрт, автомашин унах нь хүний заавал эдэлбэл зохих эрх үү эсвэл эрүүл, аюулгүй орчинд амьдрах нь зайлшгүй эдлэх эрх үү гэдэг талаар эргэн харах шаардлага тулгарч байна. Мэдээж эрүүл, аюулгүй орчин амьдрах нь хүний зайлшгүй эдлэх эрх тул иргэдийн уг эрхийг хангахын тулд тэдний автомашин унах хэрэгцээг орлуулан хангах боломжтой. Дэлхийн олон оронд зам гүүрийг нэмж барих бус харин ч улам багасгаж, хувийн автомашин унахаас илүү унадаг дугуй зэрэг авто замын ачаалал үүсгэдэггүй ердийн хөсгүүд хэрэглэхийг дэмжиж, нийтийн

тээврийн хүртээмж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг авдаг бөгөөд энэ нь хамгийн үр дүнтэй арга гэдэг нь хангалттай батлагдсан билээ.

Кейс 3: *“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт хүний эрхэд суурилсан хандлагаар шинжилсэн ерөнхий шүүмж:*

Алсын хараа – 2050 баримт бичгийн өмнөтгөл хэсэгт:

“Нийгмийн хөдөлгөгч хүч болсон дундаж давхарга эмзэг, нимгэн байгаа нь тэгш бус байдлыг бий болгож, ардчиллын суурь үнэт зүйлийг ганхуулж эхэлж байгаа нь зөвхөн Монголд ч биш, дэлхий дахины тулгамдаж буй асуудал юм. Тэгш бус байдлаас улбаатай хүндрэл Монгол Улсын хувьд ч өнгөрсөн 30 жилийн үндсэн сорилт байв. Манай улсад ядуурлыг бууруулахад чиглэн халамжийн бодлого хангалттай үр дүнд хүрч чадаагүйг хөгжлийн суурь үзүүлэлтүүд нотолж байна. Цаашид нийгмийн дундаж давхаргаа дэмжих цогц бодлого баримталж ажиллах бодит шаардлага үүсэж байна.” хэмээн өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж ирсэн хөгжлийн бодлогуудын үр дүнд тэгш бус байдлыг бууруулах тал дээр хангалттай үр дүнд хүрч чадаагүйг онцлон тэмдэглэсэн байна.

Хэдийгээр өмнөх урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн залгамж халааг үргэлжлүүлж, алдаа дутагдлыг нь засаж боловсруулагдсан ч тэгш бус байдлыг бий болгож буй шалтгааныг бодлогын арга хэмжээнүүд оновчгүй, үр дүнгүй болсонтой холбож авч үзсэн нь ажиглагдаж байна. Үүнийг бодлогын арга хэмжээнүүд, үндсэн зорилтуудыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтээс харж болох бөгөөд тоон үнэлгээний арга зүйг ашигласаар байгааг анхааралдаа авч үзэх хэрэгтэй.

Зураг 1. “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийн жишээ

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар
2 нийгмийн хөгжил							
1	Хүний хөгжлийн индекс	индекс	0.74	0.8	0.85	0.9	2018 он суурь түвшин
2	Тэгш байдлыг хангасан сургуулийн эзлэх хувь*	хувь		85	90	100	Аюулгүй орчин бүрдсэн, Хүүхдийг үе тэнгийн дарамтаас хамгаалсан, хамран сургах тойргийнхоо эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүрэн хамруулсан, багшийн ажиллах орчин бүрдсэн
3	СӨБ-д хамрагдсан малчдын хүүхдийн хувь	хувь		85	90	100	Малчин өрхөд буй хүүхдээс СӨБ-д хамрагдсан хувийг тооцно.
4	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт хамран сургалтын бохир жин	хувь	75.3	95	99	100	2018 он суурь түвшин
5	Бага боловсролын хамран сургалт хамран сургалтын бохир жин	хувь	96.6	100	100	100	2018 он суурь түвшин
6	Суурь боловсролын хамран сургалтын бохир жин	хувь	97.1	100	100	100	2018 он суурь түвшин

Жишээлбэл шалгуур үзүүлэлт 2.1-д зааснаар тэгш байдлыг хангасан сургуулийн эзлэх хувийг 2050 онд 100 хувь буюу бүх сургуулийг тэгш байдлыг хангасан бөгөөд уг сургуульд бүх хүүхдийг сургана гэж тооцоолжээ. Мөн уг шалгуур үзүүлэлтээ тайлбарлахдаа Тэгш байдлыг хангасан сургууль гэдэг нь “Аюулгүй орчин бүрдсэн, хүүхдийг үе тэнгийн дарамтаас хамгаалсан, хамран сургах тойргийнхоо эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүрэн хамруулсан, багшийн ажиллах орчин бүрдсэн байна” хэмээн тодорхойлжээ. Гэвч уг шалгуур үзүүлэлтийг хангах бодлогын арга хэмжээг баримт бичигт “Сургуулийн барилга, байгууламж, суудлын тоог эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үе шаттай нэмэгдүүлж бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд барих, орчны стандартын дагуу хүүхэд бүрд ээлтэй, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх тохижуулна.” хэмээн тусгажээ.

Уг арга хэмжээний үр дүнд сургууль цэцэрлэгийн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд л анхаарч байгаа ч сургуулийн орчныг хэрхэн үе тэнгийн дарамтгүй болгох, хэрхэн сурагчдын суралцах орчныг аюулгүй болгох талаар тусгаагүй байна.

Үүнээс нэгтгэн дүгнэхэд Алсын хараа-2050-ийг боловсруулахдаа хүний эрхэд суурилсан шинжилгээ хийгээгүй бөгөөд арга хэмжээг төлөвлөхдөө төсөв, санхүү, нөөцийг л тооцоолсон бөгөөд бодлогын үр шим хүртэгч сурагчдын нөхцөлийг хэрхэн сайжруулах талаар авч үзээгүй байна. Сургууль, цэцэрлэгийн тоо, суудлыг нэмэгдүүлж материаллаг орчныг сайжруулахыг бодлогын арга хэмжээндээ тусгаад, үр дүнгээ аюулгүй орчин бий болгох гэж тооцоолж, тухайн үр дүнгээ 100 хувьд хүргэх зорилго тавьсан нь сургуульд сурч буй хүүхдүүдийн тоог нэмэгдүүлэх хэдий ч тухайн хүүхдүүд чанартай боловсролыг аливаа дарамт, гэмт хэрэг зэргээс хамгаалагдсан аюулгүй орчин болгосон байдлаа үнэлж чадах эсэхт эргэлзээ төрүүлж байна.

Дүгнэлт

Уламжлалт арга зүйгээр бодлого боловсруулахдаа судлаачид, бодлого боловсруулагчид хяналт, шинжилгээ үнэлгээ хийхэд хялбар, бодитоор үнэлэгдэхүйц нөхцөлийг харгалзах үүднээс тоо баримт, статистикийг голчлон харгалздаг байсны дүнд бодлогын үр шим иргэдэд ялгаатай хүрч нийгэмд тэгш бус байдал үүсэх үндсэн шалтгаануудын нэг болж иржээ.

Бодлогын баримт бичиг нь нийгэмд хэрэгжиж буй арга хэмжээнүүдийг залж чиглүүлдгийн хувьд ямар агуулгаар хэрхэн бичигдсэнээс хамаарч засгийн газар өөрт буй хүний нөөц, санхүүгийн нөөцөө зарцуулдаг билээ. Тиймээс төрийн үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай нэн тэргүүний алхам бол бодлогын баримт бичиг боловсруулах арга зүйдээ шинэчлэлт хийж, нийгэмд тулгамдаж буй хэрэгцээ шаардлагаа зөв үнэлж, бодлогын баримт бичгээ чанартай боловсруулах шаардлагатай.

Өмнө боловсруулж хэрэгжүүлсэн бодлогуудын үр дүнд тэгш бус байдал буурахгүй байгаа бол бодлогын арга хэмжээгээ өөрчлөх шаардлагатайг бодлогын шинжилгээний консерватив онолуудад ч чухалчлан авч үзсэн байдаг билээ. Тэгш бус байдал буурахгүй, бодлогууд хангалттай үр өгөөжөө өгөхгүй байгаа нь судлаачид, бодлого боловсруулагчид бодлогын хувилбар арга хэмжээгээ өөрчилсөн ч шинжилгээ, боловсруулалтын арга зүйгээ шинэчилж өөрчлөхгүй байгаа нь бодлогын үр нөлөөг сулруулж байна.

Төрөөс авч хэрэгжүүлж буй аливаа бодлогын үр дүнд иргэдийн амьдарч буй нөхцөлд дорвитой өөрчлөлт гарахгүй байгааг эрдэмтэн судлаачид онцлон ажиглаж, цаашид хэрхэн бодлогын арга хэмжээнүүдийг сайжруулж болохыг эрэлхийлж буй өнөө үед хөгжлийн бодлого төлөвлөлт, боловсруулалтын

шинжилгээний арга зүйдээ хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг авч хэрэглэснээр тулгамдаж буй бодлогын асуудлыг суурь шалтгааныг зөв танин илрүүлж, бодлогын үр шим хүртэгч иргэдэд илүү таатай, аюулгүй орчин, тэдний эрхийг баталгаатайгаар эдлүүлсэн нийгмийг бүтээхэд томоохон түлхэц үзүүлэх болно.

Abstract

Many developing countries are adopting specific methods and approaches to developing development policy documents and developing them and using them in public policy planning. Further study of the issues to be considered in the development of development policy documents will provide an opportunity to map Mongolia's development and manage the development process. The government spends its human and financial resources depending on the content of the policy document, as it guides the activities to the society. Therefore, the first step in improving the functioning of the government is to reform the methodology for developing policy documents, to properly assess the needs of society, and to develop quality policy documents.

Ашигласан ном, материал

Annan, K. (2005). НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын илгээлт. *НҮБ-ийн Ерөнхий Ассемблей*. Нью Йорк: НҮБ.

DANIDA. (1997). *Evaluation of fulfillment of the main elements in Strategy for Danish Development Policy*. Copenhagen: DANIDA.

Lee, J. Y., & Anderson, C. (2008). *Policy analysis*. Seoul: Daeyoung Moonhwas Publishing.

Micheal Moran, M. R. (2006). *The Oxford handbook of public policy*. Oxford: Oxford University Press.

Sano, H.-O. (2000). Development and Human Rights: The Necessary, but Partial Integration of Human Rights and Development. *Human Rights Quarterly*, 37-52.

Uvin, P. (2007). From the right to development to the rights-based approach: how 'human rights' entered development. *Development in Practice*, 597-606.

Г.Чулуунбаатар. (2007). Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлогын зарим асуудал. *Бодлогын шинжилгээ*, 61.

Монголын Залуучуудын Эвсэл. (2019). *Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн*

хэлэлцүүлгийн гурав дахь мөчлөгт илгээж буй мэдээлэл. Улаанбаатар:
Монголын Залуучуудын Эвсэл.

Үндэсний хөгжлийн газар. (2018). *Монгол Улсын хөгжлийн нэгдсэн
төлөвлөлтийг хийх нийтлэг аргачлал (Тайлан V)*. Улаанбаатар.

Ц.Батболд. (2019). *Бодлогын шинжилгээний онол, арга зүйн үндэс*.

Улаанбаатар: Удам соёл.

Эдийн засгийн хөгжлийн яам. (2015). Хөгжлийн бодлого төлөвлөлтийн гарын
авлага. 22-23.

Эдийн засгийн хөгжлийн яам. (2015). Хөгжлийн бодлого төлөвлөлтийн гарын
авлага. 22-23.

Я.Бямбасүрэн, & П.Доржсүрэн. (2006). *Төрийн бодлого*. Улаанбаатар:

Удирдлагын академи.

James. A & Rhodes.R. (eds.). The Policy Studies Perspective. *Public administration
Review*, 40(4).

Hakim.C. (1982). *Secondary analysis research*. London.

**Ковид 19-Г ДОТООДДОО АЛДСАН ҮЕИЙН БОДЛОГО НИЙГМИЙН СЭТГЭЛ
ЗҮЙД НӨЛӨӨЛСӨН БАЙДАЛ**

Д.Бумдарь

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Б.Хишигням

МУИС, Элсэлт бүртгэлийн хэлтсийн дарга

М.Тэгшбуян

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Боловсрол, сэтгэл судлалын тэнхимийн дадлагажигч багш

Түлхүүр үг: ковид, өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорио, сонгууль, нийгмийн сэтгэл зүй, айдас

Агуулга

- *Ковид-19 Улс төрийн эрсдэлийн менежментийн тогтолцоо*
- *Ковидыг дотооддоо алдсан үеийн бодлого*

Судалгааны үр дүн (сэтгэл зүйн проектив арга)

- *Ковид 19 Айдас ба зовиол*
- *Хандлага, харилцаа ба итгэл*

Судалгааны үндэслэл

Дэлхийн дахинд шинэ төрлийн халдварт вирус дэлгэрсэнтэй холбоотойгоор ДЭМБ цар тахал хэмээн зарлаж улс орнууд өөрсдийн эрсдэлийн менежментийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 62²⁰ дугаар тогтоолын 4-т заасныг үндэслэн 2020 оны 02

²⁰ <https://www.legalinfo.mn/law/details/15081?lawid=15081>

дугаар сарын 13-ны өдөр УОК-ын даргын тушаал²¹-аар “Гамшгаас хамгаалах тухай хууль”²²-ийн 11.2, 11.3.3-т заасныг үндэслэн “өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т хэсэгчлэн шилжин ажилласан болно. Манай улсын хувьд дотоод халдвар 11 сарын 11-нд зарлагдан 12-ны өдрөөс УОК-ын саналын дагуу Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн болно.

Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой нийгмийн дунд эргэлзээ, үл итгэх байдал хүчтэй илэрч байна. Учир нь гаргасан шийдвэр болгон нь өдөр бүр өөрчлөгдөх, баттай эх сурвалжын мэдээлэл хоорондоо зөрөх зэрэг тодорхойгүй гайхсан байдалтай эхний долоо хоног өнгөрсөн болно. Энэхүү байдалтай зэрэгцэн аж ахуй нэгж, иргэдийн эдийн засгийн байдал, өдөр тутмын үйл ажиллагаанд зохицуулалт хийх, авах арга хэмжээ мөн тодорхой бус байсан нь нийгмийг ихэд бухимдуулсан.

Товчхондоо дүгнэж үзэхэд өндөржүүлсэн бэлэн байдлын үе буюу 10 сарын турш УОК-ын хийсэн үйл ажиллагааны үр дүн гарсангүй хэмээн хэлж болох юм. Иймээс төрийн засаглалын чадамжид эргэлзэх нийгмийн уур амьсгал бүрэлдсэн байна хэмээн үзэн нөлөөлсөн хүчин зүйлсийн судалгаа хийхийг зорьсон.

Судалгааны гол зорилгын хүрээнд дараах асуудлыг судлан гаргах зорилт тавьж байна.

- Улс төрийн эрсдэлийн менежментийн тогтолцоо манайд байгаа эсэх (Political crisis management system)
- Хөл хорио, засгийн газрын шийдвэрүүд, хэрэгжилт, түүнээс үүдэлтэй нийгэм-сэтгэл зүйн зарим онцлогийг илрүүлэх (Нийгэм-сэтгэлзүй (Psycho-social) нь нийгмийн хүчин зүйлс болон хувь хүний хандлага, бодол санаа, зан үйлийн харилцан хамаарлыг хэлдэг)

Ковид-19 Улс төрийн эрсдэлийн менежментийн тогтолцоо

²¹<https://nema.gov.mn/wpcontent/uploads/2020/02/%D0%A3%D0%9E%D0%9A-%D1%8B%D0%BD-%D0%B4%D0%B0%D1%80%D0%B3%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%88%D0%B0%D0%B0%D0%BB%E2%84%9604.pdf>

²²<https://www.legalinfo.mn/law/details/12458?lawid=12458>

Улс төрийн эрсдэлийн менежмент (political crisis management)²³ гэдэг энэхүү нэр томъёо нь орчин үеийн эрсдэлийн менежментэд засаглалын онцлог, хэв маягыг илэрхийлэхэд хэрэглэгддэг. Тодруулбал нийгэм бүхэлдээ эх баригчдаас эрсдэлийн нөлөө хамгийн бага байхыг шаарддаг бол сөрөг хүчин хэвлэл мэдээллийн сувгыг ашиглан бодлогын шүүмжийг хүчтэй өрнүүлэх ба үүнээс хэрхэн сэргийлж байгааг улс төрийн эрсдэлийн менежмент гэж ойлгож болно. Ийм хоёр туйлын нөхцөлд бодлого тодорхойлогч хамгийн боломжит хувилбарыг сонгох байдлыг улс төрийн эрсдэлийн менежмент сайн эсвэл засаглал сайн байна гэж үзэж болох юм.

Аливаа эрсдэл нь дараах үндсэн гурван шинжийг агуулсан байдаг гэж үздэг уламжлалт хандлага байна.

- Эрсдэл, хямрал нь урьдчилсан таамаглах аргагүй
- Гаргасан шийдвэрүүд нөхцөл байдалд тохирохгүй байх, үр дүнд хүрэхгүй байх
- Аливаа шийдвэрүүдийг түргэн шуурхай гаргах, яаралтай өөрчлөх²⁴ гэсэн шинжүүдтэй.

Тиймээс эрсдэлийн менежмент нь аюулыг урьдчилан тооцоолж, шинжлэх ухааны үндэслэлтэй өөрийн нөөц боломж, чадавхид таарсан хувилбаруудыг бодлогын түвшинд боловсруулсан байхыг хэлж байгаа юм.

Шийдвэр гаргагчид эрсдэлийн менежмент хийхдээ дараах зүйлсийг зайлшгүй анхаарах ёстой. Үүнд:

- Мэдрэмжтэй байх (Sense making)
- Шийдвэр оновчтой гаргах, гаргасан шийдвэр нь үр дүнтэй байх ёстой (Decision making and coordinating implementation)
- Бодож тунгаах, судлах (Meaning making)
- Тооцоололтой, дуусгаж сурах (Accounting and ending)
- Амжилт, алдаанаас суралцах (Learning)²⁵

²³ <https://www.controlrisks.com/jp/our-thinking/japanese/covid-19-uncertainty>

²⁴ Boin, A., 't Hart, P., Stern, E., & Sundelius, B. (2005). Crisis management in political systems: Five leadership challenges. In *The Politics of Crisis Management: Public Leadership Under Pressure* (pp. 1-17). Cambridge: Cambridge University Press. doi:10.1017/CBO9780511490880.001

²⁵ Boin, A., 't Hart, P., Stern, E., & Sundelius, B. (2005). Crisis management in political systems: Five leadership challenges. In *The Politics of Crisis Management: Public Leadership Under Pressure* (pp. 1-17). Cambridge: Cambridge University Press. doi:10.1017/CBO9780511490880.001


Дээрх байдлыг шийдвэр гаргалтын үе шатан шингээж өгөхгүй бол тухайн шийдвэр ямар нэгэн үр дүнгүй болж дуусах юм. Монгол улс цар тахалтай холбоотой шийдвэр гаргалт, үр дүнгийн талаар нийгэм таатай бус байгаа нь улс төрийн эрсдэлийн менежмент сул байна гэж дүгнэх боломжтой.

Монгол улсын цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээг өнөөдрийн байдлаар дараах үе шаттай хувааж үзэх боломжтой. Үүнд:

- Эхэн үеийн бодлого (цар тахлаас сэргийлэх, гаднаас зөөгдөж анхны халдвар илэрсэн)
- Цар тахал ба Сонгуулийн үеийн бодлого
- Ковидыг дотооддоо алдсан үеийн бодлого


Мөн манай улсад онцгой байдлын үед шийдвэр гарах, чиглэл өгөх удирдлагын тогтолцооны бүтэц хэрэгжих үе шатыг дараах схемүүдээр үзүүлье.

Схем.1. Онцгой байдлын ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт



Эх сурвалж: Судлаач өөрөө бэлтгэв.

Схем.2. Монгол Улсын онц байдлын үед шийдвэр хэрэгжих үе шат түүний
бүрэн зураглал



Эх сурвалж: Судлаач өөрөө бэлтгэв.

Манай улсад аюулгүй байдал, нийгмийг хамарсан аливаа гамшгийн үед ҮАБЗ-өөс Улсын Онцгой комисс, УИХ-аас Засгийн газар төлөөлөн хэрэгжүүлэх чиг дараалалтай байдаг. Онцгой байдлын ерөнхий комиссыг удирдан зохион байгуулах үүргийг Засгийн газарт бүрэн хариуцуулсан байдаг болохыг харж болж байна. Энэ чиг үүргийн дарааллаар бол манай улс бусад улс орнуудтай ижил гүйцэтгэх засаглалаас шийдвэр гаргалтыг хэрэгжүүлдэг байдал нь ижил байна.

Тэхээр цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дээрх схемийн дагуу харвал Засгийн газраас гарсан шийдвэр нь хамгийн эцсийн шийдвэр байдаг болохыг харах боломжтой байна. Нөгөө талаас эрх баригч намын засаглалын чадамж, улс төрийн эрсдэлийн менежмент байгаа эсэхийг харах боломжтой гэсэн үг юм.

Ковидыг дотооддоо алдсан үеийн бодлого

2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн газрын хуралдааны шийдвэр гаран анх удаа Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гарсан. Энэхүү шийдвэр гарсан цагаас эхлэн цар тахал дотооддоо алдсан тохиолдолд бид бэлэн эсэхэд эргэлзсэн шийдвэр, чиглэлүүд хөвөрч эхлэсэн болно.

Тухайлбал, хувийн унаа унах эсэх, дэлгүүр орох цагт хязгаарлалт хийх, яаралтай эмнэлгийн тусламж авах зэрэг хүний анхан шатны хэрэгцээг хэрхэн зохицуулсан талаар зааварчилгаа улс орон даяар олж хараагүй болно. Ковид 19-ийн эсрэг хуульд заасан “хүнийг ялгаварлан гадуурхаагүй, нэр төрийг нь доромжлоогүй байх” шаардлага нь анхны голомтын эерэг гарсан иргэний овог нэр, регистрийн дугаар нь орон даяар цацагдахад хуулийн хэрэгжилт хангах талаар шийдвэр гаргагчдын зүгээс дорвитой шийдвэр авч чадахгүй байсан.

Харин нийгмийн зүгээс шүүмжлэлтэй хандсаны үр дүнд хүний эрхийн зөрчлүүдийг засаж явсан. Мөн УОК, НОК-ийн уялдаагүй үйл ажиллагаанаас үүдэн гарсан шийдвэр нь маш их дарамт, хүнд суртал, хүний суурь эрхийг зөрчсөн үйлдлүүд болж байсан хэдий ч нэг сарын турш хатуу хөл хориог нийгмээрээ даван туулсан болно. Энэ хугацаанд эрх баригчдын улс төрийн манлайлал, эрсдэлийн менежмент хийгээгүй, бодлогын сонголтгүй, чадамжгүй байдалд нийгмээрээ үнэлгээ тавьсан болно.

Улмаар бүх шатны сонгуулиуд дуусаад ийнхүү дотооддоо халдварласан байдал нь хяналт сул, ялалтанд бялуурсан, бялуу хуваагдалт хүчтэй өрнөсөн, эрх мэдлийн шилжилтийн зай үүссэн нөхцөлтэй шууд хамаатуулж ойлгохоор улс төрийн хариуцлагагүй байдал гэж хэлж болно.


Цар тахал дотооддоо алдаж гаргасан шийдвэрүүд нийгэмд хэрхэн үнэлэгдэж байгааг дараах судалгаар үзүүлье.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Түүврийн бүтэц:

Судалгаанд нийт 196 хүн оролцсоноос эрэгтэй 17.3 хувь, эмэгтэй 83.2 хувийг эзэлж байна. Оролцогчдын насны медиан нь 29 ба 16-89 насны хооронд байлаа. Улаанбаатар хотын оролцогчид 84.7 хувь бол 16.3 хувь нь орон нутгийнх, оролцогчдын 75 хувь нь дээд боловсролтой, 24 хувь нь бүрэн дунд боловсролтой, 1.5 хувь нь бүрэн бус дунд боловсролтой.

Ажил эрхлэлтийн байдлыг харахад, оюутан, төрийн байгууллага, хувийн хэвшилд ажилладаг хүмүүсийн оролцоо их байв.



НЭГ. АЙДАС БА ЗОВИНОЛ

Ирээдүйд айх айдас:

Судалгаанд оролцогчид ирээдүйн 1-2 жилийн хугацаанд хамгийн их айж байгаа зүйлийг дараах байдлаар үзжээ. Үүнд:



Одоогийн нөхцөл байдалтай холбоотойгоор ирээдүйд цар тахал дуусахгүй, өвчин ихээр гарах, эдийн засаг муудах, ажлын байргүй болох, ЕБС, их, дээд сургуулийн боловсролын чанар муудах, боловсрол муутай хүмүүс бий болох,

КОВИД-ийн эмчилгээ хүртээмжгүй байхаас хамгийн их айж байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа. Бусад хэсгийг дэлгэрэнгүйгээр харвал:

Улс төрөөс, Дэглэмээс

Бизнесээс

Вакцин гарахгүй байх, үр дүнгүй байх, хүртээмжгүй байхаас

Ковидоос болж хүмүүс нас барахаас

Мэдэхгүй

Гэр бүл эрсдэлт орох вий гэхэс

Хүчирхийллээс

Шударга бус байдлаас

Ядуурлаас

Агаарын бохирдлоос

Архидалтаас

Ахмад настнуудад санаа зовж, айж байна

Бослого, хөдөлгөөн гарахаас

Ёс суртахуунгүй байдлаас

Өр, зээлнээс

Тусгаар тогтнолоо алдахаас

Хүнсний аюулгүй байдлаас

Цалин орлого багасахаас

Барааны хомсдол үүсэхээс

Ирээдүйн 1-2 жилийн хугацаанд айж байгаа зүйлийг Улаанбаатар хот болон орон нутгийн хувьд ялган харуулбал:

Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын хувьд		Орон нутгаас судалгаанд оролцогчдын хувьд	
Цар тахал дуусахгүй, өвчин гарах	16.20%	Эдийн засаг муудах	30.80%
Ажлын байргүй болох	9.70%	Боловсрол муудах	19.20%
Эдийн засаг муудах	8.40%	Цар тахал дуусахгүй, өвчин гарах	15.40%
Боловсрол муудах	7.80%	Ажлын байргүй болох	11.50%
Эрүүл мэнд, ковидын эмчилгээ хүртээмжгүй байх	7.80%	Айх зүйл алга	11.50%
Хил нээхгүй байх, гадаад явж чадахгүй	6.50%		

Ирээдүйдээ айх айдсыг ажил эрхлэлтийн байдалтай харьцуулан харахад:

Оюутнуудын хувьд:	Төрийн байгууллагын албан хаагчдын хувьд:	Хувийн хэвшилд ажилладаг хүмүүсийн хувьд:	Хувиараа хөдөлмөрлөдөг хүмүүсийн хувьд;	Тэтгэврийн хүмүүсийн хувьд:	Ажилгүй хүмүүсийн хувьд
Боловсрол муудах	Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Эрүүл мэндийн үйлчилгээ ковидын эмчилгээ	Боловсролын чанар муудах	Хорио цээр үргэлжилж гэртээ байх	Хил нээхгүй байх, гадаад явж чадахгүй

		хүртээмжгүй байх			
Эдийн засаг муудах	Ажлын байргүй болох	Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Бизнесгүй болох	Боловсролын чанар муудах	Төрийн шийдвэр буруу, оновчгүй байх
Хил нээхгүй байх, гадаад явж чадахгүй			Вакцин гарахгүй байх, үр дүнгүй байх, хүртээмжгүй байх	Архидалт	Цар тахал дуусахгүй, өвчин гарах
Цар тахал дуусахгүй, өвчин гарах			Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Вакцин гарахгүй байх, үр дүнгүй байх, хүртээмжгүй байх	Ажил олдохгүй байх
			Ажлын байргүй болох	Ёс суртахуунгүй байдал	
				Тусгаар тогтнолоо алдах	
				Хүчирхийлэл	
				Цар тахал дуусахгүй, өвчин гарах	
	Ядуурал				

Ирээдүйд айх айдсыг хүйсийн хувьд ялгаатайгаар харахад:

Эрэгтэй хүмүүсийн хувьд	Эмэгтэй хүмүүсийн хувьд
Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Цар тахал дуусахгүй, өвчин гарах
Хорио цээр үргэлжилж гэртээ байх	Боловсролын чанар муудах
Эдийн засаг муудах	Эдийн засаг муудах

Төрийн шийдвэр буруу, оновчгүй
байх

Эрүүл мэндийн үйлчилгээ, ковидын
эмчилгээ хүртээмжгүй байх

Яг одоо айж байгаа айдас:

Яг одоо айж байгаа зүйлээ судалгаанд оролцогчид дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

1	Цар тахал дуусахгүй, өвчин гарах
2	Боловсролын чанар муудах
3	Архидалт
4	Хорио цээр үргэлжилж гэртээ байх
5	Цалин, орлого, өрхийн санхүүгийн байдал
6	Гэр бүл эрсдэлд орох
7	Вакцин гарахгүй байх, үр дүнгүй байх, хүртээмжгүй байх
8	Ёс суртахуунгүй байдал
9	Төрийн шийдвэр, арга хэмжээ оновчгүй байх
10	Эдийн засаг, санхүү муудах
11	Эрүүл мэндийн үйлчилгээ, ковидын эмчилгээ
12	Улс төр, төрийн байгууллагын үйл ажиллагаа
13	Өр, зээл

Одоогийн айдсыг хүйсийн хувьд ялгаатайгаар харахад:

Эрэгтэй хүмүүсийн хувьд	Эмэгтэй хүмүүсийн хувьд
Архидалт	Архидалт
Боловсролын чанар муудах	Боловсрол муудах
Ёс суртахуунгүй байдал	Цар тахал дуусахгүй, өвчин их тархах
Хорио цээр үргэлжилж, гэртээ байх	
Цалин, орлого багасах, өрхийн санхүү	
Цар тахал дуусахгүй, өвчин их тархах	

Байршлын ялгаатай байдлаар нь харахад дараах үр дүн гарлаа.

Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын хувьд	Орон нутгаас судалгаанд оролцогчдын хувьд
Цар тахал дуусахгүй, өвчин их тархах	Цар тахал дуусахгүй, өвчин их тархах
Архидалт	Төрийн шийдвэр, арга хэмжээ
Боловсролын чанар муудах	
Цар тахал дуусахгүй, өвчин их тархах	

Боловсролын түвшингөөр нь ялгаатайгаар харахад, дийлэнх хувийг дараах айдсууд үзүүлж байна.

Бүрэн бус дунд боловсролтой

Бүрэн дунд боловсролтой

Дээд боловсролтой

Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Архидалт	Архидалт
Мэдэхгүй	Боловсролын чанар муудах	Боловсролын чанар муудах
	Төрийн шийдвэр, арга хэмжээ оновчгүй байх	Цар тахал дуусахгүй, өвчин их тархах
	Хорио цээр үргэлжилж, гэртээ байх	

Санаа зоволттой холбоотой асуудлууд:

Судалгаанд оролцогчид гэр бүлийнхээ хувьд хамгийн их санаа зовж байгаа зүйлийг дараах байдлаар үзжээ. Үүнд:



Дэлхий дахинд тархаад байгаа КОВИД-19 цар тахал дуусахгүй, цаашид улам их тархах, эдийн засаг, санхүү хямрах, цалин орлого буурах, сургуулиудийн боловсролын чанар муудах, эрүүл мэндийн үйлчилгээ болон КОВИД-ийн эмчилгээ хүртээмжгүй байхаас хамгийн их санаа зовж байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа. Түүнчлэн агаар орчны бохирдол, ажлын байргүй болох, хүнс ба барааны хомсдолд орох, өр зээлээ төлж чадахгүй болох, орон байргүй болох, төр засгийн шийдвэр арга хэмжээ буруу байх, вакциний хүртээмж, хөл хорио удаан үргэлжлэх зэрэг асуудалд санаа зовж байна.

Гэр бүлийнхээ хувьд санаа зовж байгаа зүйлийг Улаанбаатар хот болон орон нутгийн хувьд ялган харуулбал:

Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын хувьд		Орон нутгаас судалгаанд оролцогчдын хувьд	
Цар тахал үргэлжилж, тархах	38.90%	Цар тахал үргэлжилж, тархах	46.40%
Эдийн засаг, санхүү хямрах	18.50%	Эдийн засаг, санхүү хямрах	10.70%
Цалин, орлого буурах	8.30%	Цалин, орлого буурах	14.30%
Ядуурал	3.20%	Ядуурал	7.10%
Эрүүл мэнд, ковидын эмчилгээ хүртээмжгүй байх	6.40%	Эрүүл мэнд, ковидын эмчилгээ хүртээмжгүй байхаас	3.60%

Гэр бүлийнхээ талаар санаа зовж байгаа зүйлсийг боловсролын хувьд ялган харуулбал:

Санаа зовж буй зүйлс	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Дээд
Цар тахал үргэлжилж, тархах	0%	40.9%	40.6%
Эдийн засаг санхүү хямрах	33.3%	13.6%	18.1%
Хөл хорио удаан үргэлжлэх	33.3%	6.8%	2.2%

Цалин орлого буурах	0%	6.8%	10.1%
Боловсролын чанар муудах	0%	2.3%	8.7%
Эрүүл мэнд, ковидын эмчилгээ хүртээмжгүй байх	0%	0%	8%

Гэр бүлийнхээ талаар санаа зовж байгаа зүйлсийг ажил эрхлэлтээр ялган харуулбал:

Гэр бүлийн хувьд санаа зовж буй зүйлс	Оюутан	Төрийн байгууллага	Хувийн хэвшил	Хувиараа	Тэтгэвэрт	Ажилгүй
Цар тахал үргэлжилж , тархах	33.9%	53.8%	40.5%	23.1%	0%	38.5%
Эдийн засаг санхүү хямрах	21.4%	13.5%	14.3%	30.8%	20%	15.4%
Цалин орлого буурах	8.9%	5.8%	14.3%	15.4%	0%	7.7%
Ажилгүйдэл	5.4%	0%	0%	7.7%	0%	7.7%

Судалгаанд оролцогчид улс орны хувьд хамгийн их санаа зовж байгаа зүйлийг дараах байдлаар үзжээ. Үүнд:



Судалгаанд оролцогчид эдийн засаг хямрах, цар тахал үргэлжилж, тархах, улс орноороо өрөндөө баригдаж, цаашилбал газар нутгаа алдахад хүрэх вий, одоогийн цар тахлын нөхцөл байдалтай холбоотой болоод мөн цаашид төр засгийн зүгээс буруу шийдвэр гаргах, ядууралд нэрвэгдэх, хэт их улс төржих, чадваргүй хүмүүс эрх барих зэрэгт хамгийн ихээр санаа зовж байна. Бусад санаа зовж буй зүйлст авлига, ёс суртахууны доройтол, ажилгүйдэл, ард түмний амжиргааны түвшин буурах, ардчилал, хүний эрх, эрх чөлөө хумигдах, аюулгүй байдал, гэмт хэрэг, хүчилхийлэл зэргийг авч үзсэн байна.

Улс орны хувьд санаа зовж байгаа зүйлийг боловсролын байдлаар ялган харуулбал:

Улс орны хувьд санаа зовж буй зүйлс	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Дээд
Эдийн засгийн хямрал	33.3%	34.9%	34.6%
Авлигад идэгдэх	33.3%	2.3%	2.9%
Амьжиргаа доройтох	33.3%	0%	0.7%

Өр зээлэнд баригдах	0%	9.3%	8.8%
Төрийн шийдвэр, арга хэмжээ буруу байх	0%	2.3%	10.3%

ХОЁР. ХАНДЛАГА, ХАРИЛЦАА БА ИТГЭЛ

Судалгаанд оролцогчдын хөл хорио, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа шийдвэрүүд, КОВИД 19, эрх чөлөөнд хандах хандлагыг судлахад дараах үр дүн гарлаа.

Хөл хорионд хандах хандлага:



Судалгаанд оролцогчдын 57 хувь нь хөл хориог

- Өвчин тарах эсрдлээс хамгаалсан зөв алхам, зөв шийдвэр
- Шинэ зүйл сурах, өөрийгөө хөгжүүлэх, гэр бүлийнхэнтэйгээ илүү ойр харилцах боломжийг бий болгосон гэж үзэн эергээр хандаж байна.

Харин 38 хувь нь хөл хорионд сөрөг хандлагатай байна.

- Эдийн засаг, гэр бүлийн санхүү хэцүү байна
- Боломжууд хягзаарлагдмал
- Гэрийнхнээс хол байгаа хүмүүсийн хувьд хэцүү байна
- Цаг хугацааг хий дэмий өнгөрүүлж байна
- Уйтгартай, ганцаардмал байна
- Гэр хороорлолд амьдарч байгаа сурагчид хичээлээс их хоцорч байгаа. Олон хүүхэдтэй айл өрх хичээлүүдийг нөхөж үзэх боломж бага
- Гэр бүл, хүүхдийн хүчирхийлэл гарч байна.
- Ажлын хамт олон, өдөр тутмын тогтсон хэмнэлээ санаж байна.

Хөл хорионд хандах хандлагыг хүйс, байршлын хувьд ялгаатай эсэхэд статистик шинжилгээ хийж үзэхэд илэрхий ялгаатай байдал гарсангүй. Харин боловсролын хувьд болон ажил эрхлэлтийн байдлаас шалтгаалан хандлага нь өөр байна. Энэ үр дүнг дэлгэрүүлэн харуулбал:

Боловсролын түвшингөөр нь:

	Бүрэн бус дунд боловсролтой	Бүрэн дунд боловсролтой	Дээд боловсролтой
Эерэг хандлагатай	66.7%	52.9%	58%
Сөрөг хандлагатай		46.6%	35.3%
Нейтраль хандлагатай	33.3%	0.5%	6.7%


Бүрэн бус дунд боловсролтой хүмүүсийх дийлэнх нь эерэг хандаж, сөрөг хандлагагүй болох нь судалгааны үр дүнгээс гарч байна.

Ажил эрхлэлтээр нь:

	Оюутан	Төрийн байгууллагад ажилладаг	Хувийн хэвшилд ажилладаг	Хувиараа бизнес эрхэлдэг	Ажилгүй	Тэтгэвэрт
Эерэг хандлагатай	45.5%	74.5%	57.1%	53.9%	61.5%	30%
Сөрөг хандлагатай	50.9%	21.5%	33.3%	46.2%	38.5%	70%
Нейтраль хандлагатай	3.6%	4%	9.6%			

Төрийн байгууллагад ажилладаг хүмүүс болон ажилгүй хүмүүсийн хувьд хөл хорионд хандах эерэг хандлага давамгайлж байгаа бол тэтгэвэрт байгаа хүмүүсийн хувьд сөрөг хандлага дийлэнх нь байна. Тэтгэврийн хүмүүст нийгмийн харилцаа, үр хүүхэд, ач зээтэйгээ уулзах, найзуудтай уулзах, гадуур гарах хэрэгцээ их байгаа нь тэдний сөрөг хандлагаас харагдаж байна.

Засгийн газрын шийдвэрүүдэд хандах хандлага:



Судалгаанд оролцогчдын 52 хувь нь Засгийн газрын шийдвэрүүдэд сөрөг хандлагатай байна. Үүнд:

- Хот суурингийн том хаусанд амьдардаг хүмүүс цахилгаан, ус, дулааны хэрэглээндээ хэдэн зуун мянгыг төлдөг бол хөдөө орон нутгийн иргэд бага төлбөр төлдөг гэх мэт ялгаатай. Гэр хорооллын зөөврийн усны төлбөрийн талаар оновчтой арга хэмжээ аваагүй.
- Иргэдээ чин сэтгэлээсээ бодоогүй дараагийн сонгуулийн шоу
- Судалгаа, шинжилгээний үндэслэлгүй шийдвэрүүд
- Нэг гаргасан шийдвэртээ үнэнч бус, эргэж буцдаг, төрийн удирдлагууд чадваргүй байна.
- Засгийн газрын шийдвэрүүд ямарч уялдаа холбоо байхгүй. Халамж гэсэн хавтгайруулсан бодлогоос болоод маш олон тооны хүмүүс юу ч хийхгүй амьдарч болно гэсэн ойлголттой болж байна.
- Зөв шийдвэрийг хэрэгжүүлэх шатандаа буруу үйл ажиллагаа явуулж байна.

Харин 38 хувь нь Засгийн газрын шийдвэрийг зөв зүйтэй, ард иргэддээ дэмжлэг болсон гэж эергээр хандсан байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа.

Засгийн газрын шийдвэрүүдэд хандаж байгаа хандлагыг хүйс, боловсролын түвшин, байршил, эрхэлж буй ажлын ялгаатай байдлаар нь статистик шинжилгээ хийж үзэхэд илэрхий ялгаа гарсангүй.

Ирээдүйд Засгийн газартаа хандах хандлага:

Судалгаанд оролцогчдын хандлага:



Судалгаанд оролцогдын 45 хувь нь ирээдүйд Засгийн газартаа сөргөөр хандаж байна. Үүнд:

- Ард иргэддээ мөнгө тараах биш ажлын байраар хангах шаардлагатай байна.
- Хэрвээ сэтгэл хөдлөлөөрөө гаргасан шийдвэрээ үргэлжлүүлсээр байвал ард иргэд ойрын хэдэн жил хэцүүхэн амьдрал туулах болно
- Маш олон тооны өр зээл бондын эргэн төлөлт ойртож байхад сонгуулийнхаа PR хийсээр маш олон өнөө маргаашаа аргацаасан шийдвэр гаргаж байгаа нь харамсалтай. Манай улс сонгуулиас сонгуулийн хооронд амьдардаг нь ажиглагддаг.
- Жинхэнэ ард иргэдийнхээ амьдралд тус болсон оновчтой, судалгаатай шийдвэр гаргамаар байна, төрийн албан хаагчид цалин тасрахгүй байгаа, хувийн хэвшлийнхэн маш хэцүү байдалтай байна.

Судалгаанд оролцогчид Засгийн газрыг хойшид дараах байдлаар ажиллахыг хүсч байна. Үүнд:

- | | |
|--|--------|
| - Шийдвэрээ бодитой, судалгаатай гаргах | 15.20% |
| - Эрсдлийг тооцож, зөв төлөвлөгөө, хөгжлийн бодлого гаргах | 13.90% |
| - Мэргэжлийн, шударга хүмүүс ажиллуулах | 12.70% |
| - Ажлын байр хадгалах, нэмэгдүүлэх | 8.90% |
| - Бэлэн мөнгө тараах болон халамжаас татгалзах | 8.90% |
| - Иргэд, ААН-ийг дэмжих | 7.60% |

Ирээдүйд итгэх итгэл:

Судалгаанд оролцогчдын 81.4 хувь нь ирээдүйдээ итгэх итгэлтэй байна. Үүнд:

- Вакцин гарч бүх зүйл хэвийн байдалдаа орно.
- Хүн бүр эрүүл орчинд, ажлын байртай орлого сайтай сэтгэл хангалуун амьдарна.
- Шударга байдал тогтоно гэдэгт итгэлтэй байна.

Хөл хорионы үед “БИ”



Судалгаанд оролцогчдын 18.4 хувь нь өөртөө сөрөг хандаж байсан. Үүнд:

- Цахимаар өдөр шөнөгүй ажиллаж, ажлын ачаалал улам нэмэгдсэн тул стресстэй байна.
- Сэтгэл санаа тогтворгүй байна.
- Чимээгүй тайван орчинд ажилламаар байна.
- Уйдаж, ганцаардаж байна.
- Нойрны хэмнэлээ алдсан
- Үр ашиггүй цагийг хий дэмий өнгөрөөж байгаадаа харамсаж байна.

Судалгаанд оролцогчдын 13 хувь нь өөртөө эерэг хандаж байна. Үүнд:


- Сууж хийх шаардлагатай байсан амжуулаагүй ажлуудаа амжуулж байна
- Эрүүл мэнд ямар чухал болохыг илүү ихээр мэдэрч, гэр бүлийн харилцаа бол амьдралын чухал үнэт зүйл гэдгийг ойлгож байна. Гэр бүлийнхэнтэйгээ цагийг сайхан өнгөрөөж байгаа.

25.9 хувь нь өөрийгөө хөгжүүлэх цаг гарсан гэж үзжээ. Үүнд:

- Даалгавар бие даалтаа сайн хийх, гадаад хэл сурч байгаа
- Цахимаар ажиллаж мэдээлэл технологийн орчин үеийн арга техникийг эзэмшиж байна
- Шинэ хоол хийж сурч байгаа.

- Буруу зан үйлээ засахыг хичээж байна.

Гэр бүлийн харилцаа:



- Судалгаанд оролцогчдын 9.4 хувь нь гэр бүлийн харилцаа нь тааламжтай биш, гэрийнхнээсээ тусдаа баймаар байгаа талаар хариулсан байна.
- 67.8 хувь нь гэр бүлийн харилцаа илүү ойр дотно, илүү нээлттэй, аз жаргалтай байна гэжээ.

Судалгааны дүгнэлт

Судалгаанд оролцсон байдлаас харахад, эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх, оролцоо эрэгтэйчүүдээс өндөр байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь эрүүл мэндийн үйлчилгээ, түүний хүртээмж хангалтгүй байх, эдийн засгийн хүндрэл, амьжиргааны түвшин буурах, боловсролын чанар муудахаас хамгийн их айж, санаа зовинож байна.

Судалгаанд оролцогчдын 57 хувь нь хөл хорио тогтоох арга хэмжээ нь өвчин тарах эсрдлээс хамгаалсан зөв шийдвэр гэж дэмжиж байна.

Харин Засгийн газрын хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, шийдвэрүүдэд 52 хувь нь сөрөг хандлагатай байна. Шийдвэр гаргахдаа судалгаанд үндэслээгүй, олон талыг харгалзаагүй, нэг гаргасан шийдвэртээ үнэнч бус, эргэж буцдаг, одоогийн төрийн удирдлагууд чадваргүй байна гэжээ.

Засгийн газартаа сөрөг болон шүүмжлэлтэй хандаж байгаа нь 86 хувийг эзэлж байна. Халамжийн бодлогыг өөрчлөх, ард иргэддээ мөнгө тараах биш, ажлын байраар хангах, түр зүүрын бус урт хугацаандаа үр өгөөжтэй арга хэмжээ авах хэрэгтэй гэж дийлэнх нь хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын 81.4 хувь нь ирээдүйгээ өөдрөгөөр харж, ирээдүйдээ итгэх итгэл дүүрэн байна. Түүнчлэн хөл хорионы үед гэр бүлийн харилцаанд эерэг талууд бий болсон, гэр бүлийн уур амьсгал таатай, аз жаргалтай байгаа гэж 67.8 хувь үзжээ.

Дээрх судалгаанаас дүгнэлт хийхэд Засгийн газрын хэрэгжүүлж байгаа шийдвэрт 52 хувь сөрөг, Засгийн газрын чадамжинд сөрөг хандаж байгаа нь 86 хувь гэсэн судалгааны үр дүнгээс бид Өндөржүүлсэн бэлэн байдал зарласан цагаас эхлэн дотооддоо халдвар илрэх хүртэл хугацаанд төрийн зүгээс нэгдсэн хамгаалах ямар нэгэн бодлого байхгүй байж үзэж байна.

Учир нь гаргасан шийдвэр бүрт нийгмийн зүгээс сайшаалтай хүлээн авахгүй, асуудал үүсэх бүрт дахин засаж шийдвэр гаргаж байгаа нь энэхүү эргэлзээг улам бататгаж байгаа юм.

Дэлхийн улс орнууд амжилттай ковид 19-ийн эсрэг бодлого баримталж буй Улс төрчид дараах гурван зүйлийг чандлан баримтлаж байна гэж үзсэн. Үүнд:

- Шинжлэх ухаанчаар байлдан дагуулах
- Харилцааны чадвартай байх
- Хамтаараа хийж байгаа гэдгийг ойлгуулах, хамт гэсэн мэдрэмжийг төрүүлэх гэсэн байсан.

Ашигласан эх сурвалж

<https://www.legalinfo.mn/law/details/15081?lawid=15081>

<https://nema.gov.mn/wpcontent/uploads/2020/02/%D0%A3%D0%9E%D0%9A-%D1%8B%D0%BD-%D0%B4%D0%B0%D1%80%D0%B3%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%88%D0%B0%D0%B0%D0%BB%E2%84%9604.pdf>

<https://www.legalinfo.mn/law/details/12458?lawid=12458>

<https://www.controlrisks.com/jp/our-thinking/japanese/covid-19-uncertainty>

Boin, A., 't Hart, P., Stern, E., & Sundelius, B. (2005). Crisis management in political systems: Five leadership challenges. In *The Politics of Crisis Management: Public Leadership Under Pressure* (pp. 1-17). Cambridge: Cambridge University Press. doi:10.1017/CBO9780511490880.001

Boin, A., 't Hart, P., Stern, E., & Sundelius, B. (2005). Crisis management in political systems: Five leadership challenges. In *The Politics of Crisis Management: Public Leadership Under Pressure* (pp. 1-17). Cambridge: Cambridge University Press. doi:10.1017/CBO9780511490880.001

ЗОХИОГЧИД

Зохиогчийн нэр	Ажил, албан тушаал	E-mail
С.Базарпүрэв	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор	bazarpurev@num.edu.mn
О.Мөнхжаргал	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн багш	munkhjargal.o@num.edu.mn
Ц.Ганболд	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор	bazarpurev@num.edu.mn
Ц.Бямбачулуун	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант	byambachuluuntseden@gmail.com
М.Мөнхзул	ХААИС-ЭЗБС- ХААХЭЗТэнхимийн дэд профессор	munkhzul@mul.edu.mn
Л.Идэр	Доктор	lozvoi.ider88@gmail.com
О.Хатанболд	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч	khatanboldo@gmail.com
Д.Энхболд	Докторант	enkhbold201607@gmail.com
Д.Сүхболд	Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн дэд профессор	sukheemodun@yahoo.com
Д.Уртнасан	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант	toto_bear@yahoo.com
Э.Гэрэлт-Од	МУБИС-ийн НХУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш	gereltode@gmail.com
Д.Түмэнжаргал	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш	Tumeedavaa12@gmail.com
Г.Эрдэнэбаяр	МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбар, Философи, шашин судлалын тэнхимийн дэд профессор	erdenebayar.g@num.edu.mn

Pavel Mařkarinec	Department of Political Science, Faculty of Arts, Jan Evangelista Purkyně University in Ústí nad Labem, Czech Republic	maskarinec@centrum.cz
Ж.Төртогтох	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор	turtogtokh@yahoo.com
Б.Эрдэнэдалай	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш	erdenedalai.bat@gmail.com
О.Батзаяа	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант	batzaya@vip76.mn
Д.Ундрах	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	ddj_undrakh@yahoo.com
Б.Болорчимэг	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант	bbolro23@gmail.com
Т.Заяа	ХИС-ийн ОУХНС-ын тэнхимийн багш	Zaya.t@humanities.mn
Т.Есүхэй	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дадлагажигч багш	tyesukhei@num.edu.mn
Д.Бумдарь	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	bumdari@num.edu.mn
Б.Хишигням	МУИС, Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга, дэд профессор	khishignyam@num.edu.mn
М.Тэгшбуян	МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар, Боловсрол, сэтгэл судлалын тэнхимийн дадлагажигч багш	tegshbuyan@num.edu.mn